Орчуулга

PCA хэрэг № 2010-20

1991 оны 8 дугаар сарын 26-нд гарын үсэг зурсан Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хоорондын хөрөнгө оруулалтыг хөхүүлэн дэмжих, харилцан хамгаалах тухай хэлэлцээрийн дагуу явуулсан арбитрын хэрэг

(1) CHINA HEILONGJIANG INTERNATIONAL ECONOMIC & TECHNICAL COOPERATIVE CORP.
(2) BEIJING SHOUGANG MINING INVESTMENT COMPANY LIMITED
(3) QINHUANGDAOSHI QINLONG INTERNATIONAL INDUSTRIAL CO. LTD.
Нэхэмжлэгчид

болон

МОНГОЛ УЛС
Хариуцагч буюу Нэхэмжлэгчидтэй хамтад нь Талууд

АРБИТРЫН ШИЙДВЭР

Арбитрын бүрэлдэхүүн
Шүүгч Петер Томка даргалагч
Доктор Яс Банифатэми
Ноён Марк Клодфелтер

Нарийн бичгийн даргын газар
Арбитрын Байнгын шүүх

2017 оны 6 дугаар сарын 30

АГУУЛГА

I. Удиртгал

A. Талууд

B. Маргааны үндэслэл

II. Хэрэг хянан шийдвэрлэсэн ажиллагаа

III. Бодит нөхцөл байдлын баримтууд

A. Хуулийн этгээдүүд

B. Холбогдох хүмүүс

C. Төмөртэйн орд

D. Монгол Улсын байгалийн баялгаа ашиглах түүхэн оролдлогууд

E. Монголын уул уурхайн эрх зүйн зохицуулалт

F. Дархан байгуулагдсан болон Төмөртэйн ордын анхны хайгуул

G. Төмөртэйн орд ашиглах тусгай зөвшөөрөл авах БЛТ-ийн хүсэлт

H. БЛТ-ийн үйл ажиллагаа болон Төмөртэй Хүдэр байгуулагдсан нь

I. Төмөртэй Хүдэрийн тусгай зөвшөөрлийг цуцалсан нь

J. Төмөртэй Хүдэр цуцлалтыг эсэргүүцсэн болон тусгай зөвшөөрлийг Дарханд олгосон нь

IV. Маргаантай нөхцөл байдлын талаарх талуудын тайлбар

A. Дарханы Төмөртэйн ордод хийсэн хайгуулын хэмжээ болон тус ордод эдлэх эрх

B. 1997 оны техник эдийн засгийн үндэслэл болон БЛТ Төмөртэйн ордын ашиглалтын тусгай зөвшөөрлийг авсан нь

C. БЛТ болон Төмөртэй Хүдэр Төмөртэйн ордыг хөгжүүлсэн нь

D. Ноён Нацагдорж, ноён Баярцогт нарт холбогдох эрүүгийн мөрдөн шалгах ажиллагаа

V. Гаргуулахыг хүссэн шийдвэрүүд

VI. Талуудын эрх зүйн үндэслэл

A. Арбитрын харьяалал болон хэрэглэх эрх зүй

1. Оролцогч этгээдийн хувьд харьяалал буюу ratione personae

2. Маргааны зүйлийн хувьд харьяалал буюу ratione materiae

3. Хэрэглэх эрх зүй

B. Хариуцагчийн урьдчилсан татгалзлууд

1. Арбитрын харьяаллын талаарх татгалзлууд

(a) Нэхэмжлэгчдийн хөрөнгө оруулалтыг олж авах явц дахь хулгай, завших, залилан гэх асуудал

(b) Хөрөнгө албадан хураасан гэх үйлдлийн хариуцлагыг тогтоох харьяаллыг Хэлэлцээр олгосон эсэх

(c) Шаардлага хангасан хөрөнгө оруулагч болон Хятадын Засгийн газрын оролцоо

(d) Шаардлага хангасан хөрөнгө оруулалт болон Нэхэмжлэгчдийн хөрөнгө оруулалтын эрсдэл

(e) Хууль хэрэглэсэн илэрхий алдаа

(f) Маргаан шийдвэрлэх замыг сонгох болон Монголын шүүхэд хандсан асуудал

2. Нэхэмжлэгчдийн нэхэмжлэлийг хүлээн авч хэлэлцэх боломжийн талаарх татгалзал

C. Хууль бусаар хөрөнгө албадан хураасан гэх нэхэмжлэлийн үндсэн асуудал

1. Хэлэлцээрийн 4 дүгээр зүйлийн эрх зүйн шалгуур

2. Хэлэлцээрийн 4 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийг хэрэглэх нь

3. 939A тусгай зөвшөөрлийг цуцалсан нь Монголын хуульд нийцсэн эсэх

(a) 160 дугаар тогтоолын дагуу Төмөртэйн ордын эрхийг өмнө нь эзэмшиж байсан асуудал

(b) Хайгуулын зардлыг Засгийн газарт нөхөн төлөөгүй асуудал

(c) Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ болон байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөг хэрэгжүүлээгүй асуудал

(d) Шаардлагатай зөвшөөрөлгүйгээр тэсэлгээний ажиллагаа явуулсан асуудал

(e) Хүдрийг өртгөөс доогуур үнээр, зөвшөөрөлгүйгээр хууль бусаар экспортолсон асуудал

(f) Цуцлах бусад үндэслэл

(g) Мэдэгдэл хүргүүлсэн асуудал

4. Дахин маргахыг хориглох болон өмнөх байр сууриасаа буцахыг хязгаарлах зарчим

D. Хариуцагчийн сөрөг нэхэмжлэл

1. Хариуцагчийн сөрөг нэхэмжлэлийг шийдвэрлэх харьяалал

2. Хариуцагчийн сөрөг нэхэмжлэлийн үндсэн асуудал

E. Эрхийг сэргээх арга хэрэгсэл

1. Нийтлэг зарчмууд

2. Мөнгөн дүнг тооцох нь

VII. Арбитрын бүрэлдэхүүний дүн шинжилгээ

A. Оролцогч этгээдийн хувьд харьяалал буюу ratione personae

B. Маргааны зүйлийн хувьд харьяалал буюу ratione materiae болон хөрөнгө албадан хураасан гэх үйлдлийн хариуцлагыг тогтоох харьяаллыг Хэлэлцээр олгосон эсэх

VIII. Зардал

IX. Тогтоох хэсэг

ТОДОРХОЙЛСОН НЭР ТОМЬЁОНЫ ЖАГСААЛТ

939А тусгай зөвшөөрөл	Сэлэнгэ аймгийн Хүдэр сумын Төмөртэй дэх төмрийн хүдрийн ордыг ашиглах тусгай зөвшөөрөл
1990–1992 оны тайлан	1990–1992 онд Төмөртэйн төмрийн ордод хийсэн нарийвчилсан хайгуул, Хуст-Уулын төмрийн хүдрийн илрэлүүдэд хийсэн эрэл, үнэлгээний ажлын үр дүнгийн тайлан
1994 оны Ашигт малтмалын тухай хууль	Монгол Улсын 1994 оны Ашигт малтмалын тухай хууль (1994 оны 9 дүгээр сарын 30; 1995 оны 1 дүгээр сарын 1-нд хүчин төгөлдөр болсон)
1997 оны Дагаж мөрдөх журмын тухай хууль	Монгол Улсын Ашигт малтмалын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль (1997 оны 7 дугаар сарын 1; 1997 оны 7 дугаар сарын 1-нд хүчин төгөлдөр болсон)
1997 оны Ашигт малтмалын тухай хууль	Монгол Улсын 1997 оны Ашигт малтмалын тухай хууль (1997 оны 6 дугаар сарын 5; 1997 оны 7 дугаар сарын 1-нд хүчин төгөлдөр болсон)
1998 оны Ашигт малтмалын хөтөлбөр	Монгол Улсын Засгийн газрын 1998 оны 8 дугаар сарын 12-ны өдрийн 144 дүгээр тогтоолоор батлсан Ашигт малтмалын хөтөлбөр
2001 оны Тусгай зөвшөөрлийн тухай хууль	Монгол Улсын Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль (2001 оны 2 дугаар сарын 1; 2002 оны 1 дүгээр сарын 1-нд хүчин төгөлдөр болсон)
2002 оны Газрын тухай хууль	Монгол Улсын Газрын тухай хууль (2002 оны 6 дугаар сарын 7; 2003 оны 1 дүгээр сарын 1-нд хүчин төгөлдөр болсон)
2004 оны Тэсэрч дэлбэрэх бодисын тухай хууль	Монгол Улсын Тэсэрч дэлбэрэх бодис болон тэдгээрийн эргэлтэд хяналт тавих тухай хууль (2004 оны 5 дугаар сарын 6; 2005 оны 1 дүгээр сарын 1-нд хүчин төгөлдөр болсон)
2006 оны Ашигт малтмалын тухай хууль	Монгол Улсын 2006 оны Ашигт малтмалын тухай хууль (2006 оны 7 дугаар сарын 8; 2006 оны 8 дугаар сарын 26-нд хүчин төгөлдөр болсон)
Ноён Баярцогт	Ноён Луузанданбын Баярцогт
Бээжин Шоуган	Beijing Shougang Mining Investment Company Ltd
БЛТ	БЛТ ХХК
Чайна Хэйлунзян	China Heilongjiang International Economic & Technical Cooperative Corp
Нэхэмжлэгчид	Чайна Хэйлунзян, Бээжин Шоуган болон Циньлун
Хамтран арбитрчид	Доктор Банифатэми болон ноён Клодфелтер
Дархан	Дарханы төмөрлөгийн үйлдвэр
Эрдэнэс	Эрдэнэс МГЛ

Ноён Эрдэнэцог	Ноён Д. Эрдэнэцог
ЭКСИММ	ЭКСИММ ХХК
Техник, эдийн засгийн үндэслэл	БЛТ-ээс 1997 онд ашиглалтын тусгай зөвшөөрөл хүссэн өргөдлөө дэмжин Монголын Засгийн газарт хүргүүлсэн, Төмөртэйн ордыг тодорхойлсон судалгаа
Ноён Ганболд	Ноён Т. Ганболд
Ноён Ганжууржав	Ноён С. Ганжууржав
Засгийн газар	Монгол Улс, Хариуцагч
Ноён Хурц	Ноён Ч. Хурц
Хурлын тэмдэглэл	Эрчим хүч, геологи, уул уурхайн яамны Геологи, шинжлэх ухаан, техникийн зөвлөлийн 1994 оны 7 дугаар сарын 21-ний өдрийн хурлын тэмдэглэл
Ноён Ли	Ноён Ли Шаоминг
АМГТХЭГ	Ашигт малтмал, газрын тосны хэрэг эрхлэх газар
Ноён Нацагдорж	Ноён Лувсандашийн Нацагдорж
Ноён Нэргүй	Ноён Б. Нэргүй
Давтан хариу тайлбарт гаргасан татгалзал	Нэхэмжлэгчдийн 2013 оны 1 дүгээр сарын 17-ны өдрийн Давтан хариу тайлбарт гаргасан татгалзлууд
РСА	Арбитрын Байнгын шүүх
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
Циньлун	Qinhuangdaoshi Qinlong International Industrial Co. Ltd
Ажиллагааг зогсоох хүсэлт	Хариуцагчаас хамтран арбитрчдад гаргасан ажиллагааг зогсоох тухай 2013 оны 8 дугаар сарын 5-ны өдрийн хүсэлт
Л. Туяаг дуудах хүсэлт	Л. Туяаг гэрчээр ирүүлэхийг Арбитрын бүрэлдэхүүнээс даалгах тухай Хариуцагчийн 2013 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн хүсэлт
160 дугаар тогтоол	Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Сайд нарын Зөвлөлийн 1990 оны 4 дүгээр сарын 14-ний өдрийн 160 дугаар тогтоол
Хариуцагч	Монгол Улс, Засгийн газар
Ноён Шагдар	Ноён Б. Шагдар
УМХГ	Улсын мэргэжлийн хяналтын газар
Төмөрлөгийн үйлдвэр	Дархан дахь төмөрлөгийн үйлдвэрийн цогцолбор
Газрын хэвлийн тухай хууль	Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Газрын хэвлийн тухай хууль (1989 оны 7 дугаар сарын 1-нд хүчин төгөлдөр болсон)

Т-30 гэрчилгээ	1997 оны 6 дугаар сарын 21-нд олгосон орд ашиглах Т-30 дугаар тусгай зөвшөөрлийн гэрчилгээ
Хэлэлцээр	1991 оны 8 дугаар сарын 26-нд гарын үсэг зурсан Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Засгийн газар болон БНХАУ-ын Засгийн газар хоорондын хөрөнгө оруулалтыг хөхүүлэн дэмжих, харилцан хамгаалах тухай хэлэлцээр
Төмөртэй Хүдэр	Төмөртэй Хүдэр ХХК
Хатагтай Туяа	Баярцогтын эхнэр, БЛТ-ийг үүсгэн байгуулагч хатагтай Л. Туяа

I. УДИРТГАЛ

A. ТАЛУУД

1. Энэхүү арбитрын ажиллагааны нэхэмжлэгчид нь: (1) China Heilongjiang International Economic & Technical Cooperative Corp (“Чайна Хэйлунзян”), (2) Beijing Shougang Mining Investment Company Ltd (“Бээжин Шоуган”), (3) Qinhuangdaoshi Qinlong International Industrial Co. Ltd (“Циньлун”) (хамтад нь “Нэхэмжлэгчид”) болно. Чайна Хэйлунзян болон Бээжин Шоуган нь Бүгд Найрамдах Хятад Ард Улсын (“БНХАУ”) хууль тогтоомжийн дагуу байгуулагдсан төрийн өмчит компаниуд юм. Циньлун мөн БНХАУ-ын хууль тогтоомжийн дагуу байгуулагдсан хязгаарлагдмал хариуцлагатай компани болно.

2. Энэхүү ажиллагаанд Нэхэмжлэгчдийг Франц Улс, Парис 75008, 2 rue Paul Cézanne хаяг дахь Freshfields Bruckhaus Deringer LLP фирмийн ноён Питер Тернер QC; Хонконг, Two Exchange Square, 11 дүгээр давхар дахь Freshfields Bruckhaus Deringer LLP фирмийн ноён Жон Чун болон Жонатан Вонг; мөн Нэгдсэн Вант Улс, Лондон, WC2R 3AL, 20 Essex St. хаяг дахь 20 Essex Street Chambers-ийн хатагтай Белинда МакРэй нар төлөөлж байна.

3. Энэхүү арбитрын ажиллагааны хариуцагч нь Монгол Улсын Засгийн газар (“Засгийн газар”, “Монгол Улс” эсхүл “Хариуцагч”) болно.

4. Энэхүү ажиллагаанд Хариуцагчийг Монгол Улс, Улаанбаатар 210646, Засгийн газрын V байр дахь Хууль зүйн яамны Төрийн нарийн бичгийн дарга, ноён Гунгаагийн Баясгалан; мөн Америкийн Нэгдсэн Улс, Вашингтон D.C. 20006, 1850 K St NW #1100 хаяг дахь Milbank, Tweed, Hadley & McCloy LLP фирмийн ноён Майкл Д. Нолан, хатагтай Элица Попова-Талти, ноён Камел Айтелаж нар төлөөлж байна.

B. МАРГААНЫ ҮНДЭСЛЭЛ

5. Нэхэмжлэгчид болон Хариуцагчийн хооронд маргаан үүссэн бөгөөд Нэхэмжлэгчид 1991 оны 8 дугаар сарын 26-нд гарын үсэг зурсан Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хоорондын Хөрөнгө оруулалтыг хөхиүлэн дэмжих, харилцан хамгаалах тухай хэлэлцээрийн (“Хэлэлцээр”) дагуу уг маргаантай холбогдуулан арбитрын ажиллагаа эхлүүлсэн.

6. Талуудын маргаан нь Монгол Улсын Сэлэнгэ аймгийн Хүдэр сумын Төмөртэйд байрлах төмрийн хүдрийн ордын ашиглалтын тусгай зөвшөөрлийг (“939А тусгай зөвшөөрөл”) Монгол Улс Хэлэлцээрийн 4 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийг зөрчин албадан хураасан гэх асуудалтай холбоотой. Уг тусгай зөвшөөрлийг албадан хураасан гэх үйл явдлаас өмнө Нэхэмжлэгчдийн 70 хувийг эзэмшдэг Монголын компани болох “Төмөртэй Хүдэр” ХХК (“Төмөртэй Хүдэр”) 939А тусгай зөвшөөрлийг эзэмшиж байв.

II. АЖИЛЛАГААНЫ ЯВЦ

7. 2006 оны 12 дугаар сарын 26-нд ноён Ли Шаоминг Монгол Улсын Ерөнхий сайд, ноён Миеэгомбын Энхболдод захидал хүргүүлсэн бөгөөд Нэхэмжлэгчид уг захидлыг

Хэлэлцээрийн 8 дугаар зүйлийн дагуу гаргасан маргааны тухай мэдэгдэл гэж тодорхойлдог.[1]

8. 2009 оны 10 дугаар сарын 9-нд Нэхэмжлэгчдийн өмгөөлөгч Монгол Улсын Ерөнхий сайд, ноён Санжаагийн Баярт “Бүгд Найрамдах Хятад Ард Улсын (БНХАУ) Засгийн газар, Бүгд Найрамдах Монгол Ард Улсын (Монгол Улс) Засгийн газар хоорондын Хөрөнгө оруулалтыг хөхиүлэн дэмжих, харилцан хамгаалах тухай 1991 оны хэлэлцээр (Хэлэлцээр) болон 1993 онд батлагдаж, 2002 онд нэмэлт, өөрчлөлт орсон Монгол Улсын Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хуулийн (Хууль) дагуух маргаан” гэсэн гарчигтай захидал илгээх замаар Хариуцагчид маргааны талаар нэмэлт мэдэгдэл хүргүүлсэн.

9. 2010 оны 2 дугаар сарын 12-нд Нэхэмжлэгчид Хэлэлцээр болон Монгол Улсын Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хуулийн дагуу Монгол Улсад арбитрын хүсэлт хүргүүлж, энэхүү ажиллагааг эхлүүлсэн. Нэхэмжлэгчид арбитрын хүсэлтдээ Хэлэлцээрийн 8 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн дагуу Франц, Ираны иргэн, доктор Яс Банифатэмиг арбитрчаар томилсон.

10. 2010 оны 5 дугаар сарын 19-нд Хариуцагч Хэлэлцээрийн 8 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн дагуу Америкийн Нэгдсэн Улсын иргэн, ноён Марк А. Клодфелтерийг энэхүү ажиллагааны арбитрчаар томилсон.

11. 2010 оны 7 дугаар сарын 19-нд Нэхэмжлэгчид Хөрөнгө оруулалтын маргааныг шийдвэрлэх олон улсын төвийн Ерөнхий нарийн бичгийн дарга, хатагтай Мег Киннирт Хэлэлцээрийн 8 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн дагуу Арбитрын бүрэлдэхүүний даргалагчийг томилох хүсэлт гаргасан.

12. 2010 оны 8 дугаар сарын 10-нд хатагтай Киннир Америкийн Нэгдсэн Улсын иргэн, ноён Дональд Фрэнсис Донованыг даргалагч арбитрчаар томилсон.

13. 2010 оны 9 дүгээр сарын 22-нд Арбитрын бүрэлдэхүүн 2010 оны 10 дугаар сарын 1-нд Нью-Йоркт хийх ажиллагааны журмын талаарх уулзалтын хэлэлцэх асуудлыг хүргүүлсэн. 2010 оны 9 дүгээр сарын 28-нд Арбитрын бүрэлдэхүүн уг хэлэлцэх асуудлын зарим хэсгийн талаар талуудад дахин захидал илгээсэн.

14. 2010 оны 9 дүгээр сарын 30-нд талууд ажиллагааны журмын талаарх уулзалтын хэлэлцэх асуудлын зарим зүйлтэй холбогдуулан Арбитрын бүрэлдэхүүнд хамтарсан захидал хүргүүлсэн.

15. 2010 оны 10 дугаар сарын 1-нд Арбитрын бүрэлдэхүүн Нью-Йорк дахь Debevoise & Plimpton LLP фирмийн байранд талуудтай ажиллагааны журмын талаарх уулзалт хийсэн.

16. 2010 оны 11 дүгээр сарын 2-нд Арбитрын бүрэлдэхүүн энэхүү ажиллагааны зохион байгуулалтын талаар Ажиллагааны тухай 1 дүгээр захирамж гаргасан. Уг захирамжид тэмдэглэснээр, талууд харьяаллын асуудлыг маргааны мөн чанараас тусад нь салгаж хэлэлцэхгүй, харин ажиллагааг хоёр үе шатад хуваахаар тохиролцсон. Эхний үе шатад

[1] Захидал, огноо: 2006 оны 12 дугаар сарын 26 (Баримт С-2).

харьяалал болон хариуцлагыг, шаардлагатай бол хоёр дахь үе шатад нөхөн төлбөрийн хэмжээг хэлэлцэхээр болсон.

17. Мөн 2010 оны 11 дүгээр сарын 2-нд Арбитрын бүрэлдэхүүн Арбитрын Байнгын шүүхэд ("PCA") захидал хүргүүлж, арбитрын ажиллагааг захиргааны хувьд зохион байгуулах хүсэлт гаргасан. 2010 оны 11 дүгээр сарын 3-нд PCA Арбитрын бүрэлдэхүүнд хариу хүргүүлж, Ажиллагааны тухай 1 дүгээр захирамжийн арбитрын ажиллагааны захиргааны зохион байгуулалттай холбоотой хэсгүүдийг хүлээн зөвшөөрсөн.

18. 2010 оны 11 дүгээр сарын 22-нд Арбитрын бүрэлдэхүүн өөрийн хөлсний талаар Ажиллагааны тухай 2 дугаар захирамж гаргасан.

19. 2011 оны 3 дугаар сарын 1-нд Нэхэмжлэгчид ноён Луузандамбын Баярцогт, ноён Ли Шаоминг нарын гэрчийн мэдүүлгийг хавсарган нэхэмжлэлийн үндэслэлээ гаргасан. Уг баримт бичигт "Нэхэмжлэгчид Хэлэлцээрийн [4 дүгээр зүйлийн 1 дэх хэсгээс] бусад заалт болон Монгол Улсын Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хуулийн дагуу гаргасан шаардлагуудаа цаашид үргэлжлүүлэхгүй" гэж мэдэгдсэн.[2]

20. 2011 оны 4 дүгээр сарын 20-нд Нэхэмжлэгчид Арбитрын бүрэлдэхүүнд захидал хүргүүлж, Дархан-Уул аймаг дахь сум дундын шүүх 2011 оны 4 дүгээр сарын 13-нд дараах шийдвэр гаргасныг мэдэгдсэн:

> Монгол Улсын Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 69.1.5-д заасны дагуу харьяалал, хариуцлагын асуудлаар хийхээр товлосон 2013 оны 1 дүгээр сарын 14–15-ны өдрийн хуралдаан хүртэлх хугацаанд Төмөртэйн ордод байгаа "Төмөртэй Хүдэр" ХХК-ийн уул уурхайн тоног төхөөрөмж, барилга, байгууламжийг хамгаалах, хадгалалт бүрэн бүтэн байдлыг хангахтай холбоотой өмчлөх эрхийг зөрчих, мөн эдгээр хөрөнгө байрлаж буй талбайд аливаа үйл ажиллагаа явуулахыг "Дарханы төмөрлөгийн үйлдвэр" төрийн өмчит хувьцаат компанид хориглосугай. Түүнчлэн Дархан-Уул аймаг дахь сум дундын шүүхийн 2010 оны 1 дүгээр сарын 26-ны өдрийн 633 дугаар шийдвэрийн хүчин төгөлдөр байдалд нөлөөлөхгүйгээр, "Дарханы төмөрлөгийн үйлдвэр" төрийн өмчит хувьцаат компани Төмөртэйн уурхайд ашигт малтмалын эрэл, хайгуул, олборлолт явуулах, хайгуулын болон ашиглалтын ажлын төлөвлөгөө боловсруулах, судалгаа хийх зэрэг Ашигт малтмалын тухай хуульд заасан үйл ажиллагааг хэрэгжүүлэхдээ уг хугацааг хүртэл болон уг хугацаанд хуульд нийцүүлэн санхүүгийн бүртгэл, тайланг үнэн зөв хөтөлж, борлуулсан бүтээгдэхүүний хэмжээ, тоо хэмжээг үнэн зөв тайлагнах үүрэгтэй бөгөөд тусгай зөвшөөрөл болон тусгай зөвшөөрөлтэй талбайн аль нэг хэсгийг бусдад шилжүүлэх, барьцаалахыг хориглосугай.

21. 2011 оны 9 дүгээр сарын 1-нд Хариуцагч ноён С. Ганжууржав, ноён Б. Шагдар нарын гэрчийн мэдүүлгийг хавсарган хариу тайлбараа гаргасан. Уг хариу тайлбартаа Хариуцагч Арбитрын бүрэлдэхүүний харьяаллыг эсэргүүцэж, залилан мэхлэх зорилгоор худал мэдээлэл өгсний улмаас учирсан хохирлыг нөхөн төлүүлэх сөрөг нэхэмжлэл гаргасан.

22. 2011 оны 10 дугаар сарын 3-нд Хариуцагч Нэхэмжлэгчдээс баримт гаргуулах 62 хүсэлтийг Редферн хүснэгтэд нэгтгэн гаргасан.

---

[2] Нэхэмжлэгчдийн Нэхэмжлэлийн үндэслэл, догол мөр 4.

23. 2011 оны 11 дүгээр сарын 30-нд Нэхэмжлэгчид Хариуцагчийн баримт гаргуулах хүсэлтэд хариу гаргаж, Монгол Улсын хүсэлт бүрийг эсэргүүцсэн.

24. 2011 оны 12 дугаар сарын 23-нд талууд нэмэлт тайлбар солилцсоны дараа Арбитрын бүрэлдэхүүн шийдвэрлэгдээгүй хүсэлтүүдийн талаар талуудыг зөвшилцөхийг хүссэн.

25. 2012 оны 1 дүгээр сарын 6-нд Арбитрын бүрэлдэхүүн утсаар хамтарсан хэлэлцүүлэг хийж, талууд баримт гаргуулах хүсэлтүүдийн явцын талаар мэдээлэл өгсөн. Арбитрын бүрэлдэхүүн эцсийн шийдвэр нь ямар байхыг урьдчилан илэрхийлэх зорилгогүйгээ тайлбарлаад, талуудыг тохиролцоонд хүрэхэд туслах зорилгоор асуулт тавьж, санал хэлсэн.

26. 2012 оны 4 дүгээр сарын 24-нд талуудаас нэмэлт мэдээлэл ирээгүй тул Арбитрын бүрэлдэхүүн 1 дүгээр сарын 6-ны өдрийн утсан хэлэлцүүлгээр ярилцсан бүх асуудлыг шийдвэрлэсэн эсэхийг баталгаажуулахыг хүссэн.

27. 2012 оны 5 дугаар сарын 9-нд талууд баримт гаргуулахтай холбоотой үлдсэн асуудлуудаар 2012 оны 5 дугаар сарын 16-нд эцсийн тайлбараа нэгэн зэрэг гаргах хүсэлтэйгээ мэдэгдсэн. Уг өдөр тал тус бүр тайлбар болон эцсийн Редферн хүснэгтээ ирүүлсэн.

28. 2012 оны 6 дугаар сарын 22-нд Нэхэмжлэгчид ноён Ли Шаомингийн хоёр дахь гэрчийн мэдүүлгийг хавсарган хариу тайлбараа гаргасан. Нэхэмжлэгчид уг хариу тайлбартаа Хариуцагчийн сөрөг нэхэмжлэлийн хувьд Арбитрын бүрэлдэхүүн харьяалалгүй гэж татгалзал гаргасан.

29. 2012 оны 7 дугаар сарын 3-нд Арбитрын бүрэлдэхүүн Ажиллагааны тухай 3 дугаар захирамж гаргаж, хуралдааныг 2013 оны 2 дугаар сарын 23-наас 3 дугаар сарын 1-ний хооронд Сингапурт хийхээр шийдвэрлэсэн.

30. 2012 оны 8 дугаар сарын 31-нд Нэхэмжлэгчид Арбитрын бүрэлдэхүүнд захидал хүргүүлж, “Арбитрын бүрэлдэхүүний гаргасан аливаа шийдвэр эцсийн бөгөөд заавал биелэгдэх шинжтэй, мөн талууд шийдвэрийг албадан гүйцэтгэх боломжийг шууд буюу шууд бусаар сулруулах, түүнд нөлөөлөх аливаа арга хэмжээ авч болохгүйг талуудад сануулах”-ыг хүссэн. 2012 оны 9 дүгээр сарын 4-нд Хариуцагч уг хүсэлтийг эсэргүүцсэн захидал Арбитрын бүрэлдэхүүнд хүргүүлсэн. 2012 оны 9 дүгээр сарын 6-нд Нэхэмжлэгчид хүсэлттэйгээ холбогдуулан Арбитрын бүрэлдэхүүнд дахин захидал хүргүүлсэн.

31. 2012 оны 10 дугаар сарын 1-нд Хариуцагч Нэхэмжлэгчдийн бичгээр гаргасан тайлбарын зарим хэсэгт хамаарах нотлох баримт болон орчуулгад татгалзал гаргасан.

32. 2012 оны 10 дугаар сарын 6-нд Арбитрын бүрэлдэхүүн баримт гаргуулах тухай Ажиллагааны тухай 4 дүгээр захирамж гаргасан.

33. Мөн 2012 оны 10 дугаар сарын 6-нд Арбитрын бүрэлдэхүүн Ажиллагааны тухай 5 дугаар захирамж гаргаж, Нэхэмжлэгчдийн 2012 оны 8 дугаар сарын 31-ний өдрийн захидлаар хүссэн “сануулга”-ыг гаргахаас татгалзсан.

34. 2012 оны 12 дугаар сарын 14-нд Хариуцагч ноён Ч. Хурц, ноён Б. Нэргүй нарын гэрчийн мэдүүлэг болон хатагтай Антеа Робертс, хатагтай Тайваны Нацагдорж, хатагтай

Дарижавын Цэвэгжав, ноён Р. Зоригт нарын шинжээчийн дүгнэлтийг хавсарган дахин хариу тайлбар гаргасан.

35. 2013 оны 1 дүгээр сарын 7-нд ноён Донован талуудад захидал хүргүүлж, дараах мэдээллийг ил болгосон:

> Debevoise & Plimpton LLP фирм нь 1991 оны 8 дугаар сарын 26-ны өдрийн Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хоорондын Хөрөнгө оруулалтыг хөхиүлэн дэмжих, харилцан хамгаалах тухай хэлэлцээрийн 8 дугаар зүйлийн 3 дахь хэсэгтэй ижил заалт агуулсан гэрээнээс үүдэлтэй хөрөнгө оруулагч–улс хоорондын арбитрын маргааны нэг талыг төлөөлөхөөр болсон.

Энэхүү мэдээлэл аль нэг талд эргэлзээ, болгоомжлол төрүүлж байвал 2013 оны 1 дүгээр сарын 15-наас хэтрүүлэхгүйгээр Арбитрын бүрэлдэхүүнд мэдэгдэхийг ноён Донован мөн хүссэн.

36. Мөн өдөр ноён Клодфелтер талуудад захидал хүргүүлж, (a) түүний Foley Hoag LLP фирм нь “8 дугаар зүйлийн 3 дахь хэсэгтэй төстэй үг хэллэг агуулаагүй” боловч “уг 8 дугаар зүйлийн 3 дахь хэсэгтэй төстэй үг хэллэг бүхий, ижил улсуудын хооронд өмнө байгуулсан гэрээг орлосон” гэрээтэй холбоотой хэрэгт төлөөлөгчөөр ажиллахаар болсон; мөн (b) өмнө нь ил болгосон, түүний хариуцагчийг төлөөлдөг өөр хэрэгт нууц арбитрын шийдвэр гарсан бөгөөд тухайн хэрэгт хамаарах гэрээнд 8 дугаар зүйлийн 3 дахь хэсэгтэй төстэй болон түүнээс ялгаатай бусад үг хэллэг агуулагддаг, энэ хэрэгт гаргасан тайлбаруудад дурдсан зарим асуудлыг уг хэрэгт мөн хөндсөн болохыг мэдээлсэн.

37. 2013 оны 1 дүгээр сарын 16-нд Нэхэмжлэгчид Арбитрын бүрэлдэхүүнд захидал хүргүүлж, “ноён Донованы 2013 оны 1 дүгээр сарын 7-ны өдрийн захидал болон ноён Клодфелтерийн 2013 оны 1 дүгээр сарын 7-ны өдрийн захидлаар ил болгосон мэдээлэлтэй холбоотойгоор тавих асуудалгүй гэдгээ баталсан”.

38. 2013 оны 1 дүгээр сарын 17-нд Нэхэмжлэгчид Арбитрын бүрэлдэхүүнд захидал хүргүүлж, “Хариуцагчийн дахин гаргасан хариу тайлбарт оруулсан шинэ үндэслэл, нотлох баримт”-ыг эсэргүүцсэн (“Дахин гаргасан хариу тайлбарт холбогдох татгалзал”). Нэхэмжлэгчдийн үзэж байгаагаар, “Хариуцагч бичгээр тайлбар гаргах хоёр дахь ээлжийг Нэхэмжлэгчдийн нэхэмжлэлийн үндэслэлд хариу өгөх боломж болгон ашиглаж”, үүнээс өмнө гаргасан хариу тайлбартаа дурдаагүй үндэслэл, нотлох баримтыг гаргаж ирсэн.

39. 2013 оны 1 дүгээр сарын 23-нд Хариуцагч ноён Донованы ил болгосон мэдээлэлтэй холбогдуулан Арбитрын бүрэлдэхүүнд захидал хүргүүлж, дараах байдлаар мэдэгдсэн:

> Бидний өмнө үүссэн нөхцөл байдал, үүнд таны 2013 оны 1 дүгээр сарын 7-нд мэдээлэл ил болгосны дараа Debevoise фирмийн өмгөөллийн ажлын талаар нийтэд ил болсон зарим мэдээллийг нухацтай авч үзсэний эцэст, Debevoise нэг талыг төлөөлөх болсонтой холбоотой үүссэн асуудлуудыг таны захидалд дурдсан арга хэмжээ хангалттай шийдвэрлэнэ гэж Монгол Улс үзэхгүй байна.

Иймд Хариуцагч ноён Донованыг Арбитрын бүрэлдэхүүний даргалагчийн үүргээс огцрохыг хүссэн.

40. 2013 оны 1 дүгээр сарын 25-нд Хариуцагч Арбитрын бүрэлдэхүүнд захидал хүргүүлж, Нэхэмжлэгчдийн Дахин гаргасан хариу тайлбарт холбогдох татгалзлын үндэслэлийг няцаасан. Хариуцагч уг захидалдаа Нэхэмжлэгчдийн хөндсөн асуудал бүрийг нэгбүрчлэн авч үзээд, "Монгол Улсын дахин гаргасан хариу тайлбарт буй материал нь Нэхэмжлэгчдийн хариу тайлбар дахь шинэ мэдэгдэл, үндэслэлд хариу өгсөн бөгөөд Монгол Улсын өмнөх хариу тайлбарт дэвшүүлсэн үндэслэлийг дахин авч үзсэн" гэж дүгнэсэн.

41. Мөн 2013 оны 1 дүгээр сарын 25-нд талууд эсрэг талаас асуулт тавьж байцаахыг хүссэн гэрчүүдээ тодорхойлсон захидал солилцсон. Хариуцагч тухайн өдрийн захидалдаа, аль ч тал хатагтай Л. Туяагийн мэдүүлгийг ирүүлээгүй хэдий ч түүнийг гэрчээр оролцуулахыг Арбитрын бүрэлдэхүүнээр даалгуулах хүсэлт гаргасан ("Л. Туяаг гэрчээр дуудах хүсэлт").

42. 2013 оны 1 дүгээр сарын 28-нд Нэхэмжлэгчид ноён Донован, ноён Клодфелтер нарын ил болгосон мэдээллийн талаар Арбитрын бүрэлдэхүүнд дахин захидал хүргүүлсэн.

43. 2013 оны 1 дүгээр сарын 29-нд Нэхэмжлэгчид Хариуцагчийн Л. Туяаг гэрчээр дуудах хүсэлтийн талаар Арбитрын бүрэлдэхүүнд захидал хүргүүлж, бүрэлдэхүүний ажиллагааны тухай захирамжууд "талуудын зүгээс "гэрч" болгон мэдүүлээгүй этгээдэд хамаарахгүй", мөн талууд "ажиллагаанд мэдүүлэг өгөөгүй этгээдийг оролцуулахыг шаардах эрхгүй" гэж тайлбарласан.

44. 2013 оны 2 дугаар сарын 6-нд Хариуцагч ноён Донованы ил болгосон мэдээлэлтэй холбогдуулан дахин захидал хүргүүлж, хуралдааныг албан ёсоор хойшлуулах хүсэлт гаргасан.

45. 2013 оны 2 дугаар сарын 6-ны өдрийн дараахан Арбитрын бүрэлдэхүүн Ажиллагааны тухай 6 дугаар захирамж гаргаж, тухайн сард эхлэхээр товлосон хуралдааныг шинэ өдөр тогтоолгүйгээр хойшлуулж, арбитрчийг татгалзан гаргах аливаа хүсэлтийг шийдвэрлэх этгээдээр ICSID-ийн Ерөнхий нарийн бичгийн даргыг томилсон. Мөн өдөр Ажиллагааны тухай 6 дугаар захирамж гарсны дараа ноён Донован Арбитрын бүрэлдэхүүний даргалагчийн үүргээс огцорсон.

46. 2013 оны 2 дугаар сарын 14-нд доктор Банифатэми, ноён Клодфелтер ("бусад хоёр арбитрч") талуудад захидал хүргүүлж, "Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Засгийн газар хоорондын Хөрөнгө оруулалтыг хөхиүлэн дэмжих, харилцан хамгаалах тухай хэлэлцээрийн 8 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн дагуу анхны томилгоонд хэрэглэсэн журам орлох арбитрчийг томилоход мөн үйлчилнэ гэж үзэж байгаагаа" мэдэгдсэн. Талууд эсэргүүцэхгүй бол "ноён Донован огцорсноос хойш хоёр сарын дотор даргалагчийг сонгох талаар тохиролцоонд хүрэхийг хичээнэ; тохиролцоонд хүрч чадахгүй бол аль нэг тал Хөрөнгө оруулалтын маргааныг шийдвэрлэх олон улсын төвийн Ерөнхий нарийн бичгийн даргад томилгоог хийх хүсэлт гаргаж болно" гэж бусад хоёр арбитрч нэмж мэдэгдсэн.

47. 2013 оны 2 дугаар сарын 18-нд Хариуцагч Нэхэмжлэгчдэд дахин захидал хүргүүлж, Дахин гаргасан хариу тайлбарт холбогдох татгалзлыг хүлээн зөвшөөрөхгүйгээ давтан мэдэгдсэн. Нэхэмжлэгчид байр сууриа хэвээр хадгалбал тэдний гаргахыг хүссэн аливаа нэмэлт

үндэслэл, нотлох баримтын талаар хоёр тал бичгээр тайлбарлах боломж бүрдүүлэхийн тулд нэмэлт тайлбар гаргах хуваарь санал болгохыг хүссэн.

48. 2013 оны 4 дүгээр сарын 8-нд доктор Банифатэми, ноён Клодфелтер нар шинэ даргалагчийг сонгох талаар тохиролцоонд хүрч чадаагүйгээ талуудад захидлаар мэдэгдсэн.

49. 2013 оны 8 дугаар сарын 5-нд Хариуцагч бусад хоёр арбитрчид захидал хүргүүлж, ноён Донован огцорсноос хойш зургаан сар өнгөрснийг тэмдэглээд, "Нэхэмжлэгчид хэргээ орхисон болон/эсхүл нэхэмжлэлээ үргэлжлүүлээгүйг харгалзан" тэднийг "энэхүү арбитрын ажиллагааг дуусгавар болгох тухай захирамж гаргах"-ыг хүссэн ("Ажиллагааг дуусгавар болгуулах хүсэлт").

50. 2013 оны 8 дугаар сарын 7-нд бусад хоёр арбитрч талуудад захидал хүргүүлж, Хариуцагчийн Ажиллагааг дуусгавар болгуулах хүсэлтийн талаар Нэхэмжлэгчдийн тайлбарыг хүссэн.

51. 2013 оны 8 дугаар сарын 30-нд Нэхэмжлэгчид бусад хоёр арбитрчид захидал хүргүүлж, "[тэднийг] хэргээ орхисон гэж ямар ч байдлаар хэлэх боломжгүй" хэмээн мэдэгдээд, "орлох даргалагчийг томилох ажиллагааг үргэлжлүүлэхийг ICSID-ийн Ерөнхий нарийн бичгийн даргаас хүсэх" зорилготойгоо илэрхийлсэн.

52. 2013 оны 9 дүгээр сарын 5, 6-нд Хариуцагч, Нэхэмжлэгчид тус тус Ажиллагааг дуусгавар болгуулах хүсэлтийн талаар захидал солилцсон. Талууд Арбитрын бүрэлдэхүүний орлох даргалагчийн талаар тохиролцоонд хүрэхийг хичээхээ баталсан бөгөөд Хариуцагч уг хүсэлттэй холбоотой эрхээ хадгалсан.

53. 2013 оны 12 дугаар сарын 16-нд талууд шүүгч Петер Томкаг даргалагч арбитрчаар ажиллахыг хамтран урьсан. Мөн уг захидалдаа Хариуцагч харьяалал болон хариуцлагын асуудлаарх хуралдаанаас өмнө өөрийн хүсэлтийг хэлэлцүүлэхээр Арбитрын бүрэлдэхүүнд хандах эрхээ хадгалсан.

54. 2014 оны 1 дүгээр сарын 26-нд шүүгч Томка даргалагч арбитрчийн үүргийг хүлээн авсан.

55. 2014 оны 3 дугаар сарын 11-нд Арбитрын бүрэлдэхүүн Хариуцагчаас Ажиллагааг дуусгавар болгуулах хүсэлтээ хэвээр хадгалж байгаа эсэхийг тодруулахыг хүссэн.

56. 2014 оны 3 дугаар сарын 17-нд Хариуцагч хүсэлтээ хэвээр хадгалж байгаагаа мэдэгдэж, уг хүсэлттэй холбоотой тайлбарыг талууд нэгэн зэрэг гаргахыг даалгахыг Арбитрын бүрэлдэхүүнээс хүссэн. 2014 оны 3 дугаар сарын 20-нд Нэхэмжлэгчид эдгээр тайлбарыг гаргах хэлбэрийн талаар Арбитрын бүрэлдэхүүнд захидал хүргүүлсэн.

57. 2014 оны 3 дугаар сарын 21-нд Арбитрын бүрэлдэхүүн Хариуцагчийн хүсэлтийн талаар талууд ээлж дараалан тайлбар гаргахыг даалгаж, биечлэн оролцох хуралдааныг 2014 оны 6 дугаар сарын 24-нд хийхээр төлөвлөсөн.

58. 2014 оны 4 дүгээр сарын 3-нд Арбитрын бүрэлдэхүүн талуудад захидал хүргүүлж, "Ажиллагааг дуусгавар болгуулах хүсэлтийн талаар Арбитрын бүрэлдэхүүний гаргах шийдвэрийг урьдчилан хөндөхгүйгээр" харьяалал, нэхэмжлэл болон сөрөг нэхэмжлэлийн

асуудлаар хуралдаан хийх зорилгоор 2015 оны 1 дүгээр сарын 19–24-ний долоо хоногт завтай байхаар төлөвлөхийг хүссэн.

59. 2014 оны 4 дүгээр сарын 21-нд Хариуцагч Ажиллагааг дуусгавар болгуулах хүсэлтийнхээ талаар тайлбар гаргасан.

60. 2014 оны 5 дугаар сарын 21-нд Нэхэмжлэгчид Ажиллагааг дуусгавар болгуулах хүсэлтэд хариу тайлбар гаргасан. Уг тайлбартаа Нэхэмжлэгчид биечлэн оролцох хуралдааныг цуцлахыг Арбитрын бүрэлдэхүүнээс хүссэн.

61. 2014 оны 5 дугаар сарын 27-нд Хариуцагч Арбитрын бүрэлдэхүүнд захидал хүргүүлж, биечлэн оролцох хуралдааныг цуцлан, талуудын бичгээр гаргасан тайлбаруудад үндэслэн хүсэлтийг шийдвэрлэхийг зөвшөөрсөн.

62. 2014 оны 5 дугаар сарын 29-нд Арбитрын бүрэлдэхүүн талуудын тус тусын захидлыг харгалзан Хариуцагчийн Ажиллагааг дуусгавар болгуулах хүсэлтийг хэлэлцэх биечлэн оролцох хуралдааныг цуцалсныг талуудад мэдэгдсэн.

63. 2014 оны 10 дугаар сарын 13-нд Арбитрын бүрэлдэхүүн Ажиллагааны тухай 7 дугаар захирамж гаргаж, Хариуцагчийн Ажиллагааг дуусгавар болгуулах хүсэлтийг хэрэгсэхгүй болгож, уг хүсэлттэй холбоотой зардлын бүх асуудлыг дараа шийдвэрлэхээр хойшлуулсан.

64. 2014 оны 11 дүгээр сарын 17-нд Нэхэмжлэгчид хуралдаан болох газар, хуралдааны өмнөх утсан хэлэлцүүлгийн тов, мөн талууд бичгээр тайлбараа гаргаснаас хойш ихээхэн хугацаа өнгөрснийг харгалзан нэмэлт эрх зүйн эх сурвалж танилцуулах журмын талаар Арбитрын бүрэлдэхүүнд захидал хүргүүлсэн. Нэхэмжлэгчид мөн 2013 оны 1 дүгээр сарын 17-нд гаргасан Дахин гаргасан хариу тайлбарт холбогдох татгалзлаа сануулж, “энэ талаар Арбитрын бүрэлдэхүүний шийдвэрийг хүлээж байгаагаа” мэдэгдсэн.

65. 2014 оны 11 дүгээр сарын 21-нд Хариуцагч Нэхэмжлэгчдийн 11 дүгээр сарын 17-ны өдрийн захидалд хөндсөн асуудлын талаар Арбитрын бүрэлдэхүүнд захидал хүргүүлсэн. Дахин гаргасан хариу тайлбарт холбогдох татгалзлын тухайд Хариуцагч 2013 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн захидлаа сануулж, “Монгол Улсын дахин гаргасан хариу тайлбарт буй материал нь Нэхэмжлэгчдийн хариу тайлбар дахь шинэ үндэслэл, мэдэгдлүүдэд төдийгүй Монгол Улсын хариу тайлбарт өгсөн Нэхэмжлэгчдийн хариултад хариу өгсөн” гэж тайлбарласан.

66. 2014 оны 12 дугаар сарын 4-нд Арбитрын бүрэлдэхүүн Ажиллагааны тухай 8 дугаар захирамж гаргаж, Нэхэмжлэгчдийн Дахин гаргасан хариу тайлбарт холбогдох татгалзлыг хэрэгсэхгүй болгосон.

67. 2014 оны 12 дугаар сарын 17-нд, тухайн өдөр хийхээр товлосон хуралдааны өмнөх утсан хэлэлцүүлгээс өмнө Хариуцагчийн өмгөөлөгч Арбитрын бүрэлдэхүүнд захидал хүргүүлж, эрүүл мэндийн ноцтой хүндрэл гарсны улмаас 2015 оны 1 дүгээр сард товлосон хуралдаанд оролцох боломжгүй болсныг мэдэгдсэн.

68. 2014 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн дараахан Арбитрын бүрэлдэхүүн талуудтай хуралдааны өмнөх утсан хэлэлцүүлэг хийж, хуралдааныг хойшлуулах Хариуцагчийн хүсэлт болон хуралдааны зохион байгуулалттай холбоотой ажиллагааны бусад асуудлыг

хэлэлцсэн. Утсан хэлэлцүүлгийн дараа Арбитрын бүрэлдэхүүн талуудад захидал хүргүүлж, хуралдааны товыг хойшлуулсан.

69. 2014 оны 12 дугаар сарын 19-нд талууд ажиллагааг хойшлуулахтай холбоотой нэмэлт захидал солилцсон.

70. 2014 оны 12 дугаар сарын 21-нд Арбитрын бүрэлдэхүүн талуудад захидал хүргүүлж, хойшлогдсон хуралдааны шинэ товыг 2015 оны 6 дугаар сарын 8–13-ны өдрүүдэд тогтоох санал гаргасан. 2015 оны 1 дүгээр сарын 26-нд Нэхэмжлэгчид Арбитрын бүрэлдэхүүнд захидал хүргүүлж, санал болгосон шинэ тов бусад хуваарьтай давхцаж байгааг мэдэгдэн, 2015 оны 7, 8 эсхүл 9 дүгээр сард хуралдаан хийх боломжтой эсэхийг лавласан.

71. 2015 оны 2 дугаар сарын 4-нд Арбитрын бүрэлдэхүүн талуудад захидал хүргүүлж, 2015 оны 6 дугаар сарын 8–13 эсхүл 9 дүгээр сарын 14–19-ний өдрүүдэд хуралдаан хийх боломжтойгоо мэдэгдсэн. 2015 оны 2 дугаар сарын 9, 23-нд талууд өөрсдийн сонгосон товын талаар Арбитрын бүрэлдэхүүнд захидал хүргүүлсэн.

72. 2015 оны 2 дугаар сарын 25-нд Арбитрын бүрэлдэхүүн талуудад захидал хүргүүлж, хуралдааныг 2015 оны 9 дүгээр сарын 14–19-ний өдрүүдэд хийхээр товлосон.

73. 2015 оны 6 дугаар сарын 17-нд Арбитрын бүрэлдэхүүн талуудад захидал хүргүүлж, Л. Туяаг гэрчээр дуудах хүсэлтээ хэвээр хадгалж байгаа эсэхээ баталгаажуулахыг Хариуцагчаас хүссэн (дээрх 41 дэх хэсгийг үзнэ үү).

74. 2015 оны 7 дугаар сарын 1-нд Хариуцагч Арбитрын бүрэлдэхүүнд захидал хүргүүлж, Л. Туяаг гэрчээр дуудах хүсэлтээ буцаан авсан.

75. 2015 оны 7 дугаар сарын 27-нд Арбитрын бүрэлдэхүүн хуралдааны зохион байгуулалт болон 2014 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн хуралдааны өмнөх утсан хэлэлцүүлгээр талуудтай ярилцсан ажиллагааны зарим асуудлын талаар Ажиллагааны тухай 9 дүгээр захирамж гаргасан.

76. 2015 оны 8 дугаар сарын 31-нд талууд Ажиллагааны тухай 9 дүгээр захирамжид төлөвлөсний дагуу нэмэлт баримтуудаа нэгэн зэрэг ирүүлсэн.

77. 2015 оны 9 дүгээр сарын 14–18-нд Арбитрын бүрэлдэхүүн Нидерланд Улсын Гааг хот дахь Энх тайвны ордонд хуралдаан хийсэн. Арбитрын бүрэлдэхүүний гишүүдээс гадна дараах хүмүүс хуралдаанд оролцсон:

Нэхэмжлэгчдийн өмнөөс	**Хариуцагчийн өмнөөс**
Ван Юаньхэн Нэхэмжлэгчийн төлөөлөгч	Чойжанцан Нарантуяа Зоригт Э. Монгол Улсын Засгийн газар
Петер Тернер QC Жон Чун Жонатан Вонг Стефани Мбону Freshfields Bruckhaus Deringer LLP	Элчин сайд Даваадорж (9 дүгээр сарын 15–18) Бенилюксийн орнууд болон Европын Холбоонд суугаа Монгол Улсын Элчин сайд

Белинда МакРэй 20 Essex Street Chambers	Оргодол (“Оргоо”) Санжаасүрэн Цэрэнбадам Ажлын хэсгийн гишүүд
Батзаяа Мэдүүлэг өгөөгүй эрх зүйн шинжээч	Майкл Нолан Камел Айтелаж Элица Попова-Талти Жулианн Жакуит Milbank, Tweed, Hadley & McCloy LLP
Дуламын Баярмаа	Ганзориг Мэдүүлэг өгөөгүй эрх зүйн шинжээч

Үйл баримтын гэрчүүд

Луузанданбын Баярцогт
Ли Шаоминг
С. Ганжууржав
Б. Шагдар (дүрст холбоогоор)
Ч. Хурц
Б. Нэргүй

Шинжээч гэрчүүд

Нацагдорж Тайван
Цэвэгжав Дарижав

Нарийн бичгийн даргын газар

Гарт Скофилд
Арбитрын Байнгын шүүх

Хуралдааны тэмдэглэл хөтлөгчид

Диана Бёрден
Лори Хендрикс

Монгол/англи хэлний хэлмэрчид

Баярмаа Алтаннавч Мюррей
Унурмаа Жанчив
Машбилэг Майдраг

Хятад/англи хэлний хэлмэрчид

Лори Чен
Жейн Пин Франсис

78. 2015 оны 9 дүгээр сарын 17-нд хуралдааны үеэр Арбитрын бүрэлдэхүүн талуудад бичгээр асуулт тавьсан. Үүнд, Нэхэмжлэгчид нэхэмжлэлийн үндэслэлдээ Хэлэлцээрийн 4 дүгээр зүйлийн 1 дэх хэсгээс бусад заалтын дагуу шаардлагаа үргэлжлүүлэхгүй гэж шийдвэрлэснийг харгалзан, “арбитрын хүсэлтийн 75 дахь хэсэгт хийсэн мэдэгдэл нь хэвээр байгаа эсэх, мөн хоёр талт хөрөнгө оруулалтын хэлэлцээрийн 3 дугаар зүйлийн 2 дахь хэсэг болон 9 дүгээр зүйлд заасан нэн тааламжтай үндэстний нөхцөлийг үргэлжлүүлэн үндэслэж байгаа эсэхээ тодруулах”-ыг Нэхэмжлэгчдээс хүссэн. Нэхэмжлэгчдийн

өмгөөлөгч хаалтын тайлбартаа: “Бид харьяаллын талаарх үндэслэлээ гаргахдаа Хэлэлцээрийн уг заалтыг огт үндэслэхгүй” гэж баталсан.[3]

79. 2015 оны 12 дугаар сарын 7-нд Нэхэмжлэгчид Арбитрын бүрэлдэхүүнд захидал хүргүүлж, тэдний гэрч ноён Баярцогтыг Монгол Улсын Авлигатай тэмцэх газарт дуудаж байцаасныг мэдэгдсэн. Уг уулзалтын үеэр ноён Баярцогтод “түүний эсрэг эрүүгийн хэргийн мөрдөн шалгах харьяаллыг Авлигатай тэмцэх газрын Мөрдөн шалгах хэлтэст “дахин шилжүүлэх” агуулгатай прокурорын тогтоол танилцуулсан” гэж мэдүүлсэн. Нэхэмжлэгчид үүнийг зохисгүй гэж үзэж байгаагаа тэмдэглэн, ноён Баярцогтын эсрэг аливаа “үндэслэлгүй арга хэмжээ” авахыг Хариуцагчид хориглосон захирамж гаргахыг Арбитрын бүрэлдэхүүнээс хүссэн. Маргааш нь Арбитрын бүрэлдэхүүн талуудад захидал хүргүүлж, Нэхэмжлэгчдийн хүсэлтийн талаар Хариуцагчийн тайлбарыг хүссэн.

80. 2015 оны 12 дугаар сарын 19-нд тал тус бүр тухайн өдрийг хүртэл ажиллагаанд гаргасан зардлынхаа талаар тайлбар гаргасан.

81. 2015 оны 12 дугаар сарын 21-нд Хариуцагч Нэхэмжлэгчдийн 2015 оны 12 дугаар сарын 7-ны өдрийн захидалд хариу өгөх нэмэлт хугацаа хүсэж, Арбитрын бүрэлдэхүүнд захидал хүргүүлсэн.

82. 2015 оны 12 дугаар сарын 22-нд Нэхэмжлэгчид зардлын талаарх тайлбарынхаа засварласан хувилбарыг ирүүлсэн.

83. 2016 оны 1 дүгээр сарын 8-нд Хариуцагч Нэхэмжлэгчдийн 12 дугаар сарын 7-ны өдрийн захидалд хариу өгч, “дотоодын эрүүгийн ажиллагаа нь Монгол Улсын бүрэн эрхт улсын хууль сахиулах бүрэн эрхээ зохих ёсоор хэрэгжүүлж буй явдал бөгөөд ноён Баярцогтын арбитрын ажиллагаанд оролцож байгаагаас тусдаа, түүнтэй холбоогүй” гэсэн үндэслэлээр хүсэлтийг эсэргүүцсэн.

84. 2016 оны 1 дүгээр сарын 29, 2 дугаар сарын 19-нд талууд Нэхэмжлэгчдийн 2015 оны 12 дугаар сарын 7-ны өдрийн хүсэлтийн талаар нэмэлт тайлбар гаргасан.

85. 2016 оны 5 дугаар сарын 3-нд Арбитрын бүрэлдэхүүн Нэхэмжлэгчдийн 12 дугаар сарын 7-ны өдрийн захидалтай холбогдуулан Ажиллагааны тухай 10 дугаар захирамж гаргаж, дараах байдлаар шийдвэрлэсэн:

    a. Одоогоор Арбитрын бүрэлдэхүүнд танилцуулсан нөхцөл байдал нь түр хамгаалах арга хэмжээ санал болгох бүрэн эрхээ хэрэгжүүлэх, эсхүл ажиллагааг явуулахад шаардлагатай аливаа захирамж гаргахыг шаардах хэмжээнд хүрээгүй байна;

    b. Түр хамгаалах арга хэмжээ авах хүсэлттэй холбоотой гарсан зардлыг тал тус бүр өөрөө хариуцна.

86. 2016 оны 10 дугаар сарын 11-нд Нэхэмжлэгчид Арбитрын бүрэлдэхүүнд захидал хүргүүлж, Sanum Investments Limited болон Бүгд Найрамдах Ардчилсан Лаос Ард Улсын Засгийн газрын хоорондох хэрэгт Сингапурын Давж заалдах шатны шүүхээс саяхан гаргасан шийдвэрийн хуулбарыг ирүүлсэн.

[3] Сонсголын тэмдэглэл (өдөр 5, 2015 оны 9 дугаар сарын 18), 763:8–764:7.

87. 2016 оны 10 дугаар сарын 13-нд Хариуцагч Арбитрын бүрэлдэхүүнд захидал хүргүүлж, Sanum-ийн хэргийн шийдвэрийг хэрэгт оруулахыг эсэргүүцэхгүй гэдгээ мэдэгдээд, уг шийдвэр энэхүү ажиллагаанд хэрхэн хамаарах талаар тайлбарласан.

88. 2016 оны 10 дугаар сарын 19-нд Арбитрын бүрэлдэхүүн талуудад захидал хүргүүлж, Сингапурын Давж заалдах шатны шүүхийн шийдвэрийг тэмдэглэн авч, хэргийн материалд хүлээн авсан.[4]

III. ХЭРГИЙН БАРИМТАТ НӨХЦӨЛ БАЙДАЛ

А. КОМПАНИУД

89. “Дарханы төмөрлөгийн үйлдвэр” (“Дархан”) нь Засгийн газрын 160 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор 1990 оны 4 дүгээр сарын 15-нд байгуулагдсан Монголын төрийн өмчит компани юм.[5] Дархан нь 1994 оноос Дархан хотын ойролцоо төмөрлөгийн үйлдвэр ажиллуулж ирсэн.

90. БЛТ ХХК (“БЛТ”) нь 1996 оны 4 дүгээр сарын 23-нд Монгол Улсад байгуулагдсан хязгаарлагдмал хариуцлагатай компани юм.[6] БЛТ анх БНХАУ-аас эм, хүнсний бүтээгдэхүүн импортолж байсан боловч 1996 оны 8 дугаар сард улсын бүртгэлийн гэрчилгээндээ өөрчлөлт оруулж, үйл ажиллагааны чиглэлдээ геологийн ажлыг нэмсэн.[7] БЛТ эхлээд Төмөртэйн ордод хамаарах Т-30 гэрчилгээг, дараа нь 1998 оны 1 дүгээр сарын 28-нд энэхүү ажиллагааны маргааны зүйл болсон 939А тусгай зөвшөөрлийг авсан.[8] БЛТ 2005 оны 2 дугаар сарын 17-нд 939А тусгай зөвшөөрлийг Төмөртэй Хүдэрт шилжүүлсэн.[9]

91. Төмөртэй Хүдэр нь 2002 оны 6 дугаар сарын 19-нд БЛТ, Циньлун хоёрын хамтарсан үйлдвэр хэлбэрээр байгуулагдсан Монголын компани юм.[10] Доор дэлгэрэнгүй дурдсанчлан (142–144 дэх хэсгийг үзнэ үү), анх Циньлун Төмөртэй Хүдэрийн хувьцааны 70 хувийг (үлдэх 30 хувийг БЛТ) эзэмшиж байсан бөгөөд 2004 оны 1 дүгээр сард буюу тэр орчимд Төмөртэй Хүдэрт эзэмшиж байсан хувьцааныхаа зарим хэсгийг Чайна Хэйлунзян, Бээжин Шоуган нарт шилжүүлсэн.

---

[4] Sanum Investments Limited v. The Government of the Lao People’s Democratic Republic, [2016] SGCA 57 (гэж тэмдэглэсэн: Эрх зүйн эх сурвалж CLA-153).

[5] Дарханы улсын бүртгэлийн 18/191663 дугаар гэрчилгээ, 1990 оны 4 дугаар сарын 15 (Баримт С-25).

[6] БЛТ-ийн улсын бүртгэлийн 25/5308 дугаар гэрчилгээ, 1996 оны 4 дугаар сарын 25 (Баримт С-33).

[7] Ноён Баярцогтын гэрчийн мэдүүлэг, догол мөрүүд 19-21; БЛТ-ийн улсын бүртгэлийн 25/5308 дугаар гэрчилгээ, 1996 оны 4 дугаар сарын 25 (Баримт С-33).

[8] Ашигт малтмал ашиглах 939А дугаар тусгай зөвшөөрлийн гэрчилгээ, 1998 оны 1 дугаар сарын 28 (Баримт С-1).

[9] БЛТ болон Төмөртэй Хүдэрийн хооронд байгуулсан хамтран ажиллах гэрээ, 2005 оны 2 дугаар сарын 17 (Баримт С-58); Геологи, уул уурхайн кадастрын газрын даргад БЛТ-ээс гаргасан тусгай зөвшөөрөл шилжүүлэх хүсэлт, 2005 оны 2 дугаар сарын 17 (Баримт С-59).

[10] Хамтарсан үйлдвэрийн гэрээ, 2002 оны 6 дугаар сар (Баримт С-18).

92. Циньлун нь БНХАУ-д үүсгэн байгуулагдсан, ган болон төмрийн хүдрийн салбарт үйл ажиллагаа явуулдаг хязгаарлагдмал хариуцлагатай компани бөгөөд гол хувьцаа эзэмшигч нь ноён Ли Шаоминг юм.[11] Циньлун 1997 оны 12 дугаар сарын 2-нд байгуулагдсан.[12] Төмөртэй Хүдэрийг 2002 оны 6 дугаар сарын 19-нд байгуулахад Циньлун тус компанийн хувьцааны 70 хувийг эзэмшсэн.[13] Дараа нь 2004 оны 1 дүгээр сард буюу тэр орчимд Төмөртэй Хүдэрийн хувьцааны 41 хувийг Чайна Хэйлунзян, Бээжин Шоуган нарт шилжүүлсэн гэж Циньлун мэдүүлдэг.

93. Чайна Хэйлунзян нь Хятад Улсад болон гадаадад инженерийн ажил гүйцэтгэх, гадаад дахь бүтээн байгуулалтын төслүүдэд зориулсан тоног төхөөрөмж, материал экспортлох үйл ажиллагаа эрхэлдэг БНХАУ-ын төрийн өмчит аж ахуйн нэгж юм. Чайна Хэйлунзян 1981 оны 8 дугаар сарын 3-нд байгуулагдсан бөгөөд 1991 оны 6 дугаар сарын 6-нд бүтцийн өөрчлөлт хийж, дахин бүртгүүлсэн.[14] Нэхэмжлэгчдийн мэдүүлснээр, Чайна Хэйлунзян 2004 оны 1 дүгээр сард буюу тэр орчимд Циньлунаас Төмөртэй Хүдэрийн хувьцааны 11 хувийг авсан.[15]

94. Бээжин Шоуган нь БНХАУ-д үүсгэн байгуулагдсан, хөрөнгө оруулалт эзэмших үйл ажиллагаа эрхэлдэг хязгаарлагдмал хариуцлагатай компани юм. Бээжин Шоуган 2003 оны 12 дугаар сарын 1-нд байгуулагдсан[16] бөгөөд БНХАУ-ын Төрийн зөвлөлийн шууд хяналтад байдаг, 130 тэрбум юаниас давсан орлоготой төрийн өмчит аж ахуйн нэгж болох Shougang Corporation-ийн 100 хувийн охин компани юм.[17] Бээжин Шоуган 2004 оны 1 дүгээр сарын 8-нд Циньлунаас Төмөртэй Хүдэрийн хувьцааны 30 хувийг авсан.[18]

В. ХОЛБОГДОХ ХҮМҮҮС

95. Нэхэмжлэгчид талуудын маргааныг үүсгэсэн үйл явдлын талаар мэдэх дараах хүмүүсийн мэдүүлгийг ирүүлсэн:

> (а) Ноён Луузандамбын Баярцогт (“ноён Баярцогт”) Төмөртэй Хүдэрийг 2002 онд байгуулагдсан цагаас нь хойш өнөөг хүртэл гүйцэтгэх захирлаар нь ажиллаж байна.

---

[11] Нэхэмжлэгчдийн Нэхэмжлэлийн үндэслэл, догол мөр 17-18; Циньлунийн бизнесийн үйл ажиллагааны гэрчилгээ, 1997 оны 12 дугаар сарын 2 (Баримт С-16).

[12] Циньлунийн бизнесийн үйл ажиллагааны гэрчилгээ, 1997 оны 12 дугаар сарын 2 (Баримт С-16).

[13] Төмөртэй Хүдэрийг байгуулах тухай БЛТ, Циньлунийн хамтарсан үйлдвэрийн гэрээ, 2002 оны 6 дугаар сарын 19 (Баримт С-18).

[14] Чайна Хэйлунзяны бизнесийн үйл ажиллагааны гэрчилгээ, 2005 оны 8 дугаар сарын 25 (Баримт С-11).

[15] Нэхэмжлэгчдийн Нэхэмжлэлийн үндэслэл, догол мөр 149.

[16] Бээжин Шоуганы бизнесийн үйл ажиллагааны гэрчилгээ (Баримт С-12).

[17] Нэхэмжлэгчдийн Нэхэмжлэлийн үндэслэл, догол мөрүүд 14-15; Бээжин Шоуганы 2010 оны завсрын тайлан (Баримт С-13).

[18] Циньлун болон Бээжин Шоуганы хооронд байгуулсан хувьцаа шилжүүлэх гэрээ, 2004 оны 1 дугаар сарын 8 (Баримт С-56).

Ноён Баярцогт 2005 оноос БЛТ-ийн гүйцэтгэх захирлаар мөн ажиллаж байна.[19] Өмнө нь ноён Баярцогт 1994 оны 4 дүгээр сараас 1996 оны 7 дугаар сарын орчим хүртэл Улаанбаатар дахь Дарханы төлөөлөгчөөр ажиллаж байсан.[20] Тэрээр 1988 оны 9 дүгээр сараас 1992 он хүртэл Бээжин дэх Монгол Улсын Элчин сайдын яамны худалдааны атташе байсан. Энэ хугацаанд тэрээр "Хятадын хэд хэдэн компани, бизнес эрхлэгчтэй харилцаа тогтоосон".[21]

(b) Ноён Ли Шаоминг ("ноён Ли") нь Төмөртэй Хүдэрийн ТУЗ-ийн дарга бөгөөд Циньлуны олонхийн хувьцаа эзэмшигч юм.[22] Ноён Ли өмнө нь 1991–1996 онд Чайна Хэйлунзяны Бараа худалдааны хэлтсийн орлогч даргаар ажиллаж байсан[23] бөгөөд дараа нь БЛТ, Чайна Хэйлунзян хоёрын хэлэлцээнд албан бус зуучлагч, холбогчийн үүрэг гүйцэтгэсэн.

96. Хариуцагч талуудын маргааныг үүсгэсэн үйл явдлын талаар мэдэх дараах хүмүүсийн мэдүүлгийг ирүүлсэн:

(a) Ноён С. Ганжууржав ("ноён Ганжууржав") 1990–1995 онд Дарханы ерөнхий захирал, 2001–2004 онд орлогч захирлаар ажиллаж байсан. Ноён Ганжууржав 2006–2009 онд Дарханы захирлын зөвлөхөөр ажилласан.[24]

(b) Ноён Ч. Хурц ("ноён Хурц") нь 1992–1996 онд Монгол Улсын Их Хурлын гишүүн, Байгаль орчин, хөдөө аж ахуйн байнгын хорооны дарга, мөн 1994 оны Ашигт малтмалын тухай хуулийн төслийг боловсруулсан ажлын хэсгийн ахлагчаар ажиллаж байсан.[25]

(c) Ноён Б. Нэргүй ("ноён Нэргүй") 2012 оны 10 дугаар сараас Монгол Улсын Уул уурхайн яаманд газрын даргаар ажиллаж байна. Ноён Нэргүй өмнө нь Үйлдвэр, худалдааны яаманд ахлах мэргэжилтэн, дэд дарга, Эрдэс баялаг, эрчим хүчний яаманд дэд дарга, Үндэсний хөгжил, шинэтгэлийн хороо болон Эдийн засгийн хөгжлийн яаманд ахлах мэргэжилтнээр ажиллаж байсан. Ноён Нэргүй 2006 онд Үйлдвэр, худалдааны яамны Геологи, уул уурхайн кадастрын хэлтсийн ахлах мэргэжилтэн байсан бөгөөд энэ албан тушаалын хүрээнд Төмөртэйн ордод хамаарах БЛТ-ийн тусгай зөвшөөрлийг шалгаж, хянах ажлын хэсэгт оролцсон.

(d) Ноён Батсуурийн Шагдар ("ноён Шагдар") 1995 оноос 1996 оны 9 дүгээр сар хүртэл,[26] ноён Ганжууржав, ноён Нацагдорж нарын захирлаар ажилласан хугацааны завсарт Дарханы захирлаар ажиллаж байсан.

97. Энэхүү ажиллагаанд гэрчээр мэдүүлэг өгсөн хүмүүсээс гадна дараах хүмүүс талуудын маргааныг үүсгэсэн үйл явдалд оролцсон:

---

[19] Ноён Баярцогтын гэрчийн мэдүүлэг, догол мөр 1.

[20] Ноён Баярцогтын гэрчийн мэдүүлэг, догол мөрүүд 11-16.

[21] Ноён Баярцогтын гэрчийн мэдүүлэг, догол мөрүүд 6-7.

[22] Ноён Лигийн гэрчийн мэдүүлэг, догол мөр 1

[23] Ноён Лигийн гэрчийн мэдүүлэг, догол мөрүүд 3-7.

[24] Ноён Ганжууржавын гэрчийн мэдүүлэг, догол мөр 1.

[25] Ноён Хурцын гэрчийн мэдүүлэг, догол мөр 1.

[26] Төрийн өмчийн хорооны 2 дугаар тогтоол, огноо: 1996 оны 9 дугаар сарын 14 (Баримт R-51).

(a) Хатагтай Л. Туяа (“хатагтай Туяа”) нь ноён Баярцогтын эхнэр бөгөөд БЛТ-ийг үүсгэн байгуулагч юм.

(b) Ноён Лувсандашийн Нацагдорж (“ноён Нацагдорж”) 1996 оны 9 дүгээр сараас[27] 2001 он хүртэл[28] Дарханы гүйцэтгэх захирлаар ажилласан. Ноён Нацагдорж нь хатагтай Туяагийн ах, дүү бөгөөд ноён Баярцогттой хүргэн ах, дүүгийн холбоотой юм.[29]

(c) Ноён Хүдэрбат нь геологич бөгөөд 1996 он хүртэл Дарханы ажилтан байсан.[30] Тэрээр 1990–1992 онд геологийн судалгаа хийсэн.[31] БЛТ ноён Хүдэрбатыг ажилд авч, тэрээр 1996, 1997 онд БЛТ-ийн Төмөртэйн ордын судалгаа болон тусгай зөвшөөрөл авах өргөдөл гаргах ажилд оролцсон.[32]

С. ТӨМӨРТЭЙН ОРД

98. “Монгол Улс төмрийн хүдрийн асар их нөөцтэй”.[33] Уг нөөцийн “Төмөртэйн орд” хэмээн нэрлэгддэг хэсэгт хамаарах эрхүүд энэхүү маргааны гол асуудал юм.

99. БЛТ ашиглалтын тусгай зөвшөөрөл авах өргөдлөө дэмжих зорилгоор 1997 онд Монгол Улсын Засгийн газарт ирүүлсэн техник, эдийн засгийн үндэслэлд (“Техник, эдийн засгийн үндэслэл”) Төмөртэйн ордыг дараах байдлаар тодорхойлсон:

> Төмөртэйн төмрийн орд нь Сэлэнгэ аймгийн нутагт, Дулаанхааны төмөр замын өртөөнөөс 95 км, аж үйлдвэрийн томоохон төв (төмөрлөгийн үйлдвэртэй) Дархан хотоос 130 км, 35 кВ-ын Хүдэр–Бугантын өндөр хүчдэлийн цахилгаан дамжуулах шугамаас баруун хойш 8–10 км зайд, эдийн засаг, дэд бүтцийн хувьд тааламжтай байршилд оршино. Ордын орчмын газрын гадарга бага зэрэг уулархаг. Хамгийн өндөр цэг нь далайн түвшнээс дээш 1100–1250 м-т байрлах бөгөөд нутгийн ихэнх хэсэг ой модоор бүрхэгдсэн. Төмөртэйн төмрийн ордын хүдэр агуулсан биетүүд нь үндсэндээ бие даасан “Зүүн” болон “Баруун” гэсэн хоёр хэсэгт хуваагдана. Эдгээр хүдрийн биет хоорондоо 2.0–2.5 км зайтай байрлана.[34]

100. Монгол Улсын хойд хэсэгт, Оросын хилийн ойролцоо байрлах Төмөртэйн ордын байршлыг Нэхэмжлэгчдийн нэхэмжлэлийн үндэслэлийн II хавсралтад оруулсан дараах газрын зургаас харж болно:

---

[27] Ноён Баярцогтын гэрчийн мэдүүлэг, 17; Төрийн өмчийн хорооны 2 дугаар тогтоол, 1996 оны 9 дугаар сарын 14 (Баримт R-51).

[28] Хариуцагчийн Хариу үндэслэл, догол мөр 82.

[29] Ноён Баярцогтын гэрчийн мэдүүлэг, догол мөр 17.

[30] Хариуцагчийн Хариу үндэслэл, догол мөр 37.

[31] Ноён Баярцогтын гэрчийн мэдүүлэг, догол мөр 28.

[32] Ноён Баярцогтын гэрчийн мэдүүлэг, догол мөрүүд 24-28, 45.

[33] Нэхэмжлэгчдийн Арбитрын хүсэлт, догол мөр 7.

[34] Техник, эдийн засгийн үндэслэл (Баримт C-17), хуудас 23.



(Source: Haranga Resources. December 2010 Quarterly Activities Report. 31 January 2011 (available at <http://www.haranga.com/pdfs/QuarterlyActivitiesReportDec10Quarter31Jan11.pdf>)

Хот; одоо байгаа төмөр замын сүлжээ; 2010/2011 оны төмөр замын бүтээн байгуулалт; 2011 оны төмөр замын бүтээн байгуулалт; 2015 оны төмөр замын бүтээн байгуулалт; төмрийн хүдрийн уурхай; төмрийн хүдрийн орд; зэсийн буюу зэс-алтны уурхай; нүүрсний бүтээн байгуулалт.

(Эх сурвалж: Haranga Resources, 2010 оны 12 дугаар сарын улирлын үйл ажиллагааны тайлан, 2011 оны 1 дүгээр сарын 31; http://www.haranga.com/pdfs/QuarterlyActivitiesReportDec10Quarter31Jan11.pdf хаягаар авах боломжтой.)

> (Эх сурвалж: Haranga Resources, 2010 оны 12 дугаар сараар дууссан улирлын үйл ажиллагааны тайлан, 2011 оны 1 дүгээр сарын 31; <http://www.haranga.com/pdfs/QuarterlyActivitiesReportDec10Quarter31Jan11.pdf> хаягаар үзэх боломжтой.)

101. Техник, эдийн засгийн үндэслэлд орон нутгийн дэд бүтэц нь Төмөртэйн төмрийн ордыг Монгол Улсын чухал хот суурингуудтай стратегийн хувьд холбож байгааг тайлбарласан:

> Төмөртэйн төмрийн орд нь Дархан хотоор дайрсан төмөр зам, авто замаар Улаанбаатар хоттой холбогдоно. Хоорондоо 230 км зайтай Дархан, Улаанбаатар хотууд төмөр зам болон авто замаар холбогддог. Ордоос хамгийн ойр төмөр замын өртөө нь 100 км зайд байрлах Дулаанхааны өртөө юм. Аж үйлдвэрийн хот болох Дархан хүртэл 130 км. Улаанбаатараас Сүхбаатар хүрэх авто зам ордоос 80–85 км зайд өнгөрдөг.[35]

[35] Техник, эдийн засгийн үндэслэл, хуудас 10 (Баримт С-17).

102. Төмөртэйн орд нь Монгол Улсын хамгийн том төмрийн хүдрийн ордуудын нэг юм.[36]

D. БАЙГАЛИЙН БАЯЛГАА АШИГЛАХ ТАЛААР МОНГОЛ УЛСЫН ӨМНӨ ХИЙСЭН ОРОЛДЛОГУУД

103. 1924 онд өнөөгийн Монгол Улс өөрийгөө Бүгд Найрамдах Монгол Ард Улс хэмээн тунхагласан. Дараагийн хэдэн арван жилд Зөвлөлт Холбоот Улстай улс төр, эдийн засгийн нягт холбоотой байж,[37] үнэн хэрэгтээ "Зөвлөлт Холбоот Улсын дагуул улс" байдлаар оршиж байв.[38]

104. Тухайн үед Монголын төмрийн хүдрийн үйлдвэрлэл харьцангуй хөгжөөгүй байв.[39] Техник, эдийн засгийн үндэслэлд тэмдэглэснээр, Зөвлөлт Холбоот Улс "Монголын төмрийн хэрэгцээг хангана гэж мэдэгдсэн. Үүний үр дүнд Монгол Улсад хүдэр олборлох, боловсруулах үйлдвэр хөгжөөгүй".[40]

105. Гэсэн хэдий ч Зөвлөлтийн үеийн хугацаанд Монголын Засгийн газар Төмөртэйн төмрийн хүдрийн ордыг судлахад хүчин чармайлт гаргасан.[41] Нэхэмжлэгчид Төмөртэйн ордыг "1940-өөд оноос судалж ирсэн" гэж тэмдэглэсэн.[42] Техник, эдийн засгийн үндэслэлд Монголын Засгийн газраас 1970-аад онд Төмөртэйн ордод хийсэн урьдчилсан хайгуулыг тайлбарласан.[43] 1980-аад оны эхээр хийсэн төрийн судалгаагаар ордыг ашиглах нь эдийн засгийн үр ашигтай болохыг баталсан.[44]

106. 1991 онд Зөвлөлт Холбоот Улс задарсны дараа Монгол Улсад ардчилсан хувьсгал өрнөж, зах зээлийн эдийн засагт шилжсэн.[45] Энэхүү шилжилт Монгол Улсын ДНБ болон өөрийн

---

[36] Техник, эдийн засгийн үндэслэл, хуудас 20 (Баримт C-17).

[37] АНУ-ын Төрийн департамент, «Монгол Улс: ерөнхий мэдээлэл», хуудсууд 4-5 (Баримт R-1).

[38] Нэхэмжлэгчдийн Нэхэмжлэлийн үндэслэл, догол мөр 105; Хариуцагчийн Хариу үндэслэл, догол мөр 8; АНУ-ын Төрийн департамент, «Монгол Улс: ерөнхий мэдээлэл» (Баримт R-1); Техник, эдийн засгийн үндэслэл, хуудас 7 (Баримт C-17); Ричард Помфрет, «Монгол дахь шилжилт ба ардчилал» 52 EUROPE-ASIA STUD. 149, хуудас 2 (Баримт R-2).

[39] Дарханы төмөрлөгийн үйлдвэрээс Үйлдвэр, худалдааны яаманд хүргүүлсэн албан бичиг, 2006 оны 9 дугаар сарын 21 (Баримт R-18); Ноён Ганжууржавын гэрчийн мэдүүлэг, 2011 оны 8 дугаар сарын 25, догол мөр 4; Техник, эдийн засгийн үндэслэл (Баримт C-17), хуудас 7; Нэхэмжлэгчдийн Нэхэмжлэлийн үндэслэл, догол мөр 105; Хариуцагчийн Хариу үндэслэл, догол мөр 8.

[40] Техник, эдийн засгийн үндэслэл (Баримт C-17), хуудас 7.

[41] Дарханы төмөрлөгийн үйлдвэрээс Үйлдвэр, худалдааны яаманд хүргүүлсэн албан бичиг, 2006 оны 9 дугаар сарын 21 (Баримт R-18); Техник, эдийн засгийн үндэслэл (Баримт C-17), хуудас 7; Нэхэмжлэгчдийн Нэхэмжлэлийн үндэслэл, догол мөрүүд 105 болон 127; Хариуцагчийн Хариу үндэслэл, догол мөр 25.

[42] 2005–2006 оны ажлын төлөвлөгөө (Баримт C-23), хуудас 1.

[43] Техник, эдийн засгийн үндэслэл (Баримт C-17), хуудас 7.

[44] Техник, эдийн засгийн үндэслэл (Баримт C-17), хуудас 7; Ноён Ганжууржавын гэрчийн мэдүүлэг, 2011 оны 8 дугаар сарын 25, догол мөр 5.

[45] АНУ-ын Төрийн департамент, «Монгол Улс: ерөнхий мэдээлэл» (Баримт R-1); Оле Бруун, Оле Одегаард, «Шилжилтийн үеийн Монгол», 1996 (Баримт R-5); Эдди Ли, «Бага орлоготой,

хөгжлийг санхүүжүүлэх чадавхад сөргөөр нөлөөлсөн.[46] Гэсэн хэдий ч Монголын Засгийн газар бүр 1990 онд хар төмөрлөгийн үйлдвэр болон төмрийн хүдрийн ил уурхай байгуулахыг төлөвлөж байв.[47]

Е. МОНГОЛ УЛСЫН УУЛ УУРХАЙН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

107. 1988 онд, Зөвлөлтийн үеийн төгсгөл орчимд Монголын Засгийн газар Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Газрын хэвлийн тухай хуулийг баталж, уг хууль 1989 оны 7 дугаар сарын 1-нд хүчин төгөлдөр болсон ("Газрын хэвлийн тухай хууль").[48] Газрын хэвлийн тухай хуульд газрын хэвлий төрийн өмч болохыг,[49] газрын хэвлийг ашигт малтмал олборлоход ашиглаж болохыг,[50] үүнд хууль тогтоомжид заасан тохиолдолд төрийн бус аж ахуйн нэгж мөн ашиглаж болохыг заасан.[51] Газрын хэвлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлд уурхайн эдэлбэрийн асуудлыг дараах байдлаар зохицуулсан:

Ашигт малтмалын орд ашиглахад зориулан уурхайн эдэлбэр олгох

> Түгээмэл тархацтайгаас бусад ашигт малтмалын ордыг ашиглах зориулалттай уурхайн эдэлбэрийг уул уурхайн улсын хяналтын байгууллага олгоно. Түгээмэл тархацтай ашигт малтмалын ордыг ашиглах зориулалттай уурхайн эдэлбэрийг тухайн аймаг, хотын Ардын депутатуудын хурлын гүйцэтгэх захиргаа олгож, уул уурхайн улсын хяналтын байгууллагад бүртгүүлнэ. Түгээмэл тархацтай ашигт малтмалын орд хоёр буюу түүнээс олон аймаг, хотын нутаг дэвсгэрийг хамарч байвал уурхайн эдэлбэр олгох асуудлыг холбогдох аймаг, хотын Ардын депутатуудын хурлын гүйцэтгэх захиргаа хамтран шийдвэрлэнэ. Орд ашиглахад зориулан олгосон уурхайн эдэлбэрийн хилийг өөрчлөхөд уурхайн эдэлбэр олгох журмыг баримтална. Ашиглалтын зориулалтаар уурхайн эдэлбэр олгох журмыг Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Сайд нарын Зөвлөл тогтооно. Уурхайн эдэлбэрийн хилийн гадна ашигт малтмалын ордыг ашиглахыг хориглоно.

хоёрдмол бүтэцтэй эдийн засагт шилжилтийг эхлүүлэх нь: Монголын жишээ» 132 INT'L LAB. REV. 623 (1993) (Баримт R-6); Жеффри Сакс, «Монголд эрчимтэй өсөлтийг хангах эдийн засгийн стратегийн зүг», Харвардын Олон улсын хөгжлийн хүрээлэн, 1997 оны 9 дугаар сар (Баримт R-7); Хариуцагчийн Хариу үндэслэл, догол мөр 13; Нэхэмжлэгчдийн Нэхэмжлэлийн үндэслэл, догол мөр 107.

[46] Оле Бруун, Оле Одегаард, «Шилжилтийн үеийн Монгол», 1996 (Баримт R-5); Эдди Ли, «Бага орлоготой, хоёрдмол бүтэцтэй эдийн засагт шилжилтийг эхлүүлэх нь: Монголын жишээ» 132 INT'L LAB. REV. 623 (1993) (Баримт R-6); Дэлхийн банк, «Дэлхийн банкны төрийн өмчит аж ахуйн нэгжийн тойм — шинэчлэлийн замын дунд», ENTERPRISE REV., 1996 оны 11 дугаар сарын 4 (Баримт C-28), хуудас 38; Хариуцагчийн Хариу үндэслэл, догол мөрүүд 11-12; Нэхэмжлэгчдийн Нэхэмжлэлийн үндэслэл, догол мөрүүд 129-30.

[47] 1990 оны 160 дугаар тогтоол, 1990 оны 4 дугаар сарын 14 (Англи хэлний албан бус орчуулга) (Эрх зүйн эх сурвалж CLA-4, дахин хүргүүлсэн: Эрх зүйн эх сурвалж CLA-10).

[48] Монгол Улсын 1988 оны Газрын хэвлийн тухай хууль (1988 оны 11 дугаар сарын 29; хүчин төгөлдөр болсон: 1989 оны 7 дугаар сарын 1) (Эрх зүйн эх сурвалж CLA-11).

[49] Газрын хэвлийн тухай хууль, зүйл 3 (Эрх зүйн эх сурвалж CLA-11).

[50] Газрын хэвлийн тухай хууль, зүйл 10 (Эрх зүйн эх сурвалж CLA-11).

[51] Газрын хэвлийн тухай хууль, зүйл 9 (Эрх зүйн эх сурвалж CLA-11).

> Түгээмэл тархацтай ашигт малтмалын ордод уурхайн эдэлбэр олгохыг хотын Ардын депутатуудын хурлын захиргаа шийдвэрлэж, Уул уурхай, ашигт малтмалын байгууллагад бүртгүүлнэ. Түгээмэл тархацтай ашигт малтмалын орд хоёроос олон аймаг, хотын нутаг дэвсгэрт байрлавал уурхайн эдэлбэр олгох асуудлыг холбогдох Ардын депутатуудын хурлын захиргаад хамтран шийдвэрлэнэ. Түгээмэл тархацтай ашигт малтмал ашиглахад олгосон уурхайн эдэлбэрийн хилийг өөрчлөхдөө уурхайн эдэлбэрийн журмыг зохих ёсоор мөрдөнө. Ашигт малтмал ашиглахад уурхайн эдэлбэр олгох журмыг Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Сайд нарын Зөвлөл батална. Уурхайн эдэлбэрийн хилийн гадна ашигт малтмалын ордыг ашиглахыг хориглоно.[52]

108. Талууд тухайн үед ашигт малтмал ашиглах эрхийг зохицуулж байсан журам, ялангуяа Засгийн газрын тогтоолоор ашиглалтын эрх олгож болох эсэх талаар санал зөрөлддөг. Нэхэмжлэгчдийн тайлбарласнаар, Газрын хэвлийн тухай хуульд “түгээмэл тархацтай бус ашигт малтмал, түүний дотор төмрийн хүдэр ашиглах тусгай зөвшөөрлийг зөвхөн уул уурхай, ашигт малтмалын асуудал эрхэлсэн тусгай байгууллага олгох”-оор заасан[53] бөгөөд “Сайд нарын Зөвлөл ... ашиглалтын тусгай зөвшөөрөл олгох эрхгүй байсан”.[54] Харин Хариуцагчийн гэрчийн мэдүүлснээр, “1994 оноос өмнө Ашигт малтмалын тухай хууль байгаагүй тул Монгол Улсын Засгийн газар эдгээр асуудлыг хуулийн адил хүчинтэй тогтоол батлах замаар зохицуулж байсан”.[55]

109. 1990 оны 7 дугаар сард Монгол Улс анхны ардчилсан сонгуулиа явуулж, зах зээлийн эдийн засагт шилжиж эхэлсэн. Энэхүү шилжилтийн хүрээнд Монголын парламент ашигт малтмал, уул уурхай болон гадаадын хөрөнгө оруулалтын асуудлыг багтаасан хэд хэдэн шинэ хууль баталсан.

110. 1993 оны 5 дугаар сарын 10-нд Монгол Улс Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хуулийг баталсан бөгөөд уг хуулиар хуулиар хориглосноос бусад “үйлдвэрлэл, үйлчилгээний бүх салбар”-т, “Монгол Улсын нутаг дэвсгэрийн бүх хэсэг”-т гадаадын хөрөнгө оруулагч хөрөнгө оруулахыг зөвшөөрсөн.[56] Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хууль мөн гадаадын хөрөнгө оруулалтад хандахтай холбоотой тодорхой баталгааг олгосон.

111. 1994 оны 9 дүгээр сарын 30-нд Монгол Улс Ашигт малтмалын тухай хуулийг (“1994 оны Ашигт малтмалын тухай хууль”) баталж, уг хууль “Монгол Улсын нутаг дэвсгэрт ашигт малтмал эрэх, хайх, ашиглах, хайгуулын болон ашиглалтын талбайн байгаль орчныг хамгаалах харилцааг зохицуулах” зорилгоор 1995 оны 1 дүгээр сарын 1-нд хүчин төгөлдөр болсон.[57] Ийнхүү уг хууль нь “Үндсэн хууль, Газрын хэвлийн тухай хууль, энэ хууль болон тэдгээрт нийцсэн холбогдох бусад хууль тогтоомжоос бүрдэх” “ашигт малтмалын

---

[52] Газрын хэвлийн тухай хууль, зүйл 14 (Эрх зүйн эх сурвалж CLA-11).

[53] Нэхэмжлэгчдийн Нэхэмжлэлийн үндэслэл, догол мөр 106.

[54] Нэхэмжлэгчдийн Хариу тайлбар, догол мөр 34.

[55] Ноён Хурцын гэрчийн мэдүүлэг, догол мөр 6.

[56] Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хууль, зүйл 4(1) (Эрх зүйн эх сурвалж CLA-2).

[57] Монгол Улсын 1994 оны Ашигт малтмалын тухай хууль, зүйл 1 (1994 оны 9 дугаар сарын 30; хүчин төгөлдөр болсон: 1995 оны 1 дугаар сарын 1) (Эрх зүйн эх сурвалж CLA-9).

тухай хууль тогтоомж”-ийн нэг хэсэг болсон.[58] 1994 оны Ашигт малтмалын тухай хуулийн 8 дугаар зүйлээр геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад ашиглалтын тусгай зөвшөөрөл олгох эрхийг дараах байдлаар олгосон:

8 дугаар зүйл. Тусгай зөвшөөрөл олгох байгууллага

1. Стратегийн болон тусгай ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийг төрийн захиргааны төв байгууллага олгоно.

2. Холбогдох аймаг, нийслэлийн Засаг дарга нар зөвхөн төрийн захиргааны төв байгууллагын зөвшөөрлөөр түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олгож болно.

3. Ашигт малтмалын орд ашиглах тусгай зөвшөөрлийг дараах байгууллага олгож болно:

1) стратегийн болон тусгай ашигт малтмалын орд ашиглах тусгай зөвшөөрлийг төрийн захиргааны төв байгууллага олгоно;

2) түгээмэл тархацтай ашигт малтмалын орд ашиглах тусгай зөвшөөрлийг аймаг, сум, дүүрэг, нийслэлийн Засаг дарга нар энэ хуулийн 6 дугаар зүйлийн 4, 5 дахь хэсгийн дагуу олгоно.

4. Шаазан, ваар эдлэл, галд тэсвэртэй бүтээгдэхүүн, эрдэс хөвөн үйлдвэрлэхэд эсхүл цемент, төмөрлөг, шилний үйлдвэрийн түүхий эд болгон ашиглах нь хайгуул, судалгаагаар тогтоогдсон түгээмэл тархацтай ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрлийг төрийн захиргааны төв байгууллага олгоно.

5. Газар эзэмшигч нь газрын гадаргуу дээр байгаа, эсхүл уул уурхайн бус аргаар олборлож болох түгээмэл тархацтай ашигт малтмалыг ахуйн болон бусад ашгийн бус зориулалтаар тусгай зөвшөөрөлгүйгээр ашиглаж болно.[59]

112. 1994 оны Ашигт малтмалын тухай хуулийн 28, 46 дугаар зүйлд хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, цуцлах асуудлыг дараах байдлаар зохицуулсан:

28 дугаар зүйл. Хайгуулын ажлыг түдгэлзүүлэх, тусгай зөвшөөрлийг цуцлах

1. Хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч дараах зөрчлийн аль нэгийг гаргасан бол төрийн захиргааны төв байгууллага хайгуулын ажлыг 90 хүртэл хоногоор зогсоож, хайгуулыг цааш үргэлжлүүлэхийг зөвшөөрөхгүй байх шийдвэр гаргаж болно. Гүйцэтгэгч:

1) хайгуулын гэрээгээр хүлээсэн хайгуулын ажлыг санхүүжүүлэх үүргээ биелүүлээгүй;

2) зөвшөөрсөн талбайн гадна хайгуул хийсэн;

3) ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөлгүйгээр олборлолт явуулсан;

4) үйлдвэрлэлийн осол гарах, ажилтнуудын эрүүл мэнд, амь насанд аюул учруулж болзошгүй нөхцөл бүрдүүлсэн;

---

[58] Монгол Улсын 1994 оны Ашигт малтмалын тухай хууль, зүйл 2(1) (1994 оны 9 дугаар сарын 30; хүчин төгөлдөр болсон: 1995 оны 1 дугаар сарын 1) (Эрх зүйн эх сурвалж CLA-9).

[59] 1994 оны Ашигт малтмалын тухай хууль, зүйл 8 (Эрх зүйн эх сурвалж CLA-9).

5) байгаль орчныг нөхөн сэргээх, хамгаалах төлөвлөгөөт арга хэмжээг хэрэгжүүлээгүй эсхүл байгаль орчны хууль тогтоомжийг бусад байдлаар зөрчсөн бол ажлыг зогсоож болно.

2. Тусгай зөвшөөрөл эзэмшигч энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан хугацаанд зөрчлийг арилгаагүй, эсхүл татан буугдсан, дампуурсан буюу хууль зүйн бусад шалтгаанаар хуулийн этгээдийн хувьд оршин тогтнохоо больсон бол тусгай зөвшөөрөл олгосон байгууллага тусгай зөвшөөрлийг хүчингүй болгож болно. Хайгуулын ажлын гэрээнд өөрөөр заагаагүй бол ийнхүү хүчингүй болгосноос учирсан хохирлыг уг байгууллага хариуцахгүй.

3. Хайгуулын ажлыг түдгэлзүүлэх, хайгуулын тусгай зөвшөөрлийг цуцлах нь тусгай зөвшөөрөл эзэмшигчийг хууль буюу гэрээний дагуу үлдсэн үүргээ биелүүлэх, эсхүл өөрийн учруулсан хохирлыг нөхөн төлөх хариуцлагаас чөлөөлөхгүй.

4. Хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч тусгай зөвшөөрлийг цуцалсан шийдвэрийн эсрэг шүүхэд гомдол гаргаж болно.

46 дугаар зүйл. Олборлолтыг түдгэлзүүлэх, ашиглалтын тусгай зөвшөөрлийг цуцлах

1. Хуульд өөрөөр заагаагүй бол тусгай зөвшөөрөл олгосон байгууллага болон эрх бүхий хяналтын байгууллага дараах тохиолдолд зөрчлийг арилгахад шаардлагатай зохистой хугацаагаар ашиглалтын үйл ажиллагааг бүхэлд нь буюу хэсэгчлэн зогсоож болно:

1) энэ хуулийн 28 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4, 5 дахь заалтад дурдсан нөхцөл үүссэн;

2) хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр улсын буюу орон нутгийн байгууллагад төлөх төлбөр, түрээс, татварыг тогтоосон хугацаанд төлөөгүй;

3) төсөл, техник, эдийн засгийн үндэслэл, ашиглалтын эсхүл байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд заасан үндсэн технологиос зөрсөн.

2. Түрээслэгч энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан зөрчлийг тогтоосон хугацаанд арилгаагүй, эсхүл татан буугдсан, дампуурсанд тооцогдсон, хөрөнгийн захиран зарцуулагчийн удирдлагад шилжсэн буюу хуулийн этгээдийн хувьд оршин тогтнохоо больсон бол тусгай зөвшөөрөл олгосон байгууллага өөрийн санаачилгаар буюу түрээслэгчийн хүсэлтээр ашиглалтын тусгай зөвшөөрлийг хүчингүй болгож болно.

3. Хууль ёсоор түдгэлзүүлсэн аливаа хугацаанд түрээслэгч хууль тогтоомж болон түрээсийн гэрээний дагуу төлөх шимтгэл, түрээсийн төлбөр, татварын аливаа үүргээс чөлөөлөгдөхгүй.[60]

113. 1995 оны 3 дугаар сарын 30-нд Монгол Улс байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ зэрэг асуудлыг зохицуулсан Байгаль орчныг хамгаалах тухай хууль баталсан.[61] Засгийн газар мөн Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийх журмыг баталсан.[62]

---

[60] 1994 оны Ашигт малтмалын тухай хууль, зүйлүүд 28, 46 (Эрх зүйн эх сурвалж CLA-9).

[61] Монгол Улсын Байгаль орчныг хамгаалах тухай хууль (1995 оны 3 дугаар сарын 30; хүчин төгөлдөр болсон: 1995 оны 6 дугаар сарын 5) (Эрх зүйн эх сурвалж CLA-66).

[62] Төсөлд байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийх журам, Монгол Улсын Засгийн газрын 121 дүгээр тогтоол, 1994 оны 6 дугаар сарын 29 (Эрх зүйн эх сурвалж CLA-67).

114. 1997 оны 6 дугаар сарын 5-нд Монгол Улс Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг (“1997 оны Ашигт малтмалын тухай хууль”) баталсан.[63] 1997 оны Ашигт малтмалын тухай хуульд ашиглалтын тусгай зөвшөөрлийг 60 жилийн хугацаагаар олгож, нэг удаа 40 жилээр сунгаж болохоор заасан.[64]

115. 1997 оны Ашигт малтмалын тухай хуулийн 47 дугаар зүйлд тусгай зөвшөөрлийг цуцлах талаар дараах байдлаар заасан:

47 дугаар зүйл. Тусгай зөвшөөрлийг цуцлах

1. Тусгай зөвшөөрөл эзэмшигч энэ хуулийн 3 дугаар бүлэгт заасан тусгай зөвшөөрөл эзэмших эрхээ хадгалах шаардлагыг хангахгүй байгааг тогтоосон бол Геологи, уул уурхайн кадастрын алба (OGMC) энэ зүйлд заасны дагуу тухайн тусгай зөвшөөрлийг хүчингүй болгоно.

2. OGMC-ийн даргын шийдвэрээр дараах үндэслэлээр тусгай зөвшөөрлийг хүчингүй болгоно:

1) тусгай зөвшөөрөл эзэмшигч энэ хуулийн дагуу тусгай зөвшөөрөл эзэмших эрхээ алдсан; эсхүл

2) тусгай зөвшөөрөл эзэмшигч энэ хуулийн 24 дүгээр зүйлд заасан тусгай зөвшөөрлийн төлбөрийг бүрэн төлөөгүй, эсхүл энэ зүйлийн 4 дэх хэсэгт заасан хугацаанд тусгай зөвшөөрлийн төлбөр, алдангийг төлөөгүй; эсхүл

/Энэ заалтад 1999 оны 1 дүгээр сарын 8-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

3) хайгуулын буюу ашиглалтын талбайг тусгай хэрэгцээнд авч, тусгай зөвшөөрөл эзэмшигчид нөхөн төлбөрийг бүрэн олгосон.

3. Тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох үндэслэл байгааг тогтоомогц OGMC энэ хуульд заасан журмаар тусгай зөвшөөрөл эзэмшигч болон тусгай зөвшөөрлийг барьцаалагчид мэдэгдэнэ. Мэдэгдэлд тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох үндэслэлийг тодорхой заана.

4. Энэ зүйлийн 3 дахь хэсэгт заасан мэдэгдлийг хүлээн авснаас хойш гуч (30) хоногийн дотор тусгай зөвшөөрөл эзэмшигч, эсхүл тусгай зөвшөөрлийн төлбөр болон холбогдох алдангийг төлсөн тусгай зөвшөөрлийг барьцаалагч нь тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох үндэслэл байхгүйг нотлох баримтыг OGMC-д ирүүлж болно.

/Энэ заалтад 1999 оны 1 дүгээр сарын 8-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

5. Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн ирүүлсэн баримтыг хянаж, шинжилсний дараа тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох үндэслэл байхгүйг OGMC хүлээн зөвшөөрвөл хүчингүй болгох тухай мэдэгдлээ буцаан авч, тусгай зөвшөөрөл эзэмшигчид мэдэгдэнэ.

6. Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн ирүүлсэн баримт нь тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох үндэслэл байхгүйг нотлохгүй гэж OGMC үзвэл тус байгууллагын дарга тусгай зөвшөөрлийг хүчингүй болгож, тусгай зөвшөөрөл эзэмшигч болон барьцаалагчид мэдэгдэнэ.

---

[63] 1997 оны Ашигт малтмалын тухай хууль (Эрх зүйн эх сурвалж RLA-84).

[64] 1997 оны Ашигт малтмалын тухай хууль, зүйлүүд 16(6), 18(8) (Эрх зүйн эх сурвалж RLA-84).

7. Тусгай зөвшөөрөл эзэмшигч эсхүл тусгай зөвшөөрлийг барьцаалагч нь шийдвэр гарсан өдрөөс хойш гуч (30) хоногийн дотор шүүхэд гомдол гаргах эрхтэй.

8. Тусгай зөвшөөрөл эзэмшигч эсхүл тусгай зөвшөөрлийг барьцаалагч шүүхэд гомдол гаргасан бол шүүхийн хүчин төгөлдөр шийдвэр гарах хүртэл тухайн талбайд тусгай зөвшөөрөл олгохгүй.

9. OGMC тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосныг мэргэжлийн хяналтын байгууллага болон Геологи, уул уурхайн хөгжлийн агентлагт (GMDA) мэдэгдэнэ. Ашиглалтын тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон бол Сангийн яаманд мөн мэдэгдэж, хүчингүй болгосон тухай албан ёсны мэдэгдлийг нийтэд мэдээлнэ.

/Энэ хэсэгт 2000 оны 9 дүгээр сарын 1-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/[65]

1997 оны Ашигт малтмалын тухай хуулийн 52 дугаар зүйлд хууль зөрчсөн бусад үйлдэлд ногдуулах торгуулийн хэмжээг тогтоосон бөгөөд эцэст нь дараах арга хэмжээг заасан:

Тусгай зөвшөөрөл эзэмшигч байгаль орчныг хамгаалах хууль тогтоомж, уурхайн ашиглалтын аюулгүй ажиллагааны дүрэм эсхүл байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөгөө үргэлжлүүлэн зөрчвөл түүний хайгуулын болон ашиглалтын үйл ажиллагааг 60 хүртэл хоногоор зогсооно. Энэ хугацаанд зөрчлийг арилгаагүй бол тусгай зөвшөөрөл эзэмшигчийн хайгуулын үйл ажиллагааг дуусгавар болгох буюу ашиглаж буй уурхайг хаана.[66]

116. 1997 оны Ашигт малтмалын тухай хуулийг батлахтай хамт Монгол Улс шинэ хууль тогтоомж болон өмнө олгосон тусгай зөвшөөрлүүдийн хоорондын харилцааг зохицуулах Ашигт малтмалын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийг (“1997 оны Дагаж мөрдөх журмын тухай хууль”) баталсан. Уг хуулийн холбогдох хэсэгт дараах байдлаар заасан:

1 дүгээр зүйл. 1997 оны 7 дугаар сарын 1-нээс өмнө олгосон хайгуулын болон ашиглалтын бүх тусгай зөвшөөрлийг Ашигт малтмалын тухай хууль хүчин төгөлдөр болсноос хойш гурван сарын дотор шинэчлэн бүртгэнэ.

2 дугаар зүйл. Тусгай зөвшөөрөл эзэмшигч эсхүл түүний зохих ёсоор эрх олгосон төлөөлөгч энэ хуулийн 1 дүгээр зүйлд заасан шинэчилсэн бүртгэлийн баримтуудыг Геологи, уул уурхайн кадастрын хэлтэст (DGMC) ирүүлнэ. Шинэчлэн бүртгүүлэх өргөдөлд албан ёсны газрын зурагт тэмдэглэсэн холбогдох хайгуулын буюу ашиглалтын талбайн солбицол, тусгай зөвшөөрлийн гэрчилгээ болон бусад холбогдох баримтыг тусгана.

[...]

6 дугаар зүйл. Тусгай зөвшөөрөл эзэмшигч энэ хуулийн 1 дүгээр зүйлд заасны дагуу шинэчлэн бүртгүүлэх хүсэлт гаргаагүй, эсхүл энэ хуулийн 5 дугаар зүйлд заасан төлбөрийг төлөөгүй бол Ашигт малтмалын тухай хуулийн 40, 41, 42 дугаар зүйлд заасан эрх, үүргийг эдлэхгүй. Түүнчлэн түүний тусгай зөвшөөрлийг хүчингүй

[65] 1997 оны Ашигт малтмалын тухай хууль, зүйл 47 (Эрх зүйн эх сурвалж RLA-84).

[66] 1997 оны Ашигт малтмалын тухай хууль, зүйл 52(6) (Эрх зүйн эх сурвалж RLA-84).

болгож, тухайн талбайг бусад хүсэлт гаргагчид тусгай зөвшөөрлөөр олгох боломжтой болно.[67]

117. 1997 оны Дагаж мөрдөх журмын тухай хуульд мөн “улсын төсвийн хөрөнгөөр хийсэн хайгуулын ажлаар ашигт малтмалын ордыг илрүүлж, нөөцийг тогтоосон бол тухайн ордын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч өмнө нь улсаас гаргасан хайгуулын зардлыг Ашигт малтмалын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн тав (5) жилийн хугацаанд тэнцүү хэмжээгээр улсад нөхөн төлнө” гэж заасан.[68]

118. 1998 оны 1 дүгээр сарын 22-нд Монгол Улс Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн шинэчилсэн найруулгыг баталж, өмнөх үнэлгээний удирдамжид заасан шаардлагыг дэлгэрүүлэн, гэмт хэргийн шинжгүй хууль зөрчсөн үйлдэлд ногдуулах торгуулийн хэмжээг тогтоосон.[69]

119. 1998 оны 8 дугаар сарын 12-нд Монгол Улсын Засгийн газар 144 дүгээр тогтоолоор Ашигт малтмалын хөтөлбөр (“1998 оны Ашигт малтмалын хөтөлбөр”)-ийг батлсан. Уг хөтөлбөрт гадаадын хөрөнгө оруулалт болон байгаль орчныг хамгаалах асуудлыг багтаан ашигт малтмалын салбарыг хөгжүүлэх бодлогын ерөнхий чиглэлийг тодорхойлсон.[70]

120. 2001 оны 2 дугаар сарын 1-нд Монгол Улс Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийг (“2001 оны Тусгай зөвшөөрлийн тухай хууль”) батлсан.[71] Уг хуулийн 13, 14 дүгээр зүйлд тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох ерөнхий журмыг дараах байдлаар заасан:

13 дугаар зүйл. Тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх

13.1. Тусгай зөвшөөрлийн нөхцөл, хугацаа, шаардлагыг зөрчсөн бол тусгай зөвшөөрөл олгосон байгууллага холбогдох хяналтын байгууллагын дүгнэлтийг үндэслэн тусгай зөвшөөрлийг гурав хүртэл сарын хугацаагаар түдгэлзүүлж болно.

13.2. Тусгай зөвшөөрөл олгосон байгууллага түдгэлзүүлсэн тухайгаа гурав хоногийн дотор тусгай зөвшөөрөл эзэмшигч болон холбогдох татварын албанд бичгээр мэдэгдэнэ.

13.3. Тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэхэд хүргэсэн нөхцөл байдлыг арилгасан бол тусгай зөвшөөрөл олгосон байгууллага түдгэлзүүлэлтийг зогсооно.

14 дүгээр зүйл. Тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох

---

[67] Монгол Улсын Ашигт малтмалын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль (1997 оны 7 дугаар сарын 1; хүчин төгөлдөр болсон: 1997 оны 7 дугаар сарын 1) (Эрх зүйн эх сурвалж CLA-3).

[68] 1997 оны Дагаж мөрдөх журмын тухай хууль, зүйл 7 (Эрх зүйн эх сурвалж CLA-3).

[69] Монгол Улсын Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль, 1998 оны 1 дугаар сарын 22 (Эрх зүйн эх сурвалж CLA-6).

[70] Монгол Улсын Засгийн газрын 144 дүгээр тогтоол (Ашигт малтмалын хөтөлбөр), 1998 оны 8 дугаар сарын 12 (Эрх зүйн эх сурвалж CLA-68).

[71] Монгол Улсын Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль (2001 оны 2 дугаар сарын 1; хүчин төгөлдөр болсон: 2002 оны 1 дугаар сарын 1) (Эрх зүйн эх сурвалж CLA-69).

14.1. Тусгай зөвшөөрөл олгосон байгууллага дараах тохиолдолд тусгай зөвшөөрлийг хүчингүй болгоно:

14.1.1. тусгай зөвшөөрөл эзэмшигч хүсэлт гаргасан;

14.1.2. хуулийн этгээд [тусгай зөвшөөрөл эзэмшигч] татан буугдсан;

14.1.3. тусгай зөвшөөрөл авахдаа хуурамч баримт бүрдүүлсэн нь тогтоогдсон;

14.1.4. тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагыг удаа дараа буюу ноцтой зөрчсөн;

14.1.5. тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн хугацаанд түдгэлзүүлсэн шалтгааныг арилгах шаардлагыг биелүүлээгүй.

14.2. Тусгай зөвшөөрөл олгосон байгууллага хүчингүй болгох шийдвэр гаргаснаас хойш гурав хоногийн дотор энэ тухай тусгай зөвшөөрөл эзэмшигч болон холбогдох татварын албанд мэдэгдэнэ.[72]

2001 оны Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 2 дугаар зүйлд уг хууль бусад холбогдох хууль тогтоомжтой хэрхэн уялдахыг дараах байдлаар зохицуулсан:

2 дугаар зүйл. Тусгай зөвшөөрлийн тухай бусад холбогдох хууль тогтоомж

2.1. Тусгай зөвшөөрлийн тухай хууль тогтоомж нь энэ хууль, Иргэний хууль болон эдгээр хуульд нийцсэн бусад хууль тогтоомжийн актаас бүрдэнэ.

2.2. Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

2.3. Газар, байгалийн баялаг ашиглах тусгай зөвшөөрөлтэй холбоотой харилцааг Монгол Улсын Газрын тухай хууль, Газрын хэвлийн тухай хууль, Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль, Байгалийн ургамлын тухай хууль, Ан агнуурын тухай хууль, Амьтны тухай хууль, Ойн тухай хууль, Усны тухай хууль, Ховор амьтан, ургамал, тэдгээрээс гаралтай бүтээгдэхүүний гадаад худалдааны тухай хууль болон Монгол Улсын Ашигт малтмалын тухай хуулиар зохицуулна.[73]

121. 2002 оны 6 дугаар сарын 7-нд Монгол Улс Газрын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг (“2002 оны Газрын тухай хууль”) баталсан.[74] 2002 оны Газрын тухай хуулийн 33, 40 дүгээр зүйлд газар эзэмших, ашиглах эрх олгох болон хүчингүй болгох талаар дараах байдлаар заасан:

33 дугаар зүйл. Газар эзэмших эрхийн гэрчилгээ олгох

33.1. Монгол Улсын иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад газар эзэмших эрхийн гэрчилгээ олгох асуудлыг дараах байдлаар шийдвэрлэнэ:

33.1.1. Холбогдох аймаг, нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас баталсан газар зохион байгуулалтын ерөнхий болон тухайн жилийн төлөвлөгөөний

[72] 2001 оны Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль, зүйлүүд 13-14 (Эрх зүйн эх сурвалж CLA-69).

[73] 2001 оны Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль, зүйл 2 (Эрх зүйн эх сурвалж CLA-69).

[74] Монгол Улсын Газрын тухай хууль (2002 оны 6 дугаар сарын 7; хүчин төгөлдөр болсон: 2003 оны 1 дугаар сарын 1) (Эрх зүйн эх сурвалж CLA-94).

дагуу зохих шатны Засаг дарга энэ хуулийн 29.1, 29.2, 29.3-т нийцүүлэн газар эзэмшүүлэх, мөн улсын төсөвт байгууллагад зайлшгүй хэрэгцээний газрыг ашиглуулахаар олгох шийдвэр гаргана.

33.1.2. Энэ зүйлийн 33.1.1-д зааснаас бусад зориулалтаар, эсхүл энэ хуулийн 29.1, 29.2-т заасан хэмжээнээс илүү газар эзэмших эрхийн гэрчилгээг иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад олгох асуудлыг зохих шатны Засаг дарга дуудлага худалдаа буюу сонгон шалгаруулалтын журмаар шийдвэрлэнэ. Сонгон шалгаруулалт, дуудлага худалдааны журмыг Засгийн газар тогтооно.

33.2. Энэ хуулийн 33.1.2-т заасны дагуу шийдвэр гарсны дараа гэрчилгээний төлбөрийн мэдэгдэл хүлээн авсан этгээд уг төлбөрийг тогтоосон хугацаанд төлөөгүй бол тухайн газар эзэмших эрхийн гэрчилгээг дахин дуудлага худалдаанд оруулна.

33.3. Эрхийн гэрчилгээгээр газар эзэмшүүлэх шийдвэртэй холбоотой маргааныг энэ хуулийн 60.1.1-д заасны дагуу шийдвэрлэнэ.

33.4. Аймаг, нийслэл, сум, дүүргийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд эзэмшүүлж болохоор тусгаснаас бусад газрыг эзэмшүүлэхийг хориглоно.

[...]

40 дүгээр зүйл. Газар эзэмших эрхийн гэрчилгээг хүчингүй болгох

40.1. Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга дараах нөхцөлд эрхийн гэрчилгээг хүчингүй болгоно:

40.1.1. гэрчилгээ эзэмшигч газрын тухай хууль тогтоомжид заасан үүрэг, газар эзэмших гэрээний заалт, нөхцөлийг удаа дараа буюу ноцтой зөрчсөн;

40.1.2. газрыг хүний эрүүл мэнд, байгаль орчныг хамгаалах болон үндэсний аюулгүй байдлын ашиг сонирхолд хохиролтойгоор ашигласан нь эрх бүхий байгууллагын дүгнэлтээр нотлогдсон;

40.1.3. бусдаас шилжүүлэн авсан гэрчилгээг бүртгүүлж, шинээр гэрээ байгуулаагүй;

40.1.4. байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээгээр өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй;

40.1.5. гэрчилгээ эзэмшигч хуульд заасан газрын төлбөрийг хугацаанд нь бүрэн төлөөгүй;

40.1.6. хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр газрыг гэрээнд заасан зориулалтаар дараалсан хоёр жил ашиглаагүй.

40.2. Энэ хуулийн 40.1-д заасан нөхцөл байдал нотлогдвол аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга эрхийн гэрчилгээг хүчингүй болгох захирамж гаргаж, гэрчилгээ эзэмшигч эсхүл гэрчилгээг барьцаалан авсан этгээдэд мэдэгдэнэ.

40.3. Гэрчилгээ эзэмшигч эсхүл гэрчилгээг барьцаалан авсан этгээд Засаг даргын шийдвэрийг хууль бус гэж үзвэл захирамж гарсан өдрөөс хойш ажлын 10 хоногийн дотор шүүхэд гомдол гаргах эрхтэй.

40.4. Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга гэрчилгээг хүчингүй болгосон шийдвэрээ газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад мэдэгдэж, улсын бүртгэлд өөрчлөлт оруулуулна.

40.5. Гэрчилгээ эзэмшигч эсхүл гэрчилгээг барьцаалан авсан этгээд шүүхэд гомдол гаргасан бол шүүхийн хүчин төгөлдөр шийдвэр гарах хүртэл уг газарт газар эзэмших эрхийн шинэ гэрчилгээ олгохгүй.[75]

122. 2004 оны 5 дугаар сарын 6-нд Монгол Улс Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хуулийг ("2004 оны Тэсэрч дэлбэрэх бодисын тухай хууль") баталсан.[76] Уг хуулийн 11 дүгээр зүйлээр тэсэлгээний үйл ажиллагааны хувьд 2001 оны Тусгай зөвшөөрлийн тухай хуулийн шаардлагад дараах нэмэлт шаардлагыг оруулсан:

11 [дүгээр зүйл]. Тэсэлгээний ажилд тавих шаардлага

11.1. Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн [2001 оны Тусгай зөвшөөрлийн тухай хууль] 11 дүгээр зүйлд зааснаас гадна дараах шаардлага тавина:

11.1.1. мэргэжлийн ажилтантай байх;

11.1.2. тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн харуул хамгаалалттай агуулахтай байх;[77]

123. 2006 оны 7 дугаар сарын 8-нд Монгол Улс Ашигт малтмалын тухай хуулийг дахин шинэчлэн баталсан ("2006 оны Ашигт малтмалын тухай хууль").[78] Уг хуулийн 5 дугаар зүйлд стратегийн ач холбогдол бүхий, эсхүл улсын хөрөнгөөр хайгуул хийсэн ашигт малтмалын ордод төр өмчлөх буюу оролцох асуудлыг дараах байдлаар зохицуулсан:

5.3. Улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийж нөөцийг нь тогтоосон ашигт малтмалын ордод төрийн эзэмших хувь хэмжээг тухайн ордыг ашиглах гэрээгээр тогтооно.

5.4. Улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийж нөөцийг нь тогтоосон стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордыг хувийн хуулийн этгээдтэй хамтран ашиглахад төр 50 хүртэл хувийг эзэмшиж болно. Төрийн оруулсан хөрөнгө оруулалтын хэмжээг харгалзан төрийн эзэмших хувь хэмжээг орд ашиглах гэрээгээр тогтооно.

5.5. Улсын төсвөөс бусад эх үүсвэрээр хайгуул хийж нөөцийг нь тогтоосон стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордод тусгай зөвшөөрөл эзэмшигчийн оруулах хөрөнгө оруулалтын 34 хүртэл хувийг төр эзэмшиж болно. Төрийн оруулсан хөрөнгө оруулалтын хэмжээг харгалзан төрийн эзэмших хувь хэмжээг орд ашиглах гэрээгээр тогтооно.

---

[75] 2002 оны Газрын тухай хууль, зүйлүүд 33, 40.

[76] Монгол Улсын Тэсэрч дэлбэрэх бодис болон тэдгээрийн эргэлтэд хяналт тавих тухай хууль (2004 оны 5 дугаар сарын 6; хүчин төгөлдөр болсон: 2005 оны 1 дугаар сарын 1) (Эрх зүйн эх сурвалж CLA-75).

[77] 2004 оны Тэсэрч дэлбэрэх бодисын тухай хууль, зүйл 11 (Эрх зүйн эх сурвалж CLA-75).

[78] Монгол Улсын 2006 оны Ашигт малтмалын тухай хууль (2006 оны 7 дугаар сарын 8; хүчин төгөлдөр болсон: 2006 оны 8 дугаар сарын 26) (Эрх зүйн эх сурвалж RLA-85).

5.6. Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээд хувьцааныхаа 10-аас доошгүй хувийг Монголын Хөрөнгийн биржээр арилжина.[79]

2006 оны Ашигт малтмалын тухай хуульд мөн "улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийж, нөөцийг тогтоосон талбайд ашиглалтын тусгай зөвшөөрлийг сонгон шалгаруулалтаар олгоно" гэсэн шаардлага нэмсэн.[80] Эцэст нь уг хуульд тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох асуудлыг дараах байдлаар заасан:

56 дугаар зүйл. Тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох

56.1. Төрийн захиргааны байгууллага дараах үндэслэлээр тусгай зөвшөөрлийг хүчингүй болгоно:

56.1.1. тусгай зөвшөөрөл эзэмшигч энэ хуулийн 7.2[81] болон 31 дүгээр зүйлд[82] заасан шаардлагыг хангаагүй;

56.1.2. тусгай зөвшөөрөл эзэмшигч тусгай зөвшөөрлийн төлбөрийг тогтоосон хугацаанд төлөөгүй;

56.1.3. хайгуулын буюу ашиглалтын талбайг тусгай хэрэгцээнд авч, тусгай зөвшөөрөл эзэмшигчид нөхөн төлбөрийг бүрэн олгосон;

56.1.4. тухайн жилийн хайгуулын зардал энэ хуулийн 33 дугаар зүйлд[83] заасан хайгуулын зардлын доод хэмжээнээс бага байсан;

56.1.5. тусгай зөвшөөрөл эзэмшигч байгаль орчныг нөхөн сэргээх үүргээ биелүүлээгүй тухай нутгийн захиргааны байгууллагын тайланд үндэслэн байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага шийдвэр гаргасан.

56.2. Тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох үндэслэл байгааг тогтоосноос хойш ажлын тав (5) хоногийн дотор төрийн захиргааны байгууллага тусгай зөвшөөрөл эзэмшигчид мэдэгдэнэ. Мэдэгдэлд хүчингүй болгох үндэслэлийг тодорхой заана.

56.3. Тусгай зөвшөөрөл эзэмшигч энэ хуулийн 56.2-т заасан мэдэгдэлд дурдсан үндэслэлийг эс зөвшөөрвөл төрийн захиргааны байгууллагад нотлох баримт ирүүлнэ.

56.4. Төрийн захиргааны байгууллага энэ хуулийн 56.3-т заасан баримтыг хянаж, тусгай зөвшөөрөл эзэмшигчийн ирүүлсэн баримт нь хүчингүй болгох үндэслэл байхгүйг нотлохгүй гэж тогтоовол тусгай зөвшөөрлийг хүчингүй болгож, эзэмшигчид нь мэдэгдэнэ.

---

[79] 2006 оны Ашигт малтмалын тухай хууль, зүйл 5 (Эрх зүйн эх сурвалж RLA-85).

[80] 2006 оны Ашигт малтмалын тухай хууль, зүйл 26.9 (Эрх зүйн эх сурвалж RLA-85).

[81] 7.2 дугаар зүйлд тусгай зөвшөөрөл эзэмшигч нь тусгай зөвшөөрлийн хүчинтэй хугацааны туршид «Монгол Улсын хуулийн дагуу зохих ёсоор байгуулагдан үйл ажиллагаа явуулж буй хуулийн этгээд бөгөөд Монгол Улсад татвар төлөгч» байхыг шаарддаг.

[82] 2006 оны Ашигт малтмалын тухай хуулийн 31 дүгээр зүйл нь тусгай зөвшөөрлийн төлбөр болон тусгай зөвшөөрөл эзэмшигчийн тусгай зөвшөөрлийн жил бүрд хайгуулд зарцуулах ёстой доод хэмжээнд хамаарна.

[83] 2006 оны Ашигт малтмалын тухай хуулийн 33 дугаар зүйл мөн тусгай зөвшөөрөл эзэмшигчийн тусгай зөвшөөрлийн жил бүрд хайгуулд зарцуулах ёстой доод хэмжээнд хамаарна.

56.5. Энэ хуулийн 56.4-т заасан тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон шийдвэрийг эс зөвшөөрвөл эзэмшигч шүүхэд гомдол гаргах эрхтэй. Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 46.1.3-т заасны дагуу шүүх хүчингүй болгох шийдвэрийг түдгэлзүүлэхгүй;

56.6. Тусгай зөвшөөрөл эзэмшигч шүүхэд гомдол гаргасан бол шүүхийн хүчин төгөлдөр шийдвэр гарах хүртэл тухайн талбайд тусгай зөвшөөрөл олгохгүй.

56.7. Төрийн захиргааны байгууллага хайгуулын тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон бол мэргэжлийн хяналтын байгууллагад, ашиглалтын тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон бол татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад мэдэгдэж, өдөр тутмын сонинд нийтэлнэ.[84]

F. ДАРХАНЫГ БАЙГУУЛСАН НЬ БОЛОН ТӨМӨРТЭЙН ОРДЫН АНХНЫ ХАЙГУУЛ

124. 1990 оны 4 дүгээр сарын 14-нд, Монгол Улс ардчилсан тогтолцоонд шилжихийн өмнөхөн, Монголын Засгийн газар Дарханд төмөрлөгийн үйлдвэр байгуулах, Төмөртэйн ордыг ашиглах тухай 160 дугаар тогтоол баталсан. Нэхэмжлэгчдийн орчуулгаар 160 дугаар тогтоолд дараах байдлаар заасан:

1. Дарханд жилд 100.0 мянган тонн ган цувимал үйлдвэрлэх хүчин чадалтай төмөрлөгийн үйлдвэрийн цогцолбор байгуулах тухай Гадаад эдийн засгийн харилцаа, хангамжийн яамны харьяа “Монгол Импекс” корпорац болон Японы Itochu корпорацын хооронд байгуулсан гэрээг сайшаасугай.

2. Төмөрлөгийн үйлдвэрийн цогцолборын төмөр хайлуулах, цувих үйлдвэрийг 1990–1993 онд, төмрийн хүдрээс ангижруулсан төмөр үйлдвэрлэх үйлдвэрийг 1993–1995 онд барьж ашиглалтад оруулахаар эдийн засаг, нийгмийн хөгжлийн төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлэхийг Нийгэм, эдийн засгийн хөгжлийн улсын комисст даалгасугай.

3. Төмөртэйн төмрийн ордод тулгуурласан хүдэр олборлох ил уурхайг 1994 он гэхэд байгуулж, уг уурхай болон Төмөрлөгийн үйлдвэрийн цогцолборыг нэгтгэн Төмөрлөгийн үйлдвэрийн комбинат болгон өөрчлөн зохион байгуулсугай. [...][85]

160 дугаар тогтоолын дээрх хэсгүүдийн Хариуцагчийн орчуулга ихээхэн ялгаатай бөгөөд дараах агуулгатай:

1. Япон Улсын зээлээр Дархан хотод жилд 100.0 мянган тонн ган цутгамал үйлдвэрлэх хүчин чадалтай үйлдвэрийн цогцолбор барих тухай Гадаад эдийн засгийн харилцаа, хангамжийн яамны “Монголимпекс” нийгэмлэг болон Японы “Itochu” компанийн хооронд байгуулсан гэрээг дэмжсүгэй.

2. Хар төмөрлөгийн ган цутгамал үйлдвэрлэх үйлдвэрийн цогцолборыг 1990–1993 онд, төмрийн хүдрээс төмөр бүтээгдэхүүн гаргах үйлдвэрийн цехийг 1993–1995 онд барьж байгуулах, уг төслийг эдийн засаг, нийгмийн хөгжлийн төлөвлөгөөнд тусгахыг Нийгэм, эдийн засгийн хөгжлийн улсын хороонд даалгасугай.

3. “Төмөртэй” төмрийн хүдрийн ордыг ашиглах ил уурхайг 1994 он гэхэд байгуулж, уг уурхай болон хар төмөрлөгийн үйлдвэрийн цогцолборыг “Хар төмөрлөгийн үйлдвэр” болгон байгуулсугай. [...][86]

---

[84] 2006 оны Ашигт малтмалын тухай хууль, зүйл 56 (Эрх зүйн эх сурвалж RLA-85).

[85] 1990 оны 160 дугаар тогтоол, 1990 оны 4 дугаар сарын 14 (Эрх зүйн эх сурвалж CLA-10).

125. 160 дугаар тогтоол гарсны дараахан буюу 1990 оны 4 дүгээр сарын 15-нд Дархан үүсгэн байгуулагдсан бөгөөд төмөрлөгийн үйлдвэр (“Дарханы үйлдвэр”) 1994 оны 7 дугаар сарын 4-нд үйл ажиллагаагаа эхэлсэн.[87] Дарханы үйлдвэрийг хаягдал төмөр эсхүл ангижруулсан төмөр, өөрөөр хэлбэл төмрийн ислийн хүдрийн исэлдэлтийн зэргийг бууруулах замаар гарган авсан төмрөөс ган үйлдвэрлэхээр төлөвлөсөн.

126. Талууд 160 дугаар тогтоолоор Дарханд Төмөртэйн ордтой холбоотой эрх олгосон эсэх, мөн БЛТ уг ордод хайгуул, ашиглалтын тусгай зөвшөөрөл хүсэхээс өмнө ордод хэр хэмжээний хайгуул хийсэн талаар санал зөрөлддөг. Нэхэмжлэгчдийн үзэж байгаагаар, “160 дугаар тогтоолоор ямар ч этгээдэд, тэр тусмаа [Дархан]-д тодорхой эрх олгоогүй”[88] бөгөөд Дархан 1995 он гэхэд “Төмөртэйн ордод “арав гаруй жил” ажил явуулж байгаагүй”.[89] Харин Хариуцагчийн үзэж байгаагаар, “Сайд нарын Зөвлөл 1990 оны 4 дүгээр сарын 14-нд Дархан хотод үйлдвэр барих болон Төмөртэйн ордыг цогцолборыг ажиллуулах зорилгоор шинээр байгуулсан төрийн компанид хариуцуулахыг эцэслэн зөвшөөрсөн”.[90] Үүний дараа “Дархан олборлолтын талбайг бэлтгэх, төмөрлөгийн үйлдвэр болон ялгах байгууламжид боловсруулах төмрийн хүдрийн агуулгыг тогтоох зорилгоор 1991 онд Төмөртэйн төмрийн хүдрийн ордод хайгуулын ажлаа үргэлжлүүлсэн”.[91]

127. Талууд тухайн үеийн үйл явдлыг өөр өөрөөр ойлгодог хэдий ч хэргийн материалд 1991 онд (ноён Ганжууржав ерөнхий захирлаар ажиллаж байх үед) Дарханаас Төмөртэйн ордтой холбогдуулан илгээсэн дараах захидлууд багтсан:

> (a) 1991 оны 3 дугаар сарын 18-нд Дархан Геологийн хайгуулын экспедицэд дараах захидлыг хүргүүлсэн:
>
> Дархан хотын Хар төмөрлөгийн комбинатын хоёрдугаар ээлжийг ашиглалтад оруулж, төмрийн хүдэр ашиглан үйлдвэрлэл явуулах ажил 1995 онд эхлэх тул ойролцоох Төмөртэй, Төмөртолгойн төмрийн хүдрийн шинж чанарыг судалж, зохистой техник, технологи сонгох шаардлагатай байна. Иймд танай байгууллагатай байгуулах гэрээнд үндэслэн орд тус бүрээс ашиглалтын үед олборлон ашиглаж болох, химийн дундаж найрлага бүхий 350 кг төмрийн хүдрийн дээж авч өгнө үү.[92]

---

[86] Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Сайд нарын Зөвлөлийн 160 дугаар тогтоол, огноо: 1990 оны 4 дугаар сарын 14 (Баримт R-21).

[87] Дархан хотын төмөрлөгийн үйлдвэрийг хүлээлгэн өгөх Засгийн газрын комиссын акт, 1994 оны 7 дугаар сарын 4 (Баримт C-27).

[88] Нэхэмжлэгчдийн Хариу тайлбар, догол мөр 34; мөн үзнэ үү: Сонсголын тэмдэглэл (өдөр 1, 2015 оны 9 дугаар сарын 14) 102:5–103:6.

[89] Нэхэмжлэгчдийн Хариу тайлбар, догол мөр 39.

[90] Хариуцагчийн Хариу үндэслэл, догол мөр 29.

[91] Хариуцагчийн Хариу үндэслэл, догол мөр 35.

[92] Дарханаас Геологийн албанд хүргүүлсэн албан бичиг, 1991 оны 3 дугаар сарын 18 (Баримт R-31).

(b) 1991 оны 5 дугаар сарын 21-нд Дархан хотын Ардын депутатуудын хурлын гүйцэтгэх захиргаанд хүргүүлсэн захидалдаа Дархан “Төмөртэйд төмрийн хүдэр олборлох ажил 1995 онд эхэлнэ” гэж мэдэгдсэн.[93]

(c) 1991 оны 11 дүгээр сарын 7-нд Дархан “Монгол Импекс” нэгдэлд захидал хүргүүлж, “Дархан хотын Хар төмөрлөгийн үйлдвэрийн хоёрдугаар үйлдвэр болох бөгөөд Шарын голын нүүрсийг ашиглан Төмөртэй, Төмөртолгойн төмрийн хүдрийг ялгах” төмөр ялгах үйлдвэрийн үнийн саналыг гадаад нийлүүлэгчдээс авахыг хүссэн. Дархан цааш нь “үйлдвэрийн хүчин чадал 75–150 тонн байж болох бөгөөд ялгасан бүтээгдэхүүн нь 93 хувиас дээш төмөр агуулсан, цахилгаан нуман зууханд чанартай ган үйлдвэрлэхэд тохиромжтой, хаягдал төмрийг орлох болон үндсэн түүхий эд болгон ашиглах боломжтой байх ёстой” гэж тодорхойлсон.[94]

128. Эрчим хүч, геологи, уул уурхайн яамны Геологи, шинжлэх ухаан, техникийн зөвлөлийн 1994 оны 7 дугаар сарын 21-ний өдрийн хурлын тэмдэглэлд (“Хурлын тэмдэглэл”)[95] “Н. Хүдэрбат, Ц. Ноостой” нарын бичсэн “1990–1992 онд Төмөртэйн төмрийн ордод хийсэн нарийвчилсан хайгуул болон Хуст-Уулын төмрийн хүдрийн илрэлүүдэд хийсэн эрэл, үнэлгээний ажлын үр дүнгийн тайлан”-г (“1990–1992 оны тайлан”) хэлэлцсэн байна. Хурлын тэмдэглэлд “1990 оны 3 дугаар сард Төмөртэйн төмрийн ордод ... зохих аргачлалын дагуу нарийвчилсан хайгуул, эрэл-үнэлгээний ажил хийсэн”, мөн “ордыг олборлолтод бэлтгэсэн” гэж дурдсан.[96] Хурлын тэмдэглэлд цааш нь:

> Тайланд ордын геологийн тогтоц, ашигт малтмалын тархалт, хүдрийн биетийн хэлбэр, хэмжээ, эрдэсжилт, химийн найрлага, хүдрийн технологийн шинж, дагалдах эрдэс болон хорт хольцын агуулга, ордын уул-техникийн болон гидрогеологийн нөхцөл зэрэг шаардлагатай мэдээллийг тусгасан.[97]

129. БЛТ-ийн дараа нь ирүүлсэн Техник, эдийн засгийн үндэслэлд “Төмөртэйн төмрийн ордод хийсэн нарийвчилсан хайгуулыг Монгол Улсын Эрдэс баялгийн улсын зөвлөлийн 1995 оны 2 дугаар сарын 13-ны өдрийн хурлаар хэлэлцэж, нөөцийг нь баталсан” гэж дурдсан.[98]

130. Хэргийн материалд мөн 1995, 1996 онд (ноён Шагдар ерөнхий захирлаар ажиллаж байх үед) Төмөртэйн ордын талаар гаргасан Засгийн газрын зарим тогтоол болон Дарханы захидлууд багтсан:

---

[93] Дарханаас Дархан хотын АДХ-ын гүйцэтгэх захиргаанд хүргүүлсэн албан бичиг, 1991 оны 5 дугаар сарын 21 (Баримт R-34).

[94] Дарханаас Монгол Импекс нэгдэлд хүргүүлсэн албан бичиг, 1991 оны 11 дугаар сарын 7 (Баримт R-28/R-60).

[95] Эрчим хүч, геологи, уул уурхайн яамны Геологи, шинжлэх ухаан, техникийн зөвлөлийн хурлын 80 дугаар тэмдэглэл, 1994 оны 7 дугаар сарын 21 (Баримт C-24).

[96] Эрчим хүч, геологи, уул уурхайн яамны Геологи, шинжлэх ухаан, техникийн зөвлөлийн хурлын 80 дугаар тэмдэглэл, 1994 оны 7 дугаар сарын 21, хуудас 1 (Баримт C-24).

[97] Эрчим хүч, геологи, уул уурхайн яамны Геологи, шинжлэх ухаан, техникийн зөвлөлийн хурлын 80 дугаар тэмдэглэл, 1994 оны 7 дугаар сарын 21, хуудас 1 (Баримт C-24).

[98] БЛТ, Төмөртэйн ордыг ашиглах техник, эдийн засгийн үндэслэл, 1997 оны 3 дугаар сар, хуудас 16 (Баримт C-17).

(a) 1995 оны 2 дугаар сарын 3-нд Дархан Монгол Улсын Үндэсний хөгжлийн газарт ордын талаар дараах мэдээллийг хүргүүлсэн:

БНМАУ-ын (хуучин нэрээр) Сайд нарын Зөвлөлийн 1990 оны 160 дугаар тогтоолд ган цутгах үйлдвэрийг 1990–1993 онд байгуулах, төмрийн хүдрийн нөөцийн судалгааг 1990–1992 онд хийх, хүдрээс төмөр ялгах үйлдвэрийг 1994 оноос барихаар заасан. Уг тогтоолын дагуу Дарханаас зүүн хойш 130 км-т орших Төмөртэйн төмрийн хүдрийн ордод нарийвчилсан судалгаа хийж, төмөр ялгах үйлдвэр байгуулах боломжийн холбогдох судалгааг явуулсан. Өнөөгийн Монголын нөхцөлд хаягдал төмөр хомс байгаа тул түүнийг ялгасан төмрөөр орлуулах замаар Төмөрлөгийн үйлдвэрийг хангалттай түүхий эдээр хангах шаардлагатай. Төмөр ялгах үйлдвэрийн хүчин чадлыг 225,000 тонн, уурхайн хүчин чадлыг 562,500 тонноор сонгосон. Энэ хувилбарын дагуу төмөр ялгах үйлдвэр болон уурхайг байгуулбал дотоодын хэрэгцээнээс илүү гарсан бүтээгдэхүүнийг экспортлон нийт 27.6 сая ам.долларын экспортын худалдаа хийж, 9.4 тэрбум төгрөгийн ашиг олох боломжтой бөгөөд эдгээр нөхцөл нь уг үйлдвэрийг нэн даруй байгуулах үндсэн суурь болж байна. Төмөр ялгах үйлдвэр, Төмөртэйн уурхайн техник, эдийн засгийн үндэслэлийг гадаадын буцалтгүй тусламж, зээлд тулгуурлан боловсруулах бөгөөд холбогдох мэдээлэл, судалгааг манай талаас гаргана. Монголын тал холбогдох дүгнэлт гаргах, Монголын нөхцөлд тохирсон техник, эдийн засгийн тооцоо хийхэд оролцоно.[99]

(b) 1995 оны 2 дугаар сарын 9-нд Дархан Байгаль орчны яаманд Төмөртэйн ордын цаг уур, хөрс болон газар хөдлөлтийн мэдээлэл хүссэн дараах захидлыг хүргүүлсэн:

Манай комбинатын хоёрдугаар ээлжийн үйлдвэр болон уурхайг Дархан-Уул аймгийн Дархан сумын үйлдвэрийн бүс, Сэлэнгэ аймгийн Хүдэр сумын Төмөртэйн ордод (хойд өргөрөг 49°41′00″, уртраг 107°19′30″) барихаар төлөвлөж байгаа тул дээрх газрын цаг уур, хөрс болон газар хөдлөлтийн талаарх албан ёсны мэдээллийг ирүүлнэ үү. Зарим шаардлагатай үзүүлэлтийг хавсаргав.[100]

(c) 1995 оны 5 дугаар сарын 6-нд Дархан Монгол Улсын Үндэсний хөгжлийн газарт захидал хүргүүлж, “Төмөртэйн ордын уурхай болон төмөр ялгах үйлдвэрийн техник, эдийн засгийн урьдчилсан тооцоог хянаж, саналаа өгөх”-ийг хүссэн.[101]

(d) 1996 оны эхээр Монгол Улсын Засгийн газар Дарханы төмөрлөгийн үйлдвэрийн хүчин чадлын ашиглалтыг сайжруулах арга хэмжээний тухай тогтоол гаргасан бөгөөд Төмөртэйн ордын талаар дараах байдлаар дурдсан:

Дарханы төмөрлөгийн үйлдвэрийн хүчин чадлыг богино хугацаанд ашиглах, үйлдвэрлэлийн хэвийн ажиллагааг хангахад дэмжлэг үзүүлэх зорилгоор ТОГТООХ нь: [...]

8. Улсын төмрийн хүдрийн нөөцийг ашиглан Төмөрлөгийн үйлдвэрийг түүхий эдээр тогтвортой хангах, экспортын орлогыг нэмэгдүүлэх зорилгоор 1996–1998 онд

---

[99] Ганжууржаваас (Дархан) Үндэсний хөгжлийн газрын Технологи, хөрөнгө оруулалтын бодлогын газрын Батсүхэд хүргүүлсэн албан бичиг, 1995 оны 2 дугаар сарын 3 (Баримт R-41).

[100] Дарханаас Байгаль орчны яаманд хүргүүлсэн албан бичиг, 1995 оны 2 дугаар сарын 9 (Баримт R-37).

[101] Дарханаас Үндэсний хөгжлийн газарт хүргүүлсэн албан бичиг, 1995 оны 5 дугаар сарын 6 (Баримт R-36).

Шууд ангижруулсан төмрийн үйлдвэр болон Төмөртэйн ил уурхайг барьж ашиглалтад оруулахтай холбогдсон цогц арга хэмжээ авахыг Үндэсний хөгжлийн газар (Ч. Улаан), Үйлдвэр, худалдааны яам (Ц. Цогт), Эрчим хүч, геологи, уул уурхайн яам (Жигжид)-д даалгасугай.

9. Төмөртэйн ил уурхай, Шууд ангижруулсан төмрийн үйлдвэрийн техник, эдийн засгийн үндэслэл боловсруулах, барьж байгуулахад шаардагдах хөрөнгийг улсын төсөв болон гадаад улс, олон улсын байгууллагын зээл, буцалтгүй тусламжаас санхүүжүүлэхийг Сангийн яам (Э. Бямбажав), Үндэсний хөгжлийн газар (Ч. Улаан), Үйлдвэр, худалдааны яам (Ц. Цогт)-д даалгасугай.

10. Төмөртэйн ил уурхай, Шууд ангижруулсан төмрийн үйлдвэр болон холбогдох дэд бүтцийн техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулж, 1996 оны II улиралд багтаан Засгийн газарт оруулахыг Үндэсний хөгжлийн газар (Ч. Улаан), Үйлдвэр, худалдааны яам (Ц. Цогт), Дэд бүтцийн хөгжлийн яам (Сандалхаан)-д даалгасугай.[102]

(e) 1996 оны 2 дугаар сарын 2-нд Дархан Сэлэнгэ аймгийн Засаг даргад "Газар хүсэх тухай" гэсэн гарчигтай дараах захидлыг хүргүүлсэн:

Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Сайд нарын Зөвлөлийн 1990 оны 4 дүгээр сарын 160 дугаар тогтоолоор Сэлэнгэ аймгийн Хүдэр суманд орших Төмөртэйн ордод төмрийн хүдрийн ил уурхай байгуулахаар шийдвэрлэсэн. Уг тогтоолын дагуу 1991–1993 онд ил уурхай болон төмөр ялгах үйлдвэрийн техник, технологийн судалгаа хийсэн бөгөөд техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулах ажлыг 1996 онд эхлүүлэхээр төлөвлөсөн. Төмөртэйн ордын уурхай болон төмөр ялгах үйлдвэрийн техник, эдийн засгийн урьдчилсан тооцоог хянаж, саналаа ирүүлнэ үү. Иймд хөрс, ус, цаг уур болон цахилгаан хангамжийн асуудлыг бүрдүүлэх шаардлагатай байгаа тул Монгол Улсын Газрын тухай хуулийн дагуу уг газрыг манай эзэмшилд олгохыг хүсэж байна.[103]

(f) 1996 оны 4 дүгээр сарын 3-нд Дархан Эрчим хүч, геологи, уул уурхайн яаманд "Төмөртэйн төмрийн хүдрийн ордын газрыг эзэмших зөвшөөрөл хүсэх тухай" гэсэн гарчигтай дараах захидлыг хүргүүлсэн:

Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Сайд нарын Зөвлөлийн Хар төмөрлөгийн үйлдвэр байгуулах зарим арга хэмжээний тухай 1990 оны 4 дүгээр сарын 14-ний өдрийн 160 дугаар тогтоолын 3 дахь хэсэгт Төмөртэйн төмрийн хүдрийн ордод тулгуурлан үндсэн хүдрийн ил уурхай байгуулж, цаашид Хар төмөрлөгийн үйлдвэрийн цогцолбор байгуулахаар заасан. Түүнчлэн энэ оны 2 дугаар сарын 12-ны өдрийн Засгийн газрын хуралдааны 8 дугаар тэмдэглэлд заасны дагуу Төмөртэйн үндсэн хүдрийн уурхай байгуулах зураг, төсөл бүхий төслийг боловсруулж, энэ оны эхний хагаст Засгийн газарт оруулах ёстой. Дээрх шийдвэрт үндэслэн манай үйлдвэр өөрийн түүхий эд болох үндсэн хүдрийг олборлох, Төмөртэйн ордыг эзэмших техник, эдийн засгийн урьдчилсан шинжилгээг хийсэн. Дээрх ажлуудыг тусгасан техник, эдийн засгийн үзүүлэлтийн зургийн даалгаврыг баталж, хэрэгжүүлэх гэрээг Уул уурхайн хүрээлэнтэй байгуулсан. Уг төслийг хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтыг шийдвэрлэх, Уул уурхайн хүрээлэнгийн боловсруулсан техник,

[102] Дарханд холбогдох Монгол Улсын Засгийн газрын тогтоол, 1996 (Баримт R-124).

[103] Дарханаас Сэлэнгэ аймгийн Засаг даргад хүргүүлсэн албан бичиг, 1996 оны 2 дугаар сарын 2 (Баримт R-38/R-43).

эдийн засгийн үзүүлэлтийг олон улсын жишигт нийцүүлэн эцэслэхэд танай байгууллагын албан ёсны зөвшөөрөл нэн чухал байна.[104]

(g) Мөн 1996 оны 4 дүгээр сарын 3-нд Дархан Сэлэнгэ аймгийн Засаг даргад "Газар хүсэх тухай" гэсэн гарчигтай дараах захидлыг дахин хүргүүлсэн:

Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Сайд нарын Зөвлөлийн Хар төмөрлөгийн үйлдвэр байгуулах зарим арга хэмжээний тухай 1990 оны 160 дугаар тогтоолын 3 дахь хэсэгт "Төмөртэйн төмрийн хүдрийн ордод тулгуурлан үндсэн хүдрийн ил уурхайг 1994 он гэхэд байгуулж, уурхай болон Хар төмөрлөгийн үйлдвэрийн цогцолборыг Хар төмөрлөгийн комбинат болгон өөрчлөн зохион байгуулах" гэж заасан. Засгийн газрын энэ оны 2 дугаар сарын 12-ны өдрийн 8 дугаар тэмдэглэлээр Хар төмөрлөгийн үйлдвэрийн цогцолборын техник, эдийн засгийн үндэслэлийг эцэслэн боловсруулж, энэ оны I улиралд Засгийн газарт оруулахыг холбогдох байгууллагуудад үүрэг болгосон. Уг үүргийн дагуу Уул уурхайн хүрээлэнтэй хамтран Төмөртэйн төмрийн хүдрийн ил уурхай болон төмөр ялгах үйлдвэрийн техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулах ажлыг эхлүүлээд байна. Энэхүү үндэслэлийн дагуу танай аймгийн Хүдэр, Ерөө сумын хооронд Төмөртэйн төмрийн хүдрийн уурхай, төмөр ялгах үйлдвэр, цахилгааны шугам, авто зам, төмөр зам, тосгон болон холбогдох бусад барилга байгууламжийг байгуулах шаардлагатай. Иймд дээрх цогцолборыг байгуулахад зориулан Монгол Улсын Газрын тухай хуулийн дагуу газар эзэмших зөвшөөрөл олгож, аймгийн Засаг даргын албан ёсны шийдвэр гаргахыг хүсэж байна. Энэ төслийг хэрэгжүүлэх нь Сэлэнгэ аймгийн хөгжил болон төсөв бүрдүүлэлтэд эерэг нөлөө үзүүлэхийг харгалзан үзнэ үү.[105]

(h) 1996 оны 6 дугаар сарын 5-нд Дархан Эрчим хүч, геологи, уул уурхайн яаманд "Төмөртэйн уурхай болон шууд ангижруулах үйлдвэрийн техник, эдийн засгийн үндэслэл боловсруулах тухай" гэсэн гарчигтай дараах захидлыг дахин хүргүүлсэн:

Төмөртэйн хүдрийн ордод тулгуурлан Төмөрлөгийн комбинатын хоёрдугаар ээлж болох төмөр ялгах үйлдвэр байгуулах асуудлыг Засгийн газрын 1990 оны 4 дүгээр сарын 14-ний өдрийн 160 дугаар тогтоол болон 1994 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн Засгийн газрын хуралдааны 64 дүгээр тэмдэглэлд удаа дараа дурдсан. Гэвч санхүүжилтийн асуудал шийдэгдээгүйгээс өнөөг хүртэл хойшлогдоод байна. Төмөртэйн төмрийн хүдрийн орд, төмөр ялгах үйлдвэрийн техник, эдийн засгийн үндэслэл болон хөрөнгө оруулалтын асуудлыг Турк–Монголын эдийн засаг, худалдааны хамтарсан хуралдааны 1995 оны 8 дугаар сарын 23-ны өдрийн анхны хуралдааны протокол, Туркийн Эрчим хүч, эрдэс баялгийн яам болон Монголын Эрчим хүч, геологи, уул уурхайн яамны хооронд байгуулсан 1994 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн хамтын ажиллагааны протокол болон хоёр яамны байгуулсан харилцан ойлголцлын санамж бичигт тусгасан. Иймд хоёр Засгийн газрын хамтарсан комиссын Монголын талын даргаар ажиллаж байсны хувьд Төмөртэйн төмрийн хүдрийн орд, төмөр ялгах үйлдвэрийн техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулах ажлыг санхүүжүүлэх саналыг Туркийн Засгийн газарт тавьж өгөхийг хүсэж байна. Манай комбинат санал солилцох уулзалт зохион байгуулж, судалгаа хийсэн. Техник, эдийн засгийн үндэслэл боловсруулахтай холбоотой шаардлагатай

[104] Дарханаас Эрчим хүч, геологи, уул уурхайн яаманд хүргүүлсэн албан бичиг, 1996 оны 4 дугаар сарын 3 (Баримт R-39).

[105] Дарханаас Сэлэнгэ аймгийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлсэн албан бичиг, 1996 оны 4 дугаар сарын 3 (Баримт R-45).

аливаа мэдээллийг өгөх, Туркийн төлөөлөгчид ордыг биечлэн үзэхийг хүсвэл комбинатдаа хүлээн авахад бэлэн байна.[106]

131. 1996 оны 9 дүгээр сарын 19-нд ноён Нацагдорж ноён Шагдарыг орлон Дарханы ерөнхий захирал болсон.[107]

G. БЛТ-ИЙН ТӨМӨРТЭЙН ОРДЫГ АШИГЛАХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ӨРГӨДӨЛ

132. БЛТ болон ноён Хүдэрбат 1990–1992 оны тайланг (дээрх 128 дахь хэсгийг үзнэ үү) ашиглан Техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулсан бөгөөд уг үндэслэл нь БЛТ-ийн Төмөртэйн ордыг ашиглах тусгай зөвшөөрлийн өргөдлийн бүрэлдэхүүн хэсэг байсныг талууд зөвшөөрдөг. Нэхэмжлэгчдийн гэрч, ноён Баярцогтын мэдүүлснээр: "Ганголд, Баярхүү, Хүдэрбат нар ... БЛТ-ийн нэрийн өмнөөс архивт очиж, төрөл бүрийн тайлантай танилцсан".[108] Техник, эдийн засгийн үндэслэлийн зохиогчдын дунд ноён Хүдэрбатыг нэрлэсэн байна.[109]

133. Монголын Засгийн газар 1997 онд БЛТ-д Төмөртэйн ордыг ашиглах "тусгай зөвшөөрөл" олгосон.

> 1997 оны 6 дугаар сарын 21-нд Хөдөө аж ахуй, үйлдвэрийн сайд А/108 дугаар тушаал болон Ордыг ашиглах тусгай зөвшөөрлийн Т-30 дугаар гэрчилгээ ("Т-30 гэрчилгээ") гаргасан. Нэхэмжлэгчдийн үзэж байгаагаар уг гэрчилгээ нь БЛТ-д Төмөртэйн ордыг ашиглах эрх олгосон.[110] Т-30 гэрчилгээнд дараах байдлаар заасан:
>
> Монгол Улсын Хөдөө аж ахуй, үйлдвэрийн сайдын А/108 дугаар тушаалыг үндэслэн Сэлэнгэ аймгийн Хүдэр, Ерөө сумын нутагт байрлах Төмөртэй, Хуст-Уулын төмрийн ордыг ашиглах тусгай зөвшөөрлийг Улаанбаатар хотын БЛТ ХХК-д ... жилийн хугацаагаар олгов.[111]

Гэрчилгээний хугацааг заах маягтын хэсгийг бөглөөгүй байсан.

134. 1997 оны 6 дугаар сарын 30-нд Хөдөө аж ахуй, үйлдвэрийн сайд А/121 дугаар тушаал гаргаж, Т-30 гэрчилгээг түдгэлзүүлсэн.[112] Нэхэмжлэгчдийн гэрч, ноён Баярцогтын мэдүүлснээр:

> Т-30 тусгай зөвшөөрлийг БЛТ-д дөнгөж олгоод байсан тул түдгэлзүүлсэнд нь би гайхсан. Би сайд Нямсамбуугийн уулзалтад цаг авч, сайд БЛТ-ийн тусгай

---

[106] Дарханаас Эрчим хүч, геологи, уул уурхайн сайдад хүргүүлсэн албан бичиг, 1996 оны 6 дугаар сарын 5 (Баримт R-40).

[107] Төрийн өмчийн хорооны 2 дугаар тогтоол, 1996 оны 9 дугаар сарын 14 (Баримт R-51).

[108] Ноён Баярцогтын гэрчийн мэдүүлэг, догол мөрүүд 24-25.

[109] БЛТ, Төмөртэйн ордыг ашиглах техник, эдийн засгийн үндэслэл, 1997 оны 3 дугаар сар, хуудас 1 (Баримт C-17).

[110] Хөдөө аж ахуй, үйлдвэрийн сайдын А/108 дугаар тушаал, 1997 оны 6 дугаар сарын 21 (Баримт C-39); Орд ашиглах Т-30 дугаар тусгай зөвшөөрлийн гэрчилгээ (Баримт C-40).

[111] Орд ашиглах Т-30 дугаар тусгай зөвшөөрлийн гэрчилгээ (Баримт C-40).

[112] Хөдөө аж ахуй, үйлдвэрийн сайдын А/121 дугаар тушаал, 1997 оны 6 дугаар сарын 30 (Баримт C-41).

зөвшөөрлийг түдгэлзүүлэх ёсгүй гэж эсэргүүцсэн. Гэвч сайд энэ нь Засгийн газрын шийдвэр бөгөөд БЛТ нэмэлт мэдээлэл хүлээхээс өөр аргагүй гэж хэлсэн.[113]

135. 1997 оны 7 дугаар сарын 1-нд 1997 оны Ашигт малтмалын тухай хууль хүчин төгөлдөр болсон.[114] 1997 оны Дагаж мөрдөх журмын тухай хуулийн дагуу БЛТ 1997 оны 8 дугаар сарын 18-нд Т-30 гэрчилгээг 1997 оны Ашигт малтмалын тухай хуулийн дагуу шинэчлэн бүртгүүлэх хүсэлт гаргасан.[115] Үүний дараа БЛТ 1997 оны 9 дүгээр сар, 1998 оны 1 дүгээр сард Т-30 гэрчилгээний талаар Засгийн газарт дахин захидал хүргүүлсэн.[116]

136. 1998 оны 1 дүгээр сарын 16-нд Хөдөө аж ахуй, үйлдвэрийн яам А/07 дугаар тушаал гаргаж, А/121 дугаар тушаалаар Т-30 гэрчилгээг түдгэлзүүлснийг хүчингүй болгон, дараах байдлаар заасан —

> Ашигт малтмалын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 2, 3, 4, 5 дугаар зүйлийн дагуу Төмөртэй, Хуст-Уулын ордын ашиглалтын тусгай зөвшөөрлийг шинэчлэн бүртгэж, Хөдөө аж ахуй, үйлдвэрийн сайдын А/108 дугаар тушаалын нэг, хоёр дахь заалтыг үндэслэн БЛТ ХХК-д тусгай зөвшөөрөл олгохыг Ашигт малтмалын газрын дарга Д. Жаргалсайханд зөвшөөрсүгэй.[117]
>
> Шинэчилсэн энэхүү тусгай зөвшөөрлийг “939А тусгай зөвшөөрөл” гэж нэрлэдэг.

137. Яамны тушаалын дагуу БЛТ 1998 оны 1 дүгээр сарын 19-нд тусгай зөвшөөрлөө шинэчлэн авах хүсэлт гаргасан[118] бөгөөд 1998 оны 1 дүгээр сарын 28-нд Геологи, уул уурхайн хэлтэс 939А дугаар тусгай зөвшөөрөл олгосон.[119]

Н. БЛТ-ИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА БОЛОН ТӨМӨРТЭЙ ХҮДЭРИЙГ БАЙГУУЛСАН НЬ

138. 1997 оны 7 дугаар сарын 20-нд, Т-30 гэрчилгээг түдгэлзүүлснээс хойш удалгүй, БЛТ Чайна Хэйлунзянтай “Төмөртэйн төмрийн хүдрийн ордыг хамтран ашиглах тухай гэрээ” байгуулсан.[120] Ноён Ли уг гэрээг байгуулахад оролцсон бөгөөд өөрийн мэдүүлснээр тухайн үед Чайна Хэйлунзяны ерөнхий менежерийн туслах байсан, компаниас гэрээ байгуулах эрх олгосон байв. Талууд энэ нь заавал биелэгдэх гэрээ байсан уу, эсхүл албан бус харилцан

---

[113] Ноён Баярцогтын гэрчийн мэдүүлэг, догол мөр 42.

[114] 1997 оны Ашигт малтмалын тухай хууль (Эрх зүйн эх сурвалж RLA-84).

[115] БЛТ-ээс Геологи, уул уурхайн кадастрын газрын даргад гаргасан ашигт малтмал ашиглах тусгай зөвшөөрлийг дахин бүртгүүлэх хүсэлт, 1997 оны 8 дугаар сарын 18 (Баримт С-43).

[116] БЛТ-ээс Хөдөө аж ахуй, үйлдвэрийн яаманд хүргүүлсэн албан бичиг, 1997 оны 9 дугаар сарын 16 (Баримт С-185); БЛТ-ээс Ашигт малтмалын газарт хүргүүлсэн албан бичиг, 1998 оны 1 дугаар сарын 12 (Баримт С-44); БЛТ-ээс Хөдөө аж ахуй, үйлдвэрийн яаманд хүргүүлсэн албан бичиг, 1998 оны 1 дугаар сарын 13 (Баримт С-45).

[117] Хөдөө аж ахуй, үйлдвэрийн сайдын А/07 дугаар тушаал огноо: 1998 оны 1 дугаар сарын 16 (Баримт С-46).

[118] БЛТ-ээс Геологи, уул уурхайн газарт гаргасан хүсэлт, 1998 оны 1 дугаар сарын 19 (Баримт С-47).

[119] Ашигт малтмал ашиглах 939А дугаар тусгай зөвшөөрлийн гэрчилгээ, 1998 оны 1 дугаар сарын 28 (Баримт С-1).

[120] БЛТ болон Чайна Хэйлунзяны хооронд байгуулсан Төмөртэйн төмрийн хүдрийн ордыг хамтран хөгжүүлэх гэрээ, 1997 оны 7 дугаар сарын 20 (Баримт С-48).

ойлголцлын санамж бичиг байсан уу гэдэгт санал зөрөлддөг боловч уг гэрээний дагуу ямар нэгэн үйл ажиллагаа явуулсныг хэргийн материал нотлохгүй байна.

139. 1997 оны 12 дугаар сарын 2-нд ноён Ли Циньлуныг үүсгэн байгуулж, 1998 оны 6 дугаар сарын 1-нд БЛТ болон Циньлун "Монголын Төмөртэйн төмрийн хүдрийг хамтран ашиглах тухай гэрээ" байгуулсан.[121] Нэхэмжлэгчдийн мэдүүлснээр, "талууд эцэст нь 1998 оны хамтарсан үйлдвэрийн гэрээний дагуу үйл ажиллагаа явуулаагүй боловч дараагийн жилүүдэд Циньлун уурхайн бэлтгэл ажлыг санхүүжүүлсэн".[122]

140. 1998 оны 6 дугаар сарын 15-нд БЛТ Чайна Хэйлунзянтай хоёр дахь гэрээ байгуулсан[123] боловч мөн л бодит үйл ажиллагаа явуулаагүй. Нэхэмжлэгчдийн гэрч, ноён Баярцогтын мэдүүлснээр, тухайн үед БЛТ-ийн Чайна Хэйлунзянтай байгуулсан гэрээнүүд "бүгд хамтын ажиллагааны гэрээний шинжтэй байсан бөгөөд төсөл урагшлахын хэрээр дараагийн гэрээнүүдээр бодитоор орлогдсон".[124]

141. 2002 оны 6 дугаар сарын 18-нд БЛТ, MCS Holding LLC, Boroo Mining LLC нар консорциумын гэрээ байгуулсан бөгөөд уг гэрээнд "[хамтарсан үйлдвэрийн] Монголын хувьцаа эзэмшигч нь консорциум байна ... Монголын талыг (консорциумыг) БЛТ ХХК-ийн нэрээр төлөөлнө" гэж заасан.[125]

142. Маргааш нь буюу 2002 оны 6 дугаар сарын 19-нд БЛТ, Циньлун хоёр Төмөртэй Хүдэрийг байгуулах хоёр дахь хамтарсан үйлдвэрийн гэрээ байгуулсан.[126] Улмаар Төмөртэй Хүдэр 2002 оны 7 дугаар сарын 26-нд үүсгэн байгуулагдаж, хувьцааны 30 хувийг БЛТ, үлдэх 70 хувийг Циньлун эзэмшсэн.[127]

143. 2002–2004 онд БЛТ, Циньлун, Төмөртэй Хүдэр ордтой холбоотой цөөн тооны ажил хэрэгжүүлсэн бөгөөд үүнд:

    (a) 2002 оны 10 дугаар сарын 11-нд Төмөртэй Хүдэрт авто зам барих тусгай зөвшөөрөл олгосон.[128]

---

[121] БЛТ болон Циньлунийн хооронд байгуулсан Монголын Төмөртэйн төмрийн хүдрийн ордыг хамтран хөгжүүлэх гэрээ, 1998 оны 6 дугаар сарын 1 (Баримт С-49).

[122] Нэхэмжлэгчдийн Нэхэмжлэлийн үндэслэл, догол мөр 144.

[123] Монголын Улаанбаатар хотын «БЛТ» корпораци болон Чайна Хэйлунзяны хооронд байгуулсан Монголын Төмөртэйн төмрийн хүдрийн ордыг хамтран хөгжүүлэх гэрээ, 1998 оны 6 дугаар сарын 15 (Баримт С-184).

[124] Ноён Баярцогтын гэрчийн мэдүүлэг, догол мөр 55.

[125] Үзнэ үү: Төмөртэй Хүдэрийн хувьцаа эзэмшигчдийн түншлэлийн гэрээ (англи, хятад, монгол хэлний эхүүд), догол мөр 2, 2004 оны 12 дугаар сарын 23 (Баримт С-19).

[126] Төмөртэй Хүдэрийг байгуулах тухай БЛТ, Циньлунийн хамтарсан үйлдвэрийн гэрээ, 2002 оны 6 дугаар сарын 19 (Баримт С-18).

[127] Монголын Гадаадын хөрөнгө оруулалт, гадаад худалдааны агентлагийн А-615 дугаар тушаал, 2002 оны 7 дугаар сарын 26 (Баримт С-54); Төмөртэй Хүдэрийн гадаадын хөрөнгө оруулалттай компанийн 02-214 дугаар гэрчилгээ, 2002 оны 7 дугаар сарын 26 (Баримт С-6).

[128] Авто зам, замын байгууламж барих, засварлах 42 дугаар тусгай зөвшөөрөл, 2002 оны 10 дугаар сарын 11 (Баримт С-124).

(b) 2002 оны 10 дугаар сарын 14-нд Сэлэнгэ аймгийн Засаг дарга БЛТ-д Төмөртэйн ордын талбайд газар эзэмших эрх олгосон.[129]

(c) 2003 оны 3 дугаар сарын 20-нд Төмөртэй Хүдэр China Qinhuangdao Mingcheng Engineering Co. Ltd компанитай Төмөртэйн орд хүртэл авто зам барих гэрээ байгуулсан.[130]

(d) Мөн 2003 онд Төмөртэй Хүдэр Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний тайлан боловсруулсан.[131]

(e) 2004 оны 1 дүгээр сарын 28-нд Циньлун Huihua International Trading Co., Ltd компанитай уурхайн тоног төхөөрөмж худалдан авах гэрээ байгуулсан.[132]

(f) 2004 оны 4 дүгээр сарын 30-нд Төмөртэй Хүдэр түлш нийлүүлэх хэд хэдэн гэрээ байгуулсан.[133]

(g) 2004 оны 10 дугаар сарын 5-нд Ерөө сумын Засаг дарга Төмөртэй Хүдэрт авто зам барихад түгээмэл тархацтай ашигт малтмал ашиглах эрх олгосон.[134]

144. 2004 оны 1 дүгээр сарын 8-нд Циньлун Төмөртэй Хүдэрт эзэмшиж байсан хувьцааны 30 хувийг Бээжин Шоуганд шилжүүлэхээр тохиролцсон.[135] Нэхэмжлэгчдийн мэдүүлснээр, ойролцоогоор мөн үед Циньлун Төмөртэй Хүдэрийн хувьцааны 11 хувийг Чайна Хэйлунзянд шилжүүлсэн (ингэснээр Циньлуны эзэмшил 29 хувь болсон).[136] 2004 оны 12 дугаар сарын 23-нд БЛТ уг шилжүүлгийг зөвшөөрч, хувьцаа эзэмшигчид тус тусын эрхийн талаар түншлэлийн гэрээ байгуулсан.[137] 2005 оны 3 дугаар сарын 18-нд Монгол Улсын Улсын бүртгэлийн алба Бээжин Шоуган, Чайна Хэйлунзян нарыг Төмөртэй Хүдэрийн

---

[129] Сэлэнгэ аймгийн Засаг даргын 373 дугаар захирамж, 2002 оны 10 дугаар сарын 14 (Баримт С-51).

[130] Төмөртэй Хүдэр болон China Qinhuangdao Mingcheng Engineering Co. Ltd-ийн хооронд байгуулсан гэрээ, 2003 оны 3 дугаар сарын 20 (Баримт С-69).

[131] Төмөртэй Хүдэр, Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний тайлан, 2003 (Баримт С-86).

[132] Циньлун болон Zhangjiagang Free Trade Zone Huihua International Trading Co., Ltd-ийн хооронд байгуулсан гэрээ (уул уурхайн тоног төхөөрөмж худалдан авах), 2004 оны 1 дугаар сарын 28 (Баримт С-70).

[133] Төмөртэй Хүдэр болон MTDOil ХХК-ийн хооронд байгуулсан шатахуун нийлүүлэх гэрээ, 2004 оны 4 дугаар сарын 30 (Баримт С-71); Төмөртэй Хүдэр болон MTKhU-Oil ХХК-ийн хооронд байгуулсан шатахуун нийлүүлэх гэрээ, 2004 оны 4 дугаар сарын 30 (Баримт С-72); Төмөртэй Хүдэр болон MTBOil ХХК-ийн хооронд байгуулсан шатахуун нийлүүлэх гэрээ, 2004 оны 4 дугаар сарын 30 (Баримт С-73).

[134] Ерөө сумын Засаг даргын 107 дугаар захирамж, 2004 оны 10 дугаар сарын 5 (Баримт С-126).

[135] Циньлун болон Бээжин Шоуганы хооронд байгуулсан зорилгын бичиг, 2003 оны 12 дугаар сар (Баримт С-57); Циньлун болон Бээжин Шоуганы хооронд байгуулсан хувьцаа шилжүүлэх гэрээ, 2004 оны 1 дугаар сарын 8 (Баримт С-56).

[136] Нэхэмжлэгчдийн Нэхэмжлэлийн үндэслэл, догол мөр 149.

[137] Төмөртэй Хүдэрийн хувьцаа эзэмшигчдийн түншлэлийн гэрээ, 2004 оны 12 дугаар сарын 23 (Баримт С-19).

гадаадын хөрөнгө оруулагчаар бүртгэсэн.[138] Дараа нь Монгол Улсын Гадаадын хөрөнгө оруулалт, гадаад худалдааны агентлагийн дарга 2005 оны 5 дугаар сарын 16-нд Бээжин Шоуган, Чайна Хэйлунзян нарыг Төмөртэй Хүдэрийн хувьцаа эзэмшигчээр зөвшөөрч,[139] 2005 оны 6 дугаар сарын 15-нд Төмөртэй Хүдэрийн гадаадын хөрөнгө оруулалттай компанийн гэрчилгээг дахин олгосон.[140]

145. 2005 оны 2 дугаар сарын 17-нд БЛТ Төмөртэй Хүдэртэй хамтын ажиллагааны гэрээ байгуулж, 939А тусгай зөвшөөрлийг Төмөртэй Хүдэрт шилжүүлэх хүсэлтийг Геологи, уул уурхайн кадастрын хэлтэст гаргасан.[141] 2005 оны 3 дугаар сарын 7-нд Ашигт малтмал, газрын тосны хэрэг эрхлэх газар уг шилжүүлгийг зөвшөөрснөө Төмөртэй Хүдэрт мэдэгдсэн.[142]

146. 2005 оны 1 дүгээр сарын 12-нд Төмөртэй Хүдэр Сэлэнгэ аймгийн Засаг дарга болон Хүдэр, Шаамар, Ерөө сумдын Засаг дарга нартай хамтын ажиллагааны гэрээ байгуулсан.[143] Үүний дараа 2005 онд:

(а) 2005 оны турш Төмөртэй Хүдэр, БЛТ хоёр Хүдэр, Жавхлант, Шаамар сумдын Засаг даргаас газар эзэмших хэд хэдэн эрх авсан.[144]

---

[138] Төмөртэй Хүдэрийн улсын бүртгэлийн 23/1296 дугаар гэрчилгээ огноо: 2002 оны 8 дугаар сарын 5 (Баримт С-63), хуудас 2; Нэхэмжлэгчдийн Нэхэмжлэлийн үндэслэл, 151.

[139] Монголын Гадаадын хөрөнгө оруулалт, гадаад худалдааны агентлагийн А-470 дугаар тушаал огноо: 2005 оны 5 дугаар сарын 16 (Баримт С-64).

[140] Төмөртэй Хүдэрийн гадаадын хөрөнгө оруулалттай компанийн 02-214 дугаар гэрчилгээ огноо: 2005 оны 6 дугаар сарын 16 (Баримт С-7).

[141] БЛТ болон Төмөртэй Хүдэрийн хооронд байгуулсан хамтран ажиллах гэрээ, 2005 оны 2 дугаар сарын 17 (Баримт С-58); Геологи, уул уурхайн кадастрын газрын даргад БЛТ-ээс гаргасан тусгай зөвшөөрөл шилжүүлэх хүсэлт, 2005 оны 2 дугаар сарын 17 (Баримт С-59); БЛТ-ээс Ашигт малтмал, газрын тосны хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн албан бичиг, 2005 оны 2 дугаар сарын 17 (Баримт С-61).

[142] Ашигт малтмал, газрын тосны хэрэг эрхлэх газраас Төмөртэй Хүдэрт хүргүүлсэн албан бичиг огноо: 2005 оны 3 дугаар сарын 7 (Баримт С-62).

[143] Төмөртэй Хүдэр болон Сэлэнгэ аймгийн Засаг даргын хооронд байгуулсан хамтран ажиллах гэрээ, 2005 оны 1 дугаар сарын 12 (Баримт С-82); Төмөртэй Хүдэр болон Хүдэр сумын Засаг даргын хооронд байгуулсан хамтран ажиллах гэрээ, 2005 оны 1 дугаар сарын 12 (Баримт С-83); Төмөртэй Хүдэр болон Шаамар сумын Засаг даргын хооронд байгуулсан хамтран ажиллах гэрээ, Огноогүй (Баримт С-84); Төмөртэй Хүдэр болон Ерөө сумын Засаг даргын хооронд байгуулсан хамтран ажиллах гэрээ, 2005 оны 1 дугаар сарын 12 (Баримт С-85).

[144] Хүдэр сумын Засаг даргын 4 дугаар захирамж, 2005 оны 1 дугаар сарын 18 (Баримт С-127); Хүдэр сумын Засаг даргын 5 дугаар захирамж, 2005 оны 1 дугаар сарын 18 (Баримт С-128); Хүдэр сумын Засаг даргын 27 дугаар захирамж, 2005 оны 3 дугаар сарын 3 (Баримт С-129); Жавхлант сумын Засаг даргын 20 дугаар захирамж, 2005 оны 3 дугаар сарын 4 (Баримт С-130); Шаамар сумын Засаг даргын 105 дугаар захирамж, 2005 оны 5 дугаар сарын 18 (Баримт С-131); Шаамар сумын Засаг даргын 177 дугаар захирамж, 2005 оны 10 дугаар сарын 26 (Баримт С-132); Хүдэр сумын Засаг даргын 85 дугаар захирамж, 2005 оны 12 дугаар сарын 1 (Баримт С-133); Хүдэр сумын Засаг даргын 55 дугаар захирамж, 2006 оны 5 дугаар сарын 15 (Баримт С-134).

(b) 2005 оны 5 дугаар сарын 2-нд БЛТ Ашигт малтмал, газрын тосны хэрэг эрхлэх газартай “Улсын төсвийн хөрөнгөөр санхүүжүүлсэн хайгуулын ажлын зардлыг нөхөн төлөх тухай” гэрээ байгуулсан.[145]

(c) 2005 оны 5 дугаар сарын 24-нд Төмөртэй Хүдэр Монголын Засгийн газрын зөвшөөрөлтэйгээр Хятадын Экспорт-Импортын банктай 200 сая юанийн зээлийн гэрээ байгуулсан.[146]

(d) 2005 оны 10 дугаар сарын 5-нд Циньлун Qinhuangdao Engineering and Research Institute for Metallurgical Industry MMI байгууллагатай “Монголын Төмөртэйн төмрийн уурхайн олборлолт, баяжуулалтын төслийн урьдчилсан зураг төсөл” боловсруулах гэрээ байгуулсан.[147]

(e) 2005 оны 10 дугаар сарын 6-нд Төмөртэй Хүдэр “Төмөртэйн төмрийн хүдрийн ордын 2005–2006 оны уулын ажлын төлөвлөгөө”-г баталсан.[148]

(f) 2005 оны явцад Төмөртэй Хүдэр байгаль орчинд нөлөөлөх байдлын нэмэлт үнэлгээ болон байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө боловсруулсан.[149]

(g) 2005 оны 12 дугаар сарын 16-нд Төмөртэй Хүдэр тэсэлгээний зөвшөөрөл авах хүсэлт гаргасан.[150]

147. 2005 оны 10 дугаар сарын 4-нд БЛТ Сангийн яаманд захидал хүргүүлж, хийсэн ажлынхаа талаар дараах байдлаар мэдээлсэн:

> Сүүлийн жилүүдэд бид ордуудыг ашиглах судалгаа, эдийн засгийн судалгааг боловсруулж, үйлдвэрийн төсөл болон тосгон байгуулах төлөвлөгөөг дуусгасан. Энэ төслийг хэрэгжүүлснээр ил уурхайгаас жилд 1.5 сая тонн төмрийн хүдрийн баяжмал гарган авч, 800 мянган тонн төмрийн хорголж экспортлох боломжтой. Төслийн хүчин чадлыг бүрэн ашиглавал жилд 70 тэрбум төгрөгийн борлуулалт хийх боломжтой. Ордын нөөц 232 сая тонн бөгөөд төслийн хүчин чадлаар 60 жил ашиглана. Талбайд иж бүрэн хайгуул үргэлжлүүлэн хийвэл нөөц 3–4 дахин нэмэгдэх боломжтой.

---

[145] Ашигт малтмал, газрын тосны хэрэг эрхлэх газар болон БЛТ-ийн хооронд байгуулсан улсын төсвийн хөрөнгөөр санхүүжүүлсэн хайгуулын ажлын зардлыг нөхөн төлөх гэрээ, 2005 оны 5 дугаар сарын 2 (Баримт С-187).

[146] Хөнгөлөлттэй зээл олгох тухай Монгол, Хятадын харилцан ойлголцлын санамж бичиг, 2005 оны 5 дугаар сарын 24 (Баримт С-139); Төмөртэй Хүдэр болон Хятадын Экспорт-Импортын банкны хооронд байгуулсан зээлийн гэрээ, 2005 оны 5 дугаар сарын 24 (Баримт С-140).

[147] Циньлун болон Qinhuangdao Engineering and Research Institute for Metallurgical Industry MMI-ийн хооронд байгуулсан гэрээ, 2005 оны 10 дугаар сарын 5 (Баримт С-74).

[148] Төмөртэй Хүдэр, Төмөртэйн төмрийн хүдрийн ордын 2005–2006 оны олборлолтын төлөвлөгөө, 2005 оны 10 дугаар сарын 6 (Баримт С-23).

[149] Төмөртэй Хүдэр, Төмөртэйн төмрийн хүдрийн ордын байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний тайлан (нэмэлт тодруулга), 2005 (Баримт С-87); Төмөртэй Хүдэр, Сэлэнгэ аймгийн Хүдэр суманд байрлах Төмөртэйн төмрийн ордын ил уурхайн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, 2005 (Баримт С-88).

[150] Төмөртэй Хүдэрээс Үйлдвэр, худалдааны яаманд гаргасан хүсэлт, 2005 оны 12 дугаар сарын 16 (Баримт С-144).

Одоогоор барилга байгууламж, машин механизм, тоног төхөөрөмж, хайгуулын ажил, төслийн баримт бичиг, авто зам, төмөр зам болон эрчим хүчний асуудлыг шийдвэрлэхэд нийт 15 тэрбум орчим төгрөгийн хөрөнгө оруулалт хийсэн бөгөөд энэ хэмжээ 150 тэрбум төгрөгт хүрнэ. Засгийн газрын 2003 оны 194 дүгээр тогтоолоор Дулаанхаан (Ерөө төмөр замын өртөө)-аас орд хүртэл 96 км төмөр зам барих тусгай зөвшөөрөл авсан. Үүний дагуу төмөр замын далан болон замын барилгын ажлыг дуусгасан. Аймаг, сумдаас авто зам барих зөвшөөрлүүдийг мөн авсан. Энэ жил Улаанбаатар төмөр замтай хамтран ойролцоогоор 60 сая төгрөгийн төсвөөр Дулаанхааны төмөр замын өргөтгөлийн ажлыг эхлүүлсэн. Мөн 11 дүгээр сараас зам барих ажлыг эхлүүлэхээр байна. Уг зам нь Сэлэнгэ аймгийн Шаамар, Жавхлант, Ерөө, Хүдэр зэрэг таван сумын нутгийг дайрсан, 24.5 км зайтай таван зөрлөгтэй байна. Гол тээвэрлэлтийг Төмөртэйн ордоос хийх боловч орон нутгийн жилд 100 мянган тонн ачааг мөн тээвэрлэнэ.

Сүхбаатар–Замын-Үүд, Дархан–Эрдэнэтийн төмөр замыг барихад даланд ашигласан түгээмэл тархацтай ашигт малтмалыг үнэ төлбөргүй олгож байсан. Иймд 96 км төмөр замын даланд хэрэглэх түгээмэл тархацтай ашигт малтмалын төлбөрийг бууруулах буюу чөлөөлөхийг нутгийн хуралд хүссэн. Хүсэлтийг нааштай шийдвэрлэвэл тээврийн төлбөр Улаанбаатар төмөр замын тарифтай ижил байна.

Манай компани Төмөртэйн орд хүртэл 50 км шинэ авто зам барьж, Дулаанхаан хүртэл 70 км замыг зассан. Иймээс авто замтай холбоотой бүх асуудлыг бүрэн шийдвэрлэсэн. Замын ажилд ойролцоогоор 480 сая төгрөг зарцуулсан. Мөн Сүхбаатар–Хүдэрийн 35 кВ-ын шугамд холбож, цахилгааны асуудлыг эцэслэн шийдвэрлэсэн. Энэ ажилд 120 сая төгрөг зарцуулсан. Цаашид Дархан–Бугантын 110 кВ-ын шугам болон ОХУ-ын Галуу нуур–Хүдэрийн шугамд холбогдохоор төлөвлөж байна. Ингэснээр цахилгааны найдвартай холболт бүрдэнэ. Цахилгааны жилийн хэрэгцээ ойролцоогоор 17 сая кВт·ц байна.

Түүнчлэн гидрогеологийн болон төмрийн хүдрийн нөөцийг нэмэгдүүлэх хайгуулын ажил хийж байна. Энэ ажилд 2,500 сая төгрөг зарцуулсан. БНХАУ-ын холбогдох мэргэжлийн байгууллагууд Монголын талтай хамтран төмөр зам, үйлдвэрийн төслүүдийг дуусгаж байна.[151]

148. 2005 оны 12 дугаар сард Сэлэнгэ аймгийн Засаг даргын Тамгын газрын Үйлдвэрлэл, дэд бүтэц, байгаль орчны бодлогын зохицуулалтын хэлтсийн дарга Төмөртэй Хүдэрт Төмөртэйн ордыг ашиглах зөвшөөрөл олгосон.[152]

149. 2006 онд Төмөртэй Хүдэр уурхайн үйл ажиллагаатай холбоотой хэд хэдэн гэрээ байгуулсан бөгөөд хэргийн материалд дараах байдлаар тусгасан:

(а) 2006 оны 1 дүгээр сарын 2-нд Төмөртэй Хүдэр “Хустай Ерөө” ХХК-тай хамтын ажиллагааны гэрээ байгуулсан.[153]

---

[151] БЛТ-ээс Сангийн сайдад хүргүүлсэн албан бичиг, 2005 оны 10 дугаар сарын 4 (Баримт С-191).

[152] Сэлэнгэ аймгийн Засаг даргын Тамгын газраас Хүдэр сумын Засаг даргад хүргүүлсэн албан бичиг огноо: 2005 оны 12 дугаар сарын 27 (Баримт С-90).

[153] Төмөртэй Хүдэр болон Хустай Ерөө ХХК-ийн хооронд байгуулсан хамтран ажиллах гэрээ, 2006 оны 1 дугаар сарын 2 (Баримт С-65).

(b) 2006 оны 3 дугаар сарын 22-нд Төмөртэй Хүдэр “Илч Түлш” ХХК-тай тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл худалдан авах гэрээ байгуулсан.[154]

(c) 2006 оны 4 дүгээр сарын 17-нд Төмөртэй Хүдэр “Хар Луу” ХХК-тай харуул хамгаалалтын үйлчилгээ үзүүлэх гэрээ байгуулсан.[155]

(d) 2006 оны 4 дүгээр сарын 28-нд Төмөртэй Хүдэр Mongolian Insurance Group Co. компанитай даатгалын гэрээ байгуулсан.[156]

(e) 2006 оны 5 дугаар сарын 9-нд Төмөртэй Хүдэр “Бласт” ХХК-тай тэсэрч дэлбэрэх бодис, тэслүүр худалдах, худалдан авах гэрээ байгуулсан.[157]

(f) 2006 оны 5 дугаар сарын 29-нд Төмөртэй Хүдэр “Эко Натур” ХХК-тай байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ боловсруулах гэрээ байгуулсан.[158]

(g) 2006 оны 6 дугаар сарын 2-нд Төмөртэй Хүдэр Mongolian Highway Co., Ltd компанитай Дулаанхаанаас Төмөртэйн орд хүртэлх авто замыг барих, засварлах, арчлах гэрээ байгуулсан.[159]

(h) 2006 оны 6 дугаар сарын 5-нд Төмөртэй Хүдэр Ашигт малтмал, газрын тосны хэрэг эрхлэх газартай улсын төсвийн хөрөнгөөр санхүүжүүлсэн хайгуулын ажлын зардлыг нөхөн төлөх гэрээ байгуулсан.[160]

I. ТӨМӨРТЭЙ ХҮДЭРИЙН ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙГ ХҮЧИНГҮЙ БОЛГОСОН НЬ

150. 2001 оны эхээр ноён Д. Эрдэнэцог (“Эрдэнэцог”) ноён Нацагдоржийг орлон Дарханы ерөнхий захирал болсон.[161]

151. Ноён Эрдэнэцог захирлын албыг хүлээн авсны дараа, 2001 оны 4 дүгээр сарын 13-нд Дархан Үйлдвэр, худалдааны яамны Ашигт малтмалын газарт захидал хүргүүлж, БЛТ-д 939А тусгай зөвшөөрөл олгосонд гомдол гарган, уг тусгай зөвшөөрлийг хүчингүй болгохыг хүссэн. Дарханы захидал дараах агуулгатай байв:

---

[154] Төмөртэй Хүдэр болон Илч Түлш ХХК-ийн хооронд байгуулсан тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл худалдан авах гэрээ, 2006 оны 3 дугаар сарын 22 (Баримт С-65).

[155] Төмөртэй Хүдэр болон Хар Луу ХХК-ийн хооронд байгуулсан хамгаалалтын үйлчилгээ үзүүлэх гэрээ, 2006 оны 4 дугаар сарын 17 (Баримт С-77)

[156] Төмөртэй Хүдэр болон Mongolian Insurance Group Co.-ийн хооронд байгуулсан даатгалын гэрээ, 2006 оны 4 дугаар сарын 28 (Баримт С-78).

[157] Төмөртэй Хүдэр болон Бласт ХХК-ийн хооронд байгуулсан тэсрэх бодис, тэслүүр худалдах, худалдан авах гэрээ, 2006 оны 5 дугаар сарын 9 (Баримт С-79).

[158] Төмөртэй Хүдэр болон Эко Натур ХХК-ийн хооронд байгуулсан байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ боловсруулах гэрээ, 2006 оны 5 дугаар сарын 29 (Баримт С-80).

[159] Төмөртэй Хүдэр болон Mongolian Highway Co., Ltd-ийн хооронд байгуулсан Дулаанханаас Төмөртэйн орд хүртэлх замыг барих, засварлах, арчлах гэрээ, 2006 оны 6 дугаар сарын 2 (Баримт С-81).

[160] Ашигт малтмал, газрын тосны хэрэг эрхлэх газар болон Төмөртэй Хүдэрийн хооронд байгуулсан улсын төсвийн хөрөнгөөр санхүүжүүлсэн хайгуулын ажлын зардлыг нөхөн төлөх гэрээ 2006 оны 6 дугаар сарын 5 (Баримт С-9).

[161] Үзнэ үү: Хариуцагчийн Хариу үндэслэл, догол мөр 82.

Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Сайд нарын Зөвлөлийн 160 дугаар тогтоолын хоёр дахь хэсэгт "... Төмөрлөгийн үйлдвэрийн цогцолборын төмөр хайлуулах, цувих үйлдвэрийг 1990–1993 онд, төмрийн хүдрээс ангижруулсан төмөр үйлдвэрлэх үйлдвэрийг 1993–1995 онд барьж ашиглалтад оруулах", гурав дахь хэсэгт "Төмөртэйн төмрийн ордод тулгуурласан хүдэр олборлох ил уурхайг 1994 оны эцэс гэхэд байгуулж, уг уурхай болон Төмөрлөгийн үйлдвэрийн цогцолборыг нэгтгэн Төмөрлөгийн үйлдвэрийн комбинат болгон өөрчлөн зохион байгуулах" гэж заасан.

Дээрх заалтуудыг хэрэгжүүлэх зорилгоор үйлдвэр хөрөнгө, хүч гаргаж, одоогийн "Алмаз" компанид нарийвчилсан хайгуул, нөөцийн тооцоо хийлгэн, дээж болон бусад үр дүнг өөрийн хяналтад авч, харуулаар хамгаалуулсан. Төмөртэй, Төмөртолгойн ордууд шууд ангижруулахад тохирох эсэхийг үнэлэхээр Их Британийн Davy McKay, Германы Mannes Demag, Lurgi, Японы Kiwasaki, Энэтхэгийн Simmko, ОХУ-ын /Ленинград/ Hyprorud байгууллагуудаар лабораторийн болон хагас үйлдвэрийн туршилт хийлгэж, тодорхой дүгнэлт гаргуулсан. Шууд ангижруулах үйлдвэр байгуулах олон улсын тендер зарлаж, дээрх корпорац, компаниуд үнийн саналаа ирүүлсэн.

Гэвч Геологи, уул уурхайн кадастрын хэлтэс 1997 онд Дарханы төмөрлөгийн үйлдвэрийн Төмөртэй, Баянгол, Хуст-Уулын төмрийн ордын тусгай зөвшөөрлийг "БЛТ" ХХК-д, Төмөртолгойн ордын тусгай зөвшөөрлийг "Хар Морит" ХХК-д олгож, эдгээр ордыг 100 жилийн хугацаагаар үнэ төлбөргүй ашиглах боломж олгосон. Монголын хаягдал төмрийн нөөц дуусаж байгаа тул бид төмрийн хүдэр олборлож, боловсруулах ажиллагаа явуулахаар төлөвлөж байсан. Гэвч дээрх төмрийн ордууд хувийн компаниудын хяналтад орсноос үйлдвэрийн цаашдын төлөв тодорхойгүй болж, удахгүй үйл ажиллагаагаа зогсоох нөхцөлд хүрээд байна.

Тусгай зөвшөөрөл авсан дээрх компаниуд 3–4 жилийн хугацаанд ямар нэгэн олборлолт явуулаагүй. Одоо Монгол Улсын Газрын хэвлийн тухай хуулийн нэгдүгээр бүлгийн 1.3-т заасан "улсын буюу нийтийн хэрэгцээнд газрын хэвлийг буцаан авах зайлшгүй шаардлага гарсан" үндэслэл, мөн 2.1-д заасан "газрын хэвлийг олгосноос хойш 3 жилийн дотор ашиглаж эхлээгүй" үндэслэлээр газрын хэвлий ашиглах эрхийг дуусгавар болгож болно. Иймд Монголын цорын ганц төмөрлөгийн үйлдвэрийн цаашдын төлөвийг сайжруулах зорилгоор хуулийн дээрх заалтуудын дагуу "БЛТ" ХХК, "Хар Морит" ХХК-д олгосон тусгай зөвшөөрлийг дахин авч үзэж, манай үйл ажиллагаанд туслах хариу өгнө үү.[162]

152. 2001 оны 5 дугаар сарын 8-нд Дархан Монголын төмөрлөгчдийн холбоонд мөн захидал хүргүүлж, Төмөртэйн ордын тусгай зөвшөөрөл эзэмшдэг хувийн компаниуд ажлаа эхлээгүйг мэдэгдэн, Дарханы ашиг сонирхлыг хамгаалахад холбооны туслалцааг хүссэн.[163]

153. 2001 оны 5 дугаар сарын 22-нд Геологи, уул уурхайн кадастрын хэлтэс Дарханд дараах хариуг өгсөн:

[...] Дээрх тусгай зөвшөөрлүүдийг олгохоос өмнө Дархан-Уул аймаг дахь Дарханы төмөрлөгийн үйлдвэр /төрийн өмчит аж ахуйн нэгж/-ээс Сэлэнгэ аймгийн Хүдэр

[162] ДТҮ-ээс Ашигт малтмалын газарт хүргүүлсэн албан бичиг, 2001 оны 4 дугаар сарын 13 (Баримт C-92/R-29).

[163] Дарханаас Төмөрлөгчдийн холбоонд хүргүүлсэн албан бичиг, 2001 оны 5 дугаар сарын 8 (Баримт R-48).

сумын нутаг дахь Төмөртэй, Хустайн талбайн ордуудад хайгуул, ашиглалтын тусгай зөвшөөрөл хүссэн аливаа захидал, өргөдөл, хүсэлтийг Ашигт малтмалын газар болон түүний Геологи, уул уурхайн кадастрын хэлтэст ирүүлээгүй. Тусгай зөвшөөрөл эзэмшигч НГБ Спектрум ХХК, БЛТ ХХК нар эдгээр тусгай зөвшөөрлийг эзэмших эрхээ алдаагүй бөгөөд 2914Х, 939Х, 940Х тусгай зөвшөөрлүүд хүчинтэй хэвээр байна. Та манай хэлтэст ирүүлсэн захидалдаа Газрын хэвлийн тухай хуулийн 21 дүгээр зүйлд үндэслэн газрын хэвлий ашиглах эрхийг дуусгавар болгох тодорхой үндэслэлүүдийг дурдаж, дээрх тусгай зөвшөөрлүүдийг олгосон шийдвэрээ дахин авч үзэхийг хүсжээ.

1. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд бусдын өмчийг төрийн өмчид албадан авах шийдвэр гаргах, эсхүл бусдын өмчийг төрийн өмчид албадан авах асуудлыг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх нь Засгийн газрын бүрэн эрх бөгөөд ийм шийдвэр гаргах эрх зөвхөн Улсын Их Хуралд хадгалагдана гэж заасан. Энэ хуулийн дагуу бусдын тусгай зөвшөөрөлтэй талбайг улсын хэрэгцээнд албадан авах эрхийг Улсын Их Хурал, Засгийн газарт олгосон. Гэвч Дархан-Уул, Сэлэнгэ аймагт байрлах хайгуул, ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй талбай буюу төмрийн ордуудыг улсын хэрэгцээнд буцаан авах зайлшгүй шаардлагын талаар Улсын Их Хурал, Засгийн газрын ямар нэгэн тогтоол, шийдвэр Ашигт малтмалын газар болон түүний Кадастрын хэлтэст ирээгүй. Мөн газрын хэвлийг нийтийн хэрэгцээнд буцаан авах зайлшгүй шаардлагын талаар нутгийн өөрөө удирдах байгууллага болон нутгийн захиргааны ийм тогтоол, шийдвэр ирээгүй.

2. Ашиглалтын 939А, 940А дугаар тусгай зөвшөөрөл эзэмшигч БЛТ ХХК Геологи, уул уурхайн кадастрын хэлтсээс эдгээр зөвшөөрлийг авснаас хойш 3 жил өнгөрсөн. Энэ хугацаанд БЛТ ХХК олборлолт явуулаагүй, эсхүл хуульд заасан нөхцөл, шаардлага, журмын дагуу зохистой, үр ашигтай үйл ажиллагаа явуулаагүйг нотлох үндэслэл, баримт бүхий төрийн байгууллага, мэргэжлийн хяналтын байгууллагын захидал, акт, албан шаардлага, эсхүл нутгийн захиргааны байгууллагын зөвлөмж, дүгнэлт, мэдэгдэл бидэнд ирээгүй. Иймд газрын хэвлийг олгосноос хойш 3 жилийн дотор ашиглаагүй гэх үндэслэл, эсхүл улсын буюу нийтийн хэрэгцээнд газрын хэвлийг буцаан авах зайлшгүй шаардлага гэсэн үндэслэлээр Газрын хэвлийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн дагуу тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн эрхийг Геологи, уул уурхайн кадастрын хэлтэс дуусгавар болгох боломжгүй гэж үзэж байна.[164]

154. Үүний дараа, 2002 оны 2 дугаар сарын 7-нд Дархан Үйлдвэр, худалдааны яаманд 160 дугаар тогтоол болон Төмөртэйн ордтой холбоотой нэмэлт баримтууд хүргүүлж, “Кадастрын хэлтсээс “БЛТ” ХХК-д олгосон 939А, 940А дугаар ашиглалтын тусгай зөвшөөрлийг хүчингүй болгож, Төмөртэйн ордод үйл ажиллагаа явуулах манай хүчин чармайлтад туслах”-ыг хүссэн.[165]

155. 2002 оны 3 дугаар сарын 14-нд Хүдэр сумын Засаг дарга Төмөртэйн ордын талаарх Дарханы байр суурийг дэмжиж, Сэлэнгэ аймгийн Засаг даргад захидал хүргүүлэн 939А тусгай зөвшөөрлийг Дарханд шилжүүлэх саналыг холбогдох байгууллагуудад тавихыг

[164] Геологи, уул уурхайн кадастрын газрын даргаас ДТҮ-д хүргүүлсэн албан бичиг, 2001 оны 5 дугаар сарын 22 (Баримт С-93/R-49).

[165] Дарханаас Үйлдвэр, худалдааны яаманд хүргүүлсэн албан бичиг, 2002 оны 2 дугаар сарын 7 (Баримт R-32/R-63).

хүссэн.[166] Сэлэнгэ аймгийн Засаг дарга уг хүсэлтийг Ашигт малтмалын газрын дарга болон Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргад уламжилсан.[167]

156. Үүнээс хойш 2005 он хүртэл 939А тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох оролдлогын тухай нотлох баримт хэргийн материалд байхгүй. 2005 оны 10 дугаар сард Засгийн газар ойролцоох Төмөртолгойн төмрийн хүдрийн ордын тусгай зөвшөөрлийг хүчингүй болгож, Дарханд шилжүүлсэн.[168]

157. 2005 оны 4 дүгээр сарын 24-нд Сэлэнгэ аймгийн Мэргэжлийн хяналтын хэлтэс Төмөртэй Хүдэрт захидал хүргүүлж, тус компанийн тухайн үе хүртэлх үйл ажиллагааны талаарх дүгнэлтээ танилцуулсан. Тайланд дараах байдлаар заасан:

> Аймгийн Мэргэжлийн хяналтын хэлтсийн даргын өгсөн удирдамжийн дагуу аймгийн Татварын хэлтсийн дарга Батболдоор ахлуулсан, байгаль орчин, геологи, уул уурхайн улсын байцаагч Д. Төртогтох болон аймгийн Засаг даргын Тамгын газрын мэргэжилтэн Даваадорж нарын бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг 2006 оны 4 дүгээр сарын 5-нд Төмөртэйн ордыг ашиглаж буй Төмөртэй Хүдэр ХХК, Хустайн ордыг ашиглаж буй Хустай Ерөө ХХК-ийн үйл ажиллагаанд шалгалт хийж, дүгнэлт гаргав.
>
> Нэг. Төмөртэй ХХК болон Хустай Ерөө ХХК-ийн тухай
>
> Баярцогт захиралтай БТЛ ХХК нь 1997 онд байгуулагдаж, Хүдэр сумын Төмөртэй, Ерөө сумын Хустайн талбайд ашиглалтын тусгай зөвшөөрөл авсан бөгөөд 2001 онд Хүдэр сумын Төмөртэйд төмрийн хүдрийг боловсруулан хорголж үйлдвэрлэх төсөл хэрэгжүүлж эхэлсэн. Төслийн хүрээнд Төмөртэйгээс Дулаанхаан хүртэл авто зам, төмөр зам барихаар төлөвлөсөн. Одоогоор Ерөө сумын Бугантаас Төмөртэй хүртэл өндөр хүчдэлийн цахилгаан дамжуулах шугам, захиргаа, зочид буудлын зориулалттай хоёр давхар барилга, Төмөртэйгээс Ерөө хүртэл 45 км сайжруулсан зам барьсан. Гэвч төслийн гол ажил болох Төмөртэйн боловсруулах үйлдвэрийн суурийг тавиагүй, төмөр замын барилгын ажил эхлээгүй, трассын судалгаанаас бусад бүх ажил удаашралтай байна. Түүнчлэн төмрийн хүдрийн ашиглалтаас харахад ямар нэгэн боловсруулалт хийхгүйгээр хүдрийг гадаадад экспортлох нь компанид ашигтай байгаа нь илэрхий байв.
>
> БТЛ ХХК нь Ерөө сумын Хустайн төмрийн ордод тулгуурлан 2003 онд Хустай Ерөө ХХК-ийг байгуулж, 2003 онд 28,000 тонн, 2004 онд 80,000 тонн хүдэр экспортолсон. Аж ахуйн нэгжээ аймаг, орон нутагт бүртгүүлээгүй атлаа Хустай Ерөө дээр нэмж Төмөртэй Хүдэр ХХК-ийг байгуулан, баримт бичиггүйгээр 2005

---

[166] Хүдэр сумын Засаг даргаас Сэлэнгэ аймгийн Засаг даргад хүргүүлсэн албан бичиг, 2002 оны 3 дугаар сарын 14 (Баримт R-62).

[167] Р. Нямсүрэнгээс Сэлэнгэ аймгийн Засаг даргад хүргүүлсэн албан бичиг, 2002 оны 3 дугаар сарын 15 (Баримт R-42); Р. Нямсүрэнгээс Ашигт малтмалын газрын дарга Н. Жаргалсайханд хүргүүлсэн албан бичиг, 2002 оны 3 дугаар сарын 15 (Баримт R-56); Сэлэнгэ аймгийн Засаг даргаас Ашигт малтмалын газарт хүргүүлсэн албан бичиг, 2002 оны 3 дугаар сарын 15 (Баримт R-59).

[168] Нэхэмжлэгчдийн Нэхэмжлэлийн үндэслэл, догол мөр 166; Отгонжаргал, «Төмрийн орд монголчуудад “буцаж ирлээ”», Ардын эрх, 2005 оны 10 дугаар сарын 28 (Баримт C-94), Болор, «Алдсан баялаг Монголд буцаж ирлээ», Өнөөдөр, 2005 оны 10 дугаар сарын 28 (Баримт C-95).

онд нийт 166,400 тонн хүдэр экспортолсон. Өөрсдийн мэдээлснээр (газар дээрх олборлолтын ул мөр үүнээс ч их байгааг харуулж байна), 2006 оны I улиралд, 2006 оны 4 дүгээр сарын 5-ны байдлаар 34,100 тонн хүдэр олборлож, Ашигт малтмалын тухай хуульд шаардсан Тогтвортой байдлын гэрээ байгуулаагүйгээр БНХАУ руу тээвэрлэсэн.

Хоёр. Шалгалтаар илэрсэн зөрчлүүд

1. Газрын төлбөр төлөхгүйгээр ашиглалт явуулсан нь Монгол Улсын Газрын тухай хуулийн 3.1.8, 7.1, 27.2-ыг зөрчсөн.

2. Уурхайн талбайн хилийн тэмдэглэгээг тогтоолгоогүй нь Ашигт малтмалын тухай хуулийн 27.1-ийг зөрчсөн.

3. (Тэд) уурхайн нөөцийг тооцох нөөцийн үнэлгээний тайлан, техник, эдийн засгийн үндэслэл, хэмжилтийн төлөвлөгөөгүйгээр үйл ажиллагаа явуулсан.

4. (Тэд) байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ, байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөг аймаг, сум, хяналтын хэлтэст хүргүүлээгүй бөгөөд холбогдох байгууллагаас зөвшөөрөл авалгүйгээр ашиглалт явуулсан. Энэ нь Ашигт малтмалын тухай хуулийн 30.4.6, 30.4.7-г зөрчсөн.

5. Ашигт малтмал ашиглагч, эзэмшигчийн байгаль орчныг хамгаалах үүргийн тухай заалтуудыг биелүүлээгүй. Энэ нь Ашигт малтмалын тухай хуулийн 30.2.3 /байгаль орчны шинжилгээний хөтөлбөргүйгээр ажилласан/ болон 31.2.3-ыг зөрчсөн.

6. Компани улирал тутам борлуулахаар ачуулсан хүдрийн хэмжээ, олборлосон хүдрийн хэмжээ, борлуулалтын үнийг тооцсон үндэслэл, төлбөрийн нийт дүнг тусгасан тайланг Геологи, уул уурхайн хяналтын хэлтэст ирүүлээгүй нь Ашигт малтмалын тухай хуулийн 38.5-ыг зөрчсөн.

7. Хустай Ерөө ХХК, Төмөртэй Хүдэр ХХК нь 2005 оны ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг тогтоохдоо Нөөц ашигласны төлбөр тогтоох тухай хуулийн 38.2.1-ийг зөрчсөн /нэг тонн хүдрийн үнийг тухайн сарын зах зээлийн үнэ буюу олон улсад хүлээн зөвшөөрсөн зарчимд үндэслэн тогтоохын оронд дэлхийн зах зээлийн үнээс доогуур 30.5 ам.доллараар тогтоосон/.

Гурав. ДҮГНЭЛТ

1. Төмөртэй Хүдэр ХХК нь 2005 оны байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээтэй боловч 2006 оны байгаль орчны шинжилгээний хөтөлбөр, байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөгүй, баримт бичиг бүрдүүлэлт хангалтгүй байна.

2. Төмөртэй Хүдэр ХХК шинээр суурилуулсан тоног төхөөрөмж, машин механизмдаа аймгийн Мэргэжлийн хяналтын хэлтсийн холбогдох байцаагчдаар ажлын байрны дүгнэлт гаргуулаагүй, Засаг даргын Тамгын газар болон тухайн сумаас зөвшөөрөл аваагүй.

3. Төмөртэй Хүдэр ХХК, Хустай Ерөө ХХК дээр дурдсан олон заалтын зөрчлийг арилгаж, актын дагуу ногдуулсан нөөц ашигласны төлбөрийн өр, нөхөн төлбөрийг барагдуулсны дараа, холбогдох хоёр компанийн хооронд байгуулсан гэрээгээр бус, Монгол Улсын Сангийн яамтай байгуулсан гэрээний дагуу хүдэр экспортлох

нөхцөлөөр Хустай, Төмөртэйн хүдэр олборлолтыг дахин эхлүүлэх нь зүйтэй гэж дүгнэв.[169]

158. 2006 оны 5 дугаар сарын 12–14-нд “Засгийн газар хоорондын ажлын хэсэг” Хустай Ерөө, Төмөртэй Хүдэрийн төмрийн хүдэр экспортлох үйл ажиллагаанд шалгалт хийж, тайлан гаргасан. Тайлангийн бэлэн байгаа хэсэг нь голчлон хөдөлмөрийн нөхцөлд төвлөрсөн бөгөөд зөвхөн Хустай Ерөө уурхайд (БЛТ тусдаа компанийн бүтцээр дамжуулан мөн хэсэгчлэн эзэмшдэг) хийсэн үзлэгийг дараах байдлаар тайлбарласан:

> Шалгалтын гол зорилго нь БНХАУ-д их хэмжээний төмрийн хүдэр экспортолж байгаа тухай мэдээллийн үнэн зөвийг шалгах, ашиглалтын зөвшөөрөл, техник, эдийн засгийн үндэслэл, байгаль орчны нарийвчилсан үнэлгээ болон бусад холбогдох зөвшөөрөл, баримт бичгийг хуульд нийцүүлэн бүрдүүлсэн эсэхийг тодруулахад оршив.
>
> Ажлын хэсгийн гишүүд эхлээд Дулаанхаан өртөөнөөс Хятад руу төмөр замаар төмрийн хүдэр экспортолж буй байдалтай танилцсан. Тээвэрлэж буй төмрийн хүдрийг шалгаж, гаалийн бүрдүүлэлт хийхээр гаалийн улсын байцаагчдыг долоо хоног бүр нэг нэгээр нь өртөөнд томилдог. Өдөрт ойролцоогоор 34 вагон төмрийн хүдэр экспортолж, вагон тус бүрт 61 орчим тонн ачдаг. Энэ жилийн хувьд экспортын ачилтыг 1 дүгээр сарын 16-наас 3 дугаар сарын 15-ны хооронд хийж, түр завсарласны дараа 4 дүгээр сарын 21-нээс өнөөг хүртэл үргэлжлүүлсэн. 5 дугаар сарын 13-нд биднийг шалгалт эхлүүлэх үед энэ онд 1,189 вагон буюу 72,529 тонн төмрийн хүдэр экспортолсон байв. Ачаа тээврийн хэсгийн ажилтан Нагвачимбээгийн хэлснээр, экспортын ачилтын хүчин чадлыг 6 дугаар сарын 1-нээс өдөрт 100 хүртэл вагон болгохын тулд төмөр замын өргөтгөлийн ажил хийж байв. Гаалийн хураамжийн хувьд вагон бүрийн бүрдүүлэлтийн баримт бичигт 5 ам.доллар, үйлчилгээний хөлсөнд цаг тутам 7 ам.доллар авдаг. Өөр төлбөр, хураамж авдаггүй. Улаанбаатар төмөр зам Хятадын Эрээн хүртэл тээвэрлэхэд галт тэрэг тутам 1,168,500 төгрөг авдаг. Монгол Улс бусад татвар, төлбөр авдаггүй. Учир нь Хятад руу төмрийн хүдэр экспортлохыг хориглосон, эсхүл ямар нэгэн тусгай зөвшөөрөл шаардсан хуулийн заалт байхгүй. Энэ нь “хууль тогтоомжийн цоорхой”-той холбоотой. Өөрөөр хэлбэл, төмрийн хүдэр экспортлоход бүтээгдэхүүн худалдан авах гэрээ, Гаалийн төв лабораторийн дүгнэлт шаардлагатай боловч ямар нэгэн зөвшөөрөл шаарддаггүй.
>
> Дулаанхаан тосгонд ажилгүйдэл их бөгөөд төмрийн хүдэр их хэмжээгээр экспортолж буй өнөөгийн нөхцөлд оршин суугчид сөрөг хандлагатай байна. Одоогоор өдөрт 50 гаруй хүнд даацын машин 100 км замд төмрийн хүдэр тээвэрлэдэг. Жолооч нарын хэлснээр, тэдний ихэнх нь хятад хүмүүс бөгөөд монгол жолоочоос 5 дахин өндөр цалин авдаг.
>
> Дараа нь ажлын хэсэг Ерөө сумын төвд очиж, компаниас орон нутагт оруулсан хөрөнгө оруулалт, компанийн үйл ажиллагааны талаар мэдээлэл цуглуулсан. Сумын Засаг дарга С. Ганболдын хэлснээр, БЛТ ХХК-ийн уурхай болон түүний хятад түнш орон нутагт ихээхэн хөрөнгө оруулалт хийж, ажлын байр бий болгосон. Тухайн үед санхүүжилтгүйн улмаас дуусаагүй, зогссон байсан эмнэлгийн барилгад нийт 130.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийсний үр дүнд эмнэлэг одоо ажиллаж байна. Мөн

[169] Сэлэнгэ аймгийн Мэргэжлийн хяналтын газраас Төмөртэй Хүдэрт хүргүүлсэн албан бичиг, 2006 оны 4 дугаар сарын 24 (Баримт С-107).

шатсан орон нутгийн цагдаагийн байрны засварт 25.5 сая төгрөг зарцуулж, дахин ашиглалтад оруулсан. Суманд жижиг оврын трактор угсрах үйлдвэр байгуулах гэрээ байгуулсан боловч хэрэгжээгүй. Үүний оронд Хятадад үйлдвэрлэсэн 30 жижиг оврын тракторыг орон нутгийн иргэдэд лизингээр олгосон. Орон нутгийн 30 гаруй иргэнийг ажилтай болгосон боловч ажлын нөхцөл нь тун муу, хөдөлмөрийн гэрээ байгуулаагүй, хятад ажил олгогчид хүссэн үедээ халдаг. Нутгийн иргэдийг илүү олноор ажиллуулахын тулд нутгийн захиргаа хятад жолооч ажиллуулахгүй, монгол жолоочийг түлхүү ажиллуулах шаардлага тавьсан. Гэвч энэ шаардлагын биелэлт хангалтгүй байна. Түүнчлэн зөвшөөрөгдсөн ашиглалтын талбайгаас хаягдал асгаж байгаа нь байгаль орчныг бохирдуулж, хууль зөрчиж байна. Компани тус сумын нутагт 200 мянган га талбайн хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшдэг. Орон нутгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал уг талбайн ихэнхийг тусгай хамгаалалтад авах зорилготой бөгөөд тусгай зөвшөөрлийг хүчингүй болгуулахаар Ашигт малтмал, газрын тосны хэрэг эрхлэх газарт хүсэлт бэлтгэж байна. Орон нутагт өөр татвар хураадаггүй. Нөөц ашигласны төлбөрийг Сэлэнгэ аймаг дахь төрийн санд төлдөг.

Дараа нь ажлын хэсэг Ерөө суманд байрлах Хустай Ерөө уурхайд очсон. Уурхайг анх 2004 онд нээж, 2004 онд 35.0 мянган тонн, 2005 онд 165.0 мянган тонн, 2006 онд 20.0 тонн хүдэр олборлосон. Одоогоор ачилт явагдахгүй байна. Уурхайд ямар ч зөвшөөрөл байгаагүй. Хятад менежерийн хэлснээр бүх баримт бичгийг Дулаанхаан дахь төв байранд хадгалдаг. Энд илэрсэн ноцтой зөрчлийн нэг нь ямар ч зөвшөөрөлгүй тэсэлгээ хийж байгаа явдал юм. Одоогоор уурхайд 13 тонн тэсрэх бодис хадгалж байгаа бөгөөд үүнийг Улсын мэргэжлийн хяналтын газрын мэргэжилтэн Б. Амгаланбаяр, Ерөө сумын байгаль орчны улсын байцаагч Бат-Амгалан нар хураан хамгаалж, акт үйлдсэн. Одоогоор 59 монгол, 27 хятад ажилтан ажиллаж байна. Хөдөлмөрийн гэрээ байхгүй, уурхайн хятад дарга монгол ажилчдыг хүссэн үедээ дур мэдэн халдаг, мөн ямар ч зөвшөөрөл байхгүй. Эдгээр баримтад үндэслэн зөрчлийг арилгах хүртэл уурхайн үйл ажиллагааг түр зогсоож, холбогдох журмын дагуу машин механизмыг лацадсан.

(Орчуулагчийн тэмдэглэл: энд нэг хуудас дутуу байгаа бололтой.)

2. /уншигдахгүй/

3. Монгол, Хятад ажилтны зөвшөөрөгдсөн тооны хувьд Монгол Улсын холбогдох хуулийг мөрдөх;

4. Ашиглалтын талбайг нэмэгдүүлэх асуудлыг холбогдох хуулийн хүрээнд шийдвэрлэхийг Ашигт малтмал, газрын тосны хэрэг эрхлэх газарт зөвлөх;

5. Монтай Майнз ХХК-д олгосон 8888А дугаар ашиглалтын тусгай зөвшөөрлийг хүчингүй болгож, буруутай этгээдэд хариуцлага тооцон, нөхөн төлбөр төлүүлэх;

6. Баянголын ордыг 100 хувь төрийн өмчийн орд болгож, Хуст-Уул, Төмөртэйн ордуудтай хамтад нь цогц байдлаар ашиглах төсөл боловсруулж, хэрэгжүүлэх;[170]

[170] Байгаль орчны дэд сайдаар ахлуулсан Засгийн газар хоорондын Ажлын хэсгийн Сэлэнгэ аймгийн Ерөө, Хүдэр суманд байрлах Хустай Ерөө, Төмөртэй Хүдэрийн төмрийн ордод хийсэн шалгалтын тайлан, 2006 оны 5 дугаар сарын 16 (Баримт С-102).

159. 2006 оны 5 дугаар сарын 16-нд Дарханы шинэ ерөнхий захирал Т. Ганболд (“Ганболд”) Улсын Их Хуралд (Монгол Улсын парламент) захидал хүргүүлж, Төмөртэйн ордын тусгай зөвшөөрлийг Дарханд шилжүүлэх саналыг дэмжихийг хүссэн.[171]

160. 2006 оны 5 дугаар сарын 25, 6 дугаар сарын 2-нд Дархан Улсын мөрдөн байцаах газар болон Улсын ерөнхий прокурорын газарт захидал хүргүүлж, БЛТ Төмөртэйн ордын тусгай зөвшөөрлийг авсан нөхцөл байдалд эрүүгийн мөрдөн шалгалт явуулахыг хүссэн.[172]

161. 2006 оны 6 дугаар сарын 8–11-нд “Сэлэнгэ аймгийн Ерөө, Хүдэр сумын нутаг дахь “Төмөртэй Хүдэр”, “Хуст-Уул”, “Баянгол” төмрийн ордын тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн үйл ажиллагааг шалгаж, зөвлөмж боловсруулах, мөн дээрх ордын тусгай зөвшөөрөл эзэмшигчид болон нутгийн иргэдийн хоорондох маргааныг судлах”-аар “дэд ажлын хэсэг” илгээсэн.[173] Дэд ажлын хэсгийн тайлан голчлон Хустай Ерөө уурхайн тэсэлгээний үйл ажиллагаанд төвлөрч, дараах агуулгатай байв:

> Шалгалтын гол зорилго нь АМГТХЭГ-ын дэд дарга Ц. Ганхуяг, Улсын мэргэжлийн хяналтын газрын улсын байцаагч Ц. Амгаланбаяр нарын 2005 оны 5 дугаар сарын 12-нд хийсэн өмнөх шалгалтаар хаасан Хустай ууланд байрлах тэсрэх бодисын агуулахад зөвшөөрөлгүй нэвтэрсэн, улмаар зөвшөөрөлгүй тэсэлгээ хийсэн тухай мэдээллийг шалгах, өмнөх шалгалтын мөрөөр хийсэн ажлыг хянахад оршив.
>
> Хустай Ерөө ХХК-ийн уурхай 2004 онд 35 мянган тонн, 2005 онд 165 мянган тонн, 2006 оны 5 дугаар сарын 13-ны байдлаар 2006 онд 78 мянган тонн хүдэр олборлосон бол Төмөртэй Хүдэр ХХК-ийн уурхай 2004 онд 35 мянган тонн, 2005 онд 165 мянган тонн хүдэр олборлосон. Уурхайд дөрвөн экскаватор, нэг ачигч, хоёр бульдозер ажиллаж байна. Хустай Ерөө ХХК, Төмөртэй Хүдэр ХХК-ийн уурхайнуудын дотоод, гадаад тээвэрт нийт 35 өөрөө буулгагч машиныг харилцан ашигладаг. Өмнөх шалгалтаас хойш Хустай Ерөө ХХК, Төмөртэй Хүдэр ХХК Дулаанхаан төмөр замын өртөөнөөс БНХАУ руу өдөрт ойролцоогоор 2,074 тонн буюу 20 хоногт 41,480 орчим тонн хүдэр тээвэрлэсэн. Төмрийн ордоос төмөр замын өртөө хүртэл хүдрийг хүнд даацын (20 тоннын даацтай) машинаар тээвэрлэхдээ Дулаанхаан тосгоны 6 км хатуу хучилттай замыг эвдсэн. Үүний улмаас зам цаашид ашиглахад тохиромжгүй болсон. Тосгоны оршин суугчид иргэний хөдөлгөөн байгуулж, замаа засуулахын төлөө тэмцэж байна. Шалгалтын үеэр дээрх хоёр компанийн удирдлага байгаагүй тул уурхайн үйл ажиллагаатай холбоотой баримт бичигтэй танилцах боломжгүй болсон.
>
> Хустай Ерөө ХХК нь 1998 онд БЛТ ХХК-д олгосон 940А дугаар тусгай зөвшөөрлийн Хуст-Уулын ашиглалтын талбайн 216 га-д ажилладаг бөгөөд 29 хятад, 61 монгол ажилтан нь өдрийн хоолны нэг цагийн завсарлагатайгаар өдөрт 11 цаг ажилладаг. Хустай Ерөө ХХК нь Монголын БЛТ ХХК 30 хувь, Qinhuangdao

---

[171] Дарханаас Улсын Их Хуралд хүргүүлсэн албан бичиг, 2006 оны 5 дугаар сарын 16 (Баримт R-52).

[172] ДТҮ-ээс Улсын мөрдөн байцаах газарт хүргүүлсэн албан бичиг, 2006 оны 5 дугаар сарын 25 (Баримт С-98); ДТҮ-ээс Улсын ерөнхий прокурорын газарт хүргүүлсэн албан бичиг, 2006 оны 6 дугаар сарын 2 (Баримт С-99).

[173] Үйлдвэр, худалдааны сайдын 79 дүгээр тушаал, 2006 оны 6 дугаар сарын 7 (Баримт С-103).

Mincheng Construction Engineering LLC 70 хувийн хөрөнгө оруулалт хийсэн Монгол–Хятадын хамтарсан компани юм.

Хустай Ерөө ХХК, Төмөртэй Хүдэр ХХК-д илэрсэн зөрчил нь уулын ажлын төлөвлөгөө, өрөмдлөг, тэсэлгээний журам, тэсрэх бодисын агуулахын бүртгэл, тэсрэх бодисын орлого, зарлагын бүртгэлгүй байсан явдал юм. Ажилтнуудад мөн аюулгүй ажиллагааны зааварчилгаа өгдөггүй. УМХГ-ын улсын байцаагчийн хаасан агуулахаас тэсрэх бодис, тэслүүр авч, Хустай Ерөө ХХК, Төмөртэй Хүдэр ХХК-ийн уурхайд тус бүр хоёр удаа тэсэлгээ хийсэн нь тогтоогдсон. Хустай Ерөө ХХК-ийн уурхайн талбайд улсын байцаагчийн зөвшөөрөлгүй өрөмдлөг хийж байх үед өрмийн төхөөрөмж унаж, ахлах өрөмдлөгч Баатархүү бэртэн Улаанбаатар хотын эмнэлэгт хүргэгдсэн. Гэвч үйлдвэрлэлийн ослын журмыг хэрэглээгүй бололтой. Агуулахын гал унтраагуурыг цэнэглээгүй, мөн баталгаажуулаагүй байв.

Төмөртэй Хүдэр ХХК нь 1998 онд олгосон 939А дугаар тусгай зөвшөөрлийн 1,180 га ашиглалтын талбайд үйл ажиллагаа явуулдаг. Тус компанийн 35 хятад, 57 монгол ажилтан өдрийн хоолны нэг цагийн завсарлагатайгаар өдөрт 11 цаг ажилладаг. Уурхайн талбайд дөрвөн экскаватор, нэг ачигч, хоёр бульдозер ажиллаж байна.

Монтай Майнз ХХК-ийн эзэмшдэг 8888А дугаар тусгай зөвшөөрлийн Баянголын төмрийн ордын уурхайн талбайд орон сууц, албан тасалгааны зориулалттай хоёр давхар хоёр барилга, сэлбэг хадгалах хоёр чингэлэг, нэг засвар үйлчилгээний газар барьсан. Уурхайн талбайн нэг талыг тусгаарласан суваг ухсан. Уг ордод үйлдвэрлэлийн үйл ажиллагаа эхлээгүй.

Ажлын хэсэг шалгалтаар илэрсэн зөрчлүүдийг гэрэл зураг, дүрс бичлэгээр баримтжуулсан. Давхардуулахгүйн тулд өмнөх шалгалтын хэсгийн тайланд заасан арга хэмжээг энд дурдаагүй. Ажлын хэсэг дараах дүгнэлтийг гаргав.

1. Хустай Ерөө ХХК улсын байцаагчийн хаасан тэсрэх бодисын агуулахыг нээж, зөвшөөрөлгүйгээр хоёр удаа тэсэлгээ хийж, төмрийн хүдэр олборлосон. Иймд ажлын хэсгийн гишүүн, УМХГ-ын улсын байцаагч Ц. Амгаланбаяр тэсрэх бодисын агуулах болон хүдэр бутлуур, экскаватор, ачигч, бульдозер зэрэг таван машин, тоног төхөөрөмжийг лацдаж, уурхайн үйл ажиллагааг түр зогсоосон.

2. Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл, тэдгээрийн эргэлтэд хяналт тавих тухай хуулийн 2.5.1-д заасан “Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл, тэслүүр үйлдвэрлэх, хадгалах байр, агуулах нь тооцоогоор тогтоосон аюулгүйн бүстэй байна” гэсэн заалтыг зөрчсөн.

3. Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл, тэдгээрийн эргэлтэд хяналт тавих тухай хуулийн дараах заалтуудыг зөрчсөн: 11.1.2-т “... тэсэлгээ хийх зориулалтын тэсэлгээний хэрэгсэл, тэслүүр, тусгай зориулалтын тээврийн хэрэгсэл, хамгаалалт сайтай тэсрэх бодисын агуулахтай байх”; 14.1-д “Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл, тэслүүрийг тусгай зориулалтын, стандартын агуулахад хадгална”; 14.2-т “Аж ахуйн нэгж тэсэлгээний ажлын аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрмийн дагуу тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл, тэслүүрийн орлого, зарлага, үлдэгдлийг тодорхой тусгасан бүртгэл хөтөлж, улирал тутам тооллого хийнэ”; 14.4-т “Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл, тэслүүр үйлдвэрлэх, хадгалах газрын байршлыг аймаг, нийслэлийн Засаг дарга тогтооно” гэж тус тус заасан.

4. Хустай Ерөө ХХК тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл, тэслүүрийг тусгай зориулалтын тээврийн хэрэгслээр тээвэрлээгүй. Энэ нь Аюултай ачаа тээвэрлэх техникийн стандарт /MNS 4978:2000/ болон Тэсэлгээний ажлын аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрмийг зөрчсөн.[174]

162. 2006 оны 6 дугаар сарын 15-нд Улсын мэргэжлийн хяналтын газар Төмөртэй Хүдэрт дараах захидлыг хүргүүлсэн:

Улсын мэргэжлийн хяналтын газрын даргын баталсан удирдамжийн дагуу Сэлэнгэ аймгийн Хүдэр сумын нутаг дахь төмрийн ордоос хүдэр олборлож буй танай уурхайн үйл ажиллагаанд 2006 оны 6 дугаар сарын 15-нд Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Ашигт малтмалын тухай хууль, Усны тухай хууль, Газрын тухай хууль, Газрын хэвлийн тухай хууль болон бусад хууль, журмын хэрэгжилтийн байдалд шалгалт хийв. Шалгалтаар дараах зөрчил илэрсэн:

• Аж ахуйн нэгжийн уурхайн байранд байх ёстой баримт бичгийн бүрдүүлэлт хангалтгүй байгаа нь Ашигт малтмалын тухай хуулийн 39.4-ийг зөрчсөн.

• Уулын ажлын төлөвлөгөөний боловсруулалтын чанар хангалтгүй, Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө болон Байгаль орчны шинжилгээний хөтөлбөрийн хэрэгжилтийг эхлүүлээгүй нь Ашигт малтмалын тухай хуулийн 30 дугаар зүйл, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 6 дугаар зүйлийг зөрчсөн.

• Уулын ажлын төлөвлөгөө байгаа боловч зарим хэсэг нь тодорхойгүй байгаа нь Ашигт малтмалын тухай хуулийн 20.1.6-г зөрчсөн.

• Тусгай зөвшөөрөл эзэмшигч байгаль орчныг хамгаалах үүргээ хангалтгүй биелүүлсэн нь Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 31 дүгээр зүйл, Ашигт малтмалын тухай хуулийн 30 дугаар зүйлийг зөрчсөн.

• Газар, ус ашиглах гэрээ байгуулаагүй, усны шинжилгээ хийгээгүй нь Газрын тухай хуулийн 45 дугаар зүйл, Усны тухай хуулийн 25, 26, 27 дугаар зүйлийг зөрчсөн.

• Уурхайн үйлдвэрлэлийн болон ахуйн барилга байгууламжийг Улсын комисст хүлээлгэн өгөөгүй нь Барилгын тухай хуулийн 15 дугаар зүйлийг зөрчсөн.

• Үйлдвэрт дотоод хяналтын лаборатори ажиллуулаагүй нь Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 31.2-ыг зөрчсөн.

[217] Нэхэмжлэгчдийн Нэхэмжлэлийн үндэслэл, догол мөр 129.

[218] Нэхэмжлэгчдийн Нэхэмжлэлийн үндэслэл, догол мөр 192.

[219] Нэхэмжлэгчдийн Нэхэмжлэлийн үндэслэл, догол мөр 193; мөн үзнэ үү: Сонсголын тэмдэглэл (өдөр 1, 2015 оны 9 дугаар сарын 14) 102:5–103:6.

[220] Нэхэмжлэгчдийн Нэхэмжлэлийн үндэслэл, догол мөр 193.

[Дархан] Төмөртэйн ордыг ашиглах эрхгүй гэдгийг Засгийн газар ойлгож байсныг" харуулдаг гэж үзсэн.[221]

194. Үнэн хэрэгтээ Сайд нарын Зөвлөл төмрийн хүдрийн ордын ашиглалтын тусгай зөвшөөрөл олгох эрхгүй байсан тул 160 дугаар тогтоолоор Дарханд ашиглалтын эрх олгох боломжгүй байсан гэж Нэхэмжлэгчид үздэг.[222] Ямар ч тохиолдолд, хүчин төгөлдөр байдлыг нь хадгалахын тулд өмнө олгосон бүх ашиглалтын тусгай зөвшөөрлийг шинэчлэн бүртгүүлэхийг шаардсан 1997 оны Дагаж мөрдөх журмын тухай хуулийг Дархан мөрдөөгүй гэж Нэхэмжлэгчид тайлбарласан.[223]

Хариуцагчийн байр суурь

195. Хариуцагч 160 дугаар тогтоолд өөр ач холбогдол өгдөг:

> Эрлийн ажил дууссаны дараа Сайд нарын Зөвлөл 1990 оны 4 дүгээр сарын 14-нд Дархан хотод үйлдвэр барих болон Төмөртэйн ордыг цогцолборыг ажиллуулахаар шинээр байгуулсан төрийн компанид хариуцуулахыг эцэслэн зөвшөөрсөн. ... Уг тогтоол хоёр үе шат тогтоосон ... эхний үе шат нь 1994 онд дууссан гангийн үйлдвэрийг барих, хоёр дахь үе шат нь Төмөртэйн төмрийн хүдрийг ашиглах явдал байв.[224]

Хариуцагч Төмөртэйн ордыг "төрийн нэгдсэн үйлдвэрийн нэг хэсэг болгон" хөгжүүлэх Монгол Улсын түүхэн хүчин чармайлтын хүрээнд 160 дугаар тогтоолын ач холбогдлыг онцолсон.[225] Ордыг хөгжүүлэх Монголын төлөвлөгөө "1997 оноос цааш олон жилийг хамарч байсан" гэж Хариуцагч тэмдэглэсэн.[226]

196. 160 дугаар тогтоол Төмөртэйн ордын талаар Монголын Засгийн газрын зорилгыг ерөнхийлөн илэрхийлэхээс илүүтэйгээр Дарханд ашиглалтын эрх олгосон гэж Хариуцагч үздэг. Тухайн үеийн барууны эдийн засгуудаас ялгаатай нь Монгол Улс байгалийн баялгийн эрхийг тусгай зөвшөөрлөөр бус, Засгийн газрын тогтоолоор олгож байсан тул Монголын Сайд нарын Зөвлөл үүнийг шийдвэрлэх эрхтэй байсан гэж Хариуцагч тэмдэглэсэн.[227] Дархан Төмөртэйн ордод олборлолт эхлүүлэх хууль ёсны эрхтэй болсныг Хариуцагч "Монголын Сайд нарын Зөвлөлийн 1995 оны 2 дугаар сарын 13-ны зөвшөөрөл"-өөс улбаалуулсан.[228] Хариуцагчийн мэдүүлснээр, Дархан 1996 оны эхээр

---

[221] Нэхэмжлэгчдийн Нэхэмжлэлийн үндэслэл, догол мөр 198; Монгол Улсын Засгийн газрын 144 дүгээр тогтоол (Ашигт малтмалын хөтөлбөр), 1998 оны 8 дугаар сарын 12, догол мөр 2.2(h) (Эрх зүйн эх сурвалж CLA-68).

[222] Нэхэмжлэгчдийн Нэхэмжлэлийн үндэслэл, догол мөр 195.

[223] Нэхэмжлэгчдийн Нэхэмжлэлийн үндэслэл, догол мөр 196.

[224] Хариуцагчийн Хариу үндэслэл, догол мөрүүд 29-30.

[225] Сонсголын тэмдэглэл (өдөр 1, 2015 оны 9 дугаар сарын 14) 126:7–129:17.

[226] Сонсголын тэмдэглэл (өдөр 1, 2015 оны 9 дугаар сарын 14) 135:9–135:20; мөн үзнэ үү: Дарханд холбогдох Монгол Улсын Засгийн газрын тогтоол, 1996 (Баримт R-124).

[227] Сонсголын тэмдэглэл (өдөр 1, 2015 оны 9 дугаар сарын 14) 131:6–132:21.

[228] Хариуцагчийн Хариу үндэслэл, догол мөр 39.

“уурхай барих ажлыг үргэлжлүүлэхэд шаардлагатай газрыг орон нутгийн захиргааны нэгжүүдээс авсан”.[229]

197. Хариуцагч тухайн үеийн Дарханы үйл ажиллагааны цар хүрээг мөн өөрөөр тайлбарласан:

> Itochu, Mitsubishi нартай төмөрлөгийн үйлдвэр байгуулах төлөвлөгөөг хэлэлцэж байх үедээ Дархан гангийн компанийн (“Дархан”) өмнөх байгууллага Төмөртэйд нэмэлт эрэл, хайгуул хийж байсан. Ордын баруун хэсгийн нарийвчилсан зургийг 1986–1989 онд боловсруулсан. 1988–1989 онд нэмэлт эрэл, хайгуул явуулсан бөгөөд уг хайгуулын үр дүнг Эрдэс баялгийн зөвлөлд танилцуулсан.[230]

198. Сайд нарын Зөвлөл 160 дугаар тогтоол гаргасны дараа Дархан “уурхайн ажиллагааны арга техникийг улам боловсронгуй болгосон”;[231] “160 дугаар тогтоолд заасан төлөвлөгөөний хоёр дахь үе шат буюу Төмөртэйн төмрийн хүдрийн уурхайн хайгуулын нэг хэсэг болгон” төмрийн хүдэр ялгах байгууламж барихаар төлөвлөсөн;[232] Төмөртэйн уурхайн ажиллагаа болон ялгах үйлдвэрт технологи нийлүүлэх тендерийн саналуудыг авч үзсэн;[233] мөн “олборлолтын талбайг бэлтгэх, гангийн үйлдвэр болон ялгах байгууламжид боловсруулах төмрийн хүдрийн агуулгыг тогтоохын тулд 1991 онд Төмөртэйн төмрийн хүдрийн ордод хайгуулын ажлаа үргэлжлүүлсэн” гэж Хариуцагч мэдүүлсэн.[234]

199. Хариуцагч Эрчим хүч, геологи, уул уурхайн яамны Геологи, шинжлэх ухаан, техникийн зөвлөлийн 1994 оны хурлын тэмдэглэлээс ишилж, Дарханы хийсэн 1990–1992 оны судалгааг “нарийвчилсан хайгуул болон эрэл-үнэлгээний ажил” гэж тодорхойлсон.[235] Хариуцагчийн тодорхойлсноор, 1990–1992 оны судалгаа нь “арван жилийн ажлын үр дүн”-г нотолдог.[236] Хариуцагч мөн Дарханы дараа нь хийсэн, “1996 оны 2 дугаар сард санал авч, хянуулахаар тараасан” техник, эдийн засгийн үндэслэлийг тайлбарласан.[237]

В. 1997 ОНЫ ТЕХНИК, ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДЭСЛЭЛ БОЛОН БЛТ ТӨМӨРТЭЙН ОРДЫГ АШИГЛАХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ АВСАН НЬ

Нэхэмжлэгчдийн байр суурь

200. Нэхэмжлэгчид 1997 оны Техник, эдийн засгийн үндэслэл бий болсон нөхцөлийг дараах байдлаар тайлбарласан:

> Тухайн үед хүчин төгөлдөр байсан 1994 оны Ашигт малтмалын тухай хуулийн дагуу ашиглалтын тусгай зөвшөөрөл авах гол шаардлагын нэг нь ордуудыг ашиглах

---

[229] Хариуцагчийн Хариу үндэслэл, догол мөр 44.

[230] Хариуцагчийн Хариу үндэслэл, догол мөр 28; мөн үзнэ үү: Сонсголын тэмдэглэл (өдөр 1, 2015 оны 9 дугаар сарын 14) 135:21–138:8.

[231] Хариуцагчийн Хариу үндэслэл, догол мөр 32.

[232] Хариуцагчийн Хариу үндэслэл, догол мөр 33.

[233] Хариуцагчийн Хариу үндэслэл, догол мөр 34.

[234] Хариуцагчийн Хариу үндэслэл, догол мөр 35.

[235] Хариуцагчийн Хариу үндэслэл, догол мөр 38.

[236] Хариуцагчийн Хариу үндэслэл, догол мөр 40.

[237] Хариуцагчийн Хариу үндэслэл, догол мөр 43.

> хүлээн зөвшөөрөхүйц техник, эдийн засгийн үндэслэл боловсруулж, Хөдөө аж ахуй, үйлдвэрийн яаманд ирүүлэх явдал байв. Баярцогт төрийн албан тушаалтнуудаас ойлгосноор, БЛТ техник, эдийн засгийн үндэслэлдээ DMP [Дархан]-ийн түүхий эдийн хэрэгцээг шийдвэрлэх асуудлыг тусгавал тусгай зөвшөөрөл авах боломжоо нэмэгдүүлж болох байв. Иймээс БЛТ 1996 онд гаднын зөвлөхүүдийг ажиллуулж, хожим 1997 оны Техник, эдийн засгийн үндэслэл болсон баримт бичгийг боловсруулсан. Энэ нь 1994 оны Ашигт малтмалын тухай хуулийн шаардлага болон DMP-д туслах Монголын Засгийн газрын хүсэлд нийцсэн. 1997 оны Техник, эдийн засгийн үндэслэлийг 1997 оны 4 дүгээр сард Хөдөө аж ахуй, үйлдвэрийн яаманд ирүүлсэн.[238]

201. Нэхэмжлэгчид 1997 оны Техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулахдаа “Геологийн төв лабораторийн архивт байсан материал, үүнд Хүдэрбатын өөрийн 1990–1992 онд хийсэн геологийн судалгаатай танилцсан” гэж тайлбарласан.[239]

202. Нэхэмжлэгчид 1997 оны Техник, эдийн засгийн үндэслэлийн агуулгыг дараах байдлаар тодорхойлсон:

> [1997 оны Техник, эдийн засгийн үндэслэл] нь тухайн талбайнуудыг хөгжүүлэх БЛТ-ийн тэр үеийн төлөвлөгөөг, үүнд ордуудад байгаа төмрийн хүдрийн шинжилгээ болон түүнийг боловсруулах, борлуулах саналыг тусгасан. 1997 оны Техник, эдийн засгийн үндэслэл нь ордуудыг ашиглаж, төмрийн хүдрийг зах зээлд хүргэхэд шаардлагатай дэд бүтцийн хөгжил болон гүйцэтгэх боловсруулах ажлыг тодорхойлсон иж бүрэн төлөвлөгөө байсан. ... 1997 оны Техник, эдийн засгийн үндэслэлд хүдрийг цахилгаан соронзон ялгалтаар боловсруулах БЛТ-ийн зорилгыг тусгасан.[240]

203. 1997 оны Техник, эдийн засгийн үндэслэлд Дарханд түүхий эд нийлүүлэх хувилбаруудыг үнэлсэн боловч “үйлдвэр бүтээгдэхүүнийхээ дийлэнхийг Хятад, Орос руу экспортлохоор төлөвлөсөн” гэж Нэхэмжлэгчид тэмдэглэсэн.[241]

204. 1997 оны Техник, эдийн засгийн үндэслэл нь Төмөртэйн ордыг ашиглах тусгай зөвшөөрөл хүссэн Нэхэмжлэгчдийн өргөдлийн нэг хэсэг байсан.[242] Нэхэмжлэгчдийн мэдүүлснээр, Хөдөө аж ахуй, үйлдвэрийн сайд 1997 оны 5 дугаар сарын 8-ны өдрийн 4b/1261 дугаар тушаалаар БЛТ-д уг тусгай зөвшөөрлийг олгосон.[243] Сэлэнгэ аймгийн Засаг дарга 1997 оны 5 дугаар сарын 9-нд БЛТ-д Төмөртэйн “холбогдох уурхайн талбай”-д газар ашиглах эрх олгосныг Нэхэмжлэгчид дурдсан.[244] 1997 оны 5 дугаар сарын 10-нд Хүдэр сумын Засаг дарга 41 дүгээр захирамж гаргаж, Төмөртэйн уурхайг ашиглах сумын зөвшөөрлийг БЛТ-д

---

[238] Нэхэмжлэгчдийн Нэхэмжлэлийн үндэслэл, догол мөр 133.

[239] Нэхэмжлэгчдийн Хариу тайлбар, догол мөр 58; мөн үзнэ үү: Ноён Баярцогтын гэрчийн мэдүүлэг, догол мөрүүд 25-28.

[240] Нэхэмжлэгчдийн Нэхэмжлэлийн үндэслэл, догол мөр 22.

[241] Нэхэмжлэгчдийн Нэхэмжлэлийн үндэслэл, догол мөр 134.

[242] Нэхэмжлэгчдийн Нэхэмжлэлийн үндэслэл, догол мөр 135.

[243] Нэхэмжлэгчдийн Нэхэмжлэлийн үндэслэл, догол мөр 135.

[244] Нэхэмжлэгчдийн Нэхэмжлэлийн үндэслэл, догол мөр 136.

олгосон.[245] 1997 оны 6 дугаар сарын 21-нд Хөдөө аж ахуй, үйлдвэрийн сайд А/108 дугаар тушаал, Т-30 гэрчилгээгээр БЛТ-д Төмөртэйн ордыг ашиглах тусгай зөвшөөрөл олгосон.[246]

205. Нэхэмжлэгчдийн дурдсанаар, "үүний бараг дараахан ... 1997 оны 6 дугаар сарын 30-нд Хөдөө аж ахуй, үйлдвэрийн сайд ямар нэгэн үндэслэл тайлбарлалгүйгээр Т-30 тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн".[247] Гэсэн хэдий ч БЛТ "бүх тусгай зөвшөөрөл эзэмшигч тусгай зөвшөөрлөө шинэчлэн бүртгүүлэх"-ийг шаардсан 1997 оны Дагаж мөрдөх журмын тухай хуулийн дагуу "тусгай зөвшөөрлөө шинэчлэн бүртгүүлэхээр шийдсэн"[248] бөгөөд 1998 оны 1 дүгээр сарын 19-нд "DGMC БЛТ-д 939А тусгай зөвшөөрөл олгосон".[249]

206. БЛТ 939А тусгай зөвшөөрлийг авлига, залилан, худал мэдээллийн замаар авсан гэх мэдэгдлийг Нэхэмжлэгчид эрс няцаасан.[250]

Хариуцагчийн байр суурь

207. Хариуцагч Нэхэмжлэгчдийг Төмөртэйн ордыг ашиглах тусгай зөвшөөрлийг авлига, залилан, худал мэдээллийн замаар авсан гэж тайлбарласан.[251] Нэхэмжлэгчид 1990–1992 оны тайлангийн материалыг хулгайлан авч, 1997 оны Техник, эдийн засгийн үндэслэлд өөрсдийн ажил мэтээр худал танилцуулсан гэж Хариуцагч мэдүүлсэн.[252]

208. Хариуцагч БЛТ, ноён Нацагдорж, ноён Баярцогт нарыг "гол төмрийн ордууд"-тай холбоотой "хууль бус үйлдэл", "авлига"-д оролцсон гэж мэдүүлсэн.[253] Тухайлбал, ноён Баярцогт "ордын талаар Дарханаас боловсруулсан бараг бүх дотоод тайлантай танилцах боломжтой байсан" боловч ордтой холбоотойгоор Дарханаас түүнд өгсөн үүргийг биелүүлээгүй,[254] харин "Монголд уул уурхайн боломжуудыг өөрсөддөө авахын тулд" ноён Нацагдорж, ноён Ли нартай хамтран ажиллахыг илүүд үзсэн гэж Хариуцагч мэдүүлсэн.[255] Үүнтэй адил, ноён Нацагдоржийн талаар Хариуцагч дараахыг дурдсан:

> Дархан Төмөртэйн тусгай зөвшөөрлөө хадгалахад шаардлагатай үйлдлүүдийг зогсоож, мөн Дарханы Төмөртэйн уурхайд эдлэх эрхийг БЛТ рүү шилжүүлэх идэвхтэй арга хэмжээ авсан. Нацагдорж 1997 оны Ашигт малтмалын тухай хуулийн дагуу Дарханы ашиглалтын эрхийг шинэчлэн бүртгүүлээгүй. Дарханы техник, эдийн засгийн үндэслэл болон түүнийг боловсруулахад ашигласан материалыг БЛТ-

[245] Нэхэмжлэгчдийн Нэхэмжлэлийн үндэслэл, догол мөр 136.

[246] Нэхэмжлэгчдийн Нэхэмжлэлийн үндэслэл, догол мөр 137.

[247] Нэхэмжлэгчдийн Нэхэмжлэлийн үндэслэл, догол мөр 138.

[248] Нэхэмжлэгчдийн Нэхэмжлэлийн үндэслэл, догол мөр 139.

[249] Нэхэмжлэгчдийн Нэхэмжлэлийн үндэслэл, догол мөр 141.

[250] Нэхэмжлэгчдийн Хариу тайлбар, дэд хэсгүүд II(E)-(F).

[251] Хариуцагчийн Хариу үндэслэл, дэд хэсгүүд II(E)-(H).

[252] Хариуцагчийн Хариу үндэслэл, догол мөрүүд 69-70, 75.

[253] Хариуцагчийн Хариу үндэслэл, догол мөрүүд 46, 49-51.

[254] Хариуцагчийн Хариу үндэслэл, догол мөр 46.

[255] Хариуцагчийн Хариу үндэслэл, догол мөр 51.

д өгөхийг Нацагдорж хангаж өгсөн. Нацагдорж Төмөртэйн ордын газар болон орд руу орох авто замд эдлэх Дарханы газрын эрхийг хүчингүй болгохыг зөвшөөрсөн.[256]

209. Дархан өөрийн техник, эдийн засгийн үндэслэлд зориулсан геологийн нууц мэдээллийг цуглуулж, шинжлэхийг даалгасан ноён Хүдэрбатыг БЛТ болон ноён Баярцогт авлигаар татсан гэж Хариуцагч мөн мэдүүлсэн. Хариуцагчийн тайлбарласнаар:

> Хүдэрбат тайлангийнхаа эцсийн хувийг Дарханд өгөөгүй. Дарханы захирал Ганжууржав уг баримтыг Хүдэрбатаас авахыг Баярцогтод даалгасан боловч амжилт олоогүй. Харин Хүдэрбат уг баримтыг Баярцогтын БЛТ компанид өгсөн ...[257] ... Нэхэмжлэгчид Дарханы өмчийн геологийн судалгааг авахын тулд Хүдэрбатад мөнгө өгч, уг судалгааг хожим 1997 оны техник, эдийн засгийн үндэслэлд оруулсан. Нацагдоржийн ажиллаж байх үед Дарханы архиваас гаргаж авсан, Дарханд ирүүлсэн тендерийн баримтуудыг Нэхэмжлэгчид 1997 оны Техник, эдийн засгийн үндэслэлийн техникийн хэсгийн материал болгон ашигласан.[258]

210. 1997 оны Техник, эдийн засгийн үндэслэл нийтлэгдэхээс өмнө ордыг судлах эрх зөвхөн Дарханд байсан тул БЛТ уг судалгааг дангаараа зохиосон байх боломжгүй гэсэн тайлбараар Хариуцагч хулгайн талаарх мэдэгдлээ дэмжсэн.[259] Нэхэмжлэгчдийн 1997 оны Техник, эдийн засгийн үндэслэлд зарцуулсан гэж хэлсэн мөнгийг үнэндээ Дарханы ажилтнуудыг авлигаар татахад ашигласан гэж Хариуцагч үзсэн. Түүнчлэн Дарханы өмчийн, “Төмөртэйн ордыг хэрхэн ашиглах тухай тодорхой технологийн мэдээлэл” агуулсан өөр багц нууц баримтын мэдээлэл БЛТ-ийн 1997 оны Техник, эдийн засгийн үндэслэлд орсон гэж Хариуцагч мэдэгдсэн.[260] Хариуцагч мөн “Монголын эрх бүхий байгууллагууд 2005 онд Нацагдорж, Баярцогт, Туяа нарт DMP [Дархан]-ийн тусгай зөвшөөрлийг хулгайлсантай холбоотойгоор хөрөнгө завших болон бусад яллах үндэслэлээр хэрэг үүсгэсэн” гэж тэмдэглэсэн.[261]

211. Хариуцагч 1997 оны Техник, эдийн засгийн үндэслэлийн тайланд хэд хэдэн худал мэдээлэл байсан гэж тодорхойлсон. Тухайлбал, уг үндэслэлд БЛТ-ийн санхүүжилтийн эх үүсвэр,[262] уул уурхайн туршлага,[263] үйл ажиллагааны цаг хугацаа,[264] Дарханд түүхий эд

---

[256] Хариуцагчийн Хариу үндэслэл, догол мөр 54.

[257] Хариуцагчийн Хариу үндэслэл, догол мөр 58.

[258] Хариуцагчийн Хариу үндэслэл, догол мөр 63; мөн үзнэ үү: Хариуцагчийн Хариу үндэслэл, догол мөрүүд 64- 67.

[259] Хариуцагчийн Хариу үндэслэл, догол мөрүүд 59-61.

[260] Хариуцагчийн Хариу үндэслэл, догол мөрүүд 68-70.

[261] Хариуцагчийн Хариу үндэслэл, догол мөр 135; мөн үзнэ үү: Хариуцагчийн Хариу үндэслэл, догол мөрүүд 136- 137.

[262] Хариуцагчийн Хариу үндэслэл, догол мөрүүд 73-74; мөн үзнэ үү: Сонсголын тэмдэглэл (өдөр 5, 2015 оны 9 дугаар сарын 18), 813:17–814:5.

[263] Хариуцагчийн Хариу үндэслэл, догол мөрүүд 75-76; мөн үзнэ үү: Сонсголын тэмдэглэл (өдөр 1, 2015 оны 9 дугаар сарын 14) 144:18–145:17.

[264] Сонсголын тэмдэглэл (өдөр 1, 2015 оны 9 дугаар сарын 14) 149:19–150:2; мөн үзнэ үү: Сонсголын тэмдэглэл (өдөр 5, 2015 оны 9 дугаар сарын 18), 813:5–813:10.

нийлүүлэх зорилго,[265] төмрийн хүдрийг ашиглахаар төлөвлөсөн зориулалтыг[266] худал танилцуулсан гэж тэмдэглэсэн. Хариуцагч дараах дүгнэлт хийсэн:

> БЛТ-д тусгай зөвшөөрөл олгох нь техник, эдийн засгийн үндэслэлийг батлахаас хамаарч байсан тул Нэхэмжлэгчдийн худал мэдэгдлүүд шийдвэрлэх ач холбогдолтой ... Иймд тусгай зөвшөөрлийг хуурамч үндэслэлээр, Нэхэмжлэгчдийн санаатай нуун дарагдуулалт болон идэвхтэйгээр өгсөн худал мэдээлэлд тулгуурлан олгосон.[267]

С. БЛТ / ТӨМӨРТЭЙ ХҮДЭРИЙН ТӨМӨРТЭЙН ОРДОД ХИЙСЭН БҮТЭЭН БАЙГУУЛАЛТ

Нэхэмжлэгчдийн байр суурь

212. Нэхэмжлэгчид Төмөртэйн ордод оруулсан хөрөнгө оруулалтаа 2005 оны эцэс гэхэд ойролцоогоор 30 сая ам.доллар болсон гэж үнэлсэн.[268] Шууд хөрөнгө оруулалтаа Төмөртэй Хүдэрт эзэмшдэг хувьцаагаараа дамжуулан хийсэн боловч “тоног төхөөрөмж, бусад материалд шууд хөрөнгө оруулсан, ажилтан хөлсөлсөн, мөн заримдаа шууд, заримдаа Төмөртэй Хүдэрээр дамжуулан хөрөнгө оруулалтын үйл ажиллагаанд шаардлагатай гэрээнүүд байгуулсан” гэж Нэхэмжлэгчид мэдүүлсэн.[269]

213. Нэхэмжлэгчид Циньлуны “шаардлагатай бүх уурхайн тоног төхөөрөмж”-ийг худалдан авсан, “үйлдвэрлэлийн шугам байгуулсан”, Төмөртэйн ордыг судалж, хэмжилт хийсэн тухай тайлбарласан.[270]

214. Нэхэмжлэгчид Монголын хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэхийн тулд Монгол Улсын хөгжилд хувь нэмэр оруулсан гэж мөн мэдүүлсэн. Тухайлбал, 48 км шороон зам, 10 км цахилгаан дамжуулах агаарын шугам, төмөр замын өргөтгөл, ажилтнуудын орон сууц, зочид буудал, албан тасалгааны барилга, эмнэлэг, орон нутгийн клуб, оёдлын үйлдвэр, цагдаагийн байр, сургууль, гудамжны гэрэлтүүлэг барьж байгуулсан гэж мэдүүлсэн.[271]

215. 939А тусгай зөвшөөрлийг хүчингүй болгохоос өмнөх төмрийн хүдэр үйлдвэрлэлийн тухайд Нэхэмжлэгчид “2005 оны дунд үеэс Төмөртэй Хүдэр уурхайд илүү их нөөц зарцуулж, шаардлагатай ажилтнуудыг Хустайн уурхайгаас шилжүүлж эхэлсэн”[272] бөгөөд “2005 оны сүүл гэхэд томоохон ахиц гарсан” гэж тэмдэглэсэн.[273] Нэхэмжлэгчдийн мэдүүлснээр, “2006 онд, тухайн оны 9 дүгээр сард тусгай зөвшөөрлийг нь хүчингүй болгох

---

[265] Сонсголын тэмдэглэл (өдөр 1, 2015 оны 9 дугаар сарын 14) 146:8–149:9.

[266] Хариуцагчийн Хариу үндэслэл, догол мөр 79.

[267] Хариуцагчийн Хариу үндэслэл, догол мөр 83.

[268] Ноён Лигийн гэрчийн мэдүүлэг, догол мөр 27; Нэхэмжлэгчдийн Нэхэмжлэлийн үндэслэл, догол мөр 156.

[269] Нэхэмжлэгчдийн Нэхэмжлэлийн үндэслэл, догол мөр 152.

[270] Нэхэмжлэгчдийн Нэхэмжлэлийн үндэслэл, догол мөр 153.

[271] Нэхэмжлэгчдийн Нэхэмжлэлийн үндэслэл, догол мөр 154.

[272] Нэхэмжлэгчдийн Нэхэмжлэлийн үндэслэл, догол мөр 157.

[273] Нэхэмжлэгчдийн Нэхэмжлэлийн үндэслэл, догол мөр 158.

хүртэл Төмөртэй Хүдэр 461.1 мянган тонн төмрийн хүдэр олборлож, 322.7 мянган тонн боловсруулсан төмрийн хүдэр гарган авч, үүнээс 180 мянган тонныг экспортолсон".[274] Нэхэмжлэгчид мөн 2005–2006 оны ажлын төлөвлөгөөг ишлэн, "Төмөртэй Хүдэр хөрөнгө оруулалтын үйл ажиллагаагаа өргөжүүлэхийн тулд баяжуулах үйлдвэр (энэ хүрээнд төмрийн хүдрийг цахилгаан соронзон аргаар ялгах үйлдвэр), бөөгнөрүүлэх цех, цаашлаад ангижруулсан төмрийн үйлдвэр эсхүл ган хайлуулах үйлдвэр зэрэг нэмэлт боловсруулах байгууламж барихаар төлөвлөсөн" гэж тэмдэглэсэн.[275]

Хариуцагчийн байр суурь

216. Хариуцагч Нэхэмжлэгчдийн хөрөнгө оруулалтыг тэдний дурдсан дүнгийн өчүүхэн хэсгээр үнэлсэн.[276] Хариуцагчийн үзэж байгаагаар, Нэхэмжлэгчдийн ""хөрөнгө оруулалт"" болон түүнд төлсөн гэх мөнгөн дүнг "бичгийн нотлох баримт батлахгүй".[277]

217. Хариуцагч Нэхэмжлэгчид "сайндаа л шороон замд нэмэлт хийсэн" гэж мэдүүлж,[278] "асфальт, хайргаар хучаагүй" шороон замын зургийг гаргасан.[279] Нэхэмжлэгчдийн барьсан гэх байгууламжууд "үндсэндээ үнэ цэнэгүй, хэдэн сая долларын үнэ цэнэтэй бол бүр ч биш" гэсэн мэдэгдлээ дэмжих зургуудыг Хариуцагч мөн гаргасан.[280] Харин "эдгээр "туслах байгууламж"-ийг харахад л 3 сая ам.доллар, эсхүл түүнд ойр дүнгээр ч босоогүй нь тодорхой";[281] "Монголд агуулахын саравч барихад 3,142,125 ам.доллар зарцуулдаггүй" гэж мэдүүлсэн.[282] Нэхэмжлэгчид "орон сууц, зочид буудал, албан тасалгааны барилга Төмөртэйтэй ямар нэг холбоотой гэж мэдэгдээгүй"[283] бөгөөд эдгээр нь өөр уурхайд байрласан байх боломжтойг Хариуцагч мөн ач холбогдолтой гэж үзсэн.

D. НОЁН НАЦАГДОРЖ, НОЁН БАЯРЦОГТ НАРТ ХОЛБОГДОХ ЭРҮҮГИЙН МӨРДӨН ШАЛГАЛТ

Нэхэмжлэгчдийн байр суурь

218. Нэхэмжлэгчдийн мэдүүлснээр:

> (a) "2006 онд DMP-ийн (939A тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосноос шууд ашиг хүртсэн тэр этгээдийн) хүсэлтээр Монгол Улсын Ерөнхий прокурор (Монголын прокурор) Нацагдорж, Баярцогт нарт холбогдуулан эрүүгийн мөрдөн шалгалт эхлүүлсэн".[284]

---

[274] Нэхэмжлэгчдийн Нэхэмжлэлийн үндэслэл, догол мөр 161.

[275] Нэхэмжлэгчдийн Нэхэмжлэлийн үндэслэл, догол мөр 161.

[276] Хариуцагчийн Хариу үндэслэл, догол мөрүүд 112-126.

[277] Хариуцагчийн Хариу үндэслэл, догол мөр 112.

[278] Хариуцагчийн Хариу үндэслэл, догол мөр 115.

[279] Хариуцагчийн Хариу үндэслэл, догол мөр 116.

[280] Хариуцагчийн Хариу үндэслэл, догол мөр 119.

[281] Хариуцагчийн Хариу үндэслэл, догол мөр 122.

[282] Хариуцагчийн Хариу үндэслэл, догол мөр 125.

[283] Хариуцагчийн Хариу үндэслэл, догол мөр 120.

[284] Нэхэмжлэгчдийн Хариу тайлбар, догол мөр 52.

(b) “Мөрдөн шалгалт нь 160 дугаар тогтоолоор DMP-д олгосон байх тусгай зөвшөөрлийг шинэчлэн бүртгүүлээгүй гэх үйлдэл нь Монголын Эрүүгийн хуулийн 150 дугаар зүйлийн дагуу Нацагдорж, Баярцогт нарын хөрөнгө завших гэмт хэрэг мөн эсэхэд төвлөрсөн. (Монголын прокурор хулгай, залилангийн үндэслэлээр ямар нэгэн яллах шаардлага тавиагүй.)”[285]

(c) “Таван жил мөрдөн шалгасны эцэст 2011 оны 7 дугаар сарын 18-нд Монголын прокурор Нацагдорж, Баярцогт нарт тавьсан буруутгал нотлогдоогүй тул тэдэнд холбогдох хэргийг хэрэгсэхгүй болгохоор шийдвэрлэсэн”.[286]

(d) “Нотлох баримт хангалтгүйгээс хэргийг хэрэгсэхгүй болгосноос хоёр жил хагасын дараа гайхамшигтайгаар, ахлах прокурор байсан бөгөөд одоо Монголын Хууль зүйн сайд болсон Дорлигжав хэмээх хүн уг шийдвэрийг дахин хянаад, үгүй ээ, буруу шийдвэр байсан гэж байна. ... Тэрээр дүгнэлтүүд бүрэн тогтоогдож, нотлогдсон гэж хэлсэн”.[287]

Хариуцагчийн байр суурь:

219. Хариуцагчийн мэдүүлснээр, “Баярцогт, Туяа, Нацагдорж нар улсаас зугтан гарах хүртэл Монгол Улс эрүүгийн хууль зөрчсөн энэ үйлдэлд яллах ажиллагаа явуулсан. Энэхүү хууль бус үйлдэл нь мөн Төмөртэйн тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох үндэслэл болдог”.[288]

220. Түүнчлэн Хариуцагч “прокурор Энхбатын хэргийг хэрэгсэхгүй болгосон байдал нь хэвийн бус, сэжигтэй тул түүнд итгэж болохгүй” гэж тайлбарласан.[289] Үүнийг тайлбарлахдаа Хариуцагч дараахыг тэмдэглэсэн:

(a) прокурор хэргийн материалыг хүлээн авсан тэр өдөртөө хэргийг хэрэгсэхгүй болгосон;[290]

(b) хэргийн материал найман хавтас буюу ойролцоогоор 2,000 хуудастай байсан тул Монголын Эрүүгийн байцаан шийтгэх хуульд шаардсаны дагуу прокурор бодитоор хянаж үзсэн байх боломжгүй;[291]

(c) хэрэгсэхгүй болгосон шийдвэрт үндэслэл байгаагүй;[292]

(d) мөрдөн шалгагдаж буй хүмүүс Монгол Улсаас гарсан тул хэрэг түдгэлзсэн, улмаар хэрэгсэхгүй болгох боломжгүй байсан хугацаанд хэргийг хэрэгсэхгүй болгосон;[293] мөн

(e) удалгүй Энхбатыг прокурорын албан тушаалаас чөлөөлсөн.[294]

---

[285] Нэхэмжлэгчдийн Хариу тайлбар, догол мөр 52.

[286] Нэхэмжлэгчдийн Хариу тайлбар, догол мөр 52.

[287] Сонсголын тэмдэглэл (өдөр 1, 2015 оны 9 дугаар сарын 14), 120:20–121:8.

[288] Хариуцагчийн Хариу үндэслэл, догол мөр 160.

[289] Сонсголын тэмдэглэл (өдөр 1, 2015 оны 9 дугаар сарын 14), 176:24–177:2.

[290] Сонсголын тэмдэглэл (өдөр 1, 2015 оны 9 дугаар сарын 14), 177:3-8.

[291] Сонсголын тэмдэглэл (өдөр 1, 2015 оны 9 дугаар сарын 14), 177:8-24.

[292] Сонсголын тэмдэглэл (өдөр 1, 2015 оны 9 дугаар сарын 14), 177:19-23.

[293] Сонсголын тэмдэглэл (өдөр 1, 2015 оны 9 дугаар сарын 14), 177:25–178:9.

[294] Сонсголын тэмдэглэл (өдөр 1, 2015 оны 9 дугаар сарын 14), 178:9-10.

221. Хариуцагчийн мэдүүлснээр, шүүгдэгчид тухайн улсын харьяалах нутаг дэвсгэрээс гарсан тул хөөн хэлэлцэх хугацаа дуусах боломжгүй байсан, иймээс хэрэгсэхгүй болгосон шийдвэр зохисгүй гэж үзэн мөрдөн шалгалтыг дараа нь сэргээсэн.[295]

V. ГАРГАСАН ШААРДЛАГУУД

Нэхэмжлэгчдийн хүсэлт

222. Нэхэмжлэгчид арбитрын хүсэлтдээ дараах шаардлагыг гаргасан:

> 87. Нэхэмжлэгчид Арбитрын бүрэлдэхүүнээс дараахыг хүндэтгэн хүсэж байна:
>
> (a) Монгол Улс Нэхэмжлэгчдийн хөрөнгө оруулалтыг хууль бусаар албадан хураасан, тэдэнд шударга, тэгш хандаагүй, мөн тэднийг хамгаалаагүйгээс Хэлэлцээр болон Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хуулиар хүлээсэн үүргээ зөрчсөнийг тогтоох;
>
> Үүний үр дагавар болгон,
>
> (b) Дээрх 55 дахь хэсэгт заасан Нэхэмжлэгчдийн алдагдлыг хохирол нөхөн төлөх замаар барагдуулахыг Монгол Улсад даалгах; эсхүл
>
> Өөр хувилбараар,
>
> (c) Монгол Улс 939A тусгай зөвшөөрлийг Төмөртэй компанид буцаан олгох, мөн хожим тогтоох хэмжээний хохирлыг нөхөн төлөхийг даалгах;
>
> Аль ч тохиолдолд,
>
> (d) Нэхэмжлэгчдэд олгохоор тогтоосон аливаа хохирлын нөхөн төлбөрт энэхүү ажиллагааны явцад хожим тогтоох хувь хэмжээ, хугацаагаар хүү төлөхийг Монгол Улсад даалгах; мөн
>
> (e) Нэхэмжлэгчдийн энэхүү ажиллагаатай холбоотой гаргасан бүх зардал, төлбөрийг, үүнд Арбитрын бүрэлдэхүүний гишүүдийн хөлс, зардал, арбитрын байгууллагын захиргааны хураамж, Арбитрын бүрэлдэхүүн болон Нэхэмжлэгчдийн томилсон шинжээчдийн хөлс, зардал, Нэхэмжлэгчдийн хууль зүйн төлөөллийн хөлс, зардал, Нэхэмжлэгчдийн дотоод зардал болон хүүг бүрэн нөхөн төлөх үндсэн дээр Монгол Улсаар төлүүлэх.
>
> 88. Нэхэмжлэгчид шаардлагатай эсхүл зохистой гэж үзвэл нэхэмжлэл, түүний дотор энэхүү шаардлагуудаа өөрчлөх болон/эсхүл нэмэлт оруулах эрхээ хүндэтгэн хадгалж байна.[296]

223. Нэхэмжлэгчид нэхэмжлэлийн үндэслэлдээ дараах шаардлагыг гаргасан:

> 286. Дээр дурдсаныг үндэслэн Нэхэмжлэгчид Арбитрын бүрэлдэхүүнээс дараахыг хүндэтгэн хүсэж байна:
>
> • Энэхүү нэхэмжлэлийн үндэслэлд дурдсан Нэхэмжлэгчдийн шаардлагын хувьд Арбитрын бүрэлдэхүүн хэрэгт оролцогч этгээдээр тодорхойлогдох харьяалал (ratione personae) болон маргааны зүйлээр тодорхойлогдох харьяалал (ratione materiae)-тай болохыг тогтоох;

---

[295] Сонсголын тэмдэглэл (өдөр 1, 2015 оны 9 дугаар сарын 14), 178:11-24.

[296] Нэхэмжлэгчдийн Арбитрын хүсэлт, догол мөрүүд 87-88.

• Хариуцагч Нэхэмжлэгчдийн хөрөнгө оруулалтыг хууль бусаар албадан хурааснаар Хэлэлцээрийн 4 дүгээр зүйлийг зөрчсөнийг тогтоох;

Үүний үр дагавар болгон,

• Хариуцагч 939А тусгай зөвшөөрлийг Төмөртэй Хүдэрт буцаан олгохыг даалгах; мөн

• Буцаан олголтоор нөхөгдөхгүй үлдэх аливаа хохирлыг энэхүү ажиллагааны дараагийн шатад тогтоох хэмжээгээр нөхөн төлөхийг Хариуцагчид даалгах;

Өөр хувилбараар,

• Нэхэмжлэгчдийн хүлээсэн хохирлыг энэхүү ажиллагааны дараагийн шатад тогтоох хэмжээгээр бүрэн нөхөн төлөхийг Хариуцагчид даалгах;

Аль ч тохиолдолд,

• Нэхэмжлэгчдийн гаргасан бүх зардал, төлбөрийг, үүнд Арбитрын бүрэлдэхүүний хөлс, зардал, Нэхэмжлэгчдийн өмгөөлөгчдийн хөлс, зардал болон хүүг багтаан, үүгээр хязгаарлахгүйгээр бүрэн нөхөн төлөх үндсэн дээр Хариуцагчаар төлүүлэх.

287. Нэхэмжлэгчид ажиллагааны зохих үе шатад, Арбитрын бүрэлдэхүүний зааврын дагуу дараагийн тайлбаруудаа дээрх урьдчилсан шаардлагыг нэмэлтээр өөрчлөх эрхээ хадгалж байна.[297]

224. Нэхэмжлэгчид хариу тайлбартаа дараах шаардлагыг гаргасан:

Дээр дурдсаныг үндэслэн Нэхэмжлэгчид Арбитрын бүрэлдэхүүнээс дараахыг хүндэтгэн хүсэж байна:

• Нэхэмжлэлийн үндэслэл болон энэхүү хариу тайлбарт дурдсан Нэхэмжлэгчдийн шаардлагын хувьд Арбитрын бүрэлдэхүүн хэрэгт оролцогч этгээдээр тодорхойлогдох харьяалал (ratione personae) болон маргааны зүйлээр тодорхойлогдох харьяалал (ratione materiae)-тай болохыг тогтоох;

• Хариуцагч Нэхэмжлэгчдийн хөрөнгө оруулалтыг хууль бусаар албадан хурааснаар Хэлэлцээрийн 4 дүгээр зүйлийг зөрчсөнийг тогтоох;

• Хариуцагчийн хамгаалах үндэслэл болон сөрөг нэхэмжлэлийг бүхэлд нь хэрэгсэхгүй болгох;

Үүний үр дагавар болгон,

• Хариуцагч 939А тусгай зөвшөөрлийг Төмөртэй Хүдэрт буцаан олгохыг даалгах; мөн

• Буцаан олголтоор нөхөгдөхгүй үлдэх аливаа хохирлыг энэхүү ажиллагааны дараагийн шатад тогтоох хэмжээгээр нөхөн төлөхийг Хариуцагчид даалгах;

Өөр хувилбараар,

• Нэхэмжлэгчдийн хүлээсэн хохирлыг энэхүү ажиллагааны дараагийн шатад тогтоох хэмжээгээр бүрэн нөхөн төлөхийг Хариуцагчид даалгах;

Аль ч тохиолдолд,

[297] Нэхэмжлэгчдийн Нэхэмжлэлийн үндэслэл, догол мөрүүд 286-287.

• Нэхэмжлэгчдийн гаргасан бүх зардал, төлбөрийг, үүнд Арбитрын бүрэлдэхүүний хөлс, зардал, Нэхэмжлэгчдийн өмгөөлөгчдийн хөлс, зардал болон хүүг багтаан, үүгээр хязгаарлахгүйгээр бүрэн нөхөн төлөх үндсэн дээр Хариуцагчаар төлүүлэх.[298]

Хариуцагчийн хүсэлт

225. Хариуцагч хариу тайлбартаа залилан мэхлэх зорилгоор худал мэдээлэл өгсний улмаас учирсан хохиролд 100 сая ам.доллараас давсан нөхөн төлбөр шаардсан.[299]

VI. ТАЛУУДЫН ҮНДЭСЛЭЛҮҮД

А. АРБИТРЫН БҮРЭЛДЭХҮҮНИЙ ХАРЬЯАЛАЛ БОЛОН ХЭРЭГЛЭХ ЭРХ ЗҮЙ

1. Хэрэгт оролцогч этгээдээр тодорхойлогдох харьяалал (ratione personae)

226. Хэлэлцээрийн 1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн холбогдох заалтад Бүгд Найрамдах Хятад Ард Улсын хувьд “хөрөнгө оруулагч”-ийг дараах байдлаар тодорхойлсон:

(a) Бүгд Найрамдах Хятад Ард Улсын иргэншилтэй хувь хүмүүс;

(b) Бүгд Найрамдах Хятад Ард Улсын хууль тогтоомжийн дагуу байгуулагдсан бөгөөд Бүгд Найрамдах Хятад Ард Улсын нутаг дэвсгэрт байршилтай аж ахуйн нэгжүүд.[300]

227. Нэхэмжлэгчид тус бүр “БНХАУ-ын хууль тогтоомжийн дагуу байгуулагдсан, БНХАУ-ын нутаг дэвсгэрт байршилтай” “аж ахуйн нэгж” тул Хэлэлцээрийн 1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн дагуу “шаардлага хангасан хөрөнгө оруулагчид” гэж мэдүүлсэн.[301]

2. Маргааны зүйлээр тодорхойлогдох харьяалал (ratione materiae)

228. Хэлэлцээрийн 1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “хөрөнгө оруулалт”-ыг “Хэлэлцэн тохирогч нэг улсын хөрөнгө оруулагчид Хэлэлцэн тохирогч нөгөө улсын хууль тогтоомжийн дагуу түүний нутаг дэвсгэрт оруулсан бүх төрлийн хөрөнгө” гэж тодорхойлсон. Уг заалтын “хөрөнгө оруулалт”-ын тодорхойлолтод “компанийн хувьцаа, хувь оролцоо, өрийн бичиг” болон “байгалийн баялаг эрэх, ашиглах концесс зэрэг хуулиар олгосон концесс”-ыг тусгайлан багтаасан.

229. Нэхэмжлэгчид Хэлэлцээрийн 1 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн шаардлага хангасан хөрөнгө оруулалт хийсэн гэж үздэг. Тэд Төмөртэй Хүдэрийн бүртгэлтэй хувь нийлүүлсэн хөрөнгийн хувьцаанд “шууд хөрөнгө оруулалт” хийсэн гэж мэдүүлсэн.[302] 939А тусгай зөвшөөрөл Төмөртэй Хүдэрт Төмөртэйн уурхайг ашиглах эрх олгосон, харин Нэхэмжлэгчид тус компанийн хувьцаа эзэмшигчид тул шаардлага хангасан “шууд бус хөрөнгө оруулалт” мөн хийсэн гэж үзсэн. Нэхэмжлэгчдийн мэдүүлснээр, “Хэлэлцээрт

---

[298] Нэхэмжлэгчдийн Хариу тайлбар, догол мөр 218,

[299] Хариуцагчийн Хариу үндэслэл, догол мөр 293.

[300] Хэлэлцээрийн бүрэн эхийг CLA-1 эрх зүйн эх сурвалжаас үзэж болно.

[301] Нэхэмжлэгчдийн Нэхэмжлэлийн үндэслэл, догол мөр 53.

[302] Нэхэмжлэгчдийн Нэхэмжлэлийн үндэслэл, догол мөр 55.

компанийн “хөрөнгөнд эдлэх эрх”-ээс бүрдэх шууд бус хөрөнгө оруулалтыг хамгаалахаар тодорхой заасан”.[303]

3. Хэрэглэх эрх зүй

230. Хэлэлцээрийн 8 дугаар зүйлийн 7 дахь хэсэгт Арбитрын бүрэлдэхүүн Монгол Улсын эрх зүй, үүнд хуулийн зөрчилдөөний дүрэм, Хэлэлцээрийн заалтууд, мөн “Хэлэлцэн тохирогч хоёр улсын хүлээн зөвшөөрсөн олон улсын эрх зүйн нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн зарчим”-д нийцүүлэн шийдвэрлэхийг шаардсан.

В. ХАРИУЦАГЧИЙН УРЬДЧИЛСАН ТАТГАЛЗЛУУД

231. Хариуцагч Арбитрын бүрэлдэхүүний харьяаллыг дараах хэд хэдэн үндэслэлээр эсэргүүцсэн:

(a) Нэхэмжлэгчдийн хөрөнгө оруулалтыг хулгай, хөрөнгө завших, залилангийн замаар олж авсан;

(b) Хэлэлцээрийн 8 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасан Монгол Улсын арбитрт зөвшөөрсөн хүрээ нь Нэхэмжлэгчдийн шаардлагын зүйлд хамаарахгүй;

(c) Хятадын гэрээ байгуулах практикийн дагуу Бээжин Шоуган, Чайна Хэйлунзян нарыг Хэлэлцээрийн 1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “аж ахуйн нэгж” гэж ангилах боломжгүй тул тэд хөрөнгө оруулагч биш;

(d) Нэхэмжлэгчид хөрөнгө оруулалтын эрсдэл хүлээгээгүй тул шаардлага хангасан хөрөнгө оруулалт хийгээгүй;

(e) Нэхэмжлэгчид олон улсын заншлын эрх зүйд үндэслэн буцаан олголт шаардахдаа Арбитрын бүрэлдэхүүнээс эрх зүйн илэрхий алдаа гаргахыг хүсэж байгаа;

(f) Хэлэлцээрийн 8 дугаар зүйлийн 3 дахь хэсэг нь маргаан шийдвэрлэх замыг сонгох заалт агуулдаг бөгөөд Нэхэмжлэгчид ижил маргааныг Монголын шүүхэд шилжүүлэхээр сонгосон тул одоо олон улсын арбитрт хандах боломжгүй.

232. Хариуцагч мөн Нэхэмжлэгчид Арбитрын бүрэлдэхүүнд “бохир гартай” хандсан, шударга ёс, тэгш байдлын зарчим болон хууль бус үйлдлээс эрх үүсэхгүй (ex injuria jus non oritur) гэсэн зарчмын дагуу Арбитрын бүрэлдэхүүн нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгох ёстой гэсэн үндэслэлээр нэхэмжлэлийг хүлээн авч хэлэлцэх боломжийг эсэргүүцсэн.

1. Арбитрын бүрэлдэхүүний харьяаллын талаарх татгалзлууд

(a) Нэхэмжлэгчдийн хөрөнгө оруулалтыг олж авахад гарсан хулгай, хөрөнгө завших, залилангийн үйлдэл

Хариуцагчийн байр суурь

233. Хариуцагч Нэхэмжлэгчдийн хөрөнгө оруулалтыг хулгай, хөрөнгө завших, залилангийн замаар олж авсан гэсэн үндэслэлээр Арбитрын бүрэлдэхүүний харьяаллыг эсэргүүцсэн.

234. Хариуцагчийн тайлбарласнаар, Хэлэлцээрийн 1 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн шаардлагыг хангахын тулд хөрөнгө оруулалтыг “Хэлэлцэн тохирогч нөгөө улсын хууль тогтоомжийн

[303] Нэхэмжлэгчдийн Нэхэмжлэлийн үндэслэл, догол мөр 56.

дагуу” хийсэн байх ёстой.[304] “Хууль бусаар хийсэн хөрөнгө оруулалтаас үүдэлтэй маргаан нь талуудын өгсөн зөвшөөрлийн хүрээнд хамаарахгүй” гэсэн байр суурыа дэмжихдээ Хариуцагч Inceysa Vallisoletane, SL v. El Salvador хэргийг үндэслэсэн.[305] Gustav Hamester v. Ghana хэргийг ишилж, холбогдох гэрээний хууль ёсны байдлын тухай үг хэллэг хязгаарлагдмал байсан ч хууль бус байдал нь харьяаллыг үгүйсгэнэ гэж мөн тайлбарласан.[306] Нэхэмжлэгчдийн хулгай, хөрөнгө завших, залилангийн үр дагавар нь: (a) Хэлэлцээр тэдний хөрөнгө оруулалтыг хамгаалахгүй; (b) Нэхэмжлэгчид өөрсдийн хөрөнгө оруулалт гэж мэдүүлсэн зүйлдээ хүчин төгөлдөр эрхгүй болох явдал гэж Хариуцагч үзсэн.

235. Монголын эрүүгийн хууль “хөрөнгө завших, хөрөнгө завшихаар хуйвалдах, хөрөнгө завшсаныг нуун далдлах”; “залилангаар эд хөрөнгө авах, залилан үйлдэхээр хуйвалдах, залиланг нуун далдлах”; мөн “аж ахуйн нэгж, байгууллагын баримт бичгийг хулгайлах, устгах, гэмтээх, нуун далдлах”-ыг хориглодог.[307] НҮБ-ын Авлигын эсрэг конвенц болон БНХАУ, АНУ-ын дотоодын хуулийг ишилж, хөрөнгө завших нь “соёлт үндэстнүүдийн эрх зүйн суурь зарчмуудыг мөн зөрчдөг” гэж Хариуцагч тайлбарласан.[308]

236. Дарханы захирал асан ноён Нацагдорж 1990 оны 160 дугаар тогтоолоор олгосон Төмөртэйн ордыг ашиглах эрхийг Дарханаас Нэхэмжлэгчид рүү “залилангийн аргаар шилжүүлсэн” гэж Хариуцагч мэдүүлсэн.[309] Хариуцагчийн мэдүүлснээр, ноён Нацагдорж:

    (a) “Төмөртэйн ордын талаарх оюуны өмч, үүнд Дарханы техник, эдийн засгийн үндэслэл, тендерийн баримт, геологийн мэдээллийг БЛТ рүү шилжүүлсэн”;[310]

    (b) “Дарханы Төмөртэйн орд болон орд руу орох замын газрын эрхийг хүчингүй болгосон”;[311] мөн

    (c) “1997 оны Ашигт малтмалын тухай хуулийн дагуу Дарханы ордод эдлэх эрхийг бүртгүүлээгүй”.[312]

---

[304] Хэлэлцээр, зүйл 1(1).

[305] Хариуцагчийн Хариу үндэслэл, догол мөр 147; эшилсэн нь: Inceysa Vallisoletane, SL v. El Salvador, ICSID хэрэг № ARB/03/26, Арбитрын шийдвэр, 2006 оны 8 дугаар сарын 2, догол мөр 207 (Эрх зүйн эх сурвалж RLA-5).

[306] Хариуцагчийн Хариу үндэслэл, догол мөр 149; Gustav F W Hamester GmbH & Co KG v. Ghana, Арбитрын шийдвэр, ICSID хэрэг № ARB/07/24, 2010 оны 6 дугаар сарын 10, догол мөр 135 (Эрх зүйн эх сурвалж RLA-7).

[307] Хариуцагчийн Хариу үндэслэл, догол мөр 150; мөн үзнэ үү: Монгол Улсын Эрүүгийн хууль, зүйлүүд 148, 150, 234.2, & 247 (Эрх зүйн эх сурвалж RLA-8).

[308] Хариуцагчийн Хариу үндэслэл, догол мөр 154.

[309] Хариуцагчийн Хариу үндэслэл, догол мөр 156.

[310] Хариуцагчийн Хариу үндэслэл, догол мөр 157; Сонсголын тэмдэглэл (өдөр 1, 2015 оны 9 дугаар сарын 14) 151:3–157:15; Сонсголын тэмдэглэл (өдөр 5, 2015 оны 9 дугаар сарын 18), 815:5–816:13.

[311] Хариуцагчийн Хариу үндэслэл, догол мөр 157.

[312] Хариуцагчийн Хариу үндэслэл, догол мөр 157; Сонсголын тэмдэглэл (өдөр 1, 2015 оны 9 дугаар сарын 14) 157:16–161:2.

237. Нэхэмжлэгчид Дарханд ашиглалтын тусгай зөвшөөрлөө алдсаны, оюуны өмчийнх нь, эсхүл Төмөртэйн ордын гадаргын газрын эрхээс татгалзсаны нөхөн төлбөр өгөөгүй тул ийм үйлдлийг "залилангийн шинжтэй гэж урьдчилан үзэх" үндэстэй гэж Хариуцагч мэдүүлсэн.[313] Эдгээр үйлдлийг "Дарханы хуучин ажилтнуудад хахууль өгөх замаар санхүүжүүлсэн",[314] тухайлбал Нэхэмжлэгчид ноён Хүдэрбатад техник, эдийн засгийн үндэслэлийн төлөө мөнгө төлсөн тул бодитоор ч залилан байсан гэж Хариуцагч үзсэн. Ийм шалтгаанаар Монголд ноён Баярцогт, хатагтай Туяа, ноён Нацагдорж нарт эрүүгийн ажиллагаа явуулж, Нэхэмжлэгчдийн ашиглалтын тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон гэж Хариуцагч тайлбарласан.[315] Тэдэнд холбогдох эрүүгийн хэргийг хэрэгсэхгүй болгосон боловч дараа нь Ерөнхий прокурор уг шийдвэрийг хууль бус, үндэслэлгүй гэж тогтоосон хэмээн Хариуцагч нэмж дурдсан.[316] Төмөртэй Хүдэр хамтарсан үйлдвэрийг байгуулах хэлцлийн баримтуудад хууль ёсны байдлын талаар мэдэгдэл, баталгаа байгаагүй,[317] мөн Нэхэмжлэгчид Төмөртэй Хүдэрийн хувьцаанд харьцангуй бага төлбөр төлсөн[318] шалтгаан нь ч залилан байсан гэж Хариуцагч мэдүүлсэн.

238. БЛТ болон DMP-ийн техник, эдийн засгийн үндэслэлийн ижил төстэй байдлыг архив дахь нийтэд нээлттэй геологийн мэдээллээр тайлбарлах боломжтойг Хариуцагч мөн няцаасан. БЛТ-ийн техник, эдийн засгийн үндэслэл болон Дарханы өмнөх баримтууд, 160 дугаар тогтоолд үйлдвэрийн байгууламж, Японы компаниудтай хамтран ажиллах талаар ижил мэдээлэл байгааг Хариуцагч заасан.[319]

239. Эрх зүйн хувьд, авлигыг эцэслэн нотлоход бэрхшээлтэй байдаг тул хөрөнгө оруулалтын арбитрын бүрэлдэхүүнүүд нотлох өндөр босго шаардахын оронд нотлох үүргийг шилжүүлэх арга хэрэглэдэг болсон гэж Хариуцагч тайлбарласан. Asian Agricultural Products Ltd. (AAPL) v. Democratic Socialist Republic of Sri Lanka,[320] Rockwell International Systems, Inc. v. Government of the Islamic Republic of Iran,[321] ICC-ийн 6497 дугаар хэргийг[322]

---

[313] Хариуцагчийн Хариу үндэслэл, догол мөр 158.

[314] Хариуцагчийн Хариу үндэслэл, догол мөр 159.

[315] Хариуцагчийн Хариу үндэслэл, догол мөр 160.

[316] Сонсголын тэмдэглэл (өдөр 1, 2015 оны 9 дугаар сарын 14) 176:20–178:2; Монгол Улсын Ерөнхий прокурорын газрын прокурорын 1 дүгээр тогтоол буюу шийдвэр, 2014 оны 1 дугаар сарын 6 (Баримт R-133).

[317] Хариуцагчийн Хариу үндэслэл, догол мөрүүд 101-111, 162.

[318] Хариуцагчийн Хариу үндэслэл, догол мөр 163.

[319] Сонсголын тэмдэглэл (өдөр 5, 2015 оны 9 дугаар сарын 18), 819:16–823:22.

[320] Asian Agricultural Products. Ltd. (AAPL) v. Democratic Socialist Republic of Sri Lanka, ICSID хэрэг № ARB/87/3, Арбитрын шийдвэр, 1990 оны 6 дугаар сарын 27 (Эрх зүйн эх сурвалж CLA-25/RLA-98).

[321] Rockwell International Systems, Inc. v. Government of the Islamic Republic of Iran, Арбитрын шийдвэр № 438-430-1 1989 оны 9 дугаар сарын 5, 23 Iran-US Cl. Trib. Rep. 150, 188.

[322] 1994 оны 6497 дугаар хэргийн эцсийн шийдвэр, Альберт Ян ван ден Берг (ред.), «Худалдааны арбитрын жилийн эмхэтгэл 1999», XXIV боть, хуудас 72 (Эрх зүйн эх сурвалж RLA-99).

үндэслэн, Арбитрын бүрэлдэхүүн “нотлох баримт олж авахад хүндрэлтэйг баримтууд харуулсан, мөн авлигын талаарх мэдэгдлийг дэмжих анхан харахад хангалттай нотолгоо буюу үндэслэлтэй дүгнэлт байгаа тохиолдолд нотлох үүргийг эсрэг талд шилжүүлж болно” гэж Хариуцагч тайлбарласан.[323] EDF (Services) Ltd. v. Romania хэрэгт хэрэглэсэн өндөр босгыг[324] Румыний Засгийн газрын хамгийн өндөр түвшний албан тушаалтнууд оролцсонтой холбоотой шаардлага байсан гэж Хариуцагч ялган тайлбарласан.[325]

240. Хариуцагчийн тайлбарласнаар, “Нэхэмжлэгчдийн төлбөрүүдийн үл нийцэл, Дархан тусгай зөвшөөрлөө хамгаалж, хадгалж чадаагүй байдал, мөн Дарханы техникийн болон санхүүгийн нарийн мэдээлэл, тэр дундаа техник, эдийн засгийн үндэслэлийн огноог дуурайсан БЛТ-ийн “гэнэт хаанаас ч юм гарч ирсэн” санал нь энэ хэлцлийн цаана авлига байсныг бүгд харуулж байна”.[326] Иймд “Арбитрын бүрэлдэхүүний шийдвэрлэх гол асуулт ... нь Хариуцагч 939A тусгай зөвшөөрлийг хууль бусаар авсныг бүрэн нотолсон эсэх биш, харин энэхүү мэдэгдэл үнэн болохыг анхан харахад дэмжих нотолгоо гаргасан эсэх юм” гэж Хариуцагч тайлбарласан.[327]

241. Нэхэмжлэгчдийн үйлдсэн гэх хөрөнгө завших үйлдэл нь Төмөртэйн ашиглалтын тусгай зөвшөөрөлд эдлэх өмчлөх эрхийг нь хүчин төгөлдөр бус болгох тул тэдний шаардлагад харьяалал үүсгэхүйц шаардлага хангасан хөрөнгө оруулалт байхгүй гэж Хариуцагч мөн мэдүүлсэн.[328] Anderson v. Costa Rica хэргийг[329] үндэслэн “өмчлөхийг нь өөрийг нь хуулиар хориглосон хөрөнгө хөрөнгө оруулалт болж чадахгүй” гэж тайлбарлаж,[330] тусгай зөвшөөрлийг залилан, хөрөнгө завших, хулгайн замаар авсан тул Нэхэмжлэгчид БЛТ-ээр дамжуулан Төмөртэйн ашиглалтын тусгай зөвшөөрлийг хууль ёсоор эзэмшдэггүй гэж маргасан.

242. “Тусгай зөвшөөрөл авах санал гаргах боломжийг ... хөрөнгө завших замаар” олж авснаас гадна,[331] Нэхэмжлэгчид Төмөртэйн ашиглалтын тусгай зөвшөөрлийг авахын тулд Монголын эрх бүхий байгууллагуудад залилангийн шинжтэй худал мэдээлэл өгсөн гэж

---

[323] Хариуцагчийн Давтан хариу тайлбар, догол мөр 149; мөн үзнэ үү: Сонсголын тэмдэглэл (өдөр 1, 2015 оны 9 дугаар сарын 14) 172:16–173:9

[324] EDF (Services) Ltd. v. Romania, ICSID хэрэг № ARB/05/13, Арбитрын шийдвэр, 2009 оны 10 дугаар сарын 8 (Эрх зүйн эх сурвалж RLA-96).

[325] Хариуцагчийн Давтан хариу тайлбар, догол мөр 150.

[326] Хариуцагчийн Давтан хариу тайлбар, догол мөр 154; мөн үзнэ үү: Сонсголын тэмдэглэл (өдөр 1, 2015 оны 9 дугаар сарын 14) 151:24–155:14.

[327] Хариуцагчийн Давтан хариу тайлбар, догол мөр 143.

[328] Хариуцагчийн Хариу үндэслэл, догол мөр 164-168; мөн үзнэ үү: Сонсголын тэмдэглэл (өдөр 1, 2015 оны 9 дугаар сарын 14) 174:12–175:14.

[329] Alasdair Ross Anderson et al v. Republic of Costa Rica, ICSID хэрэг № ARB(AF)/07/3, Арбитрын шийдвэр, 2010 оны 5 дугаар сарын 10, догол мөр 57 (Эрх зүйн эх сурвалж RLA-13).

[330] Хариуцагчийн Хариу үндэслэл, догол мөр 167.

[331] Хариуцагчийн Хариу үндэслэл, догол мөр 165.

Хариуцагч тайлбарласан.[332] Тэрээр БЛТ-ийн “санхүүгийн чадавх”,[333] “төслийн туршлага”,[334] “хамтарсан үйлдвэрийн түншүүдийн жинхэнэ хэн болох”,[335] үйл ажиллагааны богино хугацаа,[336] Дарханд түүхий эд нийлүүлэх зорилго,[337] Япон болон барууны технологи худалдан авах зорилгын[338] талаар өгсөн худал мэдээллийг дэлгэрүүлсэн. Чайна Хэйлунзяны оролцоог Монгол Улс мэдээгүй, дэмжээгүй,[339] мөн гурван Нэхэмжлэгч бүгд 2005 он хүртэл гадаадын хөрөнгө оруулагчаар бүртгүүлээгүйг Хариуцагч давтан тэмдэглэсэн.[340]

243. Тусгай зөвшөөрөл олгохоос өмнө ноён Ли, Циньлун, Чайна Хэйлунзян нарын хооронд бизнесийн холбоо байсан;[341] БЛТ компанийг бүртгүүлэх амлалтынхаа хариуд ашгийн талаас илүү хувийг авахыг Чайна Хэйлунзян зөвшөөрөхөд бэлэн байсан;[342] эцэст нь, тусгай зөвшөөрөлд зохих нягтлан шалгалт хийсэн ямар ч нотолгоо байхгүй[343] тул Нэхэмжлэгчид БЛТ-ийн үйлдсэн гэх хууль бус үйлдлээс өөрсдийгөө салгаж чадахгүй гэж Хариуцагч тайлбарласан.

244. Энэ хэргийг Inceysa v. El Salvador хэргийн баримттай харьцуулан,[344] Нэхэмжлэгчдийн өгсөн гэх худал мэдээлэлд үндэслэн Арбитрын бүрэлдэхүүн харьяалалгүй гэж шийдвэрлэх ёстой гэж Хариуцагч маргасан.[345] Технологийг Монголд шилжүүлэх талаар Монголын эрх бүхий байгууллагуудад өгсөн БЛТ-ийн “залилангийн шинжтэй амлалтууд”[346] нь ач

---

[332] Хариуцагчийн Хариу үндэслэл, догол мөр 169; мөн үзнэ үү: Сонсголын тэмдэглэл (өдөр 5, 2015 оны 9 дугаар сарын 18) 875:4–875:14.

[333] Хариуцагчийн Хариу үндэслэл, догол мөр 170.

[334] Хариуцагчийн Хариу үндэслэл, догол мөр 171; Сонсголын тэмдэглэл (өдөр 1, 2015 оны 9 дугаар сарын 14) 144:18–145:17.

[335] Хариуцагчийн Хариу үндэслэл, догол мөр 172; мөн үзнэ үү: Сонсголын тэмдэглэл (өдөр 5, 2015 оны 9 дугаар сарын 18), 813:17–814:16.

[336] Сонсголын тэмдэглэл (өдөр 1, 2015 оны 9 дугаар сарын 14) 149:19–151:2; Сонсголын тэмдэглэл (өдөр 5, 2015 оны 9 дугаар сарын 18), 813:5–813:10.

[337] Хариуцагчийн Хариу үндэслэл, догол мөр 173; Сонсголын тэмдэглэл (өдөр 1, 2015 оны 9 дугаар сарын 14) 146:8–149:9.

[338] Хариуцагчийн Хариу үндэслэл, догол мөрүүд 176-180; Сонсголын тэмдэглэл (өдөр 5, 2015 оны 9 дугаар сарын 18), 814:17-24.

[339] Сонсголын тэмдэглэл (өдөр 1, 2015 оны 9 дугаар сарын 14) 140:9–141:14.

[340] Сонсголын тэмдэглэл (өдөр 1, 2015 оны 9 дугаар сарын 14) 168:16–170:11.

[341] Сонсголын тэмдэглэл (өдөр 1, 2015 оны 9 дугаар сарын 14) 162:5–165:7.

[342] Сонсголын тэмдэглэл (өдөр 1, 2015 оны 9 дугаар сарын 14) 167:5–168:15; БЛТ болон Чайна Хэйлунзяны хооронд байгуулсан Төмөртэйн төмрийн хүдрийн ордыг хамтран хөгжүүлэх гэрээ, 1997 оны 7 дугаар сарын 20 (Баримт C-48).

[343] Сонсголын тэмдэглэл (өдөр 1, 2015 оны 9 дугаар сарын 14) 165:18–166:17.

[344] Inceysa Vallisoletane, SL v. El Salvador, ICSID хэрэг № ARB/03/26, Арбитрын шийдвэр, 2006 оны 8 дугаар сарын 2, догол мөр 236 (Эрх зүйн эх сурвалж RLA-5).

[345] Хариуцагчийн Хариу үндэслэл, догол мөр 169.

[346] Хариуцагчийн Хариу үндэслэл, догол мөр 180.

холбогдолтой төдийгүй “Арбитрын бүрэлдэхүүн харьяаллаас татгалзах бие даасан үндэслэл” гэж тайлбарласан.[347] Plama v. Bulgaria хэргийн шийдвэрийг[348] үндэслэн, БЛТ-ийн өмчлөлийн бүтцэд орсон өөрчлөлтийг Монголын төрд ил болгох үүрэг Нэхэмжлэгчдэд байсан бөгөөд үүнийг биелүүлээгүй нь ач холбогдолтой худал мэдээлэл болсон гэж Хариуцагч мөн үзсэн.[349]

Нэхэмжлэгчдийн байр суурь

245. Хариуцагч “өөрийн мэдэгдлүүдийн алийг нь ч нотлоогүй” гэж Нэхэмжлэгчид тайлбарласан.[350] Монголын эрх бүхий байгууллагууд ноён Баярцогт, ноён Нацагдорж нарыг таван жил шалгасан ч яллаагүй, ямар ч тохиолдолд буруутгал нь Нэхэмжлэгчдэд бус, хувь хүмүүс болон БЛТ-д хамаарч байсан гэж тэмдэглэсэн.[351] Хувьцаа шилжүүлэх гэрээнд мэдэгдэл, баталгаа байгаагүй нь “юуг ч нотлохгүй”[352] бөгөөд Монгол Улс “хулгай, залилангийн талаарх мэдэгдлээ нотлох ямар ч баримт гаргаагүй” гэж Нэхэмжлэгчид мэдүүлсэн.[353] Нэгтгэн үзвэл, Хариуцагч хулгай, залилан, хөрөнгө завшсан гэх мэдэгдэлдээ нотлох үүргээ биелүүлээгүй бөгөөд хангалтгүй баримтаас ийм үйлдлүүдийг таамаглан дүгнэхийг Арбитрын бүрэлдэхүүнээс хууль бусаар шаардаж байна гэж Нэхэмжлэгчид тайлбарласан.

246. Нэхэмжлэгчдийн үзэж байгаагаар, “Хариуцагч Арбитрын бүрэлдэхүүнээс залилан байсан гэж дүгнэхийг дараах зүйлд тулгуурлан үндсэндээ хүсэж байна:

> (a) Нэхэмжлэгчид 1997 оны Техник, эдийн засгийн үндэслэлд ишилсэн баримтууд болон 1997 оноос өмнөх БЛТ, ноён Баярцогт, Ли Шаоминг нарын харилцааны бүртгэлийг ирүүлээгүй; (b) хувьцаа шилжүүлэх зарим гэрээнд 939A тусгай зөвшөөрлийн хууль ёсны байдлын талаар мэдэгдэл, баталгаа байхгүй”.[354] Үүнийг Нэхэмжлэгчид “нотлох үүргийг зөвшөөрөгдөхгүй байдлаар шилжүүлэх” явдал гэж үзсэн.[355]

247. Хариуцагчийн залилан, хулгайн талаарх мэдэгдэл “эрх зүйн хувьд үндэслэлгүй” гэж Нэхэмжлэгчид маргасан.[356] EDF v. Romania[357] болон African Holding Company v. Congo[358]

---

[347] Хариуцагчийн Хариу үндэслэл, догол мөр 180.

[348] Plama Consortium Ltd v. Bulgaria, ICSID хэрэг № ARB/03/24, Арбитрын шийдвэр, 2008 оны 8 дугаар сарын 27, догол мөр 145 (Эрх зүйн эх сурвалж RLA-19).

[349] Хариуцагчийн Хариу үндэслэл, догол мөр 175.

[350] Нэхэмжлэгчдийн Хариу тайлбар, догол мөр 90.

[351] Нэхэмжлэгчдийн Хариу тайлбар, догол мөрүүд 90, 95; мөн үзнэ үү: Сонсголын тэмдэглэл (өдөр 5, 2015 оны 9 дугаар сарын 18) 749:16–750:17, эш татсан нь: эсрэг талаас асуусан асуултад өгсөн мэдүүлэг, хатагтай Тайван, Сонсголын тэмдэглэл (өдөр 4, 2015 оны 9 дугаар сарын 17) 698:19–702:20, 728:4–728:7.

[352] Нэхэмжлэгчдийн Хариу тайлбар, догол мөр 92.

[353] Нэхэмжлэгчдийн Хариу тайлбар, догол мөр 93; мөн үзнэ үү: Сонсголын тэмдэглэл (өдөр 1, 2015 оны 9 дугаар сарын 14) 74:24–75:20

[354] Нэхэмжлэгчдийн Хариу тайлбар, догол мөр 92.

[355] Нэхэмжлэгчдийн Хариу тайлбар, догол мөр 92.

[356] Нэхэмжлэгчдийн Хариу тайлбар, догол мөр 94.

хэргийг ишилж, авлигыг нотлоход өндөр босго хэрэглэх ёстой талаар “нийтлэг зөвшилцөл” байдаг гэж тэмдэглэсэн.[359] Anderson v. Costa Rica хэрэгт нэхэмжлэгчдийг гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцсон тул энэ хэргээс бүрэн ялгаатай гэж Нэхэмжлэгчид үзсэн. Харин энд Монголын эрх бүхий байгууллагууд Нэхэмжлэгчдийн эсрэг бүх буруутгалыг хэрэгсэхгүй болгосон. 2014 оны 1 дүгээр тогтоол Монголын Эрүүгийн байцаан шийтгэх хуульд нийцээгүй, ямар ч тохиолдолд Монголын хуулиар зөвхөн шүүх гэм буруутай эсэхийг тогтоох эрхтэй гэж Нэхэмжлэгчид мөн тайлбарласан.[360]

248. Нэхэмжлэгчид ноён Ганжууржав,[361] ноён Шагдар[362] нарыг эсрэг талаас асуулт тавьж байцаасан мэдүүлэг болон ноён Хурцын гэрчийн мэдүүлгийг[363] мөн үндэслэсэн. Тэд бүгд DMP-ийн техник, эдийн засгийн үндэслэлийн хэд хэдэн хувь байсан гэж мэдүүлсэн бөгөөд ноён Ганжууржавын хэлснээр зарим нь төрийн архивт одоо ч байж болох ажээ.[364] Ноён Шагдарын хэлснээр, хулгайлсан гэх баримт нь бүрэн техник, эдийн засгийн үндэслэл бус, зөвхөн эхний шатны баримт байсан, ямар ч тохиолдолд ордын геологийн мэдээлэл ижил байх учиртайг Нэхэмжлэгчид мөн тэмдэглэсэн.[365] DMP-ийн техник, эдийн засгийн үндэслэлийг хулгайлсан талаар Монгол Улс үнэмшилтэй нотлох баримт гаргаагүй гэж Нэхэмжлэгчид тайлбарласан.[366]

249. Нэхэмжлэгчид залилангийн шинжтэй худал мэдээлэл өгсөн гэх Хариуцагчийн мэдэгдлийг мөн эсэргүүцсэн. Техник, эдийн засгийн үндэслэлд байсан аливаа алдаа нь залилангийн шинжтэй байсныг Хариуцагч тогтоогоогүй, мөн “(залилангийн шинжтэй) худал мэдээллийн гол бүрэлдэхүүн болох уг мэдээлэлд тулгуурласан байдлыг”[367] болон хууран

---

[357] EDF (Services) Ltd v. Romania, ICSID хэрэг № ARB/05/13, Арбитрын шийдвэр, 2009 оны 10 дугаар сарын 8, догол мөр 221 (Эрх зүйн эх сурвалж RLA-96).

[358] African Holding Company of America, Inc. and Société Africaine de Construction au Congo S.A.R.L. v. La République démocratique du Congo, ICSID хэрэг № ARB/05/21, Харьяаллын татгалзал болон нэхэмжлэлийг хүлээн авах боломжийн тухай шийдвэр, 2008 оны 7 дугаар сарын 29, догол мөр 55 (Эрх зүйн эх сурвалж CLA-152).

[359] Сонсголын тэмдэглэл (өдөр 1, 2015 оны 9 дугаар сарын 14) 75:21–79:2.

[360] Сонсголын тэмдэглэл (өдөр 5, 2015 оны 9 дугаар сарын 18) 759:19–761:22; эсрэг талаас асуусан асуултад өгсөн мэдүүлэг, хатагтай Тайван, Сонсголын тэмдэглэл (өдөр 4, 2015 оны 9 дугаар сарын 17) 710:13–710:17.

[361] Эсрэг талаас асуусан асуултад өгсөн мэдүүлэг, ноён Ганжууржав, Сонсголын тэмдэглэл (өдөр 3, 2015 оны 9 дугаар сарын 18) 463:6–464:6, мөн үзнэ үү: Ноён Ганжууржавын гэрчийн мэдүүлэг, догол мөр 26.

[362] Эсрэг талаас асуусан асуултад өгсөн мэдүүлэг, ноён Шагдар, Сонсголын тэмдэглэл (өдөр 3, 2015 оны 9 дугаар сарын 18) 426:22–427:1.

[363] Ноён Хурцын гэрчийн мэдүүлэг, догол мөр 9

[364] Арбитрын бүрэлдэхүүний асуултууд, ноён Ганжууржав, Сонсголын тэмдэглэл (өдөр 3, 2015 оны 9 дугаар сарын 18) 494:1–494:16.

[365] Эсрэг талаас асуусан асуултад өгсөн мэдүүлэг, ноён Шагдар, Сонсголын тэмдэглэл (өдөр 3, 2015 оны 9 дугаар сарын 18) 422:20–423:8; 427:19–427:23.

[366] Сонсголын тэмдэглэл (өдөр 5, 2015 оны 9 дугаар сарын 18) 751:17–756:1.

[367] Нэхэмжлэгчдийн Хариу тайлбар, догол мөр 98.

мэхлэх санаа зорилгыг[368] нотлоогүй гэж Нэхэмжлэгчид тайлбарласан. “Эрх бүхий байгууллага техник, эдийн засгийн үндэслэлийн тодорхой мэдээллээс шалтгаалан тусгай зөвшөөрөл олгохоос татгалзах эрхгүй байсан тул тусгай зөвшөөрөл олгох шийдвэртээ уг мэдээлэлд тулгуурласан гэж ямар ч байдлаар үзэх боломжгүй” гэж Нэхэмжлэгчид мэдүүлсэн.[369]

250. Залилангийн шинжтэй худал мэдээлэл нь хөрөнгийг албадан хураахыг зөвтгөнө гэсэн Хариуцагчийн үндэслэлийг Нэхэмжлэгчид цааш эсэргүүцэж, Хариуцагч “ийм нөхцөлд ашиглалтын тусгай зөвшөөрлийг хүчингүй болгохыг зөвшөөрсөн Монголын хуулийн ямар ч заалт” ишлээгүй гэж мэдүүлсэн.[370] Үнэн хэрэгтээ 1994 оны Ашигт малтмалын тухай хуульд залилангийн шинжтэй худал мэдээлэл өгөх нь тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох үндэслэл биш бөгөөд “худал мэдээлэл, бүртгэл” нь зөвхөн торгууль төлөх үр дагавартай.[371] Энэ талаар Хариуцагч Gustav Hamester v. Ghana, Inceysa v. El Salvador, Plama v. Bulgaria хэргүүдийг үндэслэсэн нь буруу гэж Нэхэмжлэгчид үзсэн.[372] Эдгээр хэргийн арбитрын бүрэлдэхүүнүүд залилангийн шинжтэй худал мэдээллийн тухай мэдэгдлийг “таамаглал”-аар бус, баттай нотлохыг шаардсан[373] бөгөөд Хариуцагч энэ үүргээ биелүүлээгүй гэж онцолсон.

251. Техник, эдийн засгийн үндэслэлд залилангийн шинжтэй худал мэдээлэл байсан нь тогтоогдсон ч дараах нөхцөлийн улмаас Хариуцагч түүнийг үндэслэх эрхгүй байх ёстой гэж Нэхэмжлэгчид үзсэн:

> (a) “939A тусгай зөвшөөрлийг хүчингүй болгохдоо Монголын эрх бүхий байгууллагууд эдгээр худал мэдээллийг үндэслээгүй”;[374]
>
> (b) “Монголын Засгийн газар хятад хөрөнгө оруулагчдыг Төмөртэйн уурхайд хөрөнгө оруулахыг урьсан бөгөөд Төмөртэй Хүдэрт оруулсан хөрөнгө оруулалтыг нь (Төмөртэй Хүдэрийг байгуулахыг зөвшөөрсний нэгэн адил) зөвшөөрсөн”;[375]
>
> (c) “эрх бүхий байгууллагууд 939A тусгай зөвшөөрлийг БЛТ-ээс Төмөртэй Хүдэрт шилжүүлэхийг зөвшөөрсөн”;[376] мөн
>
> (d) “Төмөртэй Хүдэр Төмөртэйн ордыг ашиглаж эхлэхээсээ өмнө ирүүлсэн ажлын төлөвлөгөөнүүдийн талаар Монголын эрх бүхий байгууллагуудад мэдээлж, тэдгээрийг баталсан. Эдгээр төлөвлөгөө нь 1997 оны Техник, эдийн засгийн

---

[368] Сонсголын тэмдэглэл (өдөр 5, 2015 оны 9 дугаар сарын 18) 756:21–757:24, эш татсан нь: эсрэг талаас асуусан асуултад өгсөн мэдүүлэг, хатагтай Дарижав, Сонсголын тэмдэглэл (өдөр 3, 2015 оны 9 дугаар сарын 18) 562:21–562:23, 563:6–563:13.

[369] Нэхэмжлэгчдийн Хариу тайлбар, догол мөр 100.

[370] Нэхэмжлэгчдийн Хариу тайлбар, догол мөр 96.

[371] Нэхэмжлэгчдийн Хариу тайлбар, догол мөрүүд 101-102.

[372] Нэхэмжлэгчдийн Хариу тайлбар, догол мөр 103-106.

[373] Нэхэмжлэгчдийн Хариу тайлбар, догол мөр 103.

[374] Нэхэмжлэгчдийн Хариу тайлбар, догол мөр 107.

[375] Нэхэмжлэгчдийн Хариу тайлбар, догол мөр 107.

[376] Нэхэмжлэгчдийн Хариу тайлбар, догол мөр 107.

үндэслэлээс хойш ордыг ашиглах төлөвлөгөө хэрхэн хөгжсөнийг бүгд харуулж байсан".[377]

(b) Албадан хураасан гэх үйлдлийн хариуцлагыг тогтоох харьяаллыг Хэлэлцээр олгож байгаа эсэх

252. Хэлэлцээрийн 8 дугаар зүйлийн холбогдох хэсэгт дараах байдлаар заасан:

> 1. Хэлэлцэн тохирогч нэг улсын хөрөнгө оруулагч болон Хэлэлцэн тохирогч нөгөө улсын хооронд тухайн нөгөө улсын нутаг дэвсгэрт хийсэн хөрөнгө оруулалттай холбоотой үүссэн аливаа маргааныг боломжтой хэмжээнд маргалдагч талуудын хэлэлцээгээр эвийн журмаар шийдвэрлэнэ.
>
> 2. Хэлэлцээгээр зургаан сарын дотор маргааныг шийдвэрлэж чадаагүй бол маргалдагч аль ч тал маргааныг хөрөнгө оруулалт хүлээн авсан Хэлэлцэн тохирогч улсын эрх бүхий шүүхэд шилжүүлэх эрхтэй.
>
> 3. Хөрөнгө албадан хураасны нөхөн төлбөрийн хэмжээтэй холбоотой маргааныг энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан хэлэлцээнд хандсанаас хойш зургаан сарын дотор шийдвэрлэж чадаагүй бол аль нэг талын хүсэлтээр тусгайлан байгуулах арбитрын бүрэлдэхүүнд шилжүүлж болно. Холбогдох хөрөнгө оруулагч энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан журмыг хэрэглэсэн бол энэ хэсгийн заалт үйлчлэхгүй. [...]

Хариуцагчийн байр суурь

253. Хэлэлцээрийн 8 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасан Монгол Улсын арбитрт зөвшөөрсөн хүрээ нь Нэхэмжлэгчдийн шаардлагын зүйлд хамаарахгүй гэсэн үндэслэлээр Хариуцагч Арбитрын бүрэлдэхүүний харьяаллыг эсэргүүцсэн.

254. Хариуцагчийн тайлбарласнаар, Хэлэлцээрийн 8 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн үг хэллэг "арбитрын хүрээг нөхөн төлбөрийн хэмжээний асуудлаарх маргаанаар тодорхой хязгаарлаж, хариуцлагын асуудлыг хөрөнгө оруулалт хүлээн авагч улсын эрх бүхий шүүхээр шийдвэрлүүлэх"-ээр заасан.[378] Хариуцагчийн үзэж байгаагаар, "8 дугаар зүйлийн 3 дахь хэсэг нь өөрийн илэрхий агуулгаараа онцгой заалт" бөгөөд хоёр талт хөрөнгө оруулалтын хэлэлцээрийн "харьяаллын ерөнхий заалт нь 8 дугаар зүйлийн 3 дахь хэсэг бус, харин 2 дахь хэсэг" буюу хөрөнгө оруулалт хүлээн авагч улсын эрх бүхий шүүхийг заасан заалт юм.[379]

255. Хэлэлцээрийн бичвэрийг тайлбарлахдаа Хариуцагч 8 дугаар зүйлийн 3 дахь хэсэг дэх "маргаан" гэсэн үгэнд төвлөрч, олон улсын эрх зүй дэх энэ нэр томьёоны утгын талаар Mavrommatis Palestine Concessions[380] хэргээс эхлэн Peace Treaties with Bulgaria, Hungary and

---

[377] Нэхэмжлэгчдийн Хариу тайлбар, догол мөр 107.

[378] Хариуцагчийн Давтан хариу тайлбар, догол мөр 156; мөн үзнэ үү: Сонсголын тэмдэглэл (өдөр 1, 2015 оны 9 дугаар сарын 14) 182:11–186:11.

[379] Хариуцагчийн Хариу үндэслэл, догол мөрүүд 192, 195.

[380] Mavrommatis Palestine Concessions (Greece v. Great Britain), Шүүхийн шийдвэр, 1924 оны 8 дугаар сарын 30, P.C.IJ. (Ser. A) No. 2, хуудас 11 (Эрх зүйн эх сурвалж RLA-103).

Romania,[381] улмаар сүүлийн үеийн хөрөнгө оруулалтын арбитрын хэргүүд хүртэл тогтвортой хэрэглэж ирсэн практикийг дурдсан. Хариуцагчийн тайлбарласнаар, 8 дугаар зүйлийн 3 дахь хэсгийг тайлбарлахад "зохистой шалгуур нь Нэхэмжлэгчдийн шаардлага нөхөн төлбөрийн хэмжээг хамарч байгаа эсэх бус, харин талуудын хоорондох маргаан нөхөн төлбөрийн хэмжээг хамарч байгаа эсэх" юм.[382] Нэхэмжлэгчид Төмөртэйн тусгай зөвшөөрлийг буцаан олгохыг хүссэн, мөнгөн нөхөн төлбөрийн шаардлага гаргаагүй тул "талууд нөхөн төлбөрийн хэмжээтэй холбоотой маргаантай гэж Нэхэмжлэгчид мэдэгдээгүй, үнэндээ мэдэгдэх ч боломжгүй" гэж Хариуцагч тайлбарласан.[383] Ямар ч тохиолдолд Хэлэлцээрийн үг хэллэг олон улсын эрх зүйн ерөнхий дүрмээс давуу үйлчлэх тул буцаан олгох шаардлага нь 8 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн хүрээнд хамаарахгүй гэж Хариуцагч үзсэн.[384] Нэхэмжлэгчид "холбоотой" гэсэн үгэнд төвлөрснийг Хариуцагч мөн эсэргүүцэж, 8 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн бүх үг, ялангуяа "...-ны нөхөн төлбөрийн хэмжээ" гэсэн шийдвэрлэх үг хэллэгийг харгалзах ёстой гэж тайлбарласан.[385]

256. Хариуцагчийн үзэж байгаагаар, Нэхэмжлэгчид 8 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн бичвэрийг авч үзэхийн оронд "EMV v. Czech Republic, Renta, Tza Yap хэргийн шийдвэрүүдийг ишлэн Хэлэлцээрийг зорилгоор нь тайлбарлах оролдлого хийж байна".[386] "Гурван хэрэг бүгд материаллаг утгаараа өөр үг хэллэгтэй, өөр өөр гэрээнд хамаардаг" тул энэ нь амжилтгүй гэж Хариуцагч үзсэн.[387] Тухайлбал, EMV, Renta шийдвэрүүдийн үндэслэл болсон Чех–Бельги/Люксембург, Орос–Испанийн гэрээнүүд хөрөнгө албадан хураах тухай зүйлүүдэд илүү ерөнхий байдлаар ишилсэн гэж тэмдэглэсэн.[388] Түүнчлэн энэ Хэлэлцээрээс ялгаатай нь EMV, Renta хэрэгт хамаарах гэрээнүүдэд "дотоодын шүүхэд харьяалал олгосон заалт" байхгүй.[389] Хариуцагч эдгээр шийдвэрийн үндэслэлийн гүнзгий байдал болон "заалтын бусад бичвэрийг орхигдуулан "холбоотой", "хамаарах" гэсэн үгсэд" тулгуурласныг мөн шүүмжилсэн.[390] Үүнийг Хятад–Монголын хэлэлцээрт шилжүүлбэл "эдгээр арбитрын бүрэлдэхүүн өөрсдөө хүсүүштэй гэж үзсэн, өөрөөр хэлбэл арбитрын хүрээг нэмэгдүүлэх зорилгыг тулган хэрэглэж, тухайн гэрээнүүдийн оршилд туссан гэж үзсэнтэй" адил болно

---

[381] Болгар, Унгар, Румынтай байгуулсан энхийн гэрээнүүдийг тайлбарлах нь, Зөвлөх дүгнэлт, 1950 оны 3 дугаар сарын 30 (эхний шат), 1950 I.C.J. Reports, хуудас 65 хуудас 74 (Эрх зүйн эх сурвалж RLA-104).

[382] Хариуцагчийн Давтан хариу тайлбар, догол мөр 179 (онцлол эхэд бий).

[383] Хариуцагчийн Давтан хариу тайлбар, догол мөр 177 (онцлол эхэд бий).

[384] Сонсголын тэмдэглэл (өдөр 1, 2015 оны 9 дугаар сарын 14) 199:2–200:4.

[385] Сонсголын тэмдэглэл (өдөр 1, 2015 оны 9 дугаар сарын 14) 183:10–186:17; мөн үзнэ үү: Сонсголын тэмдэглэл (өдөр 5, 2015 оны 9 дугаар сарын 18) 889:17–894:2.

[386] Хариуцагчийн Хариу үндэслэл, догол мөр 211.

[387] Хариуцагчийн Хариу үндэслэл, догол мөр 210; мөн үзнэ үү: Сонсголын тэмдэглэл (өдөр 1, 2015 оны 9 дугаар сарын 14) 197:11–197:19

[388] Хариуцагчийн Хариу үндэслэл, догол мөр 212.

[389] Хариуцагчийн Давтан хариу тайлбар, догол мөрүүд 213, 216.

[390] Хариуцагчийн Хариу үндэслэл, догол мөр 211.

гэж Хариуцагч тайлбарласан.[391] Нэхэмжлэгчдийн үндэслэсэн Sanum v. Laos хэргийн арбитрын бүрэлдэхүүний байр суурь Венийн конвенцод нийцээгүй бөгөөд Сингапурын Дээд шүүх түүнийг няцаасан гэж Хариуцагч тэмдэглэсэн.[392]

257. Бусад арбитрын шийдвэрээс чиглэл авч болох хэмжээнд "Нэхэмжлэгчдийн санал болгосон тайлбар нь хязгаарлагдмал зөвшөөрлийн заалтыг зүй бусаар өргөжүүлж болохгүй гэж дүгнэсэн хэд хэдэн шийдвэртэй зөрчилдөнө" гэж Хариуцагч тэмдэглэсэн.[393] Энэ талаар Austrian Airlines v. Slovakia,[394] Telenor v. Hungary,[395] Berschader v. Russia,[396] ST-AD v. Bulgaria,[397] RosInvest v. Russian Federation[398] хэргүүдийг үндэслэж, Хэлэлцээрийн 8 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн арбитрын заалтын үг хэллэг нь эдгээр хэргийн гэрээнүүдийн арбитрын заалттай хангалттай төстэй тул Арбитрын бүрэлдэхүүн ижил үр дүнд хүрэх ёстой гэж тайлбарласан.[399]

258. Хариуцагчийн хувьд Нэхэмжлэгчдийн "өргөн" тайлбар нь 8 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн хязгаарласан үг хэллэгийг утгагүй болгоно.[400] Харин илүү хязгаарлагдмал тайлбараар ийм үр дагавар гарахгүй гэж Хариуцагч маргасан. Тухайлбал, хөрөнгө албадан хураах тухай Хэлэлцээрийн 4 дүгээр зүйлд албадан хураалтыг "зарлан мэдэгдэх" тухай дурдсаныг онцолсон. Хариуцагчийн тайлбарласнаар, "Монголын хуулиар "зарлан мэдэгдсэн" албадан хураалт гэдэг нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн дагуу хийсэн албадан хураалт" юм.[401] Хятадын хуульд мөн ижил төстэй заалт байдаг тул "уг заалт Монгол болон Хятадын хуулийн аль алиных нь хувьд тодорхой хүрээтэй".[402] Иймээс 8 дугаар зүйл бүх хөрөнгө оруулагчийг эхлээд дотоодын шүүх, дараа нь арбитрт хандахыг шаардахгүй;

---

[391] Хариуцагчийн Хариу үндэслэл, догол мөр 211.

[392] Сонсголын тэмдэглэл (өдөр 1, 2015 оны 9 дүгээр сарын 14), 197:19–197:21. Гэвч үүний дараа, энэ хэргийн сонсгол дууссаны хойно Sanum хэрэгт Дээд шатны шүүхийн гаргасан шийдвэрийг Сингапурын давж заалдах шатны шүүх хүчингүй болгосныг Арбитрын бүрэлдэхүүн тэмдэглэж байна. Дээрх 88 дугаар догол мөрийг үзнэ үү.

[393] Хариуцагчийн Давтан хариу тайлбар, догол мөр 249.

[394] Austrian Airlines v. Slovak Republic, UNCITRAL, Арбитрын шийдвэр, 2009 оны 10 дугаар сарын 9 (Эрх зүйн эх сурвалж CLA-43).

[395] Telenor Mobile Communications A.S. v. The Republic of Hungary, ICSID хэрэг № ARB/04/15, Арбитрын шийдвэр, 2006 оны 9 дугаар сарын 13 (Эрх зүйн эх сурвалж CLA-113).

[396] Vladimir Berschader and Moise Berschader v. The Russian Federation, SCC хэрэг № 080/2004, Арбитрын шийдвэр, 2006 оны 4 дугаар сарын 21 (Эрх зүйн эх сурвалж CLA-41).

[397] ST-AD GmbH v. Republic of Bulgaria, UNCITRAL, Харьяаллын тухай шийдвэр, 2013 оны 7 дугаар сарын 18 (Эрх зүйн эх сурвалж RLA-199); Сонсголын тэмдэглэл (өдөр 1, 2015 оны 9 дугаар сарын 14) 197:5–197:10.

[398] RosInvestCo UK Ltd. v. The Russian Federation, SCC хэрэг № V079/2005, Харьяаллын тухай шийдвэр, 2007 оны 10 дугаар сарын 1 (Эрх зүйн эх сурвалж CLA-42).

[399] Хариуцагчийн Давтан хариу тайлбар, догол мөрүүд 249-265.

[400] Хариуцагчийн Давтан хариу тайлбар, догол мөрүүд 182-184.

[401] Хариуцагчийн Хариу үндэслэл, догол мөр 201.

[402] Хариуцагчийн Хариу үндэслэл, догол мөр 201.

“хөрөнгийг нь албадан хураасан тухай мэдэгдэл буюу түүнтэй адил эрх зүйн шийдвэр гарсан хөрөнгө оруулагчид нөхөн төлбөрийн хэмжээний талаар маргаан үүсгэж болно”.[403]

259. Үүнтэй адил, 8 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн маргаан шийдвэрлэх замыг сонгох заалт нь хөрөнгө оруулагчийг албадан хураалтын хариуцлагын асуудлыг дотоодын шүүхэд, нөхөн төлбөрийн хэмжээг арбитрын бүрэлдэхүүнд тавихад саад болохгүй гэж Хариуцагч маргасан. Төмөртэй Хүдэрийн Монголын шүүхэд гаргасан олон нэхэмжлэл Арбитрын бүрэлдэхүүний харьяаллыг үгүйсгэхгүй гэж тайлбарлахдаа Нэхэмжлэгчид талууд, нэхэмжлэлийн үндэслэл, зүйл ижил байх шаардлагыг өөрсдөө онцолсныг Хариуцагч тэмдэглэж, “хариуцлага болон нөхөн төлбөрийн хэмжээний шаардлагууд өөр өөр маргаан үүсгэнэ” гэж тайлбарласан.[404] Түүнчлэн нэхэмжлэгч албадан хураалт болсныг тогтоолгох захиргааны нэхэмжлэл гаргах сонголттой гэж үзсэн.[405] Tza Yap Shum хэргийн бүрэлдэхүүн маргаан шийдвэрлэх замыг сонгох заалтын тогтсон практикийг авч үзэлгүй, “хөрөнгө оруулагч дотоодын шүүхэд хандсаны дараа олон улсын арбитрт хандах боломжгүй” гэсэн болзолгүй, нотолгоогүй таамаглалыг хүлээн авсан гэж Хариуцагч үзсэн.[406]

260. Хариуцагчийн үзэж байгаагаар, “Хэлэлцээрийн объект, зорилго ч харьяалалгүй гэж дүгнэхийг дэмждэг”.[407] Нэхэмжлэгчид Хэлэлцээрийн оршилд хэт их ач холбогдол өгч байна гэж үзсэн боловч ямар ч тохиолдолд “Хэлэлцээрт гарын үсэг зурах үед бүрэн эрхт байдал Монгол ... болон Хятадын аль алинд онцгой чухал асуудал байсан” бөгөөд энэ нь оршилд туссан гэж Хариуцагч маргасан.[408] Мөн “Хятадын хоёр талт хөрөнгө оруулалтын хэлэлцээрүүдийн талаарх эрдэм шинжилгээний бүтээлүүдэд тэдгээрийн оршлыг хөрөнгө оруулагчид нэг талыг барьсан давуу таамаглал үүсгэхээр тайлбарлаж болохгүйг тодорхойлсон” гэж тэмдэглэсэн.[409]

261. Хэлэлцээрийн бичвэр, хам сэдвээс цааш авч үзэн, Олон улсын гэрээний эрх зүйн тухай Венийн конвенцын 32 дугаар зүйлийг хэрэглэхэд тайлбарын гурван нэмэлт хэрэгсэл Хэлэлцээрийн 8 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн талаарх Монгол Улсын тайлбарыг дэмжинэ гэж Хариуцагч мэдүүлсэн:

> (а) Нэгдүгээрт, Хятадын хөрөнгө оруулалтын гэрээний анхны бодлого болон гэрээ байгуулах өмнөх практик нь “хариуцлагын асуудлыг олон улсын арбитрт

---

[403] Хариуцагчийн Давтан хариу тайлбар, догол мөр 187; мөн үзнэ үү: Сонсголын тэмдэглэл (өдөр 1, 2015 оны 9 дугаар сарын 14) 187:8–188:7

[404] Хариуцагчийн Давтан хариу тайлбар, догол мөр 192.

[405] Сонсголын тэмдэглэл (өдөр 1, 2015 оны 9 дугаар сарын 14) 189:4–190:7

[406] Хариуцагчийн Давтан хариу тайлбар, догол мөр 196.

[407] Хариуцагчийн Давтан хариу тайлбар, догол мөр 203; мөн үзнэ үү: Сонсголын тэмдэглэл (өдөр 1, 2015 оны 9 дугаар сарын 14) 190:8–198:7

[408] Хариуцагчийн Давтан хариу тайлбар, догол мөрүүд 210-211.

[409] Хариуцагчийн Давтан хариу тайлбар, догол мөр 217; мөн үзнэ үү: Сонсголын тэмдэглэл (өдөр 1, 2015 оны 9 дугаар сарын 14) 196:3–196:21.

шилжүүлэх хүсэлгүй байсныг" харуулдаг.[410] Хариуцагч ялангуяа ICSID-ийн конвенцод холбогдуулан Хятадын хийсэн тайлбарыг онцолсон.[411] "Хятад–Монголын хоёр талт хөрөнгө оруулалтын хэлэлцээрийг байгуулах үед Хятадын иймэрхэлэлцээрүүдэд арбитрт хязгаарлагдмал зөвшөөрөл өгөх нь нийтлэг байсан", мөн "Хятадын өмнөх гэрээний практик нь харьяаллын талаар хүлээх үүргийн хүрээг хязгаарлах БНХАУ-ын зорилгыг баталдаг" гэж Хариуцагч маргасан.[412] Үүнийг Нэхэмжлэгчдийн өөрсдийн өмгөөлөгчийн эрдэм шинжилгээний бүтээлээс ч харж болно. Тэрээр өмнө нь 1990-ээд оны эцсээс өмнө БНХАУ-ын байгуулсан гэрээнүүдэд арбитрт хандах эрхийг "албадан хураалтын үед төлөх нөхөн төлбөрийн хэмжээгээр (харин албадан хураалт болсон эсэх анхны асуудлаар биш)" хязгаарлах нь түгээмэл байсан гэсэн байр суурийг дэмжиж байжээ.[413]

(b) Хоёрдугаарт, Хятадын хөрөнгө оруулалтын илүү сүүлийн үеийн практик хариуцлагын асуудлыг олон улсын арбитрт даатгадаг болсон бөгөөд үүний үр дүнд шинэ гэрээнүүдийн үг хэллэг энэ Хэлэлцээрээс чухал талаараа ялгаатай болсон.[414]

(c) Эцэст нь, Хэлэлцээрийн оршлын үг хэллэг нь БНХАУ эсхүл Монгол Улсын оролцогч болсон бусад хөрөнгө оруулалтын гэрээнээс хөрөнгө оруулагчийн ашиг сонирхлыг бага хамгаалдаг.[415]

Нэхэмжлэгчдийн байр суурь

262. Нэхэмжлэгчид дараах байдлаар тайлбарласан —

Хэлэлцээрийн хам сэдэв болон объект, зорилгын үүднээс 8 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн ердийн утгыг тайлбарлавал Арбитрын бүрэлдэхүүн Нэхэмжлэгчдийн хөрөнгө оруулалтыг албадан хураасан эсэх, уг хураалт хууль ёсны эсэх, мөн Нэхэмжлэгчдэд олгох нөхөн сэргээх арга хэмжээтэй холбоотой маргаанд харьяалалтай гэсэн утгаас өөрөөр тайлбарлах боломжгүй.[416]

263. 8 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн ердийн утгыг тайлбарлахдаа Нэхэмжлэгчид дөрвөн эрх зүйн эх сурвалжид тулгуурласан:

(a) EMV v. Czech Republic хэрэгт[417] Англи, Уэльсийн Дээд шүүх арбитрын бүрэлдэхүүний шийдвэрийг хянахдаа "нөхөн төлбөртэй холбоотой" "аливаа

---

[410] Хариуцагчийн Давтан хариу тайлбар, догол мөр 227; мөн үзнэ үү: Хариуцагчийн Давтан хариу тайлбар, догол мөрүүд 230-237; Сонсголын тэмдэглэл (өдөр 1, 2015 оны 9 дугаар сарын 14) 193:14–195:5.

[411] Сонсголын тэмдэглэл (өдөр 1, 2015 оны 9 дугаар сарын 14) 193:18–193:25.

[412] Хариуцагчийн Хариу үндэслэл, догол мөр 219.

[413] Хариуцагчийн Давтан хариу тайлбар, догол мөр 164.

[414] Хариуцагчийн Давтан хариу тайлбар, догол мөрүүд 228, 238-241; мөн үзнэ үү: Сонсголын тэмдэглэл (өдөр 1, 2015 оны 9 дугаар сарын 14) 195:6–196:2

[415] Хариуцагчийн Давтан хариу тайлбар, догол мөрүүд 229, 242-248; мөн үзнэ үү: Сонсголын тэмдэглэл (өдөр 1, 2015 оны 9 дугаар сарын 14) 190:19–191:14.

[416] Нэхэмжлэгчдийн Нэхэмжлэлийн үндэслэл, догол мөр 61; мөн үзнэ үү: Сонсголын тэмдэглэл (өдөр 1, 2015 оны 9 дугаар сарын 14) 45:15–45:24.

[417] Czech Republic v. European Media Ventures SA, [2007] EWHC 2851 (Comm) догол мөр 44 (Эрх зүйн эх сурвалж CLA-37).

маргаан” гэсэн харьяаллын заалт нь нөхөн төлбөр авах эрх байгаа эсэхийг тогтооход мөн хамаарна гэж хүлээн зөвшөөрсөн.[418]

(b) Renta v. Russia хэрэгт[419] арбитрын бүрэлдэхүүн нөхөн төлбөр төлөх үүрэг байгаа эсэх нь аливаа дүн “төлөгдөх ёстой” байхын “илэрхий урьдчилсан нөхцөл” тул арбитрын заалтын хүрээнд хамаарна гэж шийдвэрлэсэн.[420]

(c) Sanum Investments Limited v. Laos хэрэгт[421] арбитрын бүрэлдэхүүн “холбоотой байх” гэсэн нэр томьёо нь хасах бус, хамруулах шинжтэй гэж үзсэн. Өөр тайлбар боломжтойг хүлээн зөвшөөрсөн ч хоёр талт хөрөнгө оруулалтын хэлэлцээрийн бусад заалттай илүү нийцнэ гэсэн үндэслэлээр өргөн тайлбарыг дэмжсэн.[422]

(d) Эцэст нь, харьяаллын заалт нь 8 дугаар зүйлийн 3 дахь хэсэгтэй үйл ажиллагааны хувьд ижил Tza Yap Shum v. Peru хэрэгт[423] арбитрын бүрэлдэхүүн ““холбоотой” гэсэн үгийг бүрэлдэхүүний харьяаллыг зөвхөн нөхөн төлбөрийн хэмжээг тогтоохоор хязгаарласан гэж ойлгож болохгүй” гэж шийдвэрлэсэн.[424] Tza Yap Shum, EMV, Renta хэргүүдийн гэрээний заалтууд энэ Хэлэлцээрийн 8 дугаар зүйлийн 3 дахь хэсэгтэй “ижил” эсхүл төстэй тул тэдгээр шийдвэр хамааралтай гэж Нэхэмжлэгчид онцолж, холбогдох бичвэрүүдийн ялгааг утга агуулгатайгаар тайлбарлахад Хариуцагч хүндрэлтэй байгаа гэж үзсэн.[425] Sanum Investments-ийн шийдвэрийг Сингапурын Дээд шүүх анх хүчингүй болгосон боловч “Давж заалдах шатны шүүх Шүүхийн комиссар Леовын өмнөх шийдвэрийг өөрчилж, Хятад–Монголын хоёр талт хөрөнгө оруулалтын хэлэлцээрийн 8 дугаар зүйлийн 3 дахь хэсэгтэй үндсэндээ төстэй Хятад–Лаосын хэлэлцээрийн 8 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн дагуу Sanum-ийн нэхэмжлэлийн зүйлээр арбитрын бүрэлдэхүүн харьяалалтай гэж тогтоосон”-ыг Нэхэмжлэгчид онцолсон.[426]

---

[418] Нэхэмжлэгчдийн Нэхэмжлэлийн үндэслэл, догол мөрүүд 64-65; мөн үзнэ үү: Сонсголын тэмдэглэл (өдөр 1, 2015 оны 9 дугаар сарын 14) 53:16–54:21.

[419] Renta 4 S.V.S.A, et. al. v. The Russian Federation, SCC хэрэг № 24/2007, Урьдчилсан татгалзлын тухай шийдвэр, 2009 оны 3 дугаар сарын 20, догол мөр 33 (Эрх зүйн эх сурвалж CLA-36).

[420] Нэхэмжлэгчдийн Нэхэмжлэлийн үндэслэл, догол мөрүүд 66-67; мөн үзнэ үү: Сонсголын тэмдэглэл (өдөр 1, 2015 оны 9 дугаар сар) 52:4–53:15.

[421] Sanum Investments Limited v. Lao People’s Democratic Republic, UNCITRAL, PCA хэрэг № 2013-13, Харьяаллын тухай шийдвэр, 2013 оны 12 дугаар сарын 13 (Эрх зүйн эх сурвалж CLA-148).

[422] Сонсголын тэмдэглэл (өдөр 1, 2015 оны 9 дугаар сарын 14) 47:18–48:13.

[423] Tza Yap Shum v. The Republic of Peru, ICSID хэрэг № ARB/07/6, Харьяалал болон эрх хэмжээний тухай шийдвэр, 2009 оны 6 дугаар сарын 19, догол мөр 151 (Эрх зүйн эх сурвалж CLA-32).

[424] Нэхэмжлэгчдийн Нэхэмжлэлийн үндэслэл, догол мөр 68.

[425] Нэхэмжлэгчдийн Хариу тайлбар, догол мөрүүд 140-141.

[426] Нэхэмжлэгчдийн 2016 оны 10 дугаар сарын 11-ний өдрийн захидал. Уг шийдвэрийг энэхүү ажиллагааны материалд CLA-153 эрх зүйн эх сурвалж болгон хүлээн авсан. Дээрх 88 дугаар догол мөрийг үзнэ үү.

264. Нэхэмжлэгчид уг үр дүнг 8 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн хам сэдэв болон тухайн хэсгийн маргаан шийдвэрлэх замыг сонгох заалтын үйлчлэл мөн дэмжинэ гэж тайлбарласан. Нэхэмжлэгчдийн үзэж байгаагаар:

> (i) хэрэв 8 дугаар зүйлийг зөвхөн дотоодын шүүх хөрөнгө албадан хураасан эсэхийг шийдвэрлэх эрхтэй гэсэн утгаар уншвал; мөн
>
> (ii) нөхөн сэргээх аливаа арга хэмжээг тогтоохоос өмнө албадан хураалт болсон эсэхийг зайлшгүй тогтоох ёстой тул;
>
> (iii) хөрөнгө оруулагч албадан хураалт болсон эсэх тухай маргааныг дотоодын шүүхэд шилжүүлмэгц маргаан шийдвэрлэх замыг сонгох заалтын үйлчлэлээр нөхөн төлбөрийн хэмжээг тогтоох асуудлыг дараа нь арбитрын бүрэлдэхүүнд шилжүүлэх эрхгүй болно.[427]

Шууд бус албадан хураалтын үед албадан хураасан тухай зарлан мэдэгдэл байх боломжгүй тул 4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг нь маргаан шийдвэрлэх замыг сонгох заалтыг тойрон гарах боломж олгоно гэдгийг Нэхэмжлэгчид мөн эсэргүүцсэн.[428]

265. Үүнтэй адил, “уг заалтын тайлбар нь хөрөнгө оруулалтыг хамгаалах Хэлэлцээрийн объект, зорилготой нийцсэн хэвээр байхын тулд Хэлэлцээрийн 8 дугаар зүйлийн 3 дахь хэсгийг албадан хураалт болсон эсэх, хууль ёсны эсэхийг шийдвэрлэх харьяаллыг арбитрын бүрэлдэхүүнд олгосон гэж унших ёстой” гэж Нэхэмжлэгчид үзсэн.[429] Тэдний тайлбарласнаар, Хэлэлцээрийн объект, зорилго нь “гадаадын хөрөнгө оруулагчдад бодит хамгаалалт олгох замаар гадаадын хөрөнгө оруулалтыг хөхиүлэн дэмжих” явдал юм.[430] Бүрэн эрхт байдлыг хадгалах нь Хэлэлцээрийн объект, зорилго гэх Хариуцагчийн байр суурийг Нэхэмжлэгчид зөвшөөрөөгүй.[431] Хөрөнгө оруулалтын гэрээний хамгаалах зорилгыг Czech Republic v. EMV, Renta, Tza Yap Shum, SGS v. Philippines хэргүүдэд хүлээн зөвшөөрснийг мөн тэмдэглэсэн.[432] Ийм хамгаалах зорилго нь албадан хураалт болсон эсэх, хууль ёсны эсэх болон нөхөн төлбөрийн асуудлаар олон улсын арбитрын өргөн харьяалал шаардана гэж Нэхэмжлэгчид үзсэн.[433] Хэлэлцээрийн 8 дугаар зүйлийн 3 дахь хэсгийг илүү хязгаарлагдмал байдлаар тайлбарлах нь “хөрөнгө оруулагч бодитоор арбитрт хэзээ ч

---

[427] Нэхэмжлэгчдийн Нэхэмжлэлийн үндэслэл, догол мөр 70; мөн үзнэ үү: Сонсголын тэмдэглэл (өдөр 1, 2015 оны 9 дугаар сарын 14) 63:12–68:18

[428] Сонсголын тэмдэглэл (өдөр 1, 2015 оны 9 дугаар сарын 14) 67:1–68:18; Сонсголын тэмдэглэл (өдөр 5, 2015 оны 9 дугаар сарын 18), 794:13–796:3.

[429] Нэхэмжлэгчдийн Нэхэмжлэлийн үндэслэл, догол мөр 73; мөн үзнэ үү: Сонсголын тэмдэглэл (өдөр 1, 2015 оны 9 дугаар сарын 14) 55:5–55:25.

[430] Нэхэмжлэгчдийн Нэхэмжлэлийн үндэслэл, догол мөр 72.

[431] Нэхэмжлэгчдийн Хариу тайлбар, догол мөр 148.

[432] Нэхэмжлэгчдийн Нэхэмжлэлийн үндэслэл, догол мөрүүд 73-75; Сонсголын тэмдэглэл (өдөр 1, 2015 оны 9 дугаар сарын 14) 56:1–58:12.

[433] Нэхэмжлэгчдийн Нэхэмжлэлийн үндэслэл, догол мөр 77.

хандаж чадахгүй гэсэн хүлээн зөвшөөрөх боломжгүй дүгнэлтэд хүргэнэ",[434] ингэснээр гадаадын хөрөнгө оруулагчдын бодит хамгаалалтыг үгүйсгэнэ гэж тайлбарласан.[435]

266. 8 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн талаарх өөрсдийн тайлбар л заалтыг үр нөлөөтэй болгох цорын ганц тайлбар гэж Нэхэмжлэгчид мэдүүлсэн. Хэрэв хөрөнгө оруулалт хүлээн авагч улс албадан хураалт болсон эсэх, хууль ёсны эсэхийг нэг талын журмаар зарлах эрхтэй бол хоёр талт хөрөнгө оруулалтын хэлэлцээрийн 4 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн материаллаг заалтууд үр ашиггүй болно гэж тайлбарласан.[436] Түүнчлэн Арбитрын бүрэлдэхүүн хариуцлагын асуудлыг авч үзэлгүйгээр нөхөн төлбөрийн хэмжээг тогтоох боломжгүй гэж Нэхэмжлэгчид мэдүүлсэн.[437] Учир нь "яг юуг, хэрхэн албадан хураасан буюу эзэмшлээс салгасныг мэдэх" шаардлагатай.[438]

267. Эцэст нь, Хятадын бусад гэрээний талаарх практик хамааралгүй гэж Нэхэмжлэгчид тайлбарласан. Тэдний үзэж байгаагаар, "Венийн конвенцын 31 дүгээр зүйлийн 3(b)-д зааснаар "гэрээг хэрэглэх дараагийн практик" нь "гэрээний тайлбарын талаар талуудын тохиролцоог тогтоох" шинжтэй байх ёстой".[439] Монгол Улс өөрийн бодлогын талаар ямар нэг нотолгоо гаргаагүй гэж Нэхэмжлэгчид мөн үзсэн.[440]

268. Нэхэмжлэгчид харьяаллын талаар өөр байр суурийг дэмжсэн арбитрын шийдвэрүүд байгааг хүлээн зөвшөөрсөн боловч "эдгээр хэрэг нь энэ хэргээс ялгаатай, эсхүл Нэхэмжлэгчдийн үзэж байгаагаар гэрээг тайлбарлах эрх зүйн хувьд буруу тул энэ асуудлаар эрх бүхий баримжаа гэж үзэх ёсгүй" гэж маргасан.[441] Тухайлбал:

> (a) Berschader v. Russia шийдвэрийг дагах ёсгүй. Учир нь арбитрын бүрэлдэхүүний үндэслэл нь Венийн конвенцод шаардсан аргаас зөрж, гэрээний талуудын бусад гэрээн дэх дараагийн практикийг харгалзсанд тулгуурласан.[442]
>
> (b) RosInvest v. Russia шийдвэрийг дагах ёсгүй. Учир нь —
>
> RosInvest-ийн арбитрын бүрэлдэхүүн холбогдох маргаан шийдвэрлэх заалтыг үгсийн ердийн утгаар шинжилсэн боловч гадаадын хөрөнгө оруулагчдыг үр нөлөөтэй хамгаалах үндсэн зорилгынх нь үүднээс шинжлээгүй. Чухам энэ зорилго нь хэлэлцэн тохирогч улсуудыг хөрөнгө оруулалтыг харилцан хамгаалах гэрээ байгуулахад хүргэсэн юм. Тус бүрэлдэхүүн мөн хууль бус албадан хураалтын үед

---

[434] Нэхэмжлэгчдийн Нэхэмжлэлийн үндэслэл, 71, эшилсэн нь: Tza Yap Shum v. Peru, ICSID хэрэг № ARB/07/6, Харьяалал болон эрх хэмжээний тухай шийдвэр, 2009 оны 6 дугаар сарын 19, догол мөрүүд 154, 157 (Эрх зүйн эх сурвалж CLA-32).

[435] Нэхэмжлэгчдийн Нэхэмжлэлийн үндэслэл, догол мөр 77.

[436] Сонсголын тэмдэглэл (өдөр 1, 2015 оны 9 дугаар сарын 14) 58:13–59:19.

[437] Сонсголын тэмдэглэл (өдөр 1, 2015 оны 9 дугаар сарын 14) 59:20–62:12.

[438] European Media Ventures SA v. The Czech Republic, UNCITRAL, Харьяаллын тухай шийдвэр, 2007 оны 5 дугаар сарын 15, догол мөр 58 (Эрх зүйн эх сурвалж CLA-35)

[439] Нэхэмжлэгчдийн Хариу тайлбар, догол мөр 149.

[440] Сонсголын тэмдэглэл (өдөр 1, 2015 оны 9 дугаар сарын 14) 69:22–71:19.

[441] Нэхэмжлэгчдийн Нэхэмжлэлийн үндэслэл, догол мөр 82.

[442] Нэхэмжлэгчдийн Нэхэмжлэлийн үндэслэл, догол мөрүүд 83-85.

хөрөнгө оруулагчийг хамгаалалт хүсэх боломжгүй болгосноор үр нөлөөтэй тайлбарлах зарчмыг хэрэглээгүй.[443]

(c) Эцэст нь, Austrian Airlines v. Slovakia шийдвэр “энэ хэргээс ялгаатай. Учир нь Австри–Словакийн хоёр талт хөрөнгө оруулалтын хэлэлцээр “албадан хураалтын хууль ёсны байдал” болон “нөхөн төлбөрийн хэмжээ, төлбөрийн нөхцөл”-ийн шаардлагад зориулсан тусдаа хоёр заалттай байсан”.[444] Эдгээр маргаан шийдвэрлэх хоёр заалтын зөвхөн сүүлийнх нь арбитрыг зөвшөөрсөн. ST-AD-ийн шийдвэр Austrian Airlines-тай тун төстэй гэж Нэхэмжлэгчид тайлбарласан.[445]

(c) Шаардлага хангасан хөрөнгө оруулагч / Хятадын Засгийн газрын үүрэг

Хариуцагчийн байр суурь

269. Хэлэлцээрийн 1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн дагуу Бээжин Шоуган, Чайна Хэйлунзян нарыг “аж ахуйн нэгж” гэж ангилах боломжгүй, улмаар тэд хөрөнгө оруулагч биш гэсэн үндэслэлээр Хариуцагч Арбитрын бүрэлдэхүүний харьяаллыг эсэргүүцсэн.[446]

270. “Аж ахуйн нэгж” гэсэн нэр томьёоны утгыг “Хятадын гэрээний практик болон олон улсын хөрөнгө оруулалтын шүүн таслах практикийн аль алиныг харгалзан шийдвэрлэх ёстой”[447] бөгөөд ингэвэл Бээжин Шоуган, Чайна Хэйлунзян хасагдана гэж Хариуцагч тайлбарласан.[448] Хариуцагчийн үзэж байгаагаар, “энэ томьёоллыг явцуу утгаар унших ёстой”.[449] Хятадын бусад гэрээнд “засгийн газрын байгууллага”, “нийтийн байгууллага”, “нийтийн болон хагас нийтийн этгээд”-ийг шаардлага хангасан хөрөнгө оруулагч гэж тодорхой дурддаг. Хариуцагчийн хувьд “Хятад оролцогч болсон өөр хоёр талт хөрөнгө оруулалтын хэлэлцээрт ийм өргөн заалт оруулсан нь энэ Хэлэлцээрийн “аж ахуйн” нэгжийн шаардлагыг ийм этгээдүүд хангахгүй гэсэн ойлголтыг илэрхийлдэг”.[450] Нэхэмжлэгчид “арилжааны” ч биш, “ашигтай” ч биш тул “эдийн засгийн” гэсэн ердийн утгад нийцэхгүй гэж Хариуцагч мөн маргасан.[451]

271. Ямар ч тохиолдолд Бээжин Шоуган, Чайна Хэйлунзян нь “Хятадын Засгийн газрын бараг хэрэгжүүлэгч байгууллагууд” тул Хэлэлцээрийн дагуу хөрөнгө оруулагчийн шаардлага хангахгүй гэж Хариуцагч мөн маргасан.[452] Төрийн болон төрийн бус этгээдийг ялгах чиг

---

[443] Нэхэмжлэгчдийн Нэхэмжлэлийн үндэслэл, догол мөр 86.

[444] Нэхэмжлэгчдийн Нэхэмжлэлийн үндэслэл, догол мөр 87; мөн үзнэ үү: Сонсголын тэмдэглэл (өдөр 5, 2015 оны 9 дугаар сарын 18), 798:6–799:11.

[445] Сонсголын тэмдэглэл (өдөр 5, 2015 оны 9 дугаар сарын 18), 799:12–800:18.

[446] Хариуцагчийн Хариу үндэслэл, догол мөр 183

[447] Хариуцагчийн Хариу үндэслэл, догол мөр 183.

[448] Хариуцагчийн Хариу үндэслэл, догол мөр 185.

[449] Хариуцагчийн Хариу үндэслэл, догол мөр 184.

[450] Хариуцагчийн Хариу үндэслэл, догол мөр 184.

[451] Хариуцагчийн Давтан хариу тайлбар, догол мөрүүд 312-313.

[452] Хариуцагчийн Хариу үндэслэл, догол мөр 186; мөн үзнэ үү: Сонсголын тэмдэглэл (өдөр 1, 2015 оны 9 дугаар сарын 14) 200:13–207:9.

үүргийн шалгуурт[453] тулгуурлан, “Бээжин Шоуган, Чайна Хэйлунзян нь Хятадын Засгийн газрын шууд хяналтад ажилладаг бөгөөд Хятадын гадаад бодлогын зорилгод үйлчлэхийн тулд гадаадад хөрөнгө оруулах тодорхой чиглэлтэй” гэж мэдүүлсэн.[454] Бээжин Шоуганы хөрөнгө оруулалт “Хятадын чиглэл, хяналтын үр дүн”[455] гэсэн мэдэгдлээ дэмжихдээ тус компанийн толгой компани Shougang Corporation-ийг Нэхэмжлэгчид “БНХАУ-ын Төрийн зөвлөлийн шууд хяналтад байдаг” гэж тодорхойлсныг үндэслэсэн.[456] Чайна Хэйлунзяны хувьд тус компанийн “үйл ажиллагааны үндсэн хүрээ”-нд “гадаад тусламжийн эдийн засаг, технологийн төслүүдийн гэрээ байгуулах, шаардлагатай материал, тоног төхөөрөмж экспортлох” багтдагийг заасан. Энэ нь Shougang Corporation-ийн адил “гадаадад хөрөнгө оруулахдаа Чайна Хэйлунзянд тулгуурлах Хятадын тодорхой зорилгыг” илэрхийлнэ гэж Хариуцагч үзсэн.[457] Төрийн өмчит гангийн үйлдвэрүүд дэх Хятадын төрийн оролцооны талаар эрдэм шинжилгээний дүн шинжилгээ[458] болон Бээжин Шоуган, Чайна Хэйлунзян нарын Монголд хөрөнгө оруулах шийдвэр, Хятадын Засгийн газрын гадаад дахь эрдэс баялагт хөрөнгө оруулах бодлогын зэрэгцлийг дэмжлэг болгон ишилсэн.[459] Хүдрийг зах зээлийн үнээс доогуур үнээр борлуулсан нь Нэхэмжлэгчид жирийн аж ахуйн нэгжийн адил ашиг олох сэдэлгүй байсныг харуулна гэж Хариуцагч цааш тайлбарласан.[460] Монгол Улс хятад хөрөнгө оруулагчдыг уриагүй, харин БНХАУ өөрөө Төмөртэйн ордыг сонирхож байсан гэж дахин тэмдэглэсэн.[461]

272. Төрийн өмчийн бус Циньлун мөн “аж ахуйн нэгж” гэх нэр томьёонд агуулагдах шаардлагатай “тусгаар бие даасан байдал”-тай этгээд шиг ажиллаагүй гэж Хариуцагч маргасан.[462] Ноён Ли Төмөртэйн ордтой холбоотой хэд хэдэн гэрээнд гарын үсэг зурахдаа Чайна Хэйлунзяныг төлөөлсөн; Циньлун анх хамтарсан үйлдвэрийн гэрээнд гарын үсэг зурснаас хойш ойролцоогоор гурван жилийн дараа л тусгай зөвшөөрлийг Төмөртэй Хүдэрт шилжүүлсэн; Төмөртэй Хүдэрийн хувьцааг Циньлунаас Чайна Хэйлунзянд шилжүүлсэн гэрээний хуулбар яагаад байхгүйг ноён Ли тайлбарлаж чадаагүй зэргийг Хариуцагч

---

[453] Хариуцагчийн Хариу үндэслэл, догол мөр 186.

[454] Хариуцагчийн Давтан хариу тайлбар, догол мөр 293.

[455] Хариуцагчийн Давтан хариу тайлбар, догол мөр 299.

[456] Хариуцагчийн Давтан хариу тайлбар, догол мөр 295, эшилсэн нь: Нэхэмжлэгчдийн Нэхэмжлэлийн үндэслэл, догол мөр 15.

[457] Хариуцагчийн Давтан хариу тайлбар, догол мөр 300.

[458] Хариуцагчийн Давтан хариу тайлбар, догол мөрүүд 298, 307-308.

[459] Хариуцагчийн Давтан хариу тайлбар, догол мөрүүд 302-303; мөн үзнэ үү: Сонсголын тэмдэглэл (өдөр 1, 2015 оны 9 дугаар сарын 14) 200:13–207:9; Сонсголын тэмдэглэл (өдөр 5, 2015 оны 9 дугаар сарын 18) 835:25–844:3, эш татсан нь: Эсрэг талаас асуусан асуултад өгсөн мэдүүлэг, ноён Ли, Сонсголын тэмдэглэл (өдөр 2, 2015 оны 9 дугаар сарын 15) 304:4–304:20.

[460] Сонсголын тэмдэглэл (өдөр 1, 2015 оны 9 дугаар сарын 14) 203:9–204:14.

[461] Сонсголын тэмдэглэл (өдөр 5, 2015 оны 9 дугаар сарын 18) 838:21–840:20; Гадаад хэргийн яамны товч мэдээлэл, Зян Зэминь (Эрх зүйн эх сурвалж С-135).

[462] Сонсголын тэмдэглэл (өдөр 5, 2015 оны 9 дугаар сарын 18) 827:19-25.

дурдсан.[463] Төслийн оролцогчдын хооронд цаг хугацааны явцад байгуулсан төрөл бүрийн гэрээтэй холбоотой хэд хэдэн “хачирхалтай зүйл”-ийг[464] мөн зааж, БЛТ өөрөө “эрх, ашиг сонирхлыг хууль бусаар олж авахаас өөр” бодит оршин тогтнолтой байсан эсэхэд эргэлзсэн. Үүнд Чайна Хэйлунзяны 680 сая ам.долларын хөрөнгө оруулалт гэж төлөвлөсөн зүйлд БЛТ-д 51 хувийн оролцоо олгосон анхны гэрээг дурдсан.[465] Ордыг ашиглахтай холбоотой асуудлуудыг шийдвэрлэх үүргийг Хятадын Худалдааны яамны удирдлагаас авсан гэж ноён Ли өөрөө мэдүүлснийг Хариуцагч мөн ишилсэн.[466] Эцэст нь, Нэхэмжлэгчдийн гэрчүүд арбитрын хэрэгт гаргасан үндсэн тайлбаруудтай ерөнхийдөө танил бус байсныг дурдсан.[467]

273. Нэхэмжлэгчид Төмөртэй Хүдэрийн хувьцаа эзэмшигч гэдгээ, эсхүл Төмөртэй Хүдэр хувьцаа гаргасан буюу хувьцааны төлбөр хүлээн авсан гэдгийг нотлох ямар ч баримт ирүүлээгүй гэж Хариуцагч мөн маргасан.[468] БЛТ болон Нэхэмжлэгчдийн хоорондох “хачирхалтай” гэрээний зохицуулалт, 939A тусгай зөвшөөрөл авахаас өмнөх БЛТ-ийн эдийн засгийн үйл ажиллагааны нотолгоо байхгүй, 1996 оны 8 дугаар сараас өмнө БЛТ гадаад валютын банкны дансгүй байсныг Хариуцагч заасан.[469]

Нэхэмжлэгчдийн байр суурь

274. Хэлэлцээрийн 1 дүгээр зүйлийн 2(b)-ийн талаарх Хариуцагчийн тайлбар Хэлэлцээрийн бичвэрийг “гажуудуулж байна” гэж Нэхэмжлэгчид няцаасан.[470] Хэлэлцээрийн бичвэрт төрийн өмчит аж ахуйн нэгжийг хөрөнгө оруулагчийн хүрээнээс хассан ямар ч хязгаарлалт байхгүйг шийдвэрлэх ач холбогдолтой гэж онцолсон.[471] Монголын хуулиар шаардсан бүх зөвшөөрөл, батламжийг авсан гэж Нэхэмжлэгчид нэмж мэдүүлсэн.[472]

275. Нэхэмжлэгчдийн үзэж байгаагаар, Хариуцагч “Хятадын гуравдагч улсуудтай байгуулсан, өөр үг хэллэгтэй хоёр хэлэлцээрийг ... санамсаргүйгээр сонгож” утга гаргахыг оролдсон.[473]

---

[463] Сонсголын тэмдэглэл (өдөр 5, 2015 оны 9 дугаар сарын 18) 828:1-20.

[464] Сонсголын тэмдэглэл (өдөр 5, 2015 оны 9 дугаар сарын 18) 828:21–831:10.

[465] Сонсголын тэмдэглэл (өдөр 5, 2015 оны 9 дугаар сарын 18) 831:11–832:15 болон 833:10-20.

[466] Сонсголын тэмдэглэл (өдөр 5, 2015 оны 9 дугаар сарын 18) 881:4-19; Ли Шаомингоос Монгол Улсын Ерөнхий сайдад хүргүүлсэн захидал, 2006 оны 12 дугаар сарын 26 (Баримт C-2).

[467] Сонсголын тэмдэглэл (өдөр 5, 2015 оны 9 дугаар сарын 18) 832:16–833:9.

[468] Сонсголын тэмдэглэл (өдөр 5, 2015 оны 9 дугаар сарын 18) 824:17–828:20, эш татсан нь: Арбитрын бүрэлдэхүүнээс ноён Лид тавьсан асуултууд. Сонсголын тэмдэглэл (өдөр 2, 2015 оны 9 дугаар сарын 15) 332:15–332:16.

[469] Сонсголын тэмдэглэл (өдөр 5, 2015 оны 9 дугаар сарын 18) 828:21–834:18, эш татсан нь: Эсрэг талаас асуусан асуултад өгсөн мэдүүлэг, ноён Баярцогт Сонсголын тэмдэглэл (өдөр 2, 2015 оны 9 дугаар сарын 15) 264:8–264:11.

[470] Нэхэмжлэгчдийн Хариу тайлбар, догол мөр 110.

[471] Нэхэмжлэгчдийн Хариу тайлбар, догол мөр 109; мөн үзнэ үү: Сонсголын тэмдэглэл (өдөр 1, 2015 оны 9 дугаар сарын 14) 80:15–82:18.

[472] Сонсголын тэмдэглэл (өдөр 5, 2015 оны 9 дугаар сарын 18) 802:9–803:19,

[473] Нэхэмжлэгчдийн Хариу тайлбар, догол мөр 111.

Үүнийг “юуг ч нотлохгүй”[474] бөгөөд “дараагийн практик” нь гэрээний тайлбарын талаар “талуудын тохиролцоо”-г тогтоох ёстой гэж заасан Олон улсын гэрээний эрх зүйн тухай Венийн конвенцын 31 дүгээр зүйлийн 3(b)-д харш гэж Нэхэмжлэгчид үзсэн. Иймээс зөвхөн Хятадын практикийн нотолгоо хангалтгүй.[475]

276. Үүнтэй адил, ICSID-ийн конвенцыг баталсан нөхцөл байдлаас утга гаргах Хариуцагчийн оролдлогыг Нэхэмжлэгчид няцаасан. ICSID-ийн конвенц энэ ажиллагаанд үйлчлэхгүйг санууллаа, ямар ч тохиолдолд Хариуцагчийн тайлбар буруу гэж мэдүүлсэн.[476] ICSID-ийг байгуулахад гол үүрэг гүйцэтгэсэн Аарон Брохес болон профессор Кристоф Шройерийн тайлбарыг үндэслэн, “засгийн газрын төлөөлөгчийн үүрэг гүйцэтгэж байгаа эсхүл үндсэндээ төрийн чиг үүрэг хэрэгжүүлж байгаагаас бусад тохиолдолд төрийн өмчит компанийг “Хэлэлцэн тохирогч өөр улсын иргэн” гэсэн хүрээнээс хасаж болохгүй” гэж тайлбарласан.[477] Чайна Хэйлунзян, Бээжин Шоуган нь Хятадын Засгийн газрын “агентлаг” эсхүл “төрийн эрх мэдлийн ямар нэгэн хэсэг”-ийг хэрэгжүүлдэг гэхийг Нэхэмжлэгчид няцаасан.[478]

(d) Шаардлага хангасан хөрөнгө оруулалт / Нэхэмжлэгчдийн хөрөнгө оруулалтын эрсдэл

Хариуцагчийн байр суурь

277. Нэхэмжлэгчид хөрөнгө оруулалтын эрсдэл хүлээгээгүй тул шаардлага хангасан хөрөнгө оруулалт хийгээгүй гэсэн үндэслэлээр Хариуцагч Арбитрын бүрэлдэхүүний харьяаллыг эсэргүүцсэн.

278. Romak v. Uzbekistan,[479] Pantechniki v. Albania,[480] Phoenix Action v. Czech Republic,[481] Fakes v. Turkey,[482] Globex v. Ukraine[483] хэргүүдийг үндэслэн, хөрөнгө оруулалтын эрсдэл нь

---

[474] Нэхэмжлэгчдийн Хариу тайлбар, догол мөр 111.

[475] Нэхэмжлэгчдийн Хариу тайлбар, догол мөр 111.

[476] Нэхэмжлэгчдийн Хариу тайлбар, догол мөр 113.

[477] Нэхэмжлэгчдийн Хариу тайлбар, догол мөр 114, эшилсэн нь: А. Брошес, К. Х. Шройерийн «ICSID конвенц — Улс болон бусад улсын иргэдийн хоорондын хөрөнгө оруулалтын маргааныг шийдвэрлэх тухай конвенцын тайлбар» (2 дахь хэвлэл, 2009)-т эшилснээр, хуудас 161 (Эрх зүйн эх сурвалж CLA-110).

[478] Нэхэмжлэгчдийн Хариу тайлбар, догол мөр 117.

[479] Romak SA v. Uzbekistan, PCA хэрэг № AA280, Арбитрын шийдвэр, 2009 оны 11 дугаар сарын 26, догол мөр 207 (Эрх зүйн эх сурвалж RLA-27).

[480] Pantechniki SA Contractors and Engineers v. Albania, ICSID хэрэг № ARB/07/21, Арбитрын шийдвэр, 2009 оны 7 дугаар сарын 28, догол мөр 46 (Эрх зүйн эх сурвалж RLA-28).

[481] Phoenix Action Ltd v. Czech Republic, ICSID хэрэг № ARB/06/5, Арбитрын шийдвэр, 2009 оны 4 дугаар сарын 9, догол мөр 116 (Эрх зүйн эх сурвалж RLA-29).

[482] Fakes v. Turkey, ICSID хэрэг № ARB/07/20, Арбитрын шийдвэр, 2010 оны 7 дугаар сарын 12, догол мөр 110 (Эрх зүйн эх сурвалж RLA-30).

[483] Global Trading Resource Corp and Globex International, Inc v. Ukraine, ICSID хэрэг № ARB/09/11, Арбитрын шийдвэр, 2010 оны 11 дугаар сарын 23, догол мөр 56 (Эрх зүйн эх сурвалж RLA-31).

“хөрөнгө оруулалт” гэсэн нэр томьёоны салшгүй шинж гэж Хариуцагч маргасан.[484] Romak шийдвэрт үндэслэн хөрөнгө оруулалтын эрсдэлийг “хөрөнгө оруулагч хөрөнгө оруулалтаасаа өгөөж авах эсэхэд итгэлгүй, эцэст нь хэдий хэмжээний хөрөнгө зарцуулахыг ч мэдэхгүй байж болох нөхцөл” гэж тодорхойлсон.[485]

279. Хариуцагч хөрөнгө оруулалтын эрсдэлийг “бодлогын эрсдэл”-ээс цааш ялгаж, “эхнийх нь ашигтай ажиллах магадлалтай, хоёр дахь нь улсад ашиг тус бий болох магадлалтай холбоотой” гэж тодорхойлсон.[486] Энэ ялгааг “Монгол–Хятадын хоёр талт хөрөнгө оруулалтын хэлэлцээрийн хам сэдэв, объект, зорилго дэмжинэ” гэж үзсэн.[487] Хэлэлцээрийн оршил дахь “бүрэн эрхт байдлыг харилцан хүндэтгэх” гэсэн ишлэлийг зааж, Монгол, Хятад хоёрын колоничлолын дараах эхэн үеийн ээдрээтэй харилцааны дараа “Монголын ард түмний колоничлолоос ангижрах, өөртөө засан тогтнох эрхийг Хятад хүлээн зөвшөөрсний илэрхийлэл” гэж тодорхойлсон.[488] Хариуцагчийн хувьд Хэлэлцээрийн объект, зорилго нь Монголын бүрэн эрхт байдлыг хадгалахын зэрэгцээ хөрөнгө оруулалтыг дэмжих явдал байв.

280. Хятадын Засгийн газрын “хэрэгжүүлэгч этгээдүүд”[489] болох Нэхэмжлэгчдийн эрсдэл нь “төрийн бодлогын эрсдэл” бөгөөд арилжааны шинжгүй тул Хариуцагчийн үзэж байгаагаар “хөрөнгө оруулалтын эрсдэл” биш.[490] Нэхэмжлэгчид боловсруулаагүй төмрийн хүдрийг зах зээлийн үнээс доогуур борлуулсан нь “ашигт ажиллагаанаас стратегийн асуудлыг дээгүүр тавих ... чиглэлтэй нийцнэ” гэж Хариуцагч мэдүүлсэн.[491] Хятадын Монголд хийсэн хөрөнгө оруулалт нь “улс төр, төрийн бодлогоос үүдэлтэй”, Монголын “дотоод хэрэгт хөндлөнгөөс оролцсон” шинжтэй тул “Хэлэлцээрээр хамгаалуулах боломжтой хөрөнгө оруулалт биш” гэж Хариуцагч тайлбарласан.[492]

281. Нэхэмжлэгчид Монголын эдийн засгийн хөгжилд ямар ч хувь нэмэр оруулаагүй гэж Хариуцагч мөн тайлбарласан. Үүнийг дэмжихдээ Нэхэмжлэгчид техник, эдийн засгийн үндэслэлд өгсөн мэдэгдлээ биелүүлээгүй; зөвхөн баялаг олборлоход чиглэсэн гэж Хариуцагчийн үзсэн ил уурхайн арга хэрэглэсэн; өндөр агуулгатай хүдрийг сорчлон олборлох хортой стратеги баримталсан; хүдрийг зах зээлийн үнээс доогуур борлуулсан;

---

[484] Хариуцагчийн Хариу үндэслэл, догол мөрүүд 224-227.

[485] Хариуцагчийн Хариу үндэслэл, догол мөр 225, эшилсэн нь: Romak SA v. Uzbekistan, PCA хэрэг № AA280, Арбитрын шийдвэр, 2009 оны 11 дугаар сарын 26, догол мөр 230 (Эрх зүйн эх сурвалж RLA-27).

[486] Хариуцагчийн Давтан хариу тайлбар, догол мөр 320.

[487] Хариуцагчийн Хариу үндэслэл, догол мөр 229.

[488] Хариуцагчийн Хариу үндэслэл, догол мөр 229.

[489] Хариуцагчийн Хариу үндэслэл, догол мөр 186.

[490] Хариуцагчийн Хариу үндэслэл, догол мөр 228.

[491] Хариуцагчийн Давтан хариу тайлбар, догол мөр 322.

[492] Хариуцагчийн Хариу үндэслэл, догол мөр 233.

Монголд төлбөр, татвар төлөөгүй зэргийг дурдсан.[493] Нэхэмжлэгчдийн зардал маш бага бөгөөд “зөвхөн өөрсдөдөө ашиг өгөхөд чиглэсэн” гэж Хариуцагч нэмж тайлбарласан.[494]

Нэхэмжлэгчдийн байр суурь

282. Нэхэмжлэгчдийн хөрөнгө оруулалт нь Төмөртэй Хүдэрт эзэмшдэг хувьцаа болон 939A тусгай зөвшөөрөлд эдлэх шууд бус эрхээс бүрдэх бөгөөд эдгээр нь Хэлэлцээрийн 1 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “хөрөнгө оруулалт”-ын тодорхойлолтод багтана гэж Нэхэмжлэгчид тайлбарласан.[495] Уг заалтын ердийн утга тодорхой тул тайлбарын нэмэлт хэрэгсэлд хандахыг Олон улсын гэрээний эрх зүйн тухай Венийн конвенц дэмжихгүй гэж маргасан.[496]

283. Хариуцагчийн “төрийн бодлогын эрсдэл”, “хөрөнгө оруулалтын эрсдэл” гэсэн ялгаа нь “бүрэн зохиомол”, эрх зүйн үндэслэлгүй гэж Нэхэмжлэгчид үзсэн.[497] ICSID-ийн конвенц болон хөрөнгө оруулалтын тухай түүний тусгай заалт үйлчлэхгүй тул уг конвенцын шаардлагад суурилсан арбитрын шийдвэрүүдийг Хариуцагч үндэслэсэн нь зохисгүй гэж тайлбарласан.[498] Хариуцагчийн дэвшүүлсэн ICSID-ээс гадуурх цорын ганц шийдвэр болох Romak нь нийтлэг бус бөгөөд зөвхөн улаан буудай худалдах нэг удаагийн гэрээтэй холбоотой “эрс өөр баримтат нөхцөл”-тэй гэж Нэхэмжлэгчид үзсэн.[499] “Salini-ийн шалгуурууд” болон тэдгээрт дурдсан хөрөнгө оруулалтын эрсдэлийн шаардлага “нийтээр хүлээн зөвшөөрөгдөөгүй бөгөөд маш болгоомжтой хэрэглэх шаардлагатай” гэж мөн тайлбарласан.[500] Biwater v. Tanzania хэрэгт[501] “Salini хэрэгт дурдсан таван шалгуур нь “эрх зүйн хувьд хатуу тогтсон, заавал биелүүлэх шаардлага биш”“ гэж тэмдэглэснийг Нэхэмжлэгчид дурдсан.[502]

284. Ямар ч тохиолдолд Нэхэмжлэгчид хөрөнгө оруулалтын эрсдэл хүлээсэн гэж үзсэн. Тэдний тайлбарласнаар, “уул уурхайн компанийн хувьцаа болон байгалийн баялгийн концесс нь оруулсан хөрөнгө оруулалтаас өгөөж огт авахгүй буюу хангалттай өгөөж авахгүй байх

---

[493] Сонсголын тэмдэглэл (өдөр 1, 2015 оны 9 дугаар сарын 14) 207:24–210:11.

[494] Сонсголын тэмдэглэл (өдөр 1, 2015 оны 9 дугаар сарын 14) 210:12–213:1; мөн үзнэ үү: Сонсголын тэмдэглэл (өдөр 5, 2015 оны 9 дугаар сарын 18) 882:17–888:7, эш татсан нь: ноён Нэргүйгийн асуултад өгсөн мэдүүлэг, Сонсголын тэмдэглэл (өдөр 2, 2015 оны 9 дугаар сарын 15) 390:18-21; 392:19-21.

[495] Нэхэмжлэгчдийн Хариу тайлбар, догол мөрүүд 120, 123.

[496] Нэхэмжлэгчдийн Хариу тайлбар, догол мөрүүд 123-126.

[497] Нэхэмжлэгчдийн Хариу тайлбар, догол мөрүүд 122, 126; мөн үзнэ үү: Сонсголын тэмдэглэл (өдөр 1, 2015 оны 9 дугаар сарын 14) 82:19–83:14.

[498] Нэхэмжлэгчдийн Хариу тайлбар, догол мөр 127.

[499] Нэхэмжлэгчдийн Хариу тайлбар, догол мөр 133.

[500] Нэхэмжлэгчдийн Хариу тайлбар, догол мөр 128.

[501] Biwater Gauff (Tanzania) Limited v. United Republic of Tanzania, ICSID хэрэг № ARB/05/22, Арбитрын шийдвэр, 2008 оны 7 дугаар сарын 24 догол мөр 312 (Эрх зүйн эх сурвалж CLA-114).

[502] Нэхэмжлэгчдийн Хариу тайлбар, догол мөр 129.

эрсдэлийг угаасаа агуулдаг”.[503] Ил уурхайн олборлолт Монголын эдийн засгийн хөгжилд хувь нэмэр оруулаагүй гэдгийг Нэхэмжлэгчид мөн зөвшөөрөөгүй. Тэд мөнгө зарцуулсан, татвар, нөөц ашигласны төлбөр төлсөн, ямар ч тохиолдолд хөрөнгө оруулалтын үнийг ажиллагааны дараагийн шатад авч үзнэ гэж тэмдэглэсэн.[504]

(е) Эрх зүйн илэрхий алдаа

Хариуцагчийн байр суурь

285. Нэхэмжлэгчид олон улсын заншлын эрх зүйд үндэслэн буцаан олголт шаардахдаа Арбитрын бүрэлдэхүүнээс эрх зүйн илэрхий алдаа гаргахыг хүсэж байгаа гэсэн үндэслэлээр Хариуцагч харьяаллыг эсэргүүцсэн.[505] Хариуцагчийн тайлбарласнаар, “гэрээ заншлын эрх зүйг тодорхой орлож, олон улсын арбитрт шаардлага гаргасан хөрөнгө оруулагчид олдох цорын ганц арга хэмжээ нь нөхөн төлбөр гэж заасан”.[506]

286. CMS v. Argentina[507] болон Sempra v. Argentina[508] хэргүүдийн шийдвэр хүчингүй болгох тухай шийдвэрүүдийг үндэслэн, ийм алдаа “арбитрын суудлын газарт шийдвэрийг хүчингүй болгох боломж үүсгэж болно” гэж Хариуцагч тайлбарласан.[509]

Нэхэмжлэгчдийн байр суурь

287. Хариуцагчийн ишилсэн эрх зүйн эх сурвалжууд түүний байр суурийг дэмжихгүй гэж Нэхэмжлэгчид маргасан.[510] Энэ нь ICSID-ийн хэрэг биш гэдгийг давтан тэмдэглэж, CMS, Sempra шийдвэрүүдийг “Нью-Йоркийн хуулиар арбитрын шийдвэрийг хүчингүй болгох эсэхийг тогтооход хамааралгүй” гэж тодорхойлсон.[511] Хэлэлцээрийн 8 дугаар зүйлийн 3 дахь хэсэг нь албадан хураалтын нөхөн төлбөр болгон буцаан олголт даалгах эрхийг Арбитрын бүрэлдэхүүнд олгохуйц өргөн бөгөөд уг заалт “олон улсын заншлын эрх зүйг орлохгүй” гэж Нэхэмжлэгчид мөн онцолсон.[512]

---

[503] Нэхэмжлэгчдийн Хариу тайлбар, догол мөр 134.

[504] Сонсголын тэмдэглэл (өдөр 5, 2015 оны 9 дугаар сарын 18) 803:20–805:22.

[505] Хариуцагчийн Хариу үндэслэл, догол мөр 234.

[506] Хариуцагчийн Хариу үндэслэл, догол мөр 234.

[507] CMS Gas Transmission Company v. Argentina, ICSID хэрэг № ARB/01/8; IIC 303 (2007), Хүчингүй болгуулах хүсэлтийг шийдвэрлэсэн шийдвэр, 2007 оны 8 дугаар сарын 21, догол мөрүүд 130-132 (Эрх зүйн эх сурвалж RLA-66).

[508] Sempra Energy International v. Argentina, ICSID хэрэг № ARB/02/16; IIC 438 (2010), Арбитрын шийдвэрийг хүчингүй болгуулах тухай Аргентины хүсэлтийг шийдвэрлэсэн шийдвэр, 2010 оны 6 дугаар сарын 29, догол мөрүүд 188-219 (Эрх зүйн эх сурвалж RLA-67).

[509] Хариуцагчийн Хариу үндэслэл, догол мөрүүд 235-237.

[510] Нэхэмжлэгчдийн Хариу тайлбар, догол мөр 151; мөн үзнэ үү: Сонсголын тэмдэглэл (өдөр 1, 2015 оны 9 дугаар сарын 14) 83:15–84:10.

[511] Нэхэмжлэгчдийн Хариу тайлбар, догол мөр 151.

[512] Нэхэмжлэгчдийн Хариу тайлбар, догол мөр 152.

(f) Маргаан шийдвэрлэх замыг сонгох / Монголын шүүхэд хандсан байдал

Хариуцагчийн байр суурь

288. Нэхэмжлэгчид ижил маргааныг Монголын шүүхэд шилжүүлэхээр сонгосон[513] тул "нэг асуудлаар дахин боломж эдэлж болохгүй"[514] гэсэн үндэслэлээр Хариуцагч Арбитрын бүрэлдэхүүний харьяаллыг эсэргүүцсэн.

289. "Нэхэмжлэгчдийн үзэж байгаагаар, энэ ажиллагаанд 939A тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон үйлдэл хууль бус албадан хураалт болохын тулд Монголын хуулийн хувьд хууль бус байх ёстой" гэж Хариуцагч онцолсон.[515] Эсрэгээр, "маргаж буй Монгол Улсын үйлдлүүд Монголын хуульд нийцэж байвал албадан хураалт бус, харин залилан, хөрөнгө завших болон бусад хууль бус үйлдлийг засах зорилгоор Монгол Улс хууль сахиулах бүрэн эрхээ хэрэгжүүлсэн явдал болно" гэж Хариуцагч маргасан.[516]

290. Хариуцагчийн үзэж байгаагаар, энэ нь Төмөртэй Хүдэрийн "маргаад ялагдсан" ижил шаардлага юм. Иймд Нэхэмжлэгчид маргаан шийдвэрлэх замыг сонгох заалтыг үйлчлэхэд хүргэсэн бөгөөд "Монголын шүүхийн хэрэгт нэхэмжлэгч нь Нэхэмжлэгчид өөрсдөө бус, Төмөртэй Хүдэр байсан нь хамаагүй" гэж Хариуцагч маргасан.[517] Нэхэмжлэгчид тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосныг шүүхэд шууд эсэргүүцэх эрхгүй байсан тул "939A тусгай зөвшөөрөлтэй холбоотой шаардлагаа Төмөртэй Хүдэрээр дамжуулан гаргахаар сонгосон".[518] Хариуцагчийн үзэж байгаагаар, "Төмөртэй Хүдэр нь Нэхэмжлэгчдийн зөвхөн халхавч" бөгөөд "Нэхэмжлэгчид өөрсдөө "хятад хөрөнгө оруулагчид" гэж ажиллагаанд идэвхтэй оролцон, нотлох баримт гаргаж, Монголын шүүхүүд дүгнэлтдээ алдаа гаргасан гэж маргасан".[519]

291. 939A тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон асуудал нь мөн нэгэнт эцэслэн шийдвэрлэгдсэн (res judicata), эсхүл RSM v. Grenada хэргийн бүрэлдэхүүний илэрхийлснээр[520] өмнө тогтоогдсон асуудлыг дахин маргахыг хориглох зарчмаар (collateral estoppel) дахин хэлэлцэх боломжгүй асуудал гэж Хариуцагч тайлбарласан.[521] Pantechniki v. Albania хэрэгт[522] "нэхэмжлэлийн үндсэн суурь" болон "шаардаж буй эрхүүд ижил хэм хэмжээний эх сурвалжтай эсэх"-д анхаарсныг мөн дурдсан.[523] Энд "Монголын шүүхийн

---

[513] Хариуцагчийн Хариу үндэслэл, догол мөр 238.

[514] Хариуцагчийн Хариу үндэслэл, догол мөр 242.

[515] Хариуцагчийн Хариу үндэслэл, догол мөр 239.

[516] Хариуцагчийн Хариу үндэслэл, догол мөр 239.

[517] Хариуцагчийн Хариу үндэслэл, догол мөр 241.

[518] Хариуцагчийн Хариу үндэслэл, догол мөр 241.

[519] Хариуцагчийн Давтан хариу тайлбар, догол мөр 289.

[520] RSM Production Corp et. al. v. Grenada, ICSID хэрэг № ARB/10/6, Арбитрын шийдвэр, 2010 оны 12 дугаар сарын 7, догол мөрүүд 7.1.1-7.1.2 (Эрх зүйн эх сурвалж RLA-68).

[521] Хариуцагчийн Хариу үндэслэл, догол мөрүүд 242-244.

[522] Pantechniki SA Contractors and Engineers v. Albania, ICSID хэрэг № ARB/07/21, Арбитрын шийдвэр, 2009 оны 7 дугаар сарын 28, догол мөр 61 (Эрх зүйн эх сурвалж RLA-28).

[523] Хариуцагчийн Давтан хариу тайлбар, догол мөр 291.

ажиллагаа болон энэ хэргийн “хэм хэмжээний эх сурвалж” ижил буюу 939A тусгай зөвшөөрлийг албадан хураасан гэх үйлдэл” бөгөөд “Нэхэмжлэгчид өөрсдөө Монголын шүүхийн ажиллагаанд “Төмөртэй Хүдэр ХХК хамгаалагдах ёстой” гэсэн үндэслэл болгон Хятад–Монголын хөрөнгө оруулалтын хэлэлцээрийг удаа дараа ишилсэн” гэж Хариуцагч маргасан.[524]

Нэхэмжлэгчдийн байр суурь

292. Маргаан шийдвэрлэх замыг сонгох заалт үйлчлэхийн тулд дотоодын шүүх болон олон улсын арбитрт гаргасан шаардлагуудын “(a) талууд; (b) нэхэмжлэлийн үндэслэл; (c) зүйл (эсхүл хүссэн арга хэмжээ, маргааны зүйл)” ижил байх ёстой гэж Нэхэмжлэгчид тайлбарласан.[525]

293. Дотоодын нэхэмжлэлийг Нэхэмжлэгчид бус, Төмөртэй Хүдэр гаргасан тул Монголын захиргааны шүүхийн ажиллагааны хүсэлт гаргагч болон Нэхэмжлэгчид ижил биш гэж Нэхэмжлэгчид үзсэн. Арбитрын бүрэлдэхүүнүүд талууд ижил байх шаардлагыг хатуу тайлбарладаг гэж тайлбарласан.[526] Ямар ч тохиолдолд тэд Монголын шүүхэд нэхэмжлэл гаргах эрхгүй байх байсан гэж нэмж дурдсан.[527]

294. Монголын шүүхэд гаргасан шаардлага “албадан хураалт бус, тусгай зөвшөөрлийг хүчингүй болгохтой холбоотой Монголын хуулийн заалтад” үндэслэсэн тул нэхэмжлэлийн үндэслэл ижил гэхийг Нэхэмжлэгчид мөн эсэргүүцсэн.[528] Pantechniki хэрэгт хэрэглэсэн илүү өргөн “үндсэн суурь”-ийн шалгуурыг мөн няцааж, “ямар ч байсан энэ хэрэгт уг шалгуур хангагдахгүй” гэж үзсэн.[529]

295. RSM v. Grenada хэрэг нь ажиллагааг урвуулан ашигласан “онцгой нөхцөл” болон ICSID-ийн конвенцын дагуу явагдсан, “үндсэндээ ижил” зэрэгцээ арбитрын ажиллагаатай холбоотой байсан тул ялгаатай гэж Нэхэмжлэгчид тайлбарласан.[530] Харин шүүн таслах практикийн давамгай чиглэл нь тухайн улсад байгуулагдсан компанид “хөрөнгө оруулагч-хувьцаа эзэмшигчийн гэрээний дагуу шаардлага гаргах эрхийг хаалгүйгээр захиргааны хэрэг үүсгэх” боломж олгохыг дэмждэг гэж маргасан.[531]

296. Эцэст нь, Төмөртэй Хүдэрээс ялгаатай нь Нэхэмжлэгчид буцаан олголтын өөр хувилбар болгон хохирлын нөхөн төлбөр шаардаж байгаагаа тэмдэглэсэн.[532]

---

[524] Хариуцагчийн Давтан хариу тайлбар, догол мөр 291 (онцлол эхэд бий).

[525] Нэхэмжлэгчдийн Хариу тайлбар, догол мөр 154.

[526] Нэхэмжлэгчдийн Хариу тайлбар, догол мөрүүд 155-156.

[527] Сонсголын тэмдэглэл (өдөр 1, 2015 оны 9 дугаар сарын 14) 73:20–74:3

[528] Нэхэмжлэгчдийн Хариу тайлбар, догол мөр 157.

[529] Нэхэмжлэгчдийн Хариу тайлбар, догол мөр 157.

[530] Нэхэмжлэгчдийн Хариу тайлбар, догол мөр 158.

[531] Нэхэмжлэгчдийн Хариу тайлбар, догол мөр 158.

[532] Нэхэмжлэгчдийн Хариу тайлбар, догол мөр 159.

2. Нэхэмжлэгчдийн шаардлагыг хүлээн авч хэлэлцэх боломжийн талаарх татгалзлууд

Хариуцагчийн байр суурь

297. Нэхэмжлэгчид эдгээр шаардлагыг “сайн санааны үүднээс гаргах боломжгүй” гэсэн үндэслэлээр Хариуцагч нэхэмжлэлийг хүлээн авч хэлэлцэхийг эсэргүүцсэн.[533] Тухайлбал, Нэхэмжлэгчид БЛТ-д 939А тусгай зөвшөөрлийг завших санхүүжилт өгсөн, өөрсдийн зорилго, чадавхын талаар ач холбогдолтой худал мэдэгдэл хийсэн гэж Хариуцагч мэдүүлсэн.[534] Нэхэмжлэгчид Арбитрын бүрэлдэхүүнд “бохир гартай” ирсэн тул шударга ёс, тэгш байдлын суурь зарчим болон хууль бус үйлдлээс эрх үүсэхгүй (ex injuria jus non oritur) гэсэн зарчмын дагуу нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгох ёстой гэж Хариуцагч үзсэн.[535] Түүний хувьд, “Хэлэлцээр ийм шаардлага гаргахыг зөвшөөрсөн ч Арбитрын бүрэлдэхүүн тухайн шаардлагын мөн чанарыг хэлэлцэхээс татгалзах ёстой”.[536]

298. Нэхэмжлэгчид “Монголын дотоод хэрэгт хууль бусаар хөндлөнгөөс оролцсон” гэж Хариуцагч мөн тайлбарласан.[537] Олон улсын шүүхийн Military and Paramilitary Activities in and against Nicaragua шийдвэрийг[538] үндэслэн, улсын бүрэн эрхт байдлын зарчим нь нийгмийн тодорхой суурь сонголтыг тухайн улсын онцгой эрх мэдэлд үлдээдэг гэж маргасан.[539] Хариуцагчийн үзэж байгаагаар, “удаан үргэлжилсэн бараг колоничлолын өнгөрсөн үеийн дараа бие даасан байдлаа хангах чиглэлд бодит алхам хийхийн тулд Төмөртэйн ордын төмрийн хүдрийг ашиглан Дарханд хүнд төмөрлөгийн үйлдвэр хөгжүүлэх Монголын илэрхий сонголт нь ... ийм тогтолцооны сонголтын нэг хэсэг” юм.[540] Иймд “Нэхэмжлэгчдийн өмнөх улс төрийн хууль бус үйлдлүүдийн улмаас тэдний шаардлагыг хүлээн авч хэлэлцэх боломжгүй” гэж Хариуцагч тайлбарласан.[541]

Нэхэмжлэгчдийн байр суурь

299. Нэхэмжлэгчид нэхэмжлэлийг хүлээн авч хэлэлцэх боломжийн талаар Хариуцагчийн гаргасан татгалзлын баримтат үндэслэлийг эсэргүүцэж,[542] Монгол Улс ““цэвэр гар”-ын зарчим үйлчлэх ямар ч үндэслэл харуулаагүй” гэж тайлбарласан.[543]

---

[533] Хариуцагчийн Хариу үндэслэл, догол мөр 246.

[534] Хариуцагчийн Хариу үндэслэл, догол мөр 247.

[535] Хариуцагчийн Давтан хариу тайлбар, догол мөр 267, Хариуцагчийн Хариу үндэслэл, догол мөр 247.

[536] Хариуцагчийн Хариу үндэслэл, догол мөр 246.

[537] Хариуцагчийн Хариу үндэслэл, догол мөр 248.

[538] Никарагуад болон түүний эсрэг явуулсан цэргийн болон хагас цэргийн үйл ажиллагааны тухай хэрэг (Nicaragua v. US), Үндэслэл, Шүүхийн шийдвэр, 1986 I.C.J. Reports 14, хуудсууд 107-108, догол мөр 205 (Эрх зүйн эх сурвалж RLA-72).

[539] Хариуцагчийн Хариу үндэслэл, догол мөр 248.

[540] Хариуцагчийн Хариу үндэслэл, догол мөр 248.

[541] Хариуцагчийн Хариу үндэслэл, догол мөр 250.

[542] Нэхэмжлэгчдийн Хариу тайлбар, догол мөр 160.

[543] Нэхэмжлэгчдийн Хариу тайлбар, догол мөр 161.

300. Нэхэмжлэгчдийн тайлбарласнаар, “ex iniuria non oritur ius гэсэн үндэслэлээ батлахдаа Хариуцагчийн тулгуурлаж байгаа бололтой баримтын гурван мэдэгдэл ... нотлох баримтаар дэмжигдээгүй”.[544] Түүнчлэн Хариуцагч “Монгол Улс Хятадын хөрөнгө оруулалтыг ерөнхийд нь дэмжсэн, ялангуяа Нэхэмжлэгчдийн Төмөртэй Хүдэрт оруулсан хөрөнгө оруулалтыг зөвшөөрсөн байхад уул уурхайн салбар дахь Хятадын хүсээгүй оролцоонд гомдоллох нь ... үнэмшилгүй” гэж тайлбарласан.[545]

301. Нэхэмжлэгчид Монголын дотоод хэрэгт хууль бусаар хөндлөнгөөс оролцсон гэх Хариуцагчийн мэдэгдлийг мөн няцаасан. Өөрийгөө хангах гэх бодлогоо Nicaragua шийдвэрт хөндсөн асуудлуудтай адилтгасан нь үндэслэлгүй гэж Нэхэмжлэгчид үзсэн. Nicaragua хэрэгт хамаарах зарчим нь төрийн дэмжлэгтэй эдийн засгийн ашиг сонирхол бус, улсуудын оролцоогоор хязгаарлагдана гэж тайлбарласан. Түүнчлэн “энэ зарчим нь улс хүч хэрэглэн хөндлөнгөөс оролцсон нөхцөлд бий болсон бөгөөд компаниудын үйлдсэн гэх залилангаар Монголын хэрэгт хөндлөнгөөс оролцсон гэж маргаж буй энэ хэрэгт хүрээг нь тэлж болохгүй. Үнэндээ хөндлөнгөөс үл оролцох зарчмын гол элемент болох албадлага энэ хэрэгт огт байхгүй” гэж Нэхэмжлэгчид мэдүүлсэн.[546]

С. НЭХЭМЖЛЭГЧДИЙН ХУУЛЬ БУСААР ХӨРӨНГӨ ХУРААСАН ТУХАЙ НЭХЭМЖЛЭЛИЙН ҮНДЭСЛЭЛ

302. Хэлэлцээрийн 4 дүгээр зүйлд холбогдох хэсэгтээ дараах байдлаар заасан:

> 1. Хэлэлцэн тохирогч нэг улсын хөрөнгө оруулагчдын оруулсан хөрөнгө оруулалтыг хэлэлцэн тохирогч нөгөө улсын нутаг дэвсгэрт нийгмийн болон нийтийн ашиг сонирхлын хэрэгцээнээс бусад тохиолдолд улсын өмч болгох, хураах, эсхүл улсын өмч болгох буюу хураахтай адил үр нөлөөтэй арга хэмжээнд хамруулж болохгүй (цаашид “хөрөнгө хураах” гэх). Хөрөнгө хураах ажиллагааг ялгаварлан гадуурхахгүйгээр, хуульд заасан журмын дагуу, нөхөн төлбөр олгох үндсэн дээр явуулна.
>
> 2. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт дурдсан нөхөн төлбөр нь хөрөнгө хураах тухай зарласан үеийн хураасан хөрөнгө оруулалтын үнэтэй тэнцүү, хөрвөх боломжтой, чөлөөтэй шилжүүлж болохуйц байна. Нөхөн төлбөрийг үндэслэлгүйгээр саатуулахгүйгээр төлнө. [...]

1. Хэлэлцээрийн 4 дүгээр зүйлд заасан эрх зүйн шалгуур

Нэхэмжлэгчдийн байр суурь

303. Нэхэмжлэгчдийн үзэж байгаагаар Хэлэлцээрийн 4(1) дүгээр зүйл нь хөрөнгийг шууд болон шууд бусаар хураахаас аль алинаас нь хамгаалдаг. Нэхэмжлэгчдийн хэлснээр:

> Хэлэлцээрийн 4(1) дүгээр зүйл нь хөрөнгө хураалт шууд эсхүл шууд бус хэлбэрээр явагдаж болно гэсэн олон улсын заншлын эрх зүйн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмыг баталгаажуулдаг. Эхнийх нь “өмчийг шууд хураан авах” буюу хөрөнгө оруулагчийн өмчийн эрхэд нөлөөлөх арга хэмжээгээр хэрэгжинэ. Харин хоёр дахь

[544] Нэхэмжлэгчдийн Хариу тайлбар, догол мөр 161.

[545] Нэхэмжлэгчдийн Хариу тайлбар, догол мөр 161.

[546] Нэхэмжлэгчдийн Хариу тайлбар, догол мөр 163.

нь хөрөнгө оруулалтыг өмчлөх албан ёсны эрхэд нөлөөлөхгүйгээр хөрөнгө оруулагчийг хөрөнгө оруулалтаа ашиглах, үр шимийг нь хүртэх боломжгүй болгох үйлдлээр илэрнэ: ийм үйлдэл нь "улсын өмч болгох буюу хөрөнгө хураахтай адил үр нөлөөтэй" байдаг.[547]

304. Шууд бус хөрөнгө хураалтын тухайд Нэхэмжлэгчид "төрийн үйл ажиллагаа хөрөнгө хураалт мөн эсэхийг тогтооход хүлээн зөвшөөрөгдсөн шалгуур нь хөрөнгө оруулалтад үзүүлсэн эдийн засгийн нөлөөллийн хэмжээ юм" гэж мэдүүлэв. Энэ талаар Нэхэмжлэгчид дараах үндэслэлд тулгуурлав —

(a) Metalclad v. The United Mexican States хэрэгт "хөрөнгө хураалт нь ... өмчийг ашиглахад далд буюу дагалдах байдлаар хөндлөнгөөс оролцож, өмчлөгчийг өмчөө ашиглах буюу түүнээс үндэслэлтэйгээр хүлээж болох эдийн засгийн үр өгөөжийг бүхэлд нь эсхүл үлэмж хэмжээгээр хүртэх боломжгүй болгох явдлыг ... хамарна" гэсэн үндэслэл;[548]

(b) Tecmed v. The United Mexican States хэрэгт арбитрын бүрэлдэхүүн хөрөнгө оруулагчийг "хөрөнгө оруулалтаа эдийн засгийн хувьд ашиглах, үр шимийг нь хүртэх боломжгүй болгож, түүнтэй холбоотой эрхүүд, тухайлбал [хөрөнгө оруулалттай] холбоотой орлого буюу ашиг тус хүртэх эрх нь оршин байхаа больсонтой адил байдалд үндсэндээ хүргэсэн" эсэхийг тогтоохыг шаардсан үндэслэл;[549] мөн

(c) RosInvest v. The Russian Federation хэрэгт "хэрэв арга хэмжээ нь хөрөнгө оруулалтын бүхэл хэсэг буюу түүний материаллаг хэсгийг бүрдүүлж буй өмчөөс үлэмж хэмжээгээр салгах үр нөлөөтэй бөгөөд уг арга хэмжээг Хариуцагчид хамааруулж болох бол хөрөнгө хураалт болно" гэсэн үндэслэл болон дараах тайлбар —

"Улсын өмч болгох буюу хөрөнгө хураахтай адил үр нөлөөтэй арга хэмжээ" гэсэн хэллэг нь шууд бус хөрөнгө хураалтыг хамарна. Гэвч энэ нь (i) хөрөнгө оруулалтын эдийн засгийн үнэ цэнийг ... үлэмж хэмжээгээр буюу бүхэлд нь алдагдуулах, (ii) өмчлөх үндсэн эрхийг үлэмж хэмжээгээр буюу бүхэлд нь хасах, эсхүл (iii) хөрөнгө оруулалтад тулгуурласан хууль ёсны хүлээлтийг үгүй хийх шаардлагыг арилгахгүй. ... Арбитрын бүрэлдэхүүн тухайн арга хэмжээний (эсхүл цогц арга хэмжээний) "эцсийн үр нөлөө" нь шууд хөрөнгө хураалттай адил, өөрөөр хэлбэл хөрөнгийн эдийн засгийн үнэ цэнийг үлэмж хэмжээгээр буюу бүхэлд нь алдагдуулсан эсэхийг үнэлэх ёстой.[550]

---

[547] Нэхэмжлэгчдийн Нэхэмжлэлийн үндэслэл, догол мөр 92.

[548] Metalclad Corporation v. The United Mexican States, ICSID хэрэг № ARB(AF)/97/1, Арбитрын шийдвэр, 2000 оны 8 дугаар сарын 30, догол мөр 103 (Эрх зүйн эх сурвалж CLA-55).

[549] Técnicas Medioambientales Tecmed, SA v. The United Mexican States, ICSID хэрэг № ARB(AF)/00/2, Арбитрын шийдвэр, 2003 оны 5 дугаар сарын 29, догол мөр 115 (Эрх зүйн эх сурвалж CLA-28).

[550] RosInvestCo UK Ltd v. The Russian Federation, SCC хэрэг № ARB V 079/2005, Эцсийн шийдвэр, 2010 оны 9 дугаар сарын 12, догол мөрүүд 623-624 (Эрх зүйн эх сурвалж CLA-42).

305. Нэхэмжлэгчид мөн дээрх эрх зүйн эх сурвалжуудад тулгуурлан “хүлээн авагч улсын арга хэмжээ хөрөнгө оруулагчийн хууль ёсны хүлээлтийг зөрчсөн эсэхийг арбитрын бүрэлдэхүүнүүд мөн ач холбогдолтой гэж үзсэн” хэмээн мэдүүлэв.[551]

306. Гэвч Нэхэмжлэгчид Хэлэлцээрийн 4(2) дугаар зүйл (нөхөн төлбөрийн тухай) энэхүү маргаанд төв байр суурь эзлэх нь бүү хэл холбогдолтой гэдгийг ч үгүйсгэв.[552] Нэхэмжлэгчдийн үзэж байгаагаар 4(2) дугаар зүйл нь “хууль бус хөрөнгө хураалтад үйлчлэхгүй бөгөөд ийм тохиолдолд хохирлыг арилгах асуудлыг зөвхөн олон улсын заншлын эрх зүй зохицуулна”.[553]

307. Нэхэмжлэгчид Хариуцагч 4(2) дугаар зүйлд анхаарлаа төвлөрүүлж байгааг буруу, ямар ч тохиолдолд хугацаанаасаа өмнө дэвшүүлсэн асуудал гэж үзэв. Гэсэн хэдий ч Нэхэмжлэгчид “4(2) дугаар зүйл үйлчлэхийн тулд хөрөнгө хураалтыг хүлээн авагч улсын дотоодын хууль тогтоомжийн дагуу “зарласан” байх ёстой гэсэн Хариуцагчийн үндэслэл зайлшгүй буруу” гэж маргав. Учир нь ийм тайлбар нь хууль бус үйл ажиллагааг хянан шалгахаас бодитойгоор хамгаалах үр дагавартай юм.[554]

Хариуцагчийн байр суурь

308. Хэлэлцээрт заасан харьяаллын хязгаарлалтыг харгалзан Хариуцагч нөхөн төлбөрийн тухай 4(2) дугаар зүйлийг холбогдох заалт гэж үзэв.[555] Гэвч Хариуцагчийн үзэж байгаагаар “4(2) дугаар зүйлийн ердийн утга нь нөхөн төлбөр төлөх үүрэг үүсэхийн тулд хөрөнгө хураалтыг “зарласан” байхыг шаарддаг”.[556]

309. 4(1) дүгээр зүйлийн тайлбарын тухайд Хариуцагч дараах байдлаар мэдүүлэв —

> 4(1) дүгээр зүйлийн үгчилсэн утгаар хариуцлага үүсэхийн тулд хэд хэдэн бүрэлдэхүүн хангагдсан байх ёстой. Хөрөнгө оруулалт байх ёстой. Уг хөрөнгө оруулалтыг хэлэлцэн тохирогч нэг улсын хөрөнгө оруулагчид хийсэн байх ёстой. Арга хэмжээ авсан байх ёстой. Энэ арга хэмжээ нь улсын өмч болгох буюу хөрөнгө хураахтай адил үр нөлөөтэй байсан байх ёстой. Эсхүл улсын өмч болгох буюу хөрөнгө хураахтай адил арга хэмжээ авсан байх ёстой. Энэ арга хэмжээ нь нийгмийн буюу нийтийн ашиг сонирхлын хэрэгцээний төлөө, ялгаварлан гадуурхахгүйгээр, хуульд заасан журмын дагуу, нөхөн төлбөр олгох үндсэн дээр хэрэгжсэн байж болохгүй.[557]

310. Хариуцагч мөн “хөрөнгө оруулалтыг хуулийн дагуу хийгээгүй гэсэн дүгнэлт нь 4(1) дүгээр зүйлийн утгаар хөрөнгө хураалт байж болохгүй” гэж мэдүүлэв.[558] Хариуцагчийн үзэж байгаагаар “аливаа зүйл хуулийн дагуу оруулсан хөрөнгө мөн эсэхийг тогтоох нь хоёр талт

---

[551] Нэхэмжлэгчдийн Нэхэмжлэлийн үндэслэл, догол мөр 99.

[552] Нэхэмжлэгчдийн Хариу тайлбар, догол мөр 172.

[553] Нэхэмжлэгчдийн Хариу тайлбар, догол мөр 172 (онцлол эхэд бий).

[554] Нэхэмжлэгчдийн Хариу тайлбар, догол мөр 175.

[555] Хариуцагчийн Хариу үндэслэл, догол мөрүүд 251-257.

[556] Хариуцагчийн Хариу үндэслэл, догол мөр 252.

[557] Хариуцагчийн Хариу үндэслэл, догол мөрүүд 259-260.

[558] Хариуцагчийн Хариу үндэслэл, догол мөр 256.

хөрөнгө оруулалтын гэрээний хамгаалалт үйлчлэх урьдчилсан шаардлага юм. Тухайн хөрөнгийг хуулийн дагуу оруулаагүй гэж тогтоосон хэмжээнд тэр хөрөнгө нь хөрөнгө оруулалт биш тул түүнийг хураасан гэж үзэх боломжгүй".[559]

2. Хэлэлцээрийн 4(1) дүгээр зүйлийг хэрэглэх нь

Нэхэмжлэгчдийн байр суурь

311. Нэхэмжлэгчид Хариуцагч Монгол Улс дахь хөрөнгө оруулалтыг нь хоёр хэлбэрээр хураасан гэж мэдүүлэв:

> (a) нэгдүгээрт, тэдний "БЛТ-д олгож, дараа нь Төмөртэй Хүдэрт шилжүүлсэн 939A тусгай зөвшөөрөлд эзэмшиж байсан шууд бус эрх, ашиг сонирхлыг шууд хураасан; уг тусгай зөвшөөрөл нь Хэлэлцээрийн 1(b) дүгээр зүйлийн дагуу Төмөртэй Хүдэрийн "өмчид эзэмших эрх, ашиг сонирхол", мөн Хэлэлцээрийн 1(e) дүгээр зүйлийн дагуу "байгалийн баялгийг ... ашиглах концесс" аль алинд хамаарна"; мөн
>
> (b) хоёрдугаарт, Нэхэмжлэгчдийн шууд эзэмшдэг "Төмөртэй Хүдэр дэх хувьцааны үнэ цэнийг бууруулснаар шууд бусаар хураасан; уг хувьцаа нь Хэлэлцээрийн 1(b) дүгээр зүйлийн дагуу хөрөнгө оруулалтад тооцогдоно".[560]

312. Нэхэмжлэгчид хөрөнгө хураалт дараахыг багтаасан өөр өөр хэлбэртэй байж болно гэж маргав:

> (a) "өмчийн эрхийг (биет бус өмчийн эрхийг оролцуулан) албан ёсоор хураан авах";
>
> (b) "хөрөнгө оруулалтыг ашиглах боломж буюу түүний үнэ цэнийг бүхэлд нь эсхүл үлэмж хэмжээгээр алдагдуулах"; эсхүл
>
> (c) "хөрөнгө оруулалтын үйл ажиллагааг албадан зогсоох".[561]

313. Нэхэмжлэгчид 939A тусгай зөвшөөрлийг цуцалсныг өмчийн эрхийг шууд, албан ёсоор хураан авсан явдал гэж тодорхойлов. Kardassopoulos and Fuchs v. Georgia хэрэгт[562] тулгуурлан Нэхэмжлэгчид "Монгол Улс Төмөртэй Хүдэрийн тусгай зөвшөөрлийг хураан авсан нь Нэхэмжлэгчдийн Төмөртэй Хүдэрт эзэмших эрх, ашиг сонирхлын улмаас тэдний хөрөнгө оруулалтыг хураасан хэрэг болсон" гэж мэдэгдэв.[563]

314. Нэхэмжлэгчид мөн 939A тусгай зөвшөөрлийг цуцалсан явдлыг хэд хэдэн байдлаар шууд бус хөрөнгө хураалт гэж үзэв:

> 939A тусгай зөвшөөрөл ... түүнд [Төмөртэй Хүдэрт] Төмөртэйн уурхайг ашиглаж, бүтээгдэхүүнээ Монгол Улсын дотоодод буюу гадаадад борлуулах эрх олгож

---

[559] Хариуцагчийн Хариу үндэслэл, догол мөр 256.

[560] Нэхэмжлэгчдийн Нэхэмжлэлийн үндэслэл, догол мөр 252; мөн үзнэ үү: Нэхэмжлэгчдийн Хариу тайлбар, догол мөр 166.

[561] Нэхэмжлэгчдийн Нэхэмжлэлийн үндэслэл, догол мөр 254.

[562] Нэхэмжлэгчдийн Нэхэмжлэлийн үндэслэл, догол мөр 259; Joannis Kardassopoulos and Ron Fuchs v. The Republic of Georgia (ICSID хэргүүд № ARB/05/18 and ARB/07/15) Арбитрын шийдвэр, 2010 оны 3 дугаар сарын 3 (Kardassopoulos and Fuchs v. Georgia) (Эрх зүйн эх сурвалж CLA-34).

[563] Нэхэмжлэгчдийн Нэхэмжлэлийн үндэслэл, догол мөр 259.

байсан. Энэ нь Төмөртэй Хүдэрийн цорын ганц зорилго, үнэндээ цорын ганц үйл ажиллагаа бөгөөд Нэхэмжлэгчдийн хөрөнгө оруулалтын зайлшгүй нөхцөл (conditio sine qua non) байсан. 939А тусгай зөвшөөрөлгүй бол Төмөртэй Хүдэрийн хувьцаа, улмаар Нэхэмжлэгчдийн хөрөнгө оруулалт одоо бодитойгоор үнэ цэнгүй болсон. Түүнчлэн 939А тусгай зөвшөөрлийг цуцалсан нь Төмөртэй Хүдэрийг компанийнхаа зорилгыг хэрэгжүүлэх боломжгүй болгож, Нэхэмжлэгчдийн хөрөнгө оруулалтын үйл ажиллагааг бүрмөсөн зогсооход хүргэж байгаа нь илэрхий. Аль аль үр дагавар нь тухайн хувьцааг шууд бусаар хураасан явдал болно.[564]

315. Нэхэмжлэгчид Хариуцагч 939А тусгай зөвшөөрлийг цуцалснаар хөрөнгө оруулалтын талаарх тэдний хууль ёсны хүлээлтийг зөрчсөн гэж мэдэгдэв.[565] Тодруулбал, “Төмөртэй Хүдэр (түүнээс өмнө БЛТ) Төмөртэйн уурхайг ашиглаж, бүтээгдэхүүнээ дотоодод болон гадаадад борлуулах хүчин төгөлдөр тусгай зөвшөөрөл эзэмшдэг” гэсэн хүлээлт байв.[566] Нэхэмжлэгчид эдгээр хууль ёсны хүлээлтэд тулгуурлан Монгол Улсад хөрөнгө оруулсан бөгөөд Засгийн газраас БЛТ болон Төмөртэй Хүдэрт удаа дараа өгсөн дараах баталгаанууд тэдгээрийг бататгасан гэж мэдүүлэв:

• 1994 оны Ашигт малтмалын тухай хуулийн дагуу БЛТ-д анхны Т-30 тусгай зөвшөөрлийг олгож, дараа нь 1997 оны Ашигт малтмалын тухай хуулийн дагуу түүнийг 939А тусгай зөвшөөрөл болгон дахин бүртгэж уг эрхийг баталгаажуулсан;

• 939А тусгай зөвшөөрлийг БЛТ-ээс Төмөртэй Хүдэрт шилжүүлэхийг зөвшөөрсөн;

• эхлээд БЛТ-ийн, дараа нь Төмөртэй Хүдэрийн 939А тусгай зөвшөөрлийн дагуух эрхийг баталгаажуулсан газар ашиглах олон зөвшөөрөл олгосон;

• орон нутгийн дэд бүтцийг сайжруулах, орон нутгийн ажилчдыг ажиллуулах талаар орон нутгийн захиргаа Төмөртэй Хүдэртэй хамтран ажиллах гэрээ байгуулсан;

• хөрөнгө оруулалтыг нь дэмжиж буйгаа илэрхийлснээр Нэхэмжлэгчдэд Хятадын Экспорт-Импортын банкнаас санхүүжилт авахад тусалсан;

• Үйлдвэр, худалдааны яамаар дамжуулан Төмөртэй Хүдэрийг гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжээр бүртгэхийг Гадаадын хөрөнгө оруулалт, гадаад худалдааны агентлагт дэмжсэн бөгөөд тус агентлаг тав хоногийн дараа уг бүртгэлийг хийсэн;

• 939А тусгай зөвшөөрөл хүчинтэй байх хугацаанд боловсруулсан Техник, эдийн засгийн үндэслэл, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээнүүд, байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө болон 2005–2006 оны ажлын төлөвлөгөөг баталсан; эдгээр нь бүгд эхлээд БЛТ, дараа нь Төмөртэй Хүдэр төмрийн хүдрийг хэрхэн боловсруулж, борлуулахаар төлөвлөж байсныг тодорхой тайлбарласан;

• 1997 оны Дагаж мөрдөх журмын тухай хуулийн дагуу хайгуулын ажилд зарцуулсан улсын хөрөнгийг нөхөн төлөх гэрээ байгуулахыг Төмөртэй Хүдэрээс шаардсан; мөн

• Төмөртэй Хүдэр зөрчлийг арилгах арга хэмжээ авсны дараа 1997 оны Ашигт малтмалын тухай хууль, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай

[564] Нэхэмжлэгчдийн Нэхэмжлэлийн үндэслэл, догол мөр 258.

[565] Нэхэмжлэгчдийн Нэхэмжлэлийн үндэслэл, догол мөр 261.

[566] Нэхэмжлэгчдийн Нэхэмжлэлийн үндэслэл, догол мөр 260.

хууль, Байгаль орчныг хамгаалах тухай хууль болон Тэсэрч дэлбэрэх бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуулийг зөрчсөн гэх үндэслэлээр үйл ажиллагааг нь түдгэлзүүлсэн шийдвэрүүдийг хүчингүй болгосон.[567]

Нэхэмжлэгчид дээр дурдсан баталгаанууд тэдэнд хууль ёсны хүлээлт үүсгэсэн бөгөөд тусгай зөвшөөрлийг цуцлах үед уг хүлээлт зөрчигдсөн гэж үзэв.[568]

316. Нэхэмжлэгчид Монгол Улсын үйлдлийг хууль ёсны зохицуулалтын үйл ажиллагаа гэж зөвтгөж болохыг үгүйсгэв. Эрх зүйн хувьд Нэхэмжлэгчид ""төрийн зохицуулалтын бүрэн эрхийн үл хамаарах тохиолдол" гэгч нь туйлын шинжтэй биш" гэж мэдэгдэв.[569] Харин тухайн арга хэмжээ "ялгаварлан гадуурхсан шинжгүй, шударгаар, нийтийн ашиг сонирхлын төлөө авсан" тохиолдолд л уг үл хамаарах тохиолдолд багтана.[570] ADC v. Hungary хэрэгт[571] тулгуурлан Нэхэмжлэгчид нийтийн ашиг сонирхол байгааг нотлох үүрэг Хариуцагчид ногдоно[572] бөгөөд Хариуцагч уг үүргээ биелүүлээгүй гэж мэдэгдэв.[573]

317. Ямар ч тохиолдолд 939А тусгай зөвшөөрлийг цуцлахад нийгмийн болон нийтийн ашиг сонирхлыг үнэнч шударгаар хангах зорилго байгаагүй гэж Нэхэмжлэгчид үзэв.[574] Нэхэмжлэгчид цуцлалт нь "хөрөнгө завшсан гэж тогтоосон дүгнэлтэд үндэслээгүй" гэж мэдүүлж,[575] цуцлахдаа дурдсан үндэслэл болон Хариуцагчийн одоо дэвшүүлж буй авлигын талаарх мэдэгдлийн ялгааг онцлов. Цуцлах тухай мэдэгдэл болон түүнийг хэвээр үлдээсэн шүүхийн шийдвэрт зөвхөн дараах зөрчлүүдийг дурдсан гэж Нэхэмжлэгчид тэмдэглэв: (a) 160 дугаар тогтоол,

(b) Дагаж мөрдөх журмын тухай хуулийн 7 дугаар зүйл, (c) 1997 оны Ашигт малтмалын тухай хуулийн 30.1 дүгээр зүйл, (d) Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 15.10(4) дүгээр зүйл[576] болон Тэсэрч дэлбэрэх бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуулийн 11 дүгээр зүйл, мөн

(e) Монгол Улсын Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль.[577] Нэхэмжлэгчдийн үзэж байгаагаар "Төмөртэйн ордтой холбоотой авлигын хэрэгт хэзээ ч ял тулгаж байгаагүй төдийгүй Хариуцагч Хариу тайлбараа гаргах хүртэл

---

[567] Нэхэмжлэгчдийн Нэхэмжлэлийн үндэслэл, догол мөр 260.

[568] Нэхэмжлэгчдийн Нэхэмжлэлийн үндэслэл, догол мөр 261.

[569] Нэхэмжлэгчдийн Хариу тайлбар, догол мөр 183.

[570] Нэхэмжлэгчдийн Хариу тайлбар, догол мөр 183.

[571] ADC Affiliate Ltd and ADC & ADMC Management Ltd v. Hungary (ICSID хэрэг № ARB/03/16) Арбитрын шийдвэр, 2006 оны 10 дугаар сарын 2 (Эрх зүйн эх сурвалж CLA-96).

[572] Нэхэмжлэгчдийн Нэхэмжлэлийн үндэслэл, догол мөр 273.

[573] Нэхэмжлэгчдийн Нэхэмжлэлийн үндэслэл, догол мөр 277; мөн үзнэ үү: Сонсголын тэмдэглэл (өдөр 1, 2015 оны 9 дугаар сарын 14) 112:14–113:11.

[574] Нэхэмжлэгчдийн Хариу тайлбар, догол мөр 184.

[575] Нэхэмжлэгчдийн Хариу тайлбар, догол мөр 179.

[576] Монгол Улсын Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль (2001 оны 2 дугаар сарын 1; хүчин төгөлдөр болсон: 2002 оны 1 дугаар сарын 1) (Эрх зүйн эх сурвалж CLA-69).

[577] Нэхэмжлэгчдийн Хариу тайлбар, догол мөр 43.

ийм мэдэгдэл ч огт гаргаж байгаагүй".[578] Ноён Нацагдорж, ноён Баярцогт нарыг хөрөнгө завшсан хэргээр шалгасныг Нэхэмжлэгчид зөвшөөрсөн боловч "таван жилийн мөрдөн шалгах ажиллагааны дараа" тэдэнд холбогдох хэргийг хэрэгсэхгүй болгосон гэж маргав.[579]

318. Нэхэмжлэгчид мөн Монголын дотоодын шүүхийн шийдвэрүүд Арбитрын бүрэлдэхүүний анхаарлын зохистой төв байх ёстой гэдгийг үгүйсгэв. Нэгдүгээрт, Нэхэмжлэгчид "Төмөртэй Хүдэрийн амжилтгүй болсон шүүхийн маргаанд хөрөнгө хураалтын нэхэмжлэлээ үндэслээгүй" гэж тэмдэглэв.[580] Харин "902 дугаар тогтоол нь Хэлэлцээрийн 4(1) дүгээр зүйлийг зөрчсөн хууль бус хөрөнгө хураалт бөгөөд Нэхэмжлэгчдэд олон улсын эрх зүйн дагуу эрхээ хамгаалуулах эрх олгоно. Төмөртэй Хүдэр тусгай зөвшөөрөл цуцлагдсаны хариуд дотоодын эрх зүйн хамгаалалт эрэлхийлсэн нь Нэхэмжлэгчдийн нэхэмжлэлийн шинж чанарыг өөрчлөхгүй".[581] Нэхэмжлэгчид шударга шүүхээр шүүлгэх эрхийг үгүйсгэсэн тухай нэхэмжлэл гаргаагүйгээ цааш нь тодруулсан; харин шүүхийн шийдвэр агуулгын хувьд буруу байсан бөгөөд Арбитрын бүрэлдэхүүн Монголын эрх зүйн асуудлуудыг шууд авч үзэх ёстой гэж маргав.[582]

319. Нэхэмжлэгчдийн үзэж байгаагаар Арбитрын бүрэлдэхүүний өмнө тавигдсан асуудал нь "цэвэр олон улсын эрх зүйн асуудал" юм.[583] Арбитрын бүрэлдэхүүн Монголын хууль тогтоомжийг, түүний дотор хөрөнгө хураалт "хуульд заасан журмын дагуу" явагдсан эсэхийг тогтоохдоо авч үзэж болох боловч энэ нь "Монголын шүүхийн шийдвэрт захирагдах, эсхүл тэдгээрийн дүгнэлтийг дагах ёстой гэсэн үг биш".[584] Нэхэмжлэгчдийн үзэж байгаагаар "цуцлалт нь дотоодын хуулийн хувьд ч үндэслэлгүй байсан" (доорх 328–372 дугаар догол мөрийг үзнэ үү).[585] Гэсэн хэдий ч Нэхэмжлэгчид "цуцлалтыг Монголын хуулийн дагуу зөвтгөх боломжтой байсан ч энэ нь Хэлэлцээрийн дагуу гаргасан хөрөнгө хураалтын нэхэмжлэлээс хамгаалах үндэслэл болохгүй" гэж маргав.[586]

320. Эцэст нь Нэхэмжлэгчид 939A тусгай зөвшөөрлийг цуцалсан нь хууль бус хөрөнгө хураалт байсан гэж мэдүүлэв. Нэхэмжлэгчид "Хэлэлцээр нь (i) "хуульд заасан журмын дагуу", (ii) "нийгмийн болон нийтийн ашиг сонирхлын хэрэгцээний төлөө", мөн

[578] Нэхэмжлэгчдийн Хариу тайлбар, догол мөр 180.

[579] Нэхэмжлэгчдийн Хариу тайлбар, догол мөр 179.

[580] Нэхэмжлэгчдийн Хариу тайлбар, догол мөр 187.

[581] Нэхэмжлэгчдийн Хариу тайлбар, догол мөр 187.

[582] Сонсголын тэмдэглэл (өдөр 1, 2015 оны 9 дугаар сарын 14) 88:2–96:12.

[583] Нэхэмжлэгчдийн Хариу тайлбар, догол мөр 190.

[584] Нэхэмжлэгчдийн Хариу тайлбар, догол мөр 191.

[585] Нэхэмжлэгчдийн Хариу тайлбар, догол мөр 198; мөн үзнэ үү: Сонсголын тэмдэглэл (өдөр 1, 2015 оны 9 дугаар сарын 14) 85:15–86:11; Сонсголын тэмдэглэл (өдөр 5, 2015 оны 9 дугаар сарын 18) 770:13–770:25, эш татсан нь: эсрэг талаас асуусан асуултад өгсөн мэдүүлэг, хатагтай Дарижав, Сонсголын тэмдэглэл (өдөр 4, 2015 оны 9 дугаар сарын 16) 640 to 656.

[586] Нэхэмжлэгчдийн Хариу тайлбар, догол мөр 198.

(iii) “нөхөн төлбөр олгох үндсэн дээр” хийгдээгүй хөрөнгө хураалтын аливаа хэлбэрийг хориглодог” болохыг санууллав.[587] Нэхэмжлэгчдийн үзэж байгаагаар Монгол Улс эдгээр шаардлагын алийг нь ч хангаагүй:

(a) Нэгдүгээрт, Монгол Улс мэдэгдэл өгөөгүй бөгөөд гэх зөрчлүүд үнэн байсан ч тусгай зөвшөөрлийг цуцлах бус торгууль ногдуулах үндэслэлтэй байсан тул “Монгол Улс өөрийн хуульд заасан журмыг мөрдөөгүй” гэж Нэхэмжлэгчид маргав.[588] Нэхэмжлэгчид холбогдох ажиллагааны журмыг 2006 оны Ашигт малтмалын тухай хуулийн 56 дугаар зүйлд заасан гэж мэдүүлж, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 14.1.4 дүгээр зүйл үйлчлэхийг үгүйсгэв. Уг заалт үйлчилсэн ч зөрчил тус бүрийн талаар мэдэгдэх шаардлагатай журмыг мөрдөөгүй гэж Нэхэмжлэгчид цааш нь маргав.[589]

(b) Хоёрдугаарт, Монгол Улс “авсан арга хэмжээ нь Хэлэлцээрийн нийтийн ашиг сонирхлын шаардлагад нийцэж байгааг нотлох үүрэгтэй” гэж Нэхэмжлэгчид мэдүүлэв.[590] Гэвч “хөрөнгө хураах арга хэмжээ Монгол Улсын байгалийн баялагтай холбоотой эрхэд нөлөөлсөн гэх ганц баримт өөрөө хангалттай биш”[591] бөгөөд “Төмөртэйн уурхайн тусгай зөвшөөрлийг төрийн өмчит ДТҮ компанид олгох нь Монгол Улс 939A тусгай зөвшөөрлийг цуцалсан гол шалтгаан байсан болохыг баримтууд харуулж байна”.[592]

(c) Гуравдугаарт, “Монгол Улс Нэхэмжлэгчдийн хөрөнгө оруулалтыг хураасны нөхөн төлбөрийг тэдэнд олгоогүй” гэж Нэхэмжлэгчид тэмдэглэв.[593]

Хариуцагчийн байр суурь

321. Хариуцагч хөрөнгө хураалт болоогүй бөгөөд Арбитрын бүрэлдэхүүн уг асуудлыг шийдвэрлэх харьяалалтай байсан ч Хэлэлцээрийн 4 дүгээр зүйлийг хэрэглэх үндэслэл байхгүй гэж мэдүүлэв.

322. Хариуцагчийн үзэж байгаагаар улс зохицуулалтын бүрэн эрхээ хууль ёсоор хэрэгжүүлэхдээ хөрөнгө оруулагчийн өмчийг хасаж болох бөгөөд ийм тохиолдолд хөрөнгө хураалт болсон гэж үзэхгүй. Хариуцагч Chemtura Corporation v. Canada,[594] Saluka v. Czech

[587] Нэхэмжлэгчдийн Нэхэмжлэлийн үндэслэл, догол мөр 270.

[588] Нэхэмжлэгчдийн Нэхэмжлэлийн үндэслэл, догол мөр 271; мөн үзнэ үү: Сонсголын тэмдэглэл (өдөр 1, 2015 оны 9 дугаар сарын 14) 86:12–88:2; Сонсголын тэмдэглэл (өдөр 5, 2015 оны 9 дугаар сарын 18) 765:2–765:1

[589] Сонсголын тэмдэглэл (өдөр 5, 2015 оны 9 дугаар сарын 18) 765:2–767:1, 769:4–770:12, эш татсан нь: эсрэг талаас асуусан асуултад өгсөн мэдүүлэг, хатагтай Дарижав, Сонсголын тэмдэглэл (өдөр 3, 2015 оны 9 дугаар сарын 16), 591:11–591:19, 589:21–590:20.

[590] Нэхэмжлэгчдийн Нэхэмжлэлийн үндэслэл, догол мөр 273.

[591] Нэхэмжлэгчдийн Нэхэмжлэлийн үндэслэл, догол мөр 274.

[592] Нэхэмжлэгчдийн Нэхэмжлэлийн үндэслэл, догол мөр 275

[593] Нэхэмжлэгчдийн Нэхэмжлэлийн үндэслэл, догол мөр 278.

[594] Chemtura Corporation v. Canada, UNCITRAL, Арбитрын шийдвэр, 2010 оны 8 дугаар сарын 2, догол мөр 266 (Эрх зүйн эх сурвалж RLA-73).

Republic,[595] Methanex v. U.S.,[596] болон Tecmed v. Mexico[597] хэргүүдэд зохицуулалтын бүрэн эрхийн талаар хэлэлцсэнийг дурдан, хөрөнгө завшихтай тэмцэх арга хэмжээ нь зохицуулалтын бүрэн эрхийн шууд хэрэгжилт гэж маргав. Учир нь "эдгээр арга хэмжээ дэлхий даяар авлигын эсрэг олон улсын гэрээнүүдэд нийтээр хүлээн зөвшөөрсөнчлөн нийтийн аюулгүй байдал, аюулгүй орчин, ёс суртахуун болон нийтлэг сайн сайхан байдалд бүхэлдээ тулгуурладаг".[598]

323. Хариуцагчийн үзэж байгаагаар 939A тусгай зөвшөөрлийг цуцалсан нь "Нацагдорж, Баярцогт, Туяа нарыг хулгай, хөрөнгө завших, залилангийн үйлдэл хийсэн гэж тогтоосон дүгнэлтэд үндэслэсэн бөгөөд Нэхэмжлэгчид эдгээр хүмүүсийг санхүүжүүлж байснаа одоо хүлээн зөвшөөрч байгаа".[599] Түүнчлэн "Нэхэмжлэгчдийн ноцтой, давтан хууль бус үйл ажиллагаа 939A тусгай зөвшөөрлийг цуцлах үндэслэл болсон" гэж Хариуцагч маргав:[600]

> [Төмөртэй Хүдэр] Монголын хуулийг удаа дараа зөрчсөн. Зөрчлүүдээс цөөн хэдийг нэрлэвэл, зөвшөөрөлгүй тэсэлгээ хийсэн, боловсруулаагүй хүдрийг зах зээлийн үнээс хавьгүй доогуур үнээр Хятад руу хууль бусаар тээвэрлэсэн, амласан төмөр ангижруулах үйлдвэрээ барихаас татгалзсан, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний шаардлагыг удаа дараа зөрчсөн.[601]

324. Ийм нөхцөлд 939A тусгай зөвшөөрлийг цуцалсан нь Монгол Улсын "нийгмийн болон нийтийн ашиг сонирхлын хэрэгцээг" хангаж байсан гэж Хариуцагч маргав. Тухайлбал, Хариуцагч "Нэхэмжлэгчдийн залилангийн шинжтэй худал мэдүүлгийн улмаас уурхайн бүтээн байгуулалт, амласан ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр болон бусад татварын орлого алдагдах хэлбэрээр Монгол Улсад хохирол учирсан"[602] бөгөөд "Төмөртэй Хүдэрийн ноцтой, давтан зөрчлүүд нь Монголын нийтийн ашиг сонирхлыг хохироон Монголын зохицуулалтын тогтолцоог тогтмол үл тоомсорлосныг харуулдаг" гэж үзэв.[603] Иймээс Хариуцагчийн хувьд "Монгол Улсын үйлдэл ... зохицуулалтын бүрэн эрхээ хууль ёсоор хэрэгжүүлэх хүрээнд бүхэлдээ багтсан" юм.[604]

---

[595] Saluka Investments BV v. Czech Republic, UNCITRAL, Хэсэгчилсэн шийдвэр, 2006 оны 3 дугаар сарын 17, догол мөр 262 (Эрх зүйн эх сурвалж RLA-74).

[596] Methanex Corporation v. United States of America, UNCITRAL, Арбитрын шийдвэр, 2005 оны 8 дугаар сарын 3, догол мөр 410 (Эрх зүйн эх сурвалж RLA-75).

[597] Técnicas Medioambientales Tecmed S.A. v. United Mexican States, ICSID хэрэг № ARB(AF)/00/2, Арбитрын шийдвэр, 2003 оны 5 дугаар сарын 29, догол мөр 119 (Эрх зүйн эх сурвалж RLA-76).

[598] Хариуцагчийн Хариу үндэслэл, догол мөр 262.

[599] Хариуцагчийн Хариу үндэслэл, догол мөр 263.

[600] Хариуцагчийн Давтан хариу тайлбар, догол мөр 334.

[601] Хариуцагчийн Давтан хариу тайлбар, догол мөр 328.

[602] Хариуцагчийн Хариу үндэслэл, догол мөр 293.

[603] Хариуцагчийн Давтан хариу тайлбар, догол мөр 329.

[604] Хариуцагчийн Хариу үндэслэл, догол мөр 263; мөн үзнэ үү: Сонсголын тэмдэглэл (өдөр 1, 2015 оны 9 дугаар сарын 14) 213:2–220:12.

325. Хариуцагч мөн “939A тусгай зөвшөөрлийг цуцалсныг Монголын шүүхэд маргаад амжилт олоогүй тул ... Нэхэмжлэгчид нэхэмжлэлээ хангуулъя гэвэл Монголын шүүхийн шийдвэрүүд хөрөнгө хураалтын тухай заалтын утгаар шаардлага хангасан “арга хэмжээ” байх ёстой” гэж мэдүүлэв.[605] “939A тусгай зөвшөөрлийг цуцалсан нь хууль ёсны байсан эсэх асуудал нь Монголын эрх зүйн асуудал” гэж Хариуцагч маргав.[606] Нэхэмжлэгчид тусгай зөвшөөрлийг цуцалсныг Монголын шүүхэд удаа дараа маргаж, тухай бүр ялагдсан гэж Хариуцагч тэмдэглэв.[607] Ийм нөхцөлд “энэ мэт олон улсын арбитрын бүрэлдэхүүн ... дотоодын эрх зүйн асуудлаар гаргасан дүгнэлтийг, тэр тусмаа дотоодын шүүхийн тогтоосон үйл баримтыг давж заалдах журмаар хянах байгууллага биш”[608] бөгөөд “шүүх олон улсын үүргийг зөрчих үндсэн хэлбэр нь шударга шүүхээр шүүлгэх эрхийг үгүйсгэх явдал” гэж Хариуцагч үзэв.[609] Гэвч “Нэхэмжлэгчид Монголын шүүхүүд ажиллагааны ямар нэг зөрчил гаргасан, тэр тусмаа олон улсын эрх зүйн зөрчил болохуйц зөрчил гаргасан гэж огт мэдэгдээгүй тул шүүхийн шийдвэрүүд олон улсын эрх зүйн зөрчил болж чадахгүй” гэж Хариуцагч маргав.[610] Шударга шүүхээр шүүлгэх эрхийг үгүйсгэсэн тохиолдлоос бусад нөхцөлд S.D. Myers v. Canada,[611] Mondev v. United States,[612] Waste Management v. United Mexican States II,[613] Nykomb v. Latvia,[614] болон Helnan Hotels v. Egypt[615] хэргүүдийн шийдвэрийг багтаасан шүүхийн практикийн өргөн хүрээтэй цуваа нь “939A тусгай зөвшөөрлийг цуцалсан тухай Монголын шүүхийн шийдвэрүүдэд Арбитрын бүрэлдэхүүн хүндэтгэлтэй хандах ёстойг” харуулдаг гэж Хариуцагч үзэв.[616]

326. Эцэст нь Монгол Улс Нэхэмжлэгчдийг хөрөнгө оруулалтаа хэрэгжүүлж байсан этгээдээс нь бүрмөсөн буюу бүхэлд нь салгаагүй тул хөрөнгө хураалт болоогүй гэж Хариуцагч

---

[605] Хариуцагчийн Хариу үндэслэл, догол мөр 264.

[606] Хариуцагчийн Давтан хариу тайлбар, догол мөр 342.

[607] Хариуцагчийн Давтан хариу тайлбар, догол мөрүүд 346-348.

[608] Хариуцагчийн Хариу үндэслэл, догол мөр 269.

[609] Хариуцагчийн Хариу үндэслэл, догол мөр 267.

[610] Хариуцагчийн Хариу үндэслэл, догол мөр 264.

[611] S.D. Myers, Inc. v. Government of Canada, UNCITRAL, Хэсэгчилсэн шийдвэр, 2000 оны 11 дугаар сарын 13, догол мөр 263 (Эрх зүйн эх сурвалж RLA-78).

[612] Mondev International Ltd. v. United States of America, ICSID хэрэг № ARB(AF)/99/2, Арбитрын шийдвэр, 2002 оны 10 дугаар сарын 11, догол мөр 126 (Эрх зүйн эх сурвалж RLA-81).

[613] Waste Management, Inc. v. United Mexican States («2 дугаар»), ICSID хэрэг № ARB(AF)/00/3, Арбитрын шийдвэр, 2004 оны 4 дугаар сарын 30, догол мөр 130 зүүлт 84 (Эрх зүйн эх сурвалж RLA-178).

[614] Nykomb Synergetics Technology Holding AB v. The Republic of Latvia, SCC хэрэг № 118/2001, Арбитрын шийдвэр, 2003 оны 12 дугаар сарын 16, догол мөр 55 (Эрх зүйн эх сурвалж RLA-179).

[615] Helnan Int'l Hotels A/S v. Arab Republic of Egypt, ICSID хэрэг № ARB/05/19, Арбитрын шийдвэр, 2008 оны 7 дугаар сарын 3, догол мөр 106 (Эрх зүйн эх сурвалж RLA-180).

[616] Хариуцагчийн Давтан хариу тайлбар, догол мөр 349; мөн үзнэ үү:, Сонсголын тэмдэглэл (өдөр 1, 2015 оны 9 дугаар сарын 14) 220:13–221:10.

мэдүүлэв.[617] Grand River v. United States of America хэрэгт[618] тулгуурлан Хариуцагч 4(1) дүгээр зүйл “хэсэгчлэн хураах үр нөлөөтэй арга хэмжээнд үйлчлэхгүй” гэж маргав.[619] Хариуцагчийн үзэж байгаагаар 4(1) дүгээр зүйлийн ердийн утга энэ тайлбарыг дэмждэг: уг заалт нь “хөрөнгө оруулалт буюу түүний зарим хэсэг” бус, “хөрөнгө оруулалтууд” гэж заасан.[620]

327. Хариуцагч цуцлалтын үйл баримт нь Нэхэмжлэгчдийн өмчийг бүрмөсөн, бүхэлд нь хассан явдалтай адилтгахгүй гэж маргав. “Нэхэмжлэгчид Төмөртэй Хүдэрт эзэмшдэг хувьцаагаа хасуулсан гэж мэдэгдээгүй” болохыг Хариуцагч онцлов.[621] Хариуцагч мөн “Нэхэмжлэгчдийн хийсэн гэх хөрөнгө оруулалтын дийлэнх хэсэг, тухайлбал Төмөртэй Хүдэрийн тоног төхөөрөмжийг огт хураагаагүй. Харин Нэхэмжлэгчид энэ арбитрт алдсан гэж мэдүүлж буй яг тэр тоног төхөөрөмжийг бусад зэргэлдээ ордод үргэлжлүүлэн ашиглаж байна. Иймд хөрөнгө хураалт гэж үзэхэд хангалттай түвшинд хөрөнгө оруулалтыг хассан холбогдох үйлдэл байхгүй” гэж мэдүүлэв.[622]

3. Монголын эрх зүйн дагуу 939A тусгай зөвшөөрлийг цуцалсны хууль ёсны байдал

328. Хэлэлцээрийн 4 дүгээр зүйлийг хэрэглэх тухай Талуудын үндэслэлүүд нь 939A тусгай зөвшөөрлийг цуцалсан явдал Монголын эрх зүйн дагуу хууль ёсны эсэх талаар тэдний үзэл бодол зөрүүтэй байгааг харуулдаг. Энэ асуудлын ач холбогдлын талаар ч Талуудын байр суурь ялгаатай. Ерөнхийд нь хэлбэл, Нэхэмжлэгчид Монголын хууль тогтоомжийг мөрдсөн эсэх нь Хэлэлцээрийн шаардлага хангагдсан эсэхийг эцэслэн тодорхойлохгүй гэж үздэг боловч Засгийн газрын үйлдэл Монголын хуулийг зөрчсөн гэдэгт мөн итгэлтэй байна. Харин Хариуцагч өөрийн үйлдлийг Монголын шүүхүүд удаа дараа зөвтгөн хэвээр үлдээсэн нь Монголын эрх зүйн асуудлыг эцэслэн шийдвэрлэсэн гэж үздэг бөгөөд Хэлэлцээрийн аливаа зөрчил байж болохын зайлшгүй урьдчилсан нөхцөл нь Монголын хууль зөрчигдсөн байх явдал гэж мөн мэдэгддэг. Монголын хууль зөрчигдөөгүй нөхцөлд цуцлалт нь зохистой зохицуулалтын арга хэмжээний хувьд үндэслэлтэй байсан гэж Хариуцагч үздэг.

329. 939A тусгай зөвшөөрлийг цуцлахад дэвшүүлсэн дотоодын эрх зүйн янз бүрийн үндэслэлийн талаар Талуудын тус тусын байр суурийг дараах байдлаар тусгав.

---

[617] Хариуцагчийн Хариу үндэслэл, догол мөр 279.

[618] Grand River Enterprises Six Nations Ltd et al. v. United States of America, ICSID хэрэг № ARB/10/5, Арбитрын шийдвэр, 2011 оны 1 дугаар сарын 12, догол мөр 147 (Эрх зүйн эх сурвалж RLA-86).

[619] Хариуцагчийн Хариу үндэслэл, догол мөр 281.

[620] Хариуцагчийн Хариу үндэслэл, догол мөр 281, эшилсэн нь: Grand River Enterprises Six Nations Ltd et al. v. United States of America, ICSID хэрэг № ARB/10/5, Арбитрын шийдвэр, 2011 оны 1 дугаар сарын 12, догол мөр 147 (Эрх зүйн эх сурвалж RLA-86).

[621] Хариуцагчийн Хариу үндэслэл, догол мөр 280.

[622] Хариуцагчийн Хариу үндэслэл, догол мөр 282.

(а) 160 дугаар тогтоолын дагуу Төмөртэйн ордын эрхийг өмнө нь эзэмшиж байсан тухай

Нэхэмжлэгчдийн байр суурь

330. Нэхэмжлэгчдийн үзэж байгаагаар “160 дугаар тогтоол Төмөртэйн ордыг ашиглах эрх олгоогүй”.[623] Тогтоолын бичвэрт тулгуурлан Нэхэмжлэгчид “160 дугаар тогтоолд Төмөртэйн талбайд ил уурхай байгуулахаар заасан боловч ордыг ашиглах аливаа эрх олгохоор зорьсон зүйлгүй нь гурав дахь хэсгийн үг хэллэгээс харагдана” гэж мэдүүлэв.[624] Харин тогтоол нь зорилгоо илэрхийлсэн мэдэгдэл юм. Нэхэмжлэгчид мөн ямар ч тохиолдолд тэр үед ДТҮ оршин байгаагүй гэж нэмж мэдэгдэв.[625]

331. Түүнчлэн Нэхэмжлэгчдийн үзэж байгаагаар:

> 160 дугаар тогтоол Төмөртэйн ордыг ашиглах эрх олгохоор зорьсон байсан ч Монголын эрх зүйд уг тогтоолыг тийм үр нөлөөтэй байлгах хууль зүйн үндэслэл байгаагүй: 160 дугаар тогтоол батлагдах үед ашиглалтын тусгай зөвшөөрөл олгохыг зохицуулж байсан 1988 оны Газрын хэвлийн тухай хууль Сайд нарын Зөвлөлд төмрийн хүдрийн ордын ашиглалтын тусгай зөвшөөрөл олгох эрх олгоогүй. Харин 1988 оны Газрын хэвлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлд төмрийн хүдэр зэрэг түгээмэл бус тархацтай ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл олгох онцгой бүрэн эрхийг уул уурхай, ашигт малтмалын асуудал эрхэлсэн тусгай байгууллагад олгосон.[626]

Нэхэмжлэгчид “Сайд нарын Зөвлөлөөс гаргасан ... 160 дугаар тогтоол тухайн үед хүчин төгөлдөр байсан Монголын хуулийн дагуу ашиглалтын эрх олгосон байх боломжгүй” гэж дүгнэв.[627]

332. Ямар ч тохиолдолд Дархан өөрт байж болох аливаа эрхийг 1997 оны Дагаж мөрдөх журмын тухай хуульд шаардсаны дагуу дахин бүртгүүлээгүй гэж Нэхэмжлэгчид тэмдэглэв.[628] Мөн 2006 оны үйл ажиллагаанаас өмнө “Монголын Засгийн газар Төмөртэй Хүдэрийг (түүнээс өмнө БЛТ-ийг) 939А тусгай зөвшөөрлийн зүй ёсны, хууль ёсны эзэмшигч гэдгийг удаа дараа, сайн дураараа баталгаажуулж байсан” гэж мэдэгдэн, ДТҮ нь 160 дугаар тогтоол гарсны маргааш л байгуулагдсаныг онцлов.[629]

---

[623] Нэхэмжлэгчдийн Нэхэмжлэлийн үндэслэл, догол мөр 193.

[624] Нэхэмжлэгчдийн Нэхэмжлэлийн үндэслэл, догол мөр 194 (онцлол эхэд бий).

[625] Сонсголын тэмдэглэл (өдөр 1, 2015 оны 9 дугаар сарын 14) 100:10–100:13; Сонсголын тэмдэглэл (өдөр 5, 2015 оны 9 дугаар сарын 18), 776:11–777:2,

[626] Нэхэмжлэгчдийн Нэхэмжлэлийн үндэслэл, догол мөр 195.

[627] Нэхэмжлэгчдийн Нэхэмжлэлийн үндэслэл, догол мөр 195; мөн үзнэ үү: Сонсголын тэмдэглэл (өдөр 1, 2015 оны 9 дугаар сарын 14) 99:21–100:9; Сонсголын тэмдэглэл (өдөр 5, 2015 оны 9 дугаар сарын 18), 774:17–775:9, эш татсан нь: Эсрэг талаас асуусан асуултад өгсөн мэдүүлэг, ноён Хурц, Сонсголын тэмдэглэл (өдөр 3, 2015 оны 9 дугаар сарын 16) 518:7–518:12.

[628] Нэхэмжлэгчдийн Нэхэмжлэлийн үндэслэл, догол мөр 196.

[629] Нэхэмжлэгчдийн Нэхэмжлэлийн үндэслэл, догол мөр 205; мөн үзнэ үү: Сонсголын тэмдэглэл (өдөр 1, 2015 оны 9 дугаар сарын 14) 101:1–101:22.

Хариуцагчийн байр суурь

333. Хариуцагчийн үзэж байгаагаар БЛТ болон Төмөртэй Хүдэр 939А тусгай зөвшөөрлийг 1990 оны 4 дүгээр сарын 14-ний өдрийн 160 дугаар тогтоолыг зөрчин олж авсан.

334. Хариуцагч Сайд нарын Зөвлөл 160 дугаар тогтоолоор ордын эрхийг олгох бүрэн эрхтэй байсан гэж үзэж, уг байгууллагыг Монголын "төрийн захиргааны гүйцэтгэх, захиран зарцуулах дээд байгууллага", "төрийн болон хувийн өмчийн эрхэд тусгайлан чиглэсэн арга хэмжээ батлах зэрэг яамдын ажлыг удирдан чиглүүлэх" эрхтэй байгууллага гэж тодорхойлов.[630] Хариуцагч ноён Хурцын мэдүүлгийг эш татан 1990-ээд оны эхээр Монгол Улс төлөвлөгөөт эдийн засгаас зах зээлийн эдийн засагт шилжсэн бөгөөд үүний үр дүнд 1994 оноос хойш Газрын хэвлийн тухай хууль шинэ Ашигт малтмалын тухай хуультай хамт үйлчилж байсныг тайлбарлав.[631] Хариуцагч цааш нь Газрын хэвлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлд заасан журам нь ашиглалтын эрх авах бус, зөвхөн "уурхайн эдэлбэрийн талбайн" эрх авахад хамаардаг гэж тодруулав.[632] Тусгай зөвшөөрөл олгох эрх бүхий байгууллага байгаагүй тул 1990-ээд оны дунд үе хүртэл Монгол Улсад Сайд нарын Зөвлөлийн тогтоолоор ашиглалтын эрх олгох нь нийтлэг практик байсан гэж Хариуцагч мэдүүлэв.[633]

335. Дархан нь 160 дугаар тогтоол батлагдсаны дараа нэн даруй байгуулагдсан гэж Хариуцагч тэмдэглэн, энэ нь тогтоолд дурдсан Хар төмөрлөгийн үйлдвэр болон Дархан хоорондын холбоог нотолдог гэж мэдүүлэв.[634] Хариуцагч мөн ноён Шагдар, ноён Ганжууржав (тухайн үеийн Дарханы захирлууд) нарын мэдүүлэг, тухайн үеийн албан бичгүүд болон Монголын шүүхийн дүгнэлтүүдийг эш татан "160 дугаар тогтоолын дараа Төмөртэйн ордыг хэн эзэмшиж, хянаж байсан талаар эргэлзээ байгаагүй" гэж мэдүүлэв.[635]

336. Хариуцагч "Дарханы Төмөртэйн ордод эзэмшиж байсан хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хассан болохыг Нэхэмжлэгчид [эхэд ийнхүү бичсэн] нотлох аливаа тогтоол буюу бусад хууль зүйн үндэслэл байхгүй тул Дарханы эрх, ашиг сонирхлыг хасаагүй гэсэн ганц

---

[630] Хариуцагчийн Давтан хариу тайлбар, догол мөр 395; мөн үзнэ үү: Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Үндсэн хууль (тулгуур хууль), зүйлүүд 33, 37 (Эрх зүйн эх сурвалж RLA-117); Сонсголын тэмдэглэл (өдөр 5, 2015 оны 9 дугаар сарын 18) 844:15–854:21.

[631] Сонсголын тэмдэглэл (өдөр 5, 2015 оны 9 дугаар сарын 18) 845:12–848:16, эш татсан нь: Ноён Хурцын эсрэг талаас асуусан асуултад өгсөн мэдүүлэг, Сонсголын тэмдэглэл (өдөр 3, 2015 оны 9 дугаар сарын 16) 521:24–522:15.

[632] Сонсголын тэмдэглэл (өдөр 5, 2015 оны 9 дугаар сарын 18) 849:18–854:21, эш татсан нь: Ноён Хурцын эсрэг талаас асуусан асуултад өгсөн мэдүүлэг, Сонсголын тэмдэглэл (өдөр 3, 2015 оны 9 дугаар сарын 16) 522:16–523:11.

[633] Сонсголын тэмдэглэл (өдөр 5, 2015 оны 9 дугаар сарын 18) 849:18–850:10, эш татсан нь: Ноён Хурцын асуултад өгсөн мэдүүлэг, Сонсголын тэмдэглэл (өдөр 3, 2015 оны 9 дугаар сарын 16) 536:8–537:18; Сонсголын тэмдэглэл (өдөр 5, 2015 оны 9 дугаар сарын 18) 848:17–849:17, эш татсан нь: Хатагтай Дарижавын асуултад өгсөн мэдүүлэг, Сонсголын тэмдэглэл (өдөр 3, 2015 оны 9 дугаар сарын 16) 670:16–670:25.

[634] Хариуцагчийн Давтан хариу тайлбар, догол мөр 379.

[635] Хариуцагчийн Давтан хариу тайлбар, догол мөр 383.

дүгнэлт л байж болно” гэж дүгнэв.[636] Харин Дархан Улсын прокурорын газарт явуулсан захидалдаа дурдсанчлан:

> Т. Нацагдорж өөрийн хувийн ашиг сонирхлыг хангах зорилгоор эрх мэдэл, албан тушаалаа урвуулан ашиглаж ашиглалтын тусгай зөвшөөрлийг дахин бүртгүүлэх хүсэлтийг санаатайгаар гаргаагүй бөгөөд үүний улмаас манай үйлдвэрийн тусгай зөвшөөрөл хүчингүй болж, улмаар тэрээр өөрийн дүү Л. Туяа болон дотнын найз Ганбатын тусламжтайгаар Төмөртэйн төмрийн хүдрийн ордыг өөртөө авсан.[637]

Хариуцагч тусгай зөвшөөрлийг цуцлахад хэрэглэсэн шалгуур нь иргэний хариуцлагын шалгуур байсан гэдгийг онцлон,[638] “Нэхэмжлэгчид Монголын эрүүгийн үйлдэлд тавигдах шалгуурыг Арбитрын бүрэлдэхүүнд төөрөгдүүлэх байдлаар тулгахыг оролдож байна” гэж маргав.[639]

337. Хариуцагч цааш нь БЛТ-ийн үйлдэл Нэхэмжлэгчдийн нэхэмжлэлд холбогдох учиртай гэж дараах үндэслэлээр маргав:

> (a) “939A тусгай зөвшөөрлийг цуцалсан үндэслэлийн нэг нь түүнийг хууль бусаар олж авсан явдал”[640] бөгөөд Монголын хуулийн дагуу түүнийг хүчин төгөлдөр худалдаагаар шилжүүлсэн байсан ч хулгайлагдсан гэж үзнэ; мөн (b) Нэхэмжлэгчид болон БЛТ-ийн хооронд “тодорхой, нягт холбоо бий”.[641] Учир нь, бусад үндэслэлээс гадна, БЛТ нь Төмөртэй Хүдэрийн хамтарсан үйлдвэрийн түнш, харин ноён Баярцогт нь БЛТ-ийн хоёр хувьцаа эзэмшигчийн нэг бөгөөд Төмөртэй Хүдэрийн менежер юм.[642]

(b) Хайгуулын зардлыг Засгийн газарт нөхөн төлөөгүй тухай

338. 1997 оны Дагаж мөрдөх журмын тухай хуулийн 7 дугаар зүйлд дараах байдлаар заасан:

> Улсын төсвийн хөрөнгөөр явуулсан хайгуулын ажлаар ашигт малтмалын ордыг илрүүлж, нөөцийг нь тогтоосон тохиолдолд тухайн ордын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь улсаас өмнө нь гаргасан хайгуулын зардлыг Ашигт малтмалын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн таван (5) жилийн хугацаанд тэнцүү хэмжээгээр улсад нөхөн төлнө.

Нэхэмжлэгчдийн байр суурь

339. Нэхэмжлэгчид “1997 оны Дагаж мөрдөх журмын тухай хуулийн 7 дугаар зүйлд тодорхой тусгай зөвшөөрөл эзэмшигчдийг тухайн тусгай зөвшөөрөлд хамаарах талбайд өмнө нь

---

[636] Хариуцагчийн Давтан хариу тайлбар, догол мөр 388.

[637] ДТҮ-ээс Улсын ерөнхий прокурорын газарт хүргүүлсэн албан бичиг, 2006 оны 6 дугаар сарын 2 (Баримт С-99); Хариуцагчийн Давтан хариу тайлбар, догол мөр 389.

[638] Хариуцагчийн Давтан хариу тайлбар, догол мөр 391.

[639] Хариуцагчийн Давтан хариу тайлбар, догол мөр 391.

[640] Хариуцагчийн Давтан хариу тайлбар, догол мөр 393.

[641] Хариуцагчийн Давтан хариу тайлбар, догол мөр 394.

[642] Хариуцагчийн Давтан хариу тайлбар, догол мөр 394.

улсын хөрөнгөөр хийсэн хайгуулын ажлын зардлыг Засгийн газарт нөхөн төлөхийг шаардсан" болохыг хүлээн зөвшөөрөв.[643]

340. Гэвч Нэхэмжлэгчид Төмөртэй Хүдэр 2006 оны 6 дугаар сарын 5-нд нөхөн төлөх гэрээ байгуулсан гэж тэмдэглэн, "тусгай зөвшөөрөл эзэмшигчид гарын үсэг зурах гэрээний төслийг өгдөг АМГТХЭГ-тай гэрээ байгуулах мэдэгдэл хүлээн авсны дараа л 234 дүгээр тогтоолын дагуу нөхөн төлөлт хийдэг нь Монгол Улсын тогтсон практик байсан" гэж маргав.[644] Нэхэмжлэгчид мөн "234 дүгээр тогтоолд заасан томьёогоор хайгуулын зардлыг зөвхөн төрд байсан мэдээлэлд тулгуурлан тооцдог" тул "Төмөртэй Хүдэр өөрийн нөхөн төлөх үүргийн хэмжээг өөрөө тооцох боломжгүй байсан" гэж тэмдэглэв.[645]

341. Ямар ч тохиолдолд "Төмөртэй Хүдэр 1997 оны Дагаж мөрдөх журмын тухай хуулийн 7 дугаар зүйлд заасан нөхөн төлөх үүргээ зөрчсөн байсан ч тусгай зөвшөөрлийг нь цуцлах нь зохистой шийтгэл болохгүй" гэж Нэхэмжлэгчид мэдүүлэв.[646] 1997 оны Ашигт малтмалын тухай хууль болон 1997 оны Дагаж мөрдөх журмын тухай хуулийн аль нь ч ийм шийтгэл заагаагүй бөгөөд 2006 оны Ашигт малтмалын тухай хууль хугацаа хэтэрсэн төлбөрт зөвхөн торгуулийн хэмжээг тогтоосон.[647]

Хариуцагчийн байр суурь

342. Төмөртэй Хүдэр 1990–1994 онд Монгол Улсын хийсэн Төмөртэйн ордын хайгуулын төлбөрийг хугацаанд нь төлөөгүй гэж Хариуцагч мэдүүлэв. Хариуцагчийн үзэж байгаагаар энэ нь 1997 оны Дагаж мөрдөх журмын тухай хуулийн 7 дугаар зүйлийг[648] Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 14.1.4 дүгээр зүйлийн дагуу 939А тусгай зөвшөөрлийг цуцлахад хүргэхүйц ноцтой зөрчсөн явдал юм.[649]

343. Хариуцагч Нэхэмжлэгчид 2002 оны 7 дугаар сарын 1 гэхэд төлбөрийг төлөх үүрэгтэй байсан боловч зөвхөн 2006 оны 6 дугаар сараас төлж эхэлсэн гэж үзэв.[650] "Нэхэмжлэгчид хугацаа дуусахаас өмнө ... ийм гэрээ байгуулахыг эрмэлзээгүй", 2002 оны 7 дугаар сарын 1-нээс өмнө Монголын эрх бүхий байгууллагуудаас шаардлагатай мэдээлэл авахын тулд "ямар ч оролдлого хийгээгүй" тул хожим байгуулсан нөхөн төлөх гэрээ Нэхэмжлэгчдийн төлбөрийн үүргийг арилгасан гэж Хариуцагч үзээгүй.[651] Хариуцагч мөн нөхөн төлөх гэрээнд "Монгол Улс Ашигт малтмалын тухай хууль болон Аж ахуйн үйл ажиллагааны

---

[643] Нэхэмжлэгчдийн Нэхэмжлэлийн үндэслэл, догол мөр 206.

[644] Нэхэмжлэгчдийн Нэхэмжлэлийн үндэслэл, догол мөр 208; мөн үзнэ үү: Сонсголын тэмдэглэл (өдөр 1, 2015 оны 9 дугаар сарын 14) 103:14–103:24.

[645] Нэхэмжлэгчдийн Нэхэмжлэлийн үндэслэл, догол мөр 208.

[646] Нэхэмжлэгчдийн Нэхэмжлэлийн үндэслэл, догол мөр 209.

[647] Нэхэмжлэгчдийн Нэхэмжлэлийн үндэслэл, догол мөрүүд 209-211; мөн үзнэ үү: Сонсголын тэмдэглэл (өдөр 1, 2015 оны 9 дугаар сарын 14) 103:25–104:9.

[648] Хариуцагчийн Давтан хариу тайлбар, догол мөр 398.

[649] Хариуцагчийн Давтан хариу тайлбар, догол мөр 397.

[650] Хариуцагчийн Давтан хариу тайлбар, догол мөрүүд 396-397.

[651] Хариуцагчийн Давтан хариу тайлбар, догол мөр 399.

тусгай зөвшөөрлийн тухай хуулийн дагуу зөрчил арилгуулах арга хэмжээ авахаас татгалзах" ямар нэг заалт байгаагүй гэж тэмдэглэв.[652] Засгийн газар өмнө нь Хуст Уулын ордын талаар БЛТ-д бичгээр хандсан тул Төмөртэй Хүдэр уг шаардлагыг мэдэж байсан нь эргэлзээгүй юм.

344. Эцэст нь "Төмөртэй Хүдэр төлбөрийг хугацаанд нь төлөөгүй нь Дагаж мөрдөх журмын тухай хуулийг зөрчсөн болохыг Монголын шүүхүүд удаа дараа баталгаажуулсан"[653] бөгөөд "мэдээгүй байсан нь Монголын хуулийг мөрдөөгүйг зөвтгөх шалтгаан биш" гэж Хариуцагч маргав.[654]

(c) Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ болон Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөг хэрэгжүүлээгүй тухай

Нэхэмжлэгчдийн байр суурь

345. Нэхэмжлэгчид "2005 онд Төмөртэй Хүдэр тухайн талбайд зориулан боловсруулсан байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээндээ нийцүүлэн төлөвлөсөн уурхайн үйл ажиллагааны байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг багасгах нарийвчилсан төлөвлөгөө, түүний дотор нэг бүрчлэн тусгасан хяналтын хөтөлбөр бүхий Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө хүргүүлсэн" гэж мэдүүлэв.[655] Нэхэмжлэгчдийн үзэж байгаагаар Засгийн газар Төмөртэй Хүдэрээс уг төлөвлөгөөг үүнээс хурдан боловсруулж дуусгахыг бодитойгоор шаардах боломжгүй байсан бөгөөд ямар ч тохиолдолд Засгийн газар "уг төлөвлөгөөг ямар нэг тайлбар, нөхцөлгүйгээр баталсан".[656]

346. Нэхэмжлэгчид мөн "Төмөртэй Хүдэр Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөгөө хоцорч хүргүүлсэн байсан ч энэ нь тусгай зөвшөөрлийг нь цуцлах хүчин төгөлдөр үндэслэл болохгүй" гэж мэдүүлэв.[657] 1997 оны Ашигт малтмалын тухай хууль байгаль орчны тухай заалтуудыг зөрчсөн тохиолдолд торгуулийн хэмжээг тогтоосон бөгөөд "байгаль орчныг хамгаалах стандартыг үргэлжлүүлэн зөрчсөн тохиолдолд тусгай зөвшөөрлийг 60 хоног түдгэлзүүлж, уурхайг хаахаас өмнө тусгай зөвшөөрөл эзэмшигчид зөрчлийг арилгах боломж олгоно" гэж заасан.[658] Нэхэмжлэгчдийн үзэж байгаагаар Төмөртэй Хүдэрт ийм мэдэгдэл хэзээ ч өгөөгүй.[659]

---

[652] Хариуцагчийн Давтан хариу тайлбар, догол мөр 400.

[653] Хариуцагчийн Давтан хариу тайлбар, догол мөр 398.

[654] Хариуцагчийн Давтан хариу тайлбар, догол мөр 401.

[655] Нэхэмжлэгчдийн Нэхэмжлэлийн үндэслэл, догол мөр 217.

[656] Нэхэмжлэгчдийн Нэхэмжлэлийн үндэслэл, догол мөр 219; мөн үзнэ үү: Сонсголын тэмдэглэл (өдөр 1, 2015 оны 9 дугаар сарын 14) 104:10–104:23.

[657] Нэхэмжлэгчдийн Нэхэмжлэлийн үндэслэл, догол мөр 220; мөн үзнэ үү: Сонсголын тэмдэглэл (өдөр 1, 2015 оны 9 дугаар сарын 14) 105:16–106:8.

[658] Нэхэмжлэгчдийн Нэхэмжлэлийн үндэслэл, догол мөр 221.

[659] Нэхэмжлэгчдийн Нэхэмжлэлийн үндэслэл, догол мөр 222.

347. Нэхэмжлэгчид мөн Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд ч, өөр хаана ч төмрийн хүдрийг Хятад руу экспортлохыг хориглосон заалт байхгүй гэж мэдүүлэв.[660]

Хариуцагчийн байр суурь

348. Хариуцагч "Нэхэмжлэгчид байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ болон байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөндөө заасан арга хэмжээг хэрэгжүүлээгүйгээрээ 1997 оны Ашигт малтмалын тухай хуулийн 30 дугаар зүйлийг зөрчсөн" гэж мэдүүлэв.[661] Цуцлалтын үндэслэл болсон Үйлдвэр, худалдааны яамны 2006 оны 8 дугаар сарын 30-ны өдрийн албан бичигт зааснаар зөрчил нь Нэхэмжлэгчдийн хэлж байгаачлан Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний хугацаатай холбоотой бус, харин Төмөртэй Хүдэр "Ашигт малтмалын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг хэрэгжүүлээгүй, улмаар зөрчсөн" явдал байсан.[662]

349. Хариуцагчийн үзэж байгаагаар "Төмөртэй Хүдэр 2003 оны Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээндээ Төмөртэйн ордоос олборлосон хүдрийг баяжуулах талаар нэлээд дэлгэрэнгүй тусгасан".[663] Төмөртэй Хүдэр мөн "аюултай бохирдуулагч бодис байгаль орчинд "зөвшөөрөгдөх агууламж"-аас хэтрэхгүй байхаар арга хэмжээ авах, байгаль орчныг сайжруулах нөхөн сэргээлтийн ажил хийх, бохирдлынхоо нөлөөг хянах баталгаа өгсөн".[664]

350. Гэтэл үнэн хэрэгтээ "Төмөртэй Хүдэр байгаль орчны нөхөн сэргээлтийн ямар ч арга хэмжээ аваагүй төдийгүй ... баяжуулах үйлдвэрийн ажлыг бодитой урагшлуулалгүйгээр баяжуулаагүй төмрийн хүдрийг Хятад руу экспортолж, 2003 оны үнэлгээний нөхцөлийг биелүүлээгүй" гэж Хариуцагч мэдүүлэв.[665] Үүний улмаас Хариуцагчийн үзэж байгаагаар "Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль ... тухайн тусгай зөвшөөрлийн шаардлагыг үргэлжлүүлэн болон/эсхүл ноцтой зөрчсөн тохиолдолд тусгай зөвшөөрлийг цуцлахыг шууд зөвшөөрдөг; эдгээр шаардлагад тусгай зөвшөөрөл авахын тулд хүргүүлсэн баримт бичгээр хүлээсэн үүрэг мөн багтана".[666]

(d) Шаардлагатай зөвшөөрөлгүйгээр тэсэлгээний үйл ажиллагаа явуулсан тухай

Нэхэмжлэгчдийн байр суурь

351. Нэхэмжлэгчдийн үзэж байгаагаар Төмөртэй Хүдэр тэсрэх бодис ашиглах шаардлагатай тусгай зөвшөөрөлтэй байсан. Нэхэмжлэгчдийн тайлбарласнаар:

---

[660] Сонсголын тэмдэглэл (өдөр 5, 2015 оны 9 дугаар сарын 18), 772:8–773:17.

[661] Хариуцагчийн Давтан хариу тайлбар, догол мөр 404.

[662] Хариуцагчийн Давтан хариу тайлбар, догол мөр 413 (онцлол эхэд бий).

[663] Хариуцагчийн Давтан хариу тайлбар, догол мөр 405.

[664] Хариуцагчийн Давтан хариу тайлбар, догол мөр 408.

[665] Хариуцагчийн Давтан хариу тайлбар, догол мөр 409; мөн үзнэ үү: Сонсголын тэмдэглэл (өдөр 5, 2015 оны 9 дугаар сарын 18) 868:6–872:10, эш татсан нь: Ноён Нэргүйгийн асуултад өгсөн мэдүүлэг (өдөр 2, 2015 оны 9 дугаар сарын 15) 390:18–390:25

[666] Хариуцагчийн Давтан хариу тайлбар, догол мөр 411.

(a) “2006 оны 1 дүгээр сарын 26-нд тэсэлгээний тусгай зөвшөөрөл олгох асуудлаар Монголын хамгийн дээд эрх бүхий албан тушаалтан болох Үйлдвэр, худалдааны сайд Төмөртэй Хүдэрт гурван жилийн хугацаанд тэсэлгээний үйл ажиллагаа явуулахыг зөвшөөрсөн тушаал гаргасан”.[667]

(b) “2006 оны 4 дүгээр сарын 6-нд, Төмөртэй Хүдэр анхны хүсэлтээ гаргаснаас дөрвөн сар орчмын дараа УМХГ эцэст нь Төмөртэй Хүдэрт 2006 оны 12 дугаар сарын 31 хүртэл тэсэлгээний ажил хийхийг зөвшөөрсөн бичиг (46 дугаар гэрчилгээ) олгосон”.[668]

352. Гэвч уг зөвшөөрөлд эргэлзээ үүсгэхэд “Төмөртэй Хүдэр тэсэлгээний ажил гүйцэтгэх эрхтэй БЛАСТ ХХК-тай Төмөртэйн ордод тийм ажил гүйцэтгүүлэх гэрээ байгуулсан”.[669] Үүний дараа “Улсын байцаагч 2006 оны 8 дугаар сарын 21-ний өдрийн хариу бичгээр Төмөртэй Хүдэр гэх зөрчлүүдийг арилгасныг баталж, улмаар Төмөртэй Хүдэрийн тэсэлгээний үйл ажиллагааг 2006 оны 8 дугаар сарын 5-нд түдгэлзүүлсэн улсын байцаагчийн актыг хүчингүй болгосон” гэж Нэхэмжлэгчид тэмдэглэв.[670]

353. Ямар ч тохиолдолд “Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 15.10(4) дүгээр зүйлийг зөрчсөнд ногдуулах зохистой шийтгэл нь цуцлалт бус, торгууль юм. Үүнтэй адил Тэсэрч дэлбэрэх бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуулийн 11 дүгээр зүйлийг зөрчсөнд ногдуулах зохистой шийтгэл нь тэсэлгээний эсхүл ашиглалтын тусгай зөвшөөрлийн аль нэгийг цуцлах бус, торгууль юм” гэж Нэхэмжлэгчид маргав.[671]

Хариуцагчийн байр суурь

354. Хариуцагч “Төмөртэй Хүдэр 2005 оноос эхлэн тэсрэх бодисыг тусгай зөвшөөрөлгүйгээр ашиглаж, тэр хугацаанд олборлосон төмрийн хүдрээ Хятад руу тээвэрлэж байсан” гэж мэдүүлэв.[672]

355. Хариуцагч Төмөртэй Хүдэр 2006 оны 4 дүгээр сард тэсэлгээний тусгай зөвшөөрөл авах хүртэл олборлолтын үйл ажиллагаа эхлүүлээгүй гэсэн үндэслэлийг няцаав. Харин Төмөртэй Хүдэрийн үйл ажиллагааны талаарх Сэлэнгэ аймгийн аудитын тайланд тулгуурлан “2006 оны 1–3 дугаар сард Төмөртэй Хүдэр 1,750,000 тонн төмрийн хүдэр экспортолсон” гэж маргав.[673] Хариуцагч мөн “үүнээс гадна Нэхэмжлэгчид 2005 онд их

---

[667] Нэхэмжлэгчдийн Нэхэмжлэлийн үндэслэл, догол мөр 225.

[668] Нэхэмжлэгчдийн Нэхэмжлэлийн үндэслэл, догол мөр 226; мөн үзнэ үү: Сонсголын тэмдэглэл (өдөр 1, 2015 оны 9 дугаар сарын 14) 106:11–106:20.

[669] Нэхэмжлэгчдийн Нэхэмжлэлийн үндэслэл, догол мөр 227.

[670] Нэхэмжлэгчдийн Нэхэмжлэлийн үндэслэл, догол мөр 228; мөн үзнэ үү: Сонсголын тэмдэглэл (өдөр 1, 2015 оны 9 дугаар сарын 14) 106:21–107:5.

[671] Нэхэмжлэгчдийн Нэхэмжлэлийн үндэслэл, догол мөр 229; мөн үзнэ үү: Сонсголын тэмдэглэл (өдөр 1, 2015 оны 9 дугаар сарын 14) 107:5–107:9.

[672] Хариуцагчийн Давтан хариу тайлбар, догол мөр 414.

[673] Хариуцагчийн Давтан хариу тайлбар, догол мөр 416.

хэмжээний төмрийн хүдрийг баримт бичиггүйгээр Хятад руу экспортолж байсан" гэж маргав.[674]

356. Түүнчлэн Хариуцагч дараах байдлаар мэдүүлэв —

> Төмөртэй Хүдэр Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 15.10.4 дүгээр хэсгийн дагуу "тэсэлгээний үйл ажиллагаа явуулах" тусгай зөвшөөрөл хэзээ ч аваагүй. Харин Төмөртэй Хүдэр 2006 оны 4 дүгээр сарын 6-ны өдрийн Тэсэлгээний ажил явуулах гэрчилгээ авсан бөгөөд энэ нь "Төмөртэйн төмрийн ордод" тэсрэх бодис ашиглахыг зөвшөөрсөн боловч Төмөртэй Хүдэрт өөрт нь тэсрэх бодис ашиглах эрх олгоогүй. ... Төмөртэй Хүдэрийн авсан гэрчилгээ нь зөвхөн тусгай зөвшөөрөлтэй этгээдэд тухайн талбайд тэсэлгээ хийхийг зөвшөөрсөн.[675]

357. Цаашлаад Төмөртэй Хүдэр Төмөртэйн талбайд хийсэн өрөмдлөг, тэсэлгээгээ баримтжуулаагүйгээрээ Тэсэрч дэлбэрэх бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуулийн 12.1 дүгээр зүйлийг зөрчсөн гэж Хариуцагч мэдэгдэв.[676] Мөн Монголын шүүхийн шийдвэрт тулгуурлан Төмөртэй Хүдэр ХХК "улсын байцаагчийн лацадсан тэсрэх бодис агуулсан агуулахын лацыг хоёр удаа эвдэж нэвтрэн, тэсрэх бодис ашигласнаар Тэсэрч дэлбэрэх бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуулийн 2.1.5, 12.1.2, 14.1, 14.2 болон 14.4 дүгээр зүйлийг зөрчсөн" гэж Хариуцагч мэдэгдэв.[677]

358. Тэсэрч дэлбэрэх бодисын тухай хуулийн 21 дүгээр зүйлд мөнгөн торгууль заасныг хүлээн зөвшөөрсөн боловч Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 14.1.4 дүгээр зүйл нь "тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагыг удаа дараа буюу ноцтой зөрчсөн бол" тусгай зөвшөөрлийг цуцлахыг мөн зөвшөөрдөг гэж Хариуцагч маргав.[678]

(е) Хүдрийг өртгөөс доогуур үнээр, зөвшөөрөлгүйгээр хууль бусаар экспортолсон тухай

Нэхэмжлэгчдийн байр суурь

359. Нэхэмжлэгчдийн үзэж байгаагаар "Монгол Улсын мэдэгдэл тодорхой бус бөгөөд уг гэх үйлдэл 1998 оны Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн чухам аль заалтыг зөрчсөн болохыг заагаагүй".[679] Нэхэмжлэгчид мөн энэ мэдэгдлийг үйл баримтын хувьд буруу гэж үзэж, дараах байдлаар мэдүүлэв:

---

[674] Хариуцагчийн Давтан хариу тайлбар, догол мөр 416 (онцлол эхэд бий).

[675] Хариуцагчийн Давтан хариу тайлбар, догол мөрүүд 421-422 (онцлол эхэд бий).

[676] Хариуцагчийн Давтан хариу тайлбар, догол мөр 431.

[677] Хариуцагчийн Давтан хариу тайлбар, догол мөр 428, эшилсэн нь: БЛТ болон Төмөртэй Хүдэрээс Геологи, уул уурхайн кадастрын газрын даргад холбогдуулсан хэрэг, 196 дугаар шийдвэр, 2006 оны 11 дүгээр сарын 29 (Баримт R-64).

[678] Хариуцагчийн Давтан хариу тайлбар, догол мөр 434, эшилсэн нь: Тусгай зөвшөөрлийн тухай хууль, зүйл 14.1.4 (Эрх зүйн эх сурвалж CLA-69).

[679] Нэхэмжлэгчдийн Нэхэмжлэлийн үндэслэл, догол мөр 231.

(a) “Дотоодын эрэлт бага тул Төмөртэй Хүдэр Төмөртэйд олборлох төмрийн хүдрийнхээ дийлэнхийг экспортлох зорилготойгоо ямагт нээлттэй, ил тод мэдэгдэж ирсэн”.[680]

(b) Ашигт малтмалын тухай хуулийн 16(3) дугаар зүйлийн дагуу хүдэр экспортлох нь хууль ёсны. Нэхэмжлэгчид төмрийн хүдэр экспортлох зорилгоо техник, эдийн засгийн үндэслэл болон ажлын төлөвлөгөөндөө хоёуланд нь тусгасан бөгөөд Монгол Улс эдгээрийг хоёуланг нь баталсан.[681]

(c) “Төмөртэй Хүдэрийн Хятад руу экспортолсон төмрийн хүдэр боловсруулаагүй байсан гэсэн Монгол Улсын мэдэгдэл буруу”.[682] Төмөртэйн төмрийн хүдрийг холбогдох бүх баримт бичигт төлөвлөсний дагуу цахилгаан соронзон ялгалтаар боловсруулсан бөгөөд энэ баримтыг Сэлэнгэ аймгийн 2007 оны аудитад тэмдэглэсэн.[683]

(d) Хариуцагчийн гаргасан баримт бичгүүдийн алинд ч тодорхой хугацаанд ангижруулсан төмрийн үйлдвэр барих амлалт байхгүй, эсхүл ийм үйлдвэрийг боломжит хувилбараас илүү зүйл болгон авч үзээгүй.[684]

360. Нэхэмжлэгчид ийм зөрчил үнэн байсан ч 939А тусгай зөвшөөрлийг цуцлах үндэслэл болохгүй гэж дахин мэдүүлэв. 1998 оны Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд зөвхөн торгууль заасан бөгөөд Нэхэмжлэгчдийн үзэж байгаагаар байж болох аливаа зөрчил нь Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн утгаар давтан буюу ноцтой зөрчил байгаагүй.[685]

Хариуцагчийн байр суурь

361. Хариуцагч “Төмөртэй Хүдэр хүдрийг Хятад руу ОУВС-гийн тогтоосон олон улсын зах зээлийн нэг метр тонн тутмын үнийн 40 хувиас доогуур үнээр борлуулсан зэрэг үйлдлээрээ 1997 оны Ашигт малтмалын тухай хуулийг зөрчсөн” гэж мэдүүлэв.[686]

362. Хариуцагчийн үзэж байгаагаар “1997 оны Ашигт малтмалын тухай хуулийн 38(1), 38(2) дугаар зүйлд “уурхайн эдэлбэрээс олборлосон ...” экспортын бүтээгдэхүүний борлуулалтын үнийг “тухайн бүтээгдэхүүн буюу түүнтэй ижил төстэй бүтээгдэхүүний олон улсын зах зээлд тогтмол нийтэлдэг үнэ, эсхүл [олон улсын худалдаанд хүлээн зөвшөөрөгдсөн зарчим]-д үндэслэсэн сарын дундаж үнээр” тооцно гэж заасан”.[687] Хариуцагч “ОУВС-гийн нэг метр тонн тутмын зах зээлийн үнэ 2006 оны 1 дүгээр сард

---

[680] Нэхэмжлэгчдийн Нэхэмжлэлийн үндэслэл, догол мөр 232.

[681] Сонсголын тэмдэглэл (өдөр 1, 2015 оны 9 дугаар сарын 14) 107:25–108:10.

[682] Нэхэмжлэгчдийн Нэхэмжлэлийн үндэслэл, догол мөр 233.

[683] Нэхэмжлэгчдийн Нэхэмжлэлийн үндэслэл, догол мөр 233.; Сэлэнгэ аймгийн 2007 оны тайлан, хуудас 5 (Баримт С-91); мөн үзнэ үү: Сонсголын тэмдэглэл (өдөр 1, 2015 оны 9 дугаар сарын 14) 108:11–109:14.

[684] Нэхэмжлэгчдийн Нэхэмжлэлийн үндэслэл, догол мөр 234.

[685] Нэхэмжлэгчдийн Нэхэмжлэлийн үндэслэл, догол мөрүүд 235-236; мөн үзнэ үү: Сонсголын тэмдэглэл (өдөр 1, 2015 оны 9 дугаар сарын 14) 109:15–109:19.

[686] Хариуцагчийн Давтан хариу тайлбар, догол мөр 437.

[687] Хариуцагчийн Давтан хариу тайлбар, догол мөр 439.

77.35 ам.доллар байхад Төмөртэй Хүдэрийн Хятадад борлуулсан нэг метр тонн тутмын үнэ ердөө 30.50 ам.доллар байсан" гэж санууллав.[688] Хариуцагч мөн "Төмөртэй Хүдэрийн 2003 оны Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээнд Төмөртэйн ордоос олборлосон хүдрийг баяжуулах талаар нэлээд дэлгэрэнгүй тусгасан" боловч бодит байдалд их хэмжээний боловсруулаагүй хүдэр экспортолсон гэж санууллав.[689]

363. БНХАУ руу экспортлох тухай Төмөртэй Хүдэрийн ажлын төлөвлөгөө, баримт бичгүүдэд дурдсан байж болох ч "хууль бус үйлдэл нь зүгээр л хүдрийг Хятад руу тээвэрлэсэн явдал бус, харин баримтжуулалгүйгээр, олон улсын зах зээлийн үнээс хавьгүй доогуур үнээр, зохих зөвшөөрөлгүйгээр тээвэрлэсэн явдал" гэж Хариуцагч онцлов.[690] Үүний үр дагаврын тухайд Хариуцагч "Монголын хуулийн дагуу тусгай зөвшөөрлийг цуцлахад Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийг баримталдгийг Арбитрын бүрэлдэхүүн хүлээн зөвшөөрөх ёстой" бөгөөд "Төмөртэй Хүдэр хүдрийг хямд үнээр Хятад руу тээвэрлэсэн нь тусгай зөвшөөрлийг нь цуцлах хүчин төгөлдөр үндэслэл байсан, улмаар олон улсын эрх зүйн дагуу ч хүчин төгөлдөр" гэж мэдүүлэв.[691]

(f) Цуцлах бусад үндэслэл

Нэхэмжлэгчдийн байр суурь

364. Нэхэмжлэгчид "цуцлалтаас зургаан жилийн дараа Давтан хариу тайлбарт нэмэлт үндэслэл дэвшүүлэх нь зөвшөөрөгдөхгүй" гэж мэдүүлэв. Ямар ч тохиолдолд тусгай зөвшөөрлийг цуцлах шинэ үндэслэл нэмж оруулахыг Монголын хуулиар зөвшөөрдөггүй гэж Нэхэмжлэгчид үзэв.[692]

365. Нэхэмжлэгчид мөн дараах байдлаар тодруулав:

Эхний үндэслэлийн тухайд, бодит байдалд БЛТ уул уурхайн туршлагынхаа талаар ямар нэг мэдүүлэг хийгээгүй. Харин хоёр дахь үндэслэлийн тухайд, (a) БЛТ-ийн тусгай зөвшөөрлийг Газрын хэвлийн тухай хууль бус, 1994 оны, дараа нь 1997 оны Ашигт малтмалын тухай хууль зохицуулж байсан; хоёрдугаарт, (b) С-93 баримтаас харсанчлан Засгийн газар өөрөө хэдэн жилийн өмнө ДТҮ-ийн ийм хүсэлтийг хүлээн авахаас татгалзсан.[693]

Хариуцагчийн байр суурь

366. Хариуцагч 939А тусгай зөвшөөрлийг цуцлах өөр хоёр хууль зүйн үндэслэл дурдав:

(a) БЛТ уул уурхайн туршлагаа худал мэдүүлж, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийг зөрчсөн;[694] мөн

---

[688] Хариуцагчийн Давтан хариу тайлбар, догол мөр 437.

[689] Хариуцагчийн Давтан хариу тайлбар, догол мөр 441.

[690] Хариуцагчийн Давтан хариу тайлбар, догол мөр 445.

[691] Хариуцагчийн Давтан хариу тайлбар, догол мөрүүд 446-447.

[692] Сонсголын тэмдэглэл (өдөр 1, 2015 оны 9 дугаар сарын 14) 110:2–110:11.

[693] Сонсголын тэмдэглэл (өдөр 1, 2015 оны 9 дугаар сарын 14) 110:11–110:19.

[694] Хариуцагчийн Давтан хариу тайлбар, догол мөрүүд 449-451.

(b) БЛТ газрын хэвлий ашиглах тусгай зөвшөөрлөө олгосноос хойш гурван жилийн дотор ашиглаагүй нь Газрын хэвлийн тухай хуулийн 21.2 дугаар зүйлийг зөрчсөн.[695]

367. Эхний үндэслэлийн тухайд БЛТ Хөдөө аж ахуй, үйлдвэрийн яаманд явуулсан захидалдаа "[уурхайн] бүтээн байгуулалтын төслийн мэргэжилтнүүдийн баг бүрдүүлж" эхэлснээ мэдэгдсэнийг Хариуцагч сануулав.[696] Гэтэл үнэн хэрэгтээ "БЛТ нь албан ажилтан [эхэд ийнхүү бичсэн] болон дэлгүүрийн худалдагчийн удирддаг мал аж ахуйн компани байсан. Уул уурхайн туршлагатай ажилтнууд нь зөвхөн Дарханаас түр томилогдсон ажилтнууд байв. Энэ туршлагагүй байдал үр дагаваргүй өнгөрөөгүй; үнэндээ БЛТ яагаад бүтээн байгуулалтаа эхлэх хүртэл бараг таван жил хүлээснийг тайлбарлаж байна" гэж Хариуцагч маргав.[697] Хариуцагчийн үзэж байгаагаар 2006 оны Ашигт малтмалын тухай хуулийн дагуу "залилангийн шинжтэй худал мэдүүлэг нь Монголын хууль зөрчсөн үйлдэл учраас 939А тусгай зөвшөөрлийг цуцлах зөвшөөрөгдөх үндэслэл мөн".[698]

368. Хоёр дахь үндэслэлийн тухайд "БЛТ олборлолтын үйл ажиллагаа эхлэх хүртлээ тав гаруй жил хүлээсэн нь Газрын хэвлийн тухай хуулийг зөрчсөн" гэж Хариуцагч онцлов.[699] Газрын хэвлийн тухай хуулийн 21.2 дугаар зүйл нь газрын хэвлий ашиглах тусгай зөвшөөрлийг олгосноос хойш гурван жилийн хугацаанд ашиглаагүй бол цуцлахыг зөвшөөрдөг гэсэн Монголын шүүхийн дүгнэлтийг Хариуцагч сануулав.[700] "Төмөртэйн ордыг хугацаанд нь хөгжүүлээгүй нь Монголын эдийн засагт хохирол учруулсан" тул 939А тусгай зөвшөөрлийг цуцлах үндэслэлтэй байсан гэж Хариуцагч үзэв.[701]

(g) Мэдэгдэл өгсөн тухай

Нэхэмжлэгчдийн байр суурь

369. Нэхэмжлэгчид Монгол Улс 2006 оны Ашигт малтмалын тухай хууль болон Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн дагуу Төмөртэй Хүдэрийн гэх зөрчлүүдийн талаар зохих мэдэгдэл өгөөгүй гэж мэдүүлэв. Харин "Геологи, уул уурхайн кадастрын газрын дарга Төмөртэй Хүдэрт урьдчилан мэдэгдэл өгөхгүйгээр 902 дугаар тогтоолоор 939А тусгай зөвшөөрлийг шууд цуцалж, улмаар цуцлах үндэслэлүүд үндэслэлгүй болохыг тогтоолгох, эсхүл гэх зөрчлүүдийг арилгах боломжийг нь хассан" гэж Нэхэмжлэгчид маргав.[702] Ажлын хэсгийн тайланг хүчин төгөлдөр мэдэгдэл гэж үзэж болох байсан ч түүнийг 2006 оны Ашигт малтмалын тухай хуулийн 56 дугаар зүйлд

---

[695] Хариуцагчийн Давтан хариу тайлбар, догол мөрүүд 452-456.

[696] Хариуцагчийн Давтан хариу тайлбар, догол мөр 449, эшилсэн нь: БЛТ-ээс Хөдөө аж ахуй, үйлдвэрийн яаманд хүргүүлсэн албан бичиг (Баримт С-183).

[697] Хариуцагчийн Давтан хариу тайлбар, догол мөр 450.

[698] Хариуцагчийн Давтан хариу тайлбар, догол мөр 450.

[699] Хариуцагчийн Давтан хариу тайлбар, догол мөр 452.

[700] Хариуцагчийн Давтан хариу тайлбар, догол мөр 455; БЛТ болон Төмөртэй Хүдэрээс Геологи, уул уурхайн кадастрын газрын даргад холбогдуулсан хэрэг (Баримт С-64).

[701] Хариуцагчийн Хариу үндэслэл, догол мөрүүд 128-130; Хариуцагчийн Давтан хариу тайлбар, догол мөр 456.

[702] Нэхэмжлэгчдийн Нэхэмжлэлийн үндэслэл, догол мөр 271.

шаардсанчлан тусгай зөвшөөрөл эзэмшигчид бус, Засгийн газарт хүргүүлсэн гэж Нэхэмжлэгчид мэдүүлэв.[703] Мөн ноён Нэргүйгийн баталснаар Ажлын хэсэг зөвхөн уурхайн үйл ажиллагаатай холбоотой үндэслэлийг авч үзсэн бөгөөд гэх залилан буюу улсын төсвийн хөрөнгийг нөхөн төлөөгүй асуудлыг шалгаагүй.[704] Нэхэмжлэгчид Ажлын хэсгийн тайлан болон 8 дугаар сарын 30-ны өдрийн албан бичиг хоёул 1997 оны Ашигт малтмалын тухай хуулийн 47 дугаар зүйлд тулгуурласныг мөн тэмдэглэв. Нэхэмжлэгчдийн үзэж байгаагаар уг хууль үйлчлэхээ больсон байсан боловч ямар ч тохиолдолд түүнд заасан журам 2006 оны Ашигт малтмалын тухай хуулийнхтай адил юм.[705]

370. Нэхэмжлэгчид цааш нь ноён Баярцогт, ноён Нацагдорж нарын үйлдэлд хийсэн эрүүгийн мөрдөн шалгах ажиллагаа “мэдэгдлийг хүчин төгөлдөр хүргэсэн явдал байж болохгүй, учир нь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа цуцлалттай холбоогүй байсан” гэж маргав.[706]

Хариуцагчийн байр суурь

371. Хариуцагч 939А тусгай зөвшөөрлийг цуцлах үндэслэлийн талаар Нэхэмжлэгчдэд хангалттайгаас ч илүү мэдэгдэл өгсөн гэж үзэв. Хариуцагчийн үзэж байгаагаар холбогдох мэдэгдлийг дараах хэлбэрээр өгсөн:

> (a) Сэлэнгэ аймгийн Мэргэжлийн хяналтын газраас Төмөртэй Худэрт хүргүүлсэн 2006 оны 4 дүгээр сарын 24-ний өдрийн албан бичиг. Уг бичгээр “Төмөртэй Худэрийн үйл ажиллагаанд хийсэн Ажлын хэсгийн шалгалтын үр дүнг мэдээлж”, “Төмөртэй Худэр Монголын хуулийн есөөс доошгүй зөрчил гаргасан, түүний дотор хожим 939А тусгай зөвшөөрлийг цуцлах үндэслэл болсон гурван зөрчлийг” тодорхойлсон. Уг бичиг Төмөртэй Худэрийн захирал ноён Баярцогтод хаяглагдсан гэж Хариуцагч мэдүүлэв;[707]
>
> (b) Монголын Улсын мэргэжлийн хяналтын газраас Төмөртэй Худэрт хүргүүлсэн 2006 оны 6 дугаар сарын 15-ны өдрийн албан бичиг. Уг бичигт “Монголын хуулийн бие даасан арван нэгэн зөрчлийг тодорхойлсон бөгөөд тэдгээрийн заримыг 939А тусгай зөвшөөрлийг цуцлах үндэслэл болгон дахин эш татсан”;[708]
>
> (c) Улсын мэргэжлийн хяналтын газраас Төмөртэй Худэрт хүргүүлсэн 2006 оны 8 дугаар сарын 5-ны өдрийн албан бичиг. Уг бичигт “[тус газрын] Төмөртэйн

---

[703] Сонсголын тэмдэглэл (өдөр 5, 2015 оны 9 дугаар сарын 18) 765:24–766:3.

[704] Сонсголын тэмдэглэл (өдөр 5, 2015 оны 9 дугаар сарын 18) 766:23–767:12, эш татсан нь: cross-ноён Нэргүйгийн асуултад өгсөн мэдүүлэг, Сонсголын тэмдэглэл (өдөр 2, 2015 оны 9 дугаар сарын 15) 382:8–382:11, 388:18–389:22.

[705] Сонсголын тэмдэглэл (өдөр 5, 2015 оны 9 дугаар сарын 18) 768:8–768:21, эш татсан нь: эсрэг талаас асуусан асуултад өгсөн мэдүүлэг, хатагтай Дарижав, Сонсголын тэмдэглэл (өдөр 3, 2015 оны 9 дугаар сарын 16) 576:1–576:8.

[706] Нэхэмжлэгчдийн Хариу тайлбар, догол мөр 198 n.314.

[707] Хариуцагчийн Давтан хариу тайлбар, догол мөр 364; Сэлэнгэ аймгийн Мэргэжлийн хяналтын газраас Төмөртэй Худэрт хүргүүлсэн албан бичиг (Баримт С-107); мөн үзнэ үү: Сонсголын тэмдэглэл (өдөр 5, 2015 оны 9 дугаар сарын 18) 872:20–873:2.

[708] Хариуцагчийн Давтан хариу тайлбар, догол мөр 368 (онцлол эхэд бий); УМХГ-аас Төмөртэй Худэрт хүргүүлсэн албан бичиг (англи орчуулгын хамт) (Баримт С-108).

төмрийн хүдрийн ордод хийсэн шалгалтаар Төмөртэй Хүдэр “тусгай зөвшөөрөл”-гүйгээр “тэсрэх бодис, тэслүүр болон тэсэлгээний хэрэгсэл” ашиглаж байсныг илрүүлсэн” гэж тэмдэглэсэн;[709] мөн

(d) Засгийн газрын Ажлын хэсгийн 2006 оны 8 дугаар сарын 14-ний өдрийн тайлан. Уг тайлангаар “Төмөртэй Хүдэр хэд хэдэн ноцтой зөрчил гаргасныг тогтоосон” бөгөөд “түүний дүгнэлтүүд Төмөртэй Хүдэрийн үйл ажиллагааг түдгэлзүүлэхэд хүргэсэн”.[710]

372. Эдгээрийг нэгтгэн үзэхэд “Монгол Улс Төмөртэй Хүдэрт Монголын хуулийг зөрчсөн үйлдлүүдийн цар хүрээ, ноцтой байдлын талаар нэг бус, хэд хэдэн удаа мэдээлж, шалгалтын дүгнэлтийг няцаахыг оролдох төдий тооны боломжийг мөн олгосноор Ашигт малтмалын тухай хуулийн 56(2) дугаар зүйлийн шаардлагыг хангасан” гэж Хариуцагч маргав.[711]

4. Үгүйсгэн маргах эрхийг хязгаарлах болон эстоппель

Нэхэмжлэгчдийн байр суурь

373. Нэхэмжлэгчид Хариуцагчийг “байхгүй, эсхүл арилгасан гэдгийг нь өөрөө удаа дараа баталсан гэх зөрчлүүдэд тулгуурлах” эрхгүй гэж эстоппелийн зарчмын дагуу мэдүүлэв.[712] Тухайлбал, “Монгол Улс тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл олгож, хуулиар шаардсан баримт бичгүүдийг баталсан нь Төмөртэй Хүдэр аливаа хууль, журам зөрчсөн, эсхүл 160 дугаар тогтоол ДТҮ-д [Дарханд] одоо Төмөртэй Хүдэрийн эсрэг хэрэгжүүлж болох албадан биелэгдэх эрх олгосон гэж одоо мэдэгдэх боломжийг нь хаадаг” гэж Нэхэмжлэгчид мэдэгдэв.[713]

374. Нэхэмжлэгчид “улс өөрийн мэдэгдэл буюу үйлдэлд шударгаар итгэж тулгуурласан талыг хохироон, өөрийн зөрчилтэй мэдэгдэл буюу үйлдлээс ашиг хүртэж болохгүй ... улс өмнө нь хийсэн үйл баримтын тухай мэдэгдлийнхээ үнэн зөвийг үгүйсгэх эрхгүй болж болно” гэсэн “олон улсын заншлын эрх зүйн тогтсон зарчимд”[714] тулгуурлав.[715] Нэхэмжлэгчид үгүйсгэн маргах эрхийг хязгаарлуулах хүчин төгөлдөр шаардлагын талаар профессор Д. У. Боуэттийн энэ сэдвээр бичсэн алдартай өгүүлэлд заасан дараах нөхцөлийг дэмжив:

(a) “мэдэгдлийн утга нь тодорхой, хоёрдмол утгагүй байх ёстой”;

(b) “мэдэгдэл буюу илэрхийлэл нь сайн дурын, болзолгүй, эрх бүхий байх ёстой”; мөн

---

[709] Хариуцагчийн Давтан хариу тайлбар, догол мөр 369; УМХГ-аас Төмөртэй Хүдэрт хүргүүлсэн албан бичиг (англи орчуулгын хамт) (Баримт С-116).

[710] Хариуцагчийн Давтан хариу тайлбар, догол мөр 370.

[711] Хариуцагчийн Давтан хариу тайлбар, догол мөр 372.

[712] Нэхэмжлэгчдийн Нэхэмжлэлийн үндэслэл, догол мөр 263.

[713] Нэхэмжлэгчдийн Нэхэмжлэлийн үндэслэл, догол мөр 36, мөн үзнэ үү: Сонсголын тэмдэглэл (өдөр 1, 2015 оны 9 дугаар сарын 14) 100:16–101:22; Сонсголын тэмдэглэл (өдөр 5, 2015 оны 9 дугаар сарын 18), 777:3–782:23,

[714] Нэхэмжлэгчдийн Нэхэмжлэлийн үндэслэл, догол мөр 101.

[715] Нэхэмжлэгчдийн Нэхэмжлэлийн үндэслэл, догол мөр 101.

(c) “нэг талын мэдэгдэлд нөгөө тал шударгаар итгэж тулгуурласны улмаас өөрт нь хохирол учирсан (эсхүл мэдэгдэл хийсэн талд давуу байдал үүссэн) байх”.[716]

375. Нэхэмжлэгчид байр сууриа дэмжихдээ Shufeldt хэрэгт үгүйсгэн маргах эрхийг хязгаарлах асуудлыг хэрхэн авч үзсэнд мөн тулгуурлав. Уг хэрэгт арбитрч ийм хязгаарлалтыг “олон улсын эрх зүйн зарчмуудад нийцнэ” гэж үзэн,[717] дараах байдлаар шийдвэрлэсэн:

> Гватемалын Засгийн газар гэрээний хүчин төгөлдөр байдлыг зургаан жилийн турш хүлээн зөвшөөрч, гэрээний дагуу хүртэх эрхтэй бүх үр өгөөжөө хүртэж, Шуфельдтэд концесст мөнгө зарцуулсаар байх боломж олгосон тул хууль тогтоох байгууллагын зөвшөөрөл аваагүй байсан ч уг гэрээний хүчин төгөлдөр байдлыг үгүйсгэх эрхгүй.[718]

376. Энэ үндэслэлээр Нэхэмжлэгчид Хариуцагч 939A тусгай зөвшөөрлийг БЛТ-д хууль бусаар олгосон гэх үндэслэлээр цуцлахыг оролдсон нь “олон улсын заншлын эрх зүйн хувьд үр дүнгүй” гэж маргав.[719] Нэхэмжлэгчид цааш нь дараах байдлаар мэдэгдэв:

> Аль ч талаас нь үзсэн, Монгол Улс Нөхөн төлөх гэрээг байгуулснаар Төмөртэй Хүдэр 1997 оны Дагаж мөрдөх журмын тухай хуульд заасан нөхөн төлөх үүргээ зөрчсөн гэсэн аливаа үндэслэлээсээ татгалзсан. Түүнчлэн төрийн аливаа байгууллагын үйлдлийг тухайн улсын өөрийн үйлдэл гэж үздэг олон улсын эрх зүйн дагуу Монгол Улс эсрэгээр нь маргах эрхгүй. АМГТХЭГ-ын Төмөртэй Хүдэртэй байгуулсан нөхөн төлөх гэрээ нь Геологи, уул уурхайн кадастрын газрын дарга зэрэг төрийн байгууллагыг оролцуулан Монгол Улсыг үүрэгжүүлсэн. Иймд Нөхөн төлөх гэрээ байгаа хэдий ч Геологи, уул уурхайн кадастрын газрын дарга зэрэг өөр төрийн байгууллага төлбөр төлөөгүй гэх үндэслэлээр 939A тусгай зөвшөөрлийг цуцалж болно гэж Монгол Улс маргаж байгаа хэмжээнд олон улсын эрх зүйн дагуу ийнхүү маргах эрхгүй.[720]

377. Хариуцагчийн гаргасан татгалзалд хариу болгон Нэхэмжлэгчид “Хэлэлцээрт шууд заалт байхгүй бол Нэхэмжлэгчид Монгол Улсын эсрэг эстоппель хэрэглүүлэхээр шаардаж болохгүй гэсэн Монгол Улсын тайлбар ... илт буруу” гэж маргав.[721] Нэхэмжлэгчдийн үзэж байгаагаар “эстоппелийг хөрөнгө оруулалтын эрх зүйн хүрээнд хэрэглэх эрх зүйн нийтлэг зарчим гэж хүлээн зөвшөөрсөн” бөгөөд Хэлэлцээрт тусгайлан заах шаардлагагүй.[722]

---

[716] Нэхэмжлэгчдийн Нэхэмжлэлийн үндэслэл, догол мөр 102, эшилсэн нь: Д. У. Боуэтт, «Олон улсын шүүх, арбитр дахь эстоппель ба түүний дуугүй хүлээн зөвшөөрөхтэй холбогдох нь» (1957), Британийн олон улсын эрх зүйн жилийн эмхэтгэл, 33 дугаар боть, 176 хуудсууд 176-193 (Эрх зүйн эх сурвалж CLA-63).

[717] Нэхэмжлэгчдийн Нэхэмжлэлийн үндэслэл, догол мөр 103, эшилсэн нь: Shufeldt Claim (USA v. Guatemala), Арбитрчийн шийдвэр, 1930 оны 7 дугаар сарын 24, 2 RIAA 1083 хуудас 1904 (Эрх зүйн эх сурвалж CLA-64).

[718] Shufeldt Claim (USA v. Guatemala), Арбитрчийн шийдвэр, 1930 оны 7 дугаар сарын 24, 2 RIAA 1083 хуудас 1904 (Эрх зүйн эх сурвалж CLA-64).

[719] Нэхэмжлэгчдийн Нэхэмжлэлийн үндэслэл, догол мөр 179; мөн үзнэ үү: Нэхэмжлэгчдийн Нэхэмжлэлийн үндэслэл, догол мөр 190.

[720] Нэхэмжлэгчдийн Нэхэмжлэлийн үндэслэл, догол мөр 214.

[721] Нэхэмжлэгчдийн Хариу тайлбар, догол мөр 206.

[722] Нэхэмжлэгчдийн Хариу тайлбар, догол мөр 206.

Түүнчлэн “Монгол Улс өөрийн үйлдлүүд сайн дурын байгаагүй, өөрөөр хэлбэл хангалттай тодорхой бөгөөд эрх бүхий шинжтэй байгаагүй гэсэн үндэслэлдээ нотолгоо байтугай ямар ч тайлбар өгөөгүй”.[723] Эцэст нь Нэхэмжлэгчид Desert Line v. Yemen хэргийн шийдвэрийг эш татан[724] дараах байдлаар дүгнэв —

> Хариуцагч Нэхэмжлэгчдийг чухам Төмөртэйн ордод хөрөнгө оруулахыг урьсан атлаа үйл явдлаас 15 жилийн дараа ДТҮ өмнө нь эрхтэй байсан учраас 939A тусгай зөвшөөрлийг хууль ёсоор цуцалсан гэж маргах эрхгүй. [...] Нэхэмжлэгчид Хариуцагчийн баталгаа болон хөрөнгө оруулалтыг нь хүлээн зөвшөөрсөн үйлдэлд тулгуурлаад хохирсон бөгөөд Нэхэмжлэгчдийг тус улсад хөрөнгө оруулахыг урихаас нэлээд өмнө БЛТ-ийн хийсэн гэх худал мэдүүлэгт үндэслэн, мөн Монголын Засгийн газар Нэхэмжлэгчдийн хөрөнгө оруулалтыг баталсан байхад 939A тусгай зөвшөөрлийг хууль ёсоор цуцалсан гэж Хариуцагч мэдэгдэх нь утгагүй юм.[725]

Хариуцагчийн байр суурь

378. Хариуцагчийн үзэж байгаагаар “Нэхэмжлэгчид энэ хэрэгт үгүйсгэн маргах эрхийг хязгаарлах буюу эстоппелийн ямар ч хэлбэрээс ашиг хүртэх боломжгүй”.[726]

379. Юуны өмнө “зөвшөөрөл илэрхийлсэн баримт бичигт шууд зөвшөөрсөн заалт байхгүй бол хөрөнгө оруулагч төрийн эсрэг эстоппель хэрэглүүлэхээр шаардаж болохгүй” гэж Хариуцагч мэдүүлэв.[727] Хариуцагчийн үзэж байгаагаар “хөрөнгө оруулагч төртэй эрх тэгш этгээдийн хувиар харилцдаггүй” бөгөөд “иймээс нэг улсын нөгөө улстай харилцах үйлдэл болон хүлээн авагч улсын зохицуулалтын хүрээн дэх хувийн этгээдтэй харилцах үйлдлийн шинж чанар үндсээрээ ялгаатай”.[728] Хариуцагч зохицуулалтын хүрээнд эстоппель хэрэглэхийг үгүйсгэсэн АНУ-ын Дээд шүүхийн практикт тулгуурлаж,[729] хөрөнгө оруулалтын хүрээнд зөрчилтэй мэдэгдэл хариуцлага үүсгэхийн тулд эстоппель нь шударга, тэгш хандах үүргийг зөрчсөн тухай нэхэмжлэл шаардана гэж мэдүүлэв.[730]

380. Түүнчлэн Нэхэмжлэгчид эрх зүйн хувьд эстоппель буюу үгүйсгэн маргах эрхийг хязгаарлуулахыг шаардаж болох байсан ч “материаллаг ач холбогдолтой аливаа албадлага буюу залилан нь эстоппелийн шаардлагыг хүчингүй болгоно” гэж Хариуцагч маргав.[731]

---

[723] Нэхэмжлэгчдийн Хариу тайлбар, догол мөр 207.

[724] Desert Line Projects LLC v. Yemen, ICSID хэрэг № ARB/05/17, Арбитрын шийдвэр, 2008 оны 2 дугаар сарын 6, догол мөр 119 (Эрх зүйн эх сурвалж RLA-6).

[725] Нэхэмжлэгчдийн Хариу тайлбар, догол мөрүүд 209-210.

[726] Хариуцагчийн Хариу үндэслэл, догол мөр 283.

[727] Хариуцагчийн Хариу үндэслэл, догол мөр 284.

[728] Хариуцагчийн Хариу үндэслэл, догол мөр 284; мөн үзнэ үү: Сонсголын тэмдэглэл (өдөр 1, 2015 оны 9 дугаар сарын 14) 223:7–223:18.

[729] Хариуцагчийн Хариу үндэслэл, догол мөр 285; Federal Crop Ins. Corp. v. Merrill, 332 U.S. 380 (1947) (Эрх зүйн эх сурвалж RLA-87); Schwenker v. Hansen, 450 U.S. 785 (1981) (Эрх зүйн эх сурвалж RLA-89).

[730] Хариуцагчийн Хариу үндэслэл, догол мөр 286.

[731] Хариуцагчийн Хариу үндэслэл, догол мөр 288, эшилсэн нь: Д. У. Боуэтт, «Олон улсын шүүх, арбитр дахь эстоппель ба түүний дуугүй хүлээн зөвшөөрөхтэй холбогдох нь» (1957), Британийн

Төмөртэйн ордын эрхийг завшсан тул “Монголын Засгийн газрын аливаа мэдэгдэлд Нэхэмжлэгчид “шударгаар итгэж тулгуурласан” байх боломжгүй” учраас үгүйсгэн маргах эрхийг хязгаарлах боломжгүй гэж Хариуцагч үзэв.[732] Өөрөөр хэлбэл, “Нэхэмжлэгчид ... өөрсдийн залилангийн, гэмт хэргийн үйлдлийн улмаас дутуу мэдээлэлд үндэслэсэн гэдгийг нь мэдэж байсан мэдэгдэлд шударгаар итгэж тулгуурлаж болохгүй”.[733] World Duty Free v. Kenya хэрэгт[734] тулгуурлан Хариуцагч “төр авлигын талаар мэдсэн бол түүнийг дэвшүүлэх эрхийг эстоппелиэр зүгээр л хязгаарлаж болохгүй” гэж дүгнэв.[735]

D. ХАРИУЦАГЧИЙН СӨРӨГ НЭХЭМЖЛЭЛҮҮД

1. Хариуцагчийн сөрөг нэхэмжлэлүүдийг шийдвэрлэх харьяалал

Нэхэмжлэгчдийн байр суурь

381. Нэхэмжлэгчид Монгол Улсын сөрөг нэхэмжлэлүүдийг шийдвэрлэх Арбитрын бүрэлдэхүүний харьяаллыг эсэргүүцэв.[736] Нэхэмжлэгчдийн үзэж байгаагаар “сөрөг нэхэмжлэл нь үндсэн нэхэмжлэлийн адил талуудын арбитраар шийдвэрлүүлэхээр зөвшөөрсөн хүрээнд багтах ёстой” бөгөөд Хариуцагчийн сөрөг нэхэмжлэлүүд Хэлэлцээрийн 8(3) дугаар зүйлийн хүрээнд багтахгүй.[737]

382. Юуны өмнө Хариуцагчийн сөрөг нэхэмжлэлүүд Монголын хуулиас үүдэлтэй тул Хэлэлцээрийн хүрээнд багтахгүй гэж Нэхэмжлэгчид үзэв. Paushok v. Mongolia хэрэгт тулгуурлан Нэхэмжлэгчид Хариуцагчийн сөрөг нэхэмжлэлүүдийн талаар дараах байдлаар дүгнэв:

> Монголын ... хуулиас үүдэлтэй бөгөөд зөвхөн Монголын ... хуулийг мөрдөөгүй асуудлыг хөнддөг ...
>
> > Эдгээр бүх асуудал Монголын шүүхийн онцгой харьяаллын хүрээнд шууд багтдаг, Монголын ... хуулиар зохицуулагдах асуудлууд бөгөөд хоёр талт хөрөнгө оруулалтын гэрээ болон олон улсын эрх зүйд үндэслэсэн Нэхэмжлэгчдийн нэхэмжлэлийн салшгүй хэсэг, эсхүл зөвхөн хоёр талт хөрөнгө оруулалтын гэрээний дагуу харьяалалтай арбитрын бүрэлдэхүүн Нэхэмжлэгчдийн нэхэмжлэл болон

олон улсын эрх зүйн жилийн эмхэтгэл, 33 дугаар боть, 176 хуудас 190 (Эрх зүйн эх сурвалж CLA-63).

[732] Хариуцагчийн Хариу үндэслэл, догол мөр 291.

[733] Хариуцагчийн Хариу үндэслэл, догол мөр 291; мөн үзнэ үү: Сонсголын тэмдэглэл (өдөр 1, 2015 оны 9 дугаар сарын 14) 221:17–223:6, 223:19–224:4.

[734] World Duty Free Company Ltd v. Kenya, ICSID хэрэг № ARB/00/7; IIC 277 (2006), Арбитрын шийдвэр, 2006 оны 9 дугаар сарын 25 (Эрх зүйн эх сурвалж RLA-94), догол мөр 184.

[735] Хариуцагчийн Хариу үндэслэл, догол мөр 292.

[736] Нэхэмжлэгчдийн Хариу тайлбар, догол мөр 212; Сонсголын тэмдэглэл (өдөр 1, 2015 оны 9 дугаар сарын 14) 114:5–114:6

[737] Нэхэмжлэгчдийн Хариу тайлбар, догол мөр 212.

Сөрөг нэхэмжлэлүүдийг хамтад нь авч үзэхийг зөвтгөх үндэслэлтэй холбоо үүсгэж байна гэж үзэж болохгүй.[738]

383. Хоёрдугаарт, Хариуцагч “Saluka хэргийн арбитрын бүрэлдэхүүний тогтоосон харьяаллын босго шаардлагыг хангаагүй: сөрөг нэхэмжлэлүүд нь энэ маргааны үндсэн нэхэмжлэл, тухайлбал Нэхэмжлэгчдийн Хэлэлцээрт үндэслэсэн хөрөнгө хураалтын нэхэмжлэлтэй “нягт холбоотой” болохыг нотлоогүй” гэж Нэхэмжлэгчид мэдэгдэв.[739]

384. Гуравдугаарт, Spyridon Roussalis v. Romania,[740] Amco v. Indonesia[741] болон Saluka v. The Czech Republic[742] хэргүүдэд тулгуурлан Нэхэмжлэгчид Хэлэлцээр нь “сөрөг нэхэмжлэлийн зүйл болж болох ямар нэг материаллаг үүргийг хөрөнгө оруулагчдад ногдуулдаггүй” тул Хариуцагчийн сөрөг нэхэмжлэлүүдэд “хууль зүйн үндэслэл” байхгүй гэж маргав.[743] Нэхэмжлэгчид сөрөг нэхэмжлэлүүдийг материаллаг эрх зүйн үндэслэл бус, “үйл баримтын талаарх тодорхой бус мэдэгдлүүд” гэж дүгнэв.[744]

385. Эцэст нь ямар ч тохиолдолд “Монгол Улсын өөрийн харьяаллын талаарх үндэслэлүүдийг хүлээн авбал” сөрөг нэхэмжлэлүүд “хангагдах боломжгүй” гэж Нэхэмжлэгчид мэдүүлэв.[745]

Хариуцагчийн байр суурь

386. Хариуцагч Арбитрын бүрэлдэхүүний харьяаллыг ерөнхийд нь эсэргүүцэж байгаа боловч Арбитрын бүрэлдэхүүн өөрийгөө харьяалалтай гэж үзвэл Монгол Улсын сөрөг нэхэмжлэлүүдийг хянан шийдвэрлэх харьяалалтай мөн болно гэж маргав.[746]

387. Хариуцагч сөрөг нэхэмжлэлүүдийг нь хянан шийдвэрлэх Арбитрын бүрэлдэхүүний харьяаллыг Хэлэлцээрийн 8(3) дугаар зүйлийн дагуух харьяаллын дагалдах үр дагавар гэж үзэв. Сөрөг нэхэмжлэлийн харьяаллын талаар Нэхэмжлэгчдийн дэвшүүлсэн эрх зүйн шалгуурыг хүлээн авч, Хариуцагч “хууль ёсны сөрөг нэхэмжлэл нь хариу болгож гаргаж

---

[738] Нэхэмжлэгчдийн Хариу тайлбар, догол мөр 212, эшилсэн нь: Sergei Paushok, CJSC Golden East Company and CJSC Vostokneftegaz Company v. The Government of Mongolia, UNCITRAL, Харьяалал болон хариуцлагын тухай шийдвэр, 2011 оны 4 дугаар сарын 28, догол мөр 694 (Эрх зүйн эх сурвалж CLA-140).

[739] Нэхэмжлэгчдийн Хариу тайлбар, догол мөр 213; Сонсголын тэмдэглэл (өдөр 1, 2015 оны 9 дугаар сар) 114: 7 to 114:13

[740] Spyridon Roussalis v. Romania, ICSID хэрэг № ARB/06/1, Арбитрын шийдвэр, 2011 оны 12 дугаар сарын 7, догол мөр 871 (Эрх зүйн эх сурвалж CLA-139).

[741] Amco Asia Corporation болон бусад v. Republic of Indonesia, ICSID хэрэг № ARB/81/1, Харьяаллын тухай шийдвэр, 1988 оны 5 дугаар сарын 10, 89 I.L.R. 552.

[742] Saluka Investments B.V. v. The Czech Republic, UNCITRAL, Чех Улсын сөрөг нэхэмжлэлийг шийдвэрлэх харьяаллын тухай шийдвэр, 2004 оны 5 дугаар сарын 7, догол мөр 61 (Эрх зүйн эх сурвалж CLA-138).

[743] Нэхэмжлэгчдийн Хариу тайлбар, догол мөр 214; мөн үзнэ үү: Сонсголын тэмдэглэл (өдөр 1, 2015 оны 9 дугаар сарын 14) 114:14–114:16

[744] Нэхэмжлэгчдийн Хариу тайлбар, догол мөр 215.

[745] Сонсголын тэмдэглэл (өдөр 1, 2015 оны 9 дугаар сарын 14) 114:3–114:6

[746] Хариуцагчийн Давтан хариу тайлбар, догол мөр 460

буй үндсэн нэхэмжлэлтэйгээ нягт холбоотой байх ёстой" гэж маргав.[747] Хариуцагч өөрийн сөрөг нэхэмжлэлүүдийг Нэхэмжлэгчдийн хөрөнгө хураалтын нэхэмжлэлтэй "шууд холбоотой" гэж үзэв.[748] Учир нь "тэдгээр нь БЛТ 939А тусгай зөвшөөрлийг хууль бусаар олж авсан явдалд үндэслэсэн бөгөөд энэ нь тусгай зөвшөөрлийг цуцлах илэрхий үндэслэл байсан".[749]

388. Нэхэмжлэгчдийн татгалзлыг няцааж, Хариуцагч Saluka v. The Czech Republic хэргийн үйл баримт энэ хэргээс ялгаатай гэж тайлбарлав. Хариуцагч "энэ маргааны сөрөг нэхэмжлэлүүд нь бусад зүйлсийн хамт 939А тусгай зөвшөөрлийг цуцлахад хүргэсэн зүй бус үйлдэлд шууд хариу болгон гаргасан" гэж тэмдэглэв.[750] Өөрөөр хэлбэл, нэхэмжлэл болон сөрөг нэхэмжлэлүүд ижил үйл баримтаас үүдэлтэй. Харин Saluka хэргийн арбитрын бүрэлдэхүүн сөрөг нэхэмжлэлүүдийг "өөрийн заавал мөрдөх арбитрын заалт бүхий тусдаа гэрээнээс үүдэлтэй байсан тул" харьяалан шийдвэрлэхээс татгалзсан гэж Хариуцагч тэмдэглэв.[751] Энэ хүрээнд Монголын хуулийг хэрэглэхийг дэмжихээр Хариуцагч Хэлэлцээрийн 8(7), 4(2) дугаар зүйлд улсын хууль тогтоомжид буцаан заасан байдлыг мөн онцлов.[752]

389. Хариуцагч цааш нь Spyridon Roussalis хэрэгт профессор Рейсманы гаргасан тусгай саналд тулгуурлан, сөрөг нэхэмжлэлүүдийг харьяалан шийдвэрлэхээс татгалзах нь "утгагүй биш гэхэд егөөдөлтэй үр дүн" үүсгэнэ гэж үзэв. Учир нь Монгол Улсыг "нэхэмжлэлээ өөрийн шүүхэд гаргахыг шаардаж, төрийн тогтолцооноос гадуур маргаанаа шийдвэрлүүлэх газар эрэлхийлсэн яг тэр хөрөнгө оруулагчийг одоо тэнд хариуцагч болохоос аргагүй болгоно".[753] Хариуцагч мөн Saluka хэргийн арбитрын бүрэлдэхүүнийг оролцуулан арбитрын бүрэлдэхүүнүүд хөрөнгө оруулалтын гэрээнүүд сөрөг нэхэмжлэлийн харьяалал олгодгийг хүлээн зөвшөөрсөн гэж онцлов.[754]

---

[747] Хариуцагчийн Давтан хариу тайлбар, догол мөр 464, эшилсэн нь: Sergei Paushok, CJSC Golden East Company and CJSC Vostokneftegaz Company v. The Government of Mongolia (UNCITRAL) Харьяалал болон хариуцлагын тухай шийдвэр, 2011 оны 4 дугаар сарын 28 (Эрх зүйн эх сурвалж CLA-140); мөн үзнэ үү: Saluka Investments BV v. The Czech Republic (UNCITRAL) Чех Улсын сөрөг нэхэмжлэлийг шийдвэрлэх харьяаллын тухай шийдвэр, 2004 оны 5 дугаар сарын 7, догол мөр 75 (Эрх зүйн эх сурвалж CLA-138).

[748] Хариуцагчийн Давтан хариу тайлбар, догол мөр 461; Сонсголын тэмдэглэл (өдөр 1, 2015 оны 9 дугаар сарын 14), 229:4–229:14

[749] Хариуцагчийн Давтан хариу тайлбар, догол мөр 462.

[750] Хариуцагчийн Давтан хариу тайлбар, догол мөр 465.

[751] Хариуцагчийн Давтан хариу тайлбар, догол мөр 465.

[752] Хариуцагчийн Давтан хариу тайлбар, догол мөр 457.

[753] Хариуцагчийн Давтан хариу тайлбар, догол мөр 469, эшилсэн нь: Spyridon Roussalis v. Romania, У. Майкл Рейсманы мэдэгдэл, ICSID хэрэг № ARB/06/1, 2011 оны 11 дугаар сарын 28 (Эрх зүйн эх сурвалж RLA-184).

[754] Хариуцагчийн Давтан хариу тайлбар, догол мөр 468.

2. Хариуцагчийн сөрөг нэхэмжлэлүүдийн үндэслэл

Хариуцагчийн байр суурь

390. Хариуцагч сөрөг нэхэмжлэлүүдээ дараах байдлаар нэгтгэн тайлбарлав:

> (a) "БЛТ-ийн залилангийн үйлдлийн үр дүнд Дарханд харьяалагдаж байсан ашиглалтын эрхийг олж авсан бөгөөд ингэснээр Монгол Улсад нэн шаардлагатай байсан боловсруулах үйлдвэрийн бүтээн байгуулалтыг саатуулсан";[755]
>
> (b) "БЛТ ашиглалтын эрхтэй болсныхоо дараа олборлолтын үйл ажиллагаа явуулах хүртлээ тав гаруй жил хүлээж, Монгол Улсыг нэн шаардлагатай ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрөөс нь салгасан бөгөөд ингэхдээ Монголын Газрын хэвлийн тухай хуулийг зөрчсөн";[756]
>
> (c) "БЛТ болон Төмөртэй Хүдэр боловсруулах үйлдвэр байгуулах амласан хуваариа мөн мөрдөөгүй тул Монгол Улс одоо ч боловсруулсан хүдэр авахын тулд олон улсын тохиролцоонд орох шаардлагатай болж байна";[757]
>
> (d) "Төмөртэй Хүдэр боловсруулаагүй хүдрийг Монголын хуулиар шаардсан олон улсын зах зээлийн үнээр борлуулаагүйн улмаас Монгол Улс олон сая ам.долларын хохирол амссан".[758]

391. Хариуцагч "Нэхэмжлэгчдийн залилангийн шинжтэй худал мэдүүлгүүд уурхайн бүтээн байгуулалт болон амласан ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр, бусад татварын орлого алдагдах хэлбэрээр Монгол Улсад хохирол учруулсан" гэж маргав.[759] Хариуцагч хохирлоо "100 сая ам.доллараас давсан" гэж тооцож,[760] төмрийн үнэ өссөнийг харгалзан уг хохирол "үлэмж их" гэж үзэв.[761]

392. Нэхэмжлэгчид ордыг ашиглахдаа өндөр агуулгатай хэсгийг сонгон олборлох арга хэрэглэснээр ордын үнэ цэнийг бууруулж, улмаар Монгол Улсад хохирол учруулсан гэж Хариуцагч мэдүүлэв.[762]

Нэхэмжлэгчдийн байр суурь

393. Нэхэмжлэгчид Хариуцагчийн сөрөг нэхэмжлэлүүд "үйл баримтын үндэслэл нь үнэн зөв ч биш, нотлогдсон ч биш тул агуулгын хувьд хэрэгсэхгүй болох ёстой" гэж маргав.[763] Нэхэмжлэгчид дараах байдлаар дэлгэрүүлэв:

---

[755] Хариуцагчийн Давтан хариу тайлбар, догол мөр 470; мөн үзнэ үү: Сонсголын тэмдэглэл (өдөр 1, 2015 оны 9 дугаар сарын 14) 229:15–229:23.

[756] Хариуцагчийн Давтан хариу тайлбар, догол мөр 470.

[757] Хариуцагчийн Давтан хариу тайлбар, догол мөр 470; мөн үзнэ үү: Сонсголын тэмдэглэл (өдөр 1, 2015 оны 9 дугаар сарын 14) 229:17–229:19.

[758] Хариуцагчийн Давтан хариу тайлбар, догол мөр 470; мөн үзнэ үү: Сонсголын тэмдэглэл (өдөр 1, 2015 оны 9 дугаар сарын 14) 229:11–229:16.

[759] Хариуцагчийн Хариу үндэслэл, догол мөр 293.

[760] Хариуцагчийн Хариу үндэслэл, догол мөр 293.

[761] Хариуцагчийн Хариу үндэслэл, догол мөр 293.

[762] Сонсголын тэмдэглэл (өдөр 1, 2015 оны 9 дугаар сарын 14) 230:7–230:10.

> Монгол Улсын сөрөг нэхэмжлэлүүд нь Нэхэмжлэгчдийн “хөрөнгө завшсан болон залилангийн” үйлдлийн улмаас учирсан гэх хохирол, мөн “Нэхэмжлэгчид тусгай зөвшөөрлийг залилангаар олж авснаар Монгол Улсад учруулсан бодит хохирол”-д тулгуурлаж байгаа бололтой. Хөрөнгө завшсан гэх мэдэгдлийн тухайд Монгол Улсын өөрийн байгууллага хөрөнгө завшсан хэргийг хэрэгсэхгүй болгосон тул түүнд учирсан “эдийн засгийн ноцтой хохирол” нь зөвхөн төсөөллийн зүйл байж таарна. Хохирол учирсныг анхан шатанд үнэмшилтэй харуулах баримт ч байхгүй. Т-30 тусгай зөвшөөрөл хүсэхдээ залилан үйлдсэн гэх асуудлын тухайд дээр онцлон тайлбарласанчлан Монгол Улс энэ ноцтой мэдэгдлийг нотлох үнэмшилтэй баримт гаргаж өгөөгүй.[764]

394. Нэхэмжлэгчид БЛТ нь Хуст-Уулын тусгай зөвшөөрлийг оролцуулан 66 тусгай зөвшөөрөл эзэмшдэг тул “Монголд боломжтой байсан бусад 6,000 тусгай зөвшөөрлөөс” Төмөртэйн ордын тусгай зөвшөөрлийг хүссэн нь түүнийг зохисгүй аргаар олж авсны нотолгоо байж болохгүй гэж онцлов.[765]

395. Нэхэмжлэгчид мөн нотлох баримт хангалтгүйгээс хэргийг хэрэгсэхгүй болгосон прокурорын шийдвэрийг дахин хянаж буй асуудлыг Арбитрын бүрэлдэхүүн “ноцтой авч үзэх ёсгүй” гэж мэдүүлэв. Учир нь уг баримтыг хэрэгсэхгүй болгосноос хоёр жил хагасын дараа, хөөн хэлэлцэх хугацаа дууссаны хойно, сонсголоос долоо хоногийн өмнө “яг тохируулан” гаргаж ирсэн.[766]

Е. ЭРХ СЭРГЭЭХ АРГА ХЭМЖЭЭ

1. Нийтлэг зарчмууд

Нэхэмжлэгчдийн байр суурь

396. Нэхэмжлэгчдийн үзэж байгаагаар “олон улсын заншлын эрх зүйн зарчмуудын дагуу Нэхэмжлэгчид Монгол Улс олон улсын үүргээ зөрчсөний улмаас учирсан хохирлоо бүрэн арилгуулах эрхтэй”.[767] Эдгээр заншлын эрх зүйн зарчмын агуулгыг Олон улсын шударга ёсны байнгын шүүх Factory at Chorzow хэрэгт[768] дараах байдлаар тодорхойлсныг Нэхэмжлэгчид сануулав:

> Хохирлыг арилгах арга хэмжээ нь боломжтой хэмжээнд хууль бус үйлдлийн бүх үр дагаврыг арилгаж, уг үйлдэл хийгдээгүй бол бүх магадлалаар оршин байх байсан нөхцөл байдлыг сэргээх ёстой. Биет байдлаар буцаан сэргээх, эсхүл энэ нь

---

[763] Нэхэмжлэгчдийн Хариу тайлбар, догол мөр 216; мөн үзнэ үү: Сонсголын тэмдэглэл (өдөр 1, 2015 оны 9 дугаар сарын 14) 113:18–122:11.

[764] Нэхэмжлэгчдийн Хариу тайлбар, догол мөр 216.

[765] Сонсголын тэмдэглэл (өдөр 1, 2015 оны 9 дугаар сарын 14) 119:1–119:22.

[766] Сонсголын тэмдэглэл (өдөр 1, 2015 оны 9 дугаар сарын 14) 120:7–122:11.

[767] Нэхэмжлэгчдийн Нэхэмжлэлийн үндэслэл, догол мөр 280.

[768] Нэхэмжлэгчдийн Нэхэмжлэлийн үндэслэл, догол мөр 280; Хоржувын үйлдвэрийн тухай хэрэг (Герман Польшийн эсрэг) (Нөхөн төлбөрийн нэхэмжлэл) (Үндэслэл), PCIJ, A цуврал, № 17 (1928) (Эрх зүйн эх сурвалж CLA-99).

боломжгүй бол биет байдлаар буцаан сэргээсэнтэй дүйцэх үнэ бүхий мөнгөн дүнг төлөх ёстой.[769]

397. Энэ хэрэгт 939А тусгай зөвшөөрлийг сэргээх нь бодитойгоор боломжгүй зүйл биш бөгөөд Хариуцагчид дарамт болохоосоо илүү Монголын эдийн засагт үнэндээ ашиг тустай гэж Нэхэмжлэгчид маргав. Нэхэмжлэгчид мөн "зөвхөн буцаан сэргээх нь хохирлыг бүрэн арилгахад хангалтгүй тул"[770] "буцаан сэргээснээр арилгахгүй аливаа алдагдалд" нөхөн төлбөр олгох ёстой гэж маргав.[771]

398. Үүнээс өөр хувилбараар Нэхэмжлэгчид "хоёр үе шатанд хуваасан энэхүү ажиллагааны хоёр дахь шатанд хөрөнгө оруулалтыг нь хураасны улмаас амссан алдагдлаа бүрэн нөхөн төлүүлэхийг шаардана" гэж мэдүүлэв.[772]

Хариуцагчийн байр суурь

399. Хариуцагч Нэхэмжлэгчдийн буцаан сэргээх шаардлагыг эсэргүүцэж, "Монгол Улс Ашигт малтмалын тухай хуулийн 56(2) дугаар зүйлийг мөрдөөгүй гэх зөрчилд авах зохистой арга хэмжээ яагаад боломжит хамгийн эрс шийдэл буюу тусгай зөвшөөрлийг шууд буцаан олгох байх ёстойг Нэхэмжлэгчид тайлбарлаагүй. Нэхэмжлэгчид энэ саналыг дэмжих ямар ч үндэслэл гаргалгүйгээр, зүгээр л илэрхий зүйл мэт үзэж байна" гэж мэдүүлэв.[773]

400. Хариуцагч мөн хоёр талт хөрөнгө оруулалтын гэрээний 4(2) дугаар зүйл энэхүү маргаанд үйлчлэхгүй гэж маргав. Учир нь 4(2) дугаар зүйлийн бичвэр хөрөнгө хураалтыг "зарласан" байхыг шаарддаг бөгөөд Монгол Улс хөрөнгө хураалт зарлаагүй тул 4(2) дугаар зүйлийн нөхөн төлбөр төлөх шаардлага үйлчлэхгүй.[774]

2. Хэмжээг тогтоох

401. Арбитрын бүрэлдэхүүний Процессын 1 дүгээр захирамжийн 38 дугаар догол мөрд зааснаар: "Талууд ажиллагааг хоёр үе шатанд хуваахаар тохиролцсон бөгөөд эхний шатанд харьяалал болон хариуцлагыг, шаардлагатай бол хоёр дахь шатанд хохирлын хэмжээг авч үзнэ."

VII. АРБИТРЫН БҮРЭЛДЭХҮҮНИЙ ДҮН ШИНЖИЛГЭЭ

402. Арбитрын бүрэлдэхүүн өөрийн харьяалал, маргааны үндсэн асуудал болон Хариуцагчийн сөрөг нэхэмжлэлийн талаар Талуудын гаргасан дэлгэрэнгүй үндэслэлүүдийг, түүнчлэн Талуудын маргааныг үүсгэсэн ээдрээтэй үйл баримтын нөхцөл байдлыг нягтлан авч үзсэн. Хэрэг хянан шийдвэрлэсэн ажиллагааны тэмдэглэлийг бүрэн байлгахын тулд Талуудын нэхэмжлэл, сөрөг нэхэмжлэлийн талаарх тайлбарыг дээр дурдсанаар бүрэн хадгалахаар бүрэлдэхүүн шийдсэн. Гэвч доор тодорхой болохчлон, харьяаллын талаар гаргасан

[769] Нэхэмжлэгчдийн Нэхэмжлэлийн үндэслэл, догол мөр 280.

[770] Нэхэмжлэгчдийн Нэхэмжлэлийн үндэслэл, догол мөр 284.

[771] Нэхэмжлэгчдийн Нэхэмжлэлийн үндэслэл, догол мөр 284.

[772] Нэхэмжлэгчдийн Нэхэмжлэлийн үндэслэл, догол мөр 285.

[773] Хариуцагчийн Давтан хариу тайлбар, догол мөр 374.

[774] Хариуцагчийн Давтан хариу тайлбар, догол мөрүүд 457-458.

шийдвэрийн улмаас Талуудын нэхэмжлэл, сөрөг нэхэмжлэлийн үндсэн асуудлаар аливаа шийдвэр гаргах боломжгүй болсон.

403. Энэ шийдвэрийг гаргахдаа Арбитрын бүрэлдэхүүн эхлээд өөрийн харьяаллыг авч үзнэ. Үүнтэй холбоотойгоор Хариуцагч хэд хэдэн татгалзал гаргасан (дээрх 231–301 дүгээр догол мөрийг үзнэ үү). Хариуцагчийн татгалзлуудыг дээр тэдгээрийг гаргасан дарааллаар нь тусгасан боловч Арбитрын бүрэлдэхүүн харьяаллын асуудлыг өөрийн зохистой гэж үзсэн дарааллаар авч үзэж, эхлээд хэрэгт оролцогч этгээдээр тодорхойлогдох харьяалал буюу ratione personae болон үүнтэй холбоотой Хариуцагчийн татгалзлаас эхэлнэ. Дараа нь маргааны зүйлээр тодорхойлогдох харьяалал буюу ratione materiae болон түүнд холбогдох Хариуцагчийн татгалзлуудыг авч үзнэ. Харин Хэлэлцээрийн 8(3) дугаар зүйл болон Монгол Улс олон улсын арбитрт зөвшөөрөл өгсөн хүрээний талаар эцэст нь хүрсэн, доор дурдах дүгнэлтийг харгалзан Хариуцагчийн үлдсэн татгалзлуудаар шийдвэр гаргах шаардлагагүй гэж бүрэлдэхүүн үзэв.

А. ХЭРЭГТ ОРОЛЦОГЧ ЭТГЭЭДЭЭР ТОДОРХОЙЛОГДОХ ХАРЬЯАЛАЛ (RATIONE PERSONAE)

404. Хариуцагч Нэхэмжлэгчид Хэлэлцээрийн 1(2) дугаар зүйлийн дагуу хөрөнгө оруулагчид хамаарахгүй гэсэн үндэслэлээр Арбитрын бүрэлдэхүүний ratione personae харьяалалд татгалзал гаргасан (дээрх 269–276 дугаар догол мөрийг үзнэ үү).

405. Энэ ажиллагааны Нэхэмжлэгчид нь Хятадын гурван компани юм. Хэлэлцээрээр хамгаалагдах Хятадын хөрөнгө оруулагчид хамаарахын тулд тэд 1(2)(b) дугаар зүйлд заасан дараах гурван шаардлагыг хангах ёстой. Үүнд:

(a) “аж ахуйн нэгж” байх;

(b) БНХАУ-ын “хууль тогтоомжийн дагуу байгуулагдсан” байх; мөн

(c) БНХАУ-ын “нутаг дэвсгэрт оршин байрладаг” байх.[775]

406. Нэхэмжлэгчид БНХАУ-ын хууль тогтоомжийн дагуу байгуулагдсан бөгөөд холбогдох бүх хугацаанд БНХАУ-ын нутаг дэвсгэрт оршин байрлаж байсан гэдэгт Талууд санал нийлж байна.

407. Харин Нэхэмжлэгчдийг “аж ахуйн нэгж” гэж үзэж болох эсэх талаар Талууд маргаж байна.

408. “Аж ахуйн нэгж” гэдэг нь “хувийн, арилжааны байгууллага” эсхүл “эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлдэг аливаа төрлийн байгууллага”-ыг илэрхийлж болохыг Хариуцагч хүлээн зөвшөөрсөн.[776] Гэхдээ Бээжин Шоуган, Чайна Хэйлунзян нь “аж ахуйн нэгж” мөн эсэхийг дан ганц Хэлэлцээрийг үзээд шийдвэрлэх боломжгүй, Хятадын олон улсын гэрээний практикаас удирдамж авах ёстой гэж үзжээ. Тэр практикт төрийн байгууллагыг хамгаалагдах хөрөнгө оруулагчид илэрхий хамруулсан цөөн гэрээ байдаг нь, ийм тусгай заалтгүй бол төрийн байгууллагыг “аж ахуйн” нэгж гэж үзэхгүй гэсэн санааг агуулна гэж

[775] Хэлэлцээр, зүйл 1(2).

[776] Хариуцагчийн Хариу үндэслэл, догол мөр 183.

Хариуцагч тайлбарлав.[777] Хариуцагчийн үзэж байгаагаар Чайна Хэйлунзян, Бээжин Шоуган нь арилжааны байгууллага бус, төрийн өмчит байгууллага тул Хэлэлцээрийн "хөрөнгө оруулагч" гэсэн тодорхойлолтод хамаарахгүй.[778] Мөн тэдгээрийн үйл ажиллагаа "аж ахуйн" шинжтэй биш,[779] учир нь тэд "аж ахуйн нэгжийн тухайд ердийн байдлаар ойлгодог утгаар ашиг олох зорилгоор үйл ажиллагаа явуулдаггүй" гэж Хариуцагч маргажээ.[780] Түүнчлэн тэд өмчлөгч болох Хятадын төрөөс "хангалттай хараат бусаар" ажилладаггүй,[781] харин үнэн хэрэгтээ "Хятадын Засгийн газрын бараг хэрэгжүүлэгч байгууллагууд"[782] бөгөөд "Хятадын Засгийн газрын шууд хяналтад, [] Хятадын гадаад бодлогын зорилгод үйлчлэхийн тулд гадаадад хөрөнгө оруулах тухай илэрхий зааврын дагуу" ажилладаг гэж үзсэн.[783]

409. Үүний нэгэн адил Циньлун нь компанийн хэлбэртэй, Хятадын Засгийн газрын өмч биш боловч "аж ахуйн нэгж" гэх ойлголтод агуулагдах шаардлагатай "тусгаар байдлыг" хангасан байгууллага байдлаар ажиллаагүй гэж Хариуцагч маргасан.[784] Үүнийг нотлох нөхцөлүүдийн нэг нь Циньлуны цорын ганц хувьцаа эзэмшигч ноён Ли Төмөртэйн ордтой холбоотой, "анхаарал татахуйц зарим онцлогтой" хэд хэдэн гэрээнд Чайна Хэйлунзяны нэрийн өмнөөс өөр өөр цаг хугацаанд гарын үсэг зурж,[785] мөн Хятадын Засгийн газрын нэрийн өмнөөс гүйцэтгэсэн үүрэг юм гэж үзжээ.[786]

410. Түүнчлэн Нэхэмжлэгчид Төмөртэй Хүдэр дэх хувьцаа эзэмшлээ нотлох ямар ч баримт гаргаагүй гэж Хариуцагч мэдэгдсэн.[787]

411. Эдгээр асуудлаарх Хариуцагчийн тайлбарууд Арбитрын бүрэлдэхүүнийг үнэмшүүлсэнгүй.

412. Нэгдүгээрт, Арбитрын бүрэлдэхүүн Хэлэлцээрийн 1(2) дугаар зүйлд хэрэглэсэн нэр томьёог авч үзэв. Монгол Улс болон БНХАУ-ын аль алиных нь хамгаалагдах хуулийн этгээдийг тодорхойлсон "аж ахуйн нэгж" гэсэн хэллэг нь өргөн утгаар илэрхийлэгдсэн бөгөөд зохион байгуулалтын төрөл, бизнесийн зорилго, өмчлөл, хяналтаар ялгаагүй байна. Иймд Хэлэлцээрийг боловсруулагчид ямар нэг хязгаарлалт тогтоохыг зориогүй байхад 1(2)

---

[777] Хариуцагчийн Хариу үндэслэл, догол мөр 184.

[778] Хариуцагчийн Хариу үндэслэл, догол мөр 185.

[779] Хариуцагчийн Давтан хариу тайлбар, догол мөр 312.

[780] Сонсголын тэмдэглэл (өдөр 1, 2015 оны 9 дугаар сарын 14) 203:9–203:14; Хариуцагчийн Давтан хариу тайлбар, догол мөр 313.

[781] Сонсголын тэмдэглэл (өдөр 1, 2015 оны 9 дугаар сарын 14) 201:8–202:17.

[782] Хариуцагчийн Хариу үндэслэл, догол мөр 186.

[783] Хариуцагчийн Давтан хариу тайлбар, догол мөр 293; мөн үзнэ үү: Хариуцагчийн Давтан хариу тайлбар, догол мөрүүд 293-302, 319.

[784] Сонсголын тэмдэглэл (өдөр 5, 2015 оны 9 дугаар сарын 18) 827:19-25.

[785] Сонсголын тэмдэглэл (өдөр 5, 2015 оны 9 дугаар сарын 18) 828:1–832:15, 833:10-20.

[786] Сонсголын тэмдэглэл (өдөр 5, 2015 оны 9 дугаар сарын 18) 881:4-19; Ли Шаомингоос Монгол Улсын Ерөнхий сайдад хүргүүлсэн захидал, 2006 оны 12 дугаар сарын 26 (Баримт С-2).

[787] Сонсголын тэмдэглэл (өдөр 5, 2015 оны 9 дугаар сарын 18) 824:17–828:20.

дугаар зүйлд хөрөнгө оруулагчийн зохион байгуулалт, бизнесийн зорилго, өмчлөл эсхүл хяналттай холбоотой хязгаарлалтыг нэмж унших үндэслэлгүй гэж бүрэлдэхүүн үзэв.

413. Үүнтэй холбогдуулан Арбитрын бүрэлдэхүүн Олон улсын гэрээний эрх зүйн тухай Венийн конвенцын 31(4) дүгээр зүйлийн дагуу нэр томьёонд зөвхөн “талууд тийм санаа зорилготой байсан нь тогтоогдсон тохиолдолд” тусгай утга оноож болохыг тэмдэглэв. Хэлэлцээрийг боловсруулагчид “аж ахуйн нэгж” гэсэн нэр томьёонд тусгай утга оноохыг зорьсон гэх шинж байхгүй. Хариуцагчийн уг нэр томьёонд хамааруулахыг хүсэж буй “тусгаар байдал”[788] болон “хараат бус байдал”[789] гэх ойлголтууд Хэлэлцээрт, эсхүл Хариуцагчийн ирүүлсэн бусад нотлох баримтад үндэслэлгүй бөгөөд БНХАУ, Монгол Улс “аж ахуйн нэгж” гэсэн өргөн нэр томьёонд тусгай бөгөөд хязгаарлагдмал утга оноохыг зорьсон гэдгийг Хариуцагч тогтоож чадаагүй.

414. Зөвхөн БНХАУ-ын гэрээний практикийг эшилсэн нь Хариуцагчийн байр суурийг дэмжихгүй. Олон улсын гэрээг тайлбарлах үүднээс, БНХАУ-ын дангаар нь авч үзсэн гэрээний практикийн цөөн жишээ нь “аж ахуйн нэгж” гэх нэр томьёонд оноосон утгыг тогтооход хамааралтай гэж Арбитрын бүрэлдэхүүн үзэхгүй.[790] Венийн конвенцын 31(3) дугаар зүйлийн дагуу Хэлэлцээрийг хэрэглэх талаар талуудын тохиролцоог тогтоосон, түүнийг хэрэглэх явц дахь дараагийн практикийг бүрэлдэхүүн харгалзан үзэж болно. Гэвч Хариуцагч 1(2) дугаар зүйлийг хязгаарлагдмал утгаар тайлбарлах өөрийн байр суурийг дэмжих ийм тохиролцооны ямар ч нотлох баримт гаргаагүй. Мөн Хариуцагчийн тайлбарласан БНХАУ-ын практикийг Монгол Улс хуваалцдаг эсхүл тэр нь Монголын гэрээний практиктай нийтлэг гэх санааг нотлох зүйл ирүүлээгүй.

415. Арбитрын бүрэлдэхүүн Хэлэлцээрийн 1(2) дугаар зүйлийн “аж ахуйн нэгж” гэсэн нэр томьёо нь эдийн засгийн эсхүл бизнесийн үйл ажиллагаа эрхэлдэг аливаа төрлийн хуулийн этгээдийг илэрхийлнэ гэж дүгнэв.

416. Энэ хэргийн нөхцөлд гурван Нэхэмжлэгч бүгд Хэлэлцээрийн 1(2) дугаар зүйлийн зорилгоор “аж ахуйн нэгж” гэж үзэхэд шаардлагатай хэмжээнд эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлсэн компаниуд болох нь тодорхой байна.

417. Түүнчлэн Хятадын төр Бээжин Шоуган, Чайна Хэйлунзяныг шууд эсхүл шууд бусаар өмчилдөг нь тэдгээрийг Хэлэлцээрийн 1(2) дугаар зүйлийн дагуу “аж ахуйн нэгж” гэж үзэхэд хамааралгүй гэж Арбитрын бүрэлдэхүүн үзэв.

418. Хоёрдугаарт, Бээжин Шоуган, Чайна Хэйлунзян нь “Хятадын Засгийн газрын бараг хэрэгжүүлэгч байгууллагууд” байдлаар ажилласан гэх Хариуцагчийн нэмэлт үндэслэл Арбитрын бүрэлдэхүүнийг үнэмшүүлсэнгүй.[791] Ийм дүгнэлт, эсхүл тэд Хятадын Засгийн

---

[788] Сонсголын тэмдэглэл (өдөр 1, 2015 оны 9 дугаар сарын 14) 200:20–201:7; (өдөр 5, 2015 оны 9 дугаар сарын 18) 827:23.

[789] Сонсголын тэмдэглэл (өдөр 1, 2015 оны 9 дугаар сарын 14) 201:24–202:6.

[790] Хариуцагч мөн өөрийн эш татсан хоёр гэрээ Хятадын гэрээ байгуулах практикийг төлөөлж байгааг нотолж чадаагүй.

[791] Хариуцагчийн Хариу үндэслэл, догол мөр 186.

газрын “Хятадын гадаад бодлогын зорилгод үйлчлэхийн тулд гадаадад хөрөнгө оруулах тухай илэрхий заавар”-аар ажилласан гэх дүгнэлтийг дэмжих нотлох баримт хэргийн материалд алга.[792] Түүнчлэн Циньлуны хяналтын хувьцаа эзэмшигч ноён Лигийн гүйцэтгэсэн үүргийн аль нь ч Циньлун төрийн хяналт эсхүл зааврын дагуу ажиллаж байсныг нотлох хэмжээнд хүрэхгүй байна.

419. Хуралдааны үеэр Хариуцагч “Нэхэмжлэгчид анх эрхэмлэж байсан нэхэмжлэлийн үндэслэлээ орхиж, Хятадын BIT-үүдэд хөрөнгө албадан хураасан эсэхийг тогтоохыг зөвшөөрдөггүй гэж нийтлэг ойлгодог заалтад дангаар нь тулгуурлах болсон” тул “[шударга, тэгш хандах] болон [нэн тааламжтай үндэстний нөхцөл]-ийн үндэслэл гаргах нь БНХАУ-ын гадаадын хөрөнгө оруулагчдад хандах өөрийн практикт эрсдэл учруулах байсан гэж дүгнэх нь зүйтэй. Төрөөс хараат бус ажилладаг аж ахуйн нэгж өөрт нь боломжтой гэж илт үзэж буй үндэслэлүүдээ орхих ямар ч шалтгаангүй” гэж маргасан нь мөн бүрэлдэхүүнийг үнэмшүүлсэнгүй.[793] Харин ч 1998 оноос хойших Хятадын гэрээний практикийн хөгжил нь БНХАУ өөрт нь хөрөнгө оруулж буй гадаадын хөрөнгө оруулагчид болон бусад улсад хөрөнгө оруулж буй Хятадын хөрөнгө оруулагчдад олгох хамгаалалтыг өргөжүүлэхийг сүүлийн үед хүсэж байгааг харуулдаг. Ийм нөхцөлд гэрээний нэр томьёонд оноох утгын талаар ерөнхий дүгнэлт хийхийн тулд маргагч талууд ямар үндэслэл гаргах, алийг нь орхих тухай стратегийн шийдвэрийг Арбитрын бүрэлдэхүүн таамаглан тайлбарлаж, түүнд хэт их утга оноож болохгүй.

420. Эцэст нь, Нэхэмжлэгчид Төмөртэй Хүдэрийн хувьцааг эзэмшдэгээ нотолсон эсэх, эсхүл Төмөртэй Хүдэр хэзээ нэгэн цагт хувьцаа гаргасан буюу хувьцааны төлбөр хүлээн авсан эсэх нь Нэхэмжлэгчдийг Хэлэлцээрээр хамгаалагдах хөрөнгө оруулагч гэж үзэх эсэхийг тогтооход хамааралгүй гэж Арбитрын бүрэлдэхүүн үзэв.

421. Ямартай ч Төмөртэй Хүдэрийн үүсгэн байгуулалтын гэрчилгээнд Монгол Улс өөрөө Нэхэмжлэгчдийг тус компанид “хөрөнгө оруулагчид”[794] бөгөөд тус компанид “хөрөнгө оруулсан”[795] гэж тодорхойлсныг Арбитрын бүрэлдэхүүн тэмдэглэв. Дээр тайлбарласнаар Хэлэлцээрийн дагуу “хөрөнгө оруулагчид” хамаарахын тулд Нэхэмжлэгчид 1(2) дугаар зүйлд заасан гурван шаардлагыг хангах ёстой.[796] Гурван Нэхэмжлэгч бүгд БНХАУ-ын хууль тогтоомжийн дагуу байгуулагдсан, холбогдох бүх хугацаанд тус улсын нутаг дэвсгэрт оршин байрласан аж ахуйн нэгжүүд мөн гэж бүрэлдэхүүн үзэж байна. Иймээс тэд Хэлэлцээрийн зорилгоор хамгаалагдах “хөрөнгө оруулагчид” хамаарна.

422. Иймд Арбитрын бүрэлдэхүүний ratione personae харьяалалд гаргасан Хариуцагчийн татгалзлыг хэрэгсэхгүй болгов.

---

[792] Хариуцагчийн Давтан хариу тайлбар, догол мөр 293.

[793] Сонсголын тэмдэглэл (өдөр 1, 2015 оны 9 дугаар сарын 14) 181:4–181:14.

[794] Монголын Гадаадын хөрөнгө оруулалт, гадаад худалдааны агентлагийн А-470 дугаар тушаал, 2005 оны 5 дугаар сарын 16 (Баримт С-64).

[795] Төмөртэй Хүдэрийн гадаадын хөрөнгө оруулалттай компанийн 02-214 дугаар гэрчилгээ, 2005 оны 6 дугаар сарын 15 (Баримт С-7).

[796] Дээрх 405 дугаар догол мөрийг үзнэ үү.

B. МАРГААНЫ ЗҮЙЛЭЭР ТОДОРХОЙЛОГДОХ ХАРЬЯАЛАЛ (RATIONE MATERIAE) — ХӨРӨНГӨ АЛБАДАН ХУРААСАН ГЭХ ҮЙЛДЛИЙН ХАРИУЦЛАГЫГ ТОГТООХ ХАРЬЯАЛЛЫГ ХЭЛЭЛЦЭЭР ОЛГОСОН ЭСЭХ

423. Хариуцагч Хэлэлцээрийн 8(3) дугаар зүйлд заасан Монгол Улсын арбитрт өгсөн зөвшөөрөл нь Нэхэмжлэгчдийн нэхэмжлэлийн зүйлд хамаарахгүй гэсэн үндэслэлээр Арбитрын бүрэлдэхүүний харьяалалд татгалзал гаргасан (дээрх 252–268 дугаар догол мөрийг үзнэ үү).

424. Хариуцагчийн татгалзлын улмаас Арбитрын бүрэлдэхүүн өөрийн ratione materiae харьяаллын хүрээг тогтоох шаардлагатай. Үүний тулд тусгай арбитрын бүрэлдэхүүний харьяаллыг тогтоосон цорын ганц заалт болох Хэлэлцээрийн 8 дугаар зүйлийн 3 дахь хэсгийг тайлбарлах ёстой. Уг заалт дараах агуулгатай:

> Хөрөнгө албадан хураасны нөхөн төлбөрийн хэмжээтэй холбоотой маргааныг энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу хэлэлцээ эхлүүлснээс хойш зургаан сарын дотор шийдвэрлэж чадаагүй бол аль нэг талын хүсэлтээр тусгай арбитрын бүрэлдэхүүнд шилжүүлж болно. Холбогдох хөрөнгө оруулагч энэ зүйлийн [ ] 2 дахь хэсэгт заасан журмыг хэрэглэсэн бол энэ хэсгийн заалтууд үйлчлэхгүй.

425. Дээр эш татсан заалтыг дангаар нь тусгаарлан тайлбарлаж болохгүй. Венийн конвенцын 31 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт тусгасан тайлбарлах ерөнхий дүрмийн дагуу “гэрээг түүний нэр томьёонд хам сэдвийнх нь хүрээнд оноох ердийн утга болон гэрээний зорилго, зориулалтыг харгалзан шударгаар тайлбарлана”.

426. Тусгай арбитрын бүрэлдэхүүний харьяаллын тухай заалт нь Хэлэлцэн тохиролцогч нэг улсын хөрөнгө оруулагч болон Хэлэлцэн тохиролцогч нөгөө улсын хоорондын маргааныг шийдвэрлэхэд зориулсан 8 дугаар зүйлийн нэг хэсэг юм. Уг зүйл найман хэсэгтэй. Эхний гурван хэсэг нь[797] хөрөнгө оруулалтын ийм маргааныг хэлэлцээгээр эвийн журмаар шийдвэрлэх (1 дэх хэсэг), хөрөнгө оруулалтыг хүлээн авсан Хэлэлцэн тохиролцогч улсын эрх бүхий шүүхийн ажиллагаагаар шийдвэрлэх (2 дахь хэсэг), эсхүл олон улсын арбитраар шийдвэрлэх (3 дахь хэсэг) аргуудтай холбоотой. Харин 4–8 дахь хэсэг нь тусгай арбитрын бүрэлдэхүүнийг байгуулах журам, ажиллагааны дүрэм, шийдвэр гаргах, бүрэлдэхүүний хэрэглэх эрх зүй болон зардлыг зохицуулдаг. Эдгээр хэсэг (4–8) нь Арбитрын бүрэлдэхүүний ratione materiae харьяаллын хүрээнд онцгой хамааралгүй.

427. Иймээс Арбитрын бүрэлдэхүүн цаашдын дүн шинжилгээндээ 8 дугаар зүйлийн эхний гурван хэсэгт анхаарлаа төвлөрүүлнэ. 1 дэх хэсэгт:

> Хэлэлцэн тохиролцогч нэг улсын хөрөнгө оруулагч болон Хэлэлцэн тохиролцогч нөгөө улсын хооронд, нөгөө улсын нутаг дэвсгэрт хийсэн хөрөнгө оруулалттай холбоотой аливаа маргааныг боломжтой хэмжээнд маргааны талуудын хоорондын хэлэлцээгээр эвийн журмаар шийдвэрлэнэ.

Ийнхүү уг заалт BIT-ийн 8 дугаар зүйлийн маргаан шийдвэрлэх зохицуулалтын хүрээнд хамаарч болох маргааны төрлийг тогтоож байна. Нэгдүгээрт, ratione personae буюу оролцогч этгээдийн хувьд маргаан нь Хятадын хөрөнгө оруулагч ба Монгол Улс, эсхүл

[797] Эдгээр гурван хэсгийн бичвэрийг дээрх 252 дугаар догол мөрд тусгасан.

Монголын хөрөнгө оруулагч ба Хятад Улсын хооронд байх ёстой. Ratione materiae буюу маргааны зүйлийн хувьд тэр нь “хөрөнгө оруулалттай холбоотой” үүссэн, өөрөөр хэлбэл хөрөнгө оруулалтын маргаан байх ёстой.

428. Хэлэлцээрийн дагуу хөрөнгө оруулалтын маргаан гэх ангилалд юу хамаарахыг түүний материаллаг зохицуулалтууд, ялангуяа 3–5 болон 9 дүгээр зүйлийг харгалзан тогтооно. 3 дугаар зүйл нь хөрөнгө оруулагчдын хөрөнгө оруулалт, түүнтэй холбоотой өгөөж болон үйл ажиллагаанд шударга, тэгш хандах баталгааг олгодог. Мөн хөрөнгө оруулалтыг хүлээн авсан улсын нутаг дэвсгэрт эдгээр хөрөнгө оруулалт, өгөөж, үйл ажиллагааг хамгаалах баталгааг олгоно. Ийнхүү хандах байдал болон хамгаалалт нь гуравдагч улсын хөрөнгө оруулагчдын хөрөнгө оруулалт, өгөөж эсхүл үйл ажиллагаанд үзүүлдэг нөхцөлөөс дор байж болохгүй.

429. 4 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн дагуу Хэлэлцэн тохиролцогч нөгөө улсын хөрөнгө оруулагчдын хөрөнгө оруулалтыг зарчмын хувьд “улсын өмч болгох, албадан хураах эсхүл улсын өмч болгох буюу албадан хураахтай адил үр нөлөөтэй арга хэмжээнд оруулах” ёсгүй. Эдгээр гурван ангиллыг Хэлэлцээрт цаашид “хөрөнгө албадан хураах” гэсэн нэр томьёогоор нэрлэсэн. Хөрөнгө албадан хураахыг зөвхөн “нийгэм болон нийтийн ашиг сонирхлын шаардлагаар” зөвшөөрөх бөгөөд “ялгаварлан гадуурхахгүй үндсэн дээр, хуульд заасан журмын дагуу, нөхөн төлбөртэйгөөр” хэрэгжүүлэх ёстой. Тус зүйлийн 2 дахь хэсэг нь нөхөн төлбөрийг тогтоох, төлөх шалгуурыг заасан.

430. Хэлэлцээрийн 5 дугаар зүйл нь Хэлэлцэн тохиролцогч нэг улсын хөрөнгө оруулагчид нөгөө улсын нутаг дэвсгэрт байгаа хөрөнгө оруулалт болон өгөөжөө чөлөөтэй шилжүүлэх баталгааг олгодог.

431. Хэлэлцээрийн 9 дүгээр зүйлийн дагуу хөрөнгө оруулалтыг хүлээн авсан улсын хууль тогтоомжийн дагуу хөрөнгө оруулалтад үзүүлэх нөхцөл нь Хэлэлцээрт зааснаас илүү тааламжтай бол хөрөнгө оруулагчид тэр илүү тааламжтай нөхцөлийг эдлэх эрхтэй.

432. Ийнхүү хөрөнгө оруулалтыг хүлээн авсан улс Хэлэлцээрийн дагуух аль нэг үүргээ зөрчсөн гэж хөрөнгө оруулагч мэдэгдсэн хөрөнгө оруулалтын маргааны өргөн ангиллыг хэлэлцээгээр эвийн журмаар шийдвэрлэх ёстой. Эвийн журмаар шийдвэрлэхийг оролдсон байх нь 8 дугаар зүйлийн 2 дахь хэсэг (шүүхийн ажиллагаа) эсхүл 3 дахь хэсэгт (арбитрын ажиллагаа) заасан бусад журмыг хэрэглэх урьдчилсан нөхцөл болно.

433. Шүүхийн болон арбитрын хоёр журмын нийтлэг тал нь тэдгээрээс өмнө зургаан сарын “тайвшрах” хугацаа өнгөрсөн байх ёстой явдал юм. Иймээс 8 дугаар зүйлийн 2 болон 3 дахь хэсэг тус бүр шүүхийн эсхүл арбитрын журмыг хэрэглэх урьдчилсан нөхцөл тогтоож, зөвхөн “маргааныг зургаан сарын дотор хэлэлцээгээр шийдвэрлэж чадаагүй бол” тэдгээрийг хэрэглэх боломжтой гэж заажээ.[798]

---

[798] Хэлэлцээр, 8(2) дугаар зүйл. 3 дахь хэсэгт мөн адил нөхцөлийг ялимгүй өөр үг хэллэгээр заасан: «Хэрэв албадан хураалтын нөхөн төлбөрийн хэмжээг хамарсан маргааныг энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу хэлэлцээ хийж эхэлснээс хойш зургаан сарын дотор шийдвэрлэж чадаагүй бол».

434. Гэвч хоёр журмын нийтлэг тал үүгээр дуусна. Хөрөнгө оруулалтыг хүлээн авсан Хэлэлцэн тохиролцогч улсын шүүхийн харьяалал хавьгүй өргөн. Хөрөнгө оруулагч болон Хэлэлцэн тохиролцогч улсын хоорондын хөрөнгө оруулалтын аливаа маргааныг зургаан сарын дотор эвийн журмаар шийдвэрлэзгүй бол шүүхэд гаргаж болно. Учир нь Хэлэлцээрийн 8 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт "маргаан" гэж заасан бөгөөд 1 дэх хэсэгт түүнийг "Хэлэлцэн тохиролцогч нэг улсын хөрөнгө оруулагч болон Хэлэлцэн тохиролцогч нөгөө улсын хооронд, нөгөө улсын нутаг дэвсгэрт хийсэн хөрөнгө оруулалттай холбоотой аливаа маргаан . . . ." гэж тодорхойлсон. Ийм маргаан нь Хэлэлцээрийн 3 дугаар зүйлд шаардсанчлан хөрөнгө оруулалт, түүнтэй холбоотой өгөөж, үйл ажиллагаанд шударга, тэгш хандаагүй эсхүл хамгаалаагүй гэх асуудал, эсхүл хөрөнгө албадан хураасан гэх үйлдэл болон 4 дүгээр зүйлийн дагуу улс ийм ажиллагаа явуулж болох нөхцөлтэй холбоотой байж болно. Мөн 5 дугаар зүйлд зааснаар хөрөнгө оруулагчдын хөрөнгө оруулалт, өгөөжөө чөлөөтэй шилжүүлэх баталгааг хангаагүй, эсхүл 9 дүгээр зүйлд нийцүүлэн илүү тааламжтай нөхцөл олгоогүй гэх асуудалтай холбоотой байж болно.

435. Арбитрын бүрэлдэхүүний үзэж байгаагаар 8 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн дагуух дотоодын шүүхийн харьяалал нь Хэлэлцэн тохиролцогч нэг улсын хөрөнгө оруулагч болон нөгөө улсын хооронд, тэр улс Хэлэлцээрийн үүргээ биелүүлсэн эсэхтэй холбоотой үүсэж болох бүх маргааныг хамарна. Үүнд нийгэм, нийтийн ашиг сонирхлын шаардлагаас бусад тохиолдолд хөрөнгө оруулалтыг албадан хураах арга хэмжээнд оруулахгүй байх, мөн ийм шаардлагаар хураахдаа ялгаварлан гадуурхахгүй байх, үндэслэлгүй удаашруулахгүйгээр зохих нөхөн төлбөр төлөх үүргийг хүндэтгэх улсын үүрэг багтана.

436. Харин Хэлэлцээрийн 8 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн дагуух тусгай арбитрын бүрэлдэхүүний ratione materiae харьяалал хавьгүй явцуу бөгөөд зөвхөн "хөрөнгө албадан хураасны нөхөн төлбөрийн хэмжээтэй холбоотой маргаан"-ыг хамарна. Энэ хэллэгийн утга, улмаар харьяаллынхаа нарийн хүрээг бүрэлдэхүүн цааш тогтоох шаардлагатай боловч улс Хэлэлцээрийн 3, 5 эсхүл 9 дүгээр зүйлийн үүргээ биелүүлээгүй гэх маргаан тусгай арбитрын бүрэлдэхүүний харьяаллын гадна байх нь эргэлзээгүй. Хэлэлцээрийн эдгээр гурван зүйлийн үүргийг биелүүлэхтэй холбоотой маргааны хувьд хөрөнгө оруулалтыг хүлээн авсан улсын эрх бүхий шүүх онцгой харьяалалтай. Хөрөнгө оруулагч ийм маргааныг зөвхөн тэр улсын шүүхэд гаргаж болно. Нэхэмжлэгчид арбитрын ажиллагааны явцад үүнийг ойлгосон бололтой. Тэд Арбитрын хүсэлтдээ "Монгол Улс Нэхэмжлэгчдийн хөрөнгө оруулалтыг хууль бусаар албадан хурааж, тэдэнд шударга, тэгш хандаагүй бөгөөд хамгаалаагүйгээрээ Хэлэлцээрийн дагуух үүргээ . . . зөрчсөн болохыг тогтоох"-ыг хүссэн (дээрх 222 дугаар догол мөрийг үзнэ үү; тодотгол нэмэв). Харин хожим Нэхэмжлэлийн үндэслэл болон Хариу тайлбартаа шударга, тэгш хандах болон хамгаалах үүргийг биелүүлээгүй гэх нэхэмжлэлээ орхиж, "Хариуцагч Нэхэмжлэгчдийн хөрөнгө оруулалтыг хууль бусаар албадан хурааснаараа Хэлэлцээрийн 4 дүгээр зүйлийг зөрчсөн болохыг зарлах"-ыг бүрэлдэхүүнээс хүссэн (дээрх 223, 224 дүгээр догол мөрийг үзнэ үү).

437. Хөрөнгө албадан хураасны нөхөн төлбөрийн хэмжээтэй холбоотой маргааны хувьд шүүхэд ч, тусгай арбитрын бүрэлдэхүүнд ч онцгой харьяалал олгоогүй. Хөрөнгө оруулагч сонголттой: ийм маргааныг BIT-ийн 8 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн дагуу хөрөнгө

оруулалтыг хүлээн авсан улсын эрх бүхий шүүхэд, эсхүл 3 дахь хэсгийн дагуу тусгай арбитрын бүрэлдэхүүнд гаргаж болно. Гэвч хөрөнгө оруулагч “хөрөнгө албадан хураасны нөхөн төлбөрийн хэмжээтэй холбоотой маргаан”-ыг шүүхэд гаргаж сонголтоо хийсэн бол тэр сонголт эцсийнх болж, тусгай арбитрын бүрэлдэхүүний харьяалал хаагдана. Энэ эрх зүйн үр дагавар нь BIT-ийн 8 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн сүүлийн өгүүлбэр болох “холбогдох хөрөнгө оруулагч энэ зүйлийн [ ] 2 дахь хэсэгт заасан журмыг хэрэглэсэн бол энэ хэсгийн заалтууд үйлчлэхгүй” гэсэн заалтаас үүднэ.

438. Ингээд бүрэлдэхүүн 8 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн эхний өгүүлбэр, ялангуяа “хөрөнгө албадан хураасны нөхөн төлбөрийн хэмжээтэй холбоотой маргаан” гэсэн хэллэгийг тайлбарлах гол асуудалд хүрч байна.

439. Арбитрын бүрэлдэхүүний үзэж байгаагаар “хөрөнгө албадан хураасны нөхөн төлбөрийн хэмжээтэй холбоотой” гэсэн үгсийн зорилго нь тусгай арбитрын бүрэлдэхүүний харьяалалд хамаарч болох маргааны ангиллыг тодотгох явдал юм. Иймээс уг хэллэг нь зөвхөн хөрөнгө албадан хураасны нөхөн төлбөрийн хэмжээтэй холбоотой маргааныг хамруулахаар харьяаллыг хязгаарлах зорилготой. “Хөрөнгө албадан хураасны нөхөн төлбөрийн хэмжээ” гэсэн нэр томьёоны ердийн утга хүндрэл үүсгэхгүй мэт боловч “холбоотой” (“involving”) гэсэн үгийн хувьд өөр байна. “Холбоотой” гэсэн үг нь уг хэллэгийн хүрээг зөвхөн нөхөн төлбөрийн хэмжээний маргаанаар хязгаарлаж, өөр юуг ч хамруулахгүй юу? Эсхүл нөхөн төлбөрийн хэмжээ маргааны нэг бүрэлдэхүүн хэсэг л бол хөрөнгө албадан хураахтай холбоотой үүсэж болох бүх маргааныг хамруулах уу? Хятад–Лаосын BIT-ийн ижил заалтыг тайлбарлах шаардлагатай болсон Sanum хэрэгт Сингапурын Давж заалдах шатны шүүх “‘involve’ гэдэг үг өргөн болон явцуу тайлбарын аль алиныг дэмжих боломжтой нь эргэлзээгүй бөгөөд түүний байж болох тодорхойлолтуудын талаар жижиг зүйлээр маргалдах нь 8(3) дугаар зүйлийг тайлбарлахад туслахгүй . . . . Харин уг заалтын хам сэдвийг авч үзсэнээр л түүний үгсийг зөв, илүү утга учиртай ойлгож болно” гэж үзсэнтэй Арбитрын бүрэлдэхүүн санал нийлнэ.[799]

440. Одоо авч үзэж буй хэллэгийг агуулсан 8 дугаар зүйлийн маргаан шийдвэрлэх заалтуудыг бүрэлдэхүүн нэгэнт тайлбарласан.[800] Эдгээр нь “хөрөнгө албадан хураасны нөхөн төлбөрийн хэмжээтэй холбоотой маргаан” гэсэн хэллэгийг тайлбарлахдаа харгалзан үзэх хам сэдвийн нэг хэсэг юм. Хөрөнгө албадан хураах асуудлыг зохицуулсан Хэлэлцээрийн 4 дүгээр зүйл ч мөн тэр хам сэдвийн хэсэг болно.[801] Арбитрын бүрэлдэхүүний үзэж байгаагаар 8 дугаар зүйлийн 3 дахь хэсгийг 8 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсэг болон 4 дүгээр зүйлийн аль алиных нь хам сэдэвт тайлбарлах ёстой.

---

[799] Sanum Investments Limited v. The Government of the Lao People’s Democratic Republic, [2016] SGCA 57, догол мөр 126 (Эрх зүйн эх сурвалж CLA-153).

[800] Дээрх 426–435 дугаар догол мөрийг үзнэ үү.

[801] Венийн конвенцын 31 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт гэрээг тайлбарлах зорилгоор авч үзэх хам сэдэвт оршил болон хавсралтуудыг оролцуулсан гэрээний бичвэр мөн багтана гэдгийг баталгаажуулдаг.

441. Энэ үед Хэлэлцээрийн 4 дүгээр зүйлийн 1, 2 дахь хэсгийг[802] бүрэн эшлэх нь зүйтэй. Тэдгээрт:

> 1. Хэлэлцэн тохиролцогч нэг улсын хөрөнгө оруулагчдын хийсэн хөрөнгө оруулалтыг нөгөө улсын нутаг дэвсгэрт нийгэм болон нийтийн ашиг сонирхлын шаардлагаас бусад тохиолдолд улсын өмч болгох, албадан хураах эсхүл улсын өмч болгох буюу албадан хураахтай адил үр нөлөөтэй арга хэмжээнд оруулахгүй (цаашид "хөрөнгө албадан хураах" гэх). Хөрөнгө албадан хураах ажиллагааг ялгаварлан гадуурхахгүй үндсэн дээр, хуульд заасан журмын дагуу, нөхөн төлбөртэйгөөр хэрэгжүүлнэ.
>
> 2. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт дурдсан нөхөн төлбөр нь хөрөнгө албадан хураахыг зарласан үеийн хураагдсан хөрөнгө оруулалтын үнэ цэнтэй тэнцүү, хөрвөх болон чөлөөтэй шилжүүлэх боломжтой байна. Нөхөн төлбөрийг үндэслэлгүй удаашруулахгүйгээр төлнө.

442. Бүрэлдэхүүний тэмдэглэснээр, "хөрөнгө албадан хураасны нөхөн төлбөрийн хэмжээтэй холбоотой" гэсэн үгс нь тусгай арбитрын бүрэлдэхүүнд шилжүүлж болох маргааныг тодотгож байна. Нөхөн төлбөрийн хэмжээтэй холбоотой маргаан гэдэг нь төрөөс нөхөн төлбөр болгон төлөх мөнгөн дүн "хөрөнгө албадан хураахыг зарласан үеийн хураагдсан хөрөнгө оруулалтын үнэ цэнтэй тэнцүү" эсэх тухай маргаан юм.[803]

443. BIT-ийн 8 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт "хөрөнгө албадан хураасны нөхөн төлбөртэй холбоотой маргаан" бус, "хөрөнгө албадан хураасны нөхөн төлбөрийн хэмжээтэй холбоотой маргаан" гэж хэрэглэснийг бүрэлдэхүүн тэмдэглэв (тодотгол нэмэв). Энэ нь бүрэлдэхүүний үзэж байгаагаар 8 дугаар зүйлийн 3 дахь хэсгийг BIT-ийн 4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгтэй холбож байна.

444. Хөрөнгө албадан хураасны нөхөн төлбөр төлөх нь Хэлэлцээрийн 4 дүгээр зүйлийн 1 дэх хэсгээр хүлээлгэсэн үндсэн үүрэг юм. Тус хэсгийн сүүлийн өгүүлбэрт "хөрөнгө албадан хураах ажиллагааг ялгаварлан гадуурхахгүй үндсэн дээр, хуульд заасан журмын дагуу, нөхөн төлбөртэйгөөр хэрэгжүүлнэ" гэж заасан (тодотгол нэмэв).

445. Иймээс "хөрөнгө албадан хураасны нөхөн төлбөрийн хэмжээтэй холбоотой маргаан" гэсэн хэллэг нь маргааны тодорхой ангиллыг, өөрөөр хэлбэл BIT-ийн 4 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн дагуу төлөх ёстой нөхөн төлбөр нь мөн зүйлийн 2 дахь хэсэгт заасанчлан "хөрөнгө албадан хураахыг зарласан үеийн хураагдсан хөрөнгө оруулалтын үнэ цэнтэй тэнцүү" эсэх тухай маргааныг тодорхойлж байна (тодотгол нэмэв).

446. Арбитрын бүрэлдэхүүний үзэж байгаагаар "холбоотой" ("involving") гэдэг нь саармаг үг юм. Энэ үг өөрөө бүрэлдэхүүний харьяалалд хамаарах маргааны ангиллыг өргөжүүлэхгүй, хязгаарлахгүй; асуудлын шийдэл түүнээс хамаарахгүй. Харин шийдвэрлэх ач холбогдолтой үгс нь "хөрөнгө албадан хураасны нөхөн төлбөрийн хэмжээ" юм.

---

[802] 4 дүгээр зүйл нь дайн, улсын онц байдал, бослого, үймээн самуун болон бусад ижил төстэй үйл явдлын үеэр хөрөнгө оруулагчдын амссан алдагдлын тухай 3 дахь хэсгийг мөн агуулдаг. Энэ нь одоогийн асуудалд онцгой холбогдолгүй.

[803] Хэлэлцээр, зүйл 4(2).

447. Бусад хоёр талт хөрөнгө оруулалтын гэрээний төстэй заалтуудыг зарим арбитрын бүрэлдэхүүн болон Сингапурын Давж заалдах шатны шүүх өөрөөр тайлбарласныг энэ бүрэлдэхүүн мэдэж байна. Тэдгээр шийдвэрийн олонх нь өөр улсууд оролцсон, энэ Хэлэлцээрийн заалтаас материаллаг байдлаар ялгаатай гэрээг авч үзсэн боловч зарим нь БНХАУ-ын байгуулсан, үндсэндээ төстэй бусад гэрээг шинжилсэн.[804] Эдгээр бүрэлдэхүүн болон Давж заалдах шатны шүүх дүгнэлтээ голлон effet utile буюу заалтыг бодит үр нөлөөтэй байлгах зарчимд үндэслэсэн. Энэ хэргийн Нэхэмжлэгчдийн нэгэн адил тэд холбогдох заалтыг явцуу утгаар унших нь түүнийг аливаа практик утгагүй болгоно гэж үзсэн.

448. Бусдын байр суурийг хүндэтгэн үзэж байгаа боловч энэ бүрэлдэхүүн уг болгоомжлолтой санал нийлэхгүй. Бүрэлдэхүүний үзэж байгаагаар 8 дугаар зүйлийн 3 дахь хэсэг эрх зүйн үр нөлөөгөө хадгална. Хөрөнгө албадан хураасныг албан ёсоор зарласан бөгөөд төрөөс хөрөнгө оруулагчид хураагдсан хөрөнгө оруулалтынх нь төлөө төлөх мөнгөн дүн маргаантай тохиолдолд тусгай арбитрын бүрэлдэхүүнд хандах боломжтой. Өөрөөр хэлбэл, маргаан нь болсон эсэхэд нь талууд маргаагүй, зарлан мэдэгдсэн хөрөнгө албадан хураалтын нөхөн төлбөрийн хэмжээгээр үнэхээр хязгаарлагдаж байгаа үед арбитрт хандах боломжтой. Албан ёсоор зарлан мэдэгдсэн хөрөнгө албадан хураалт нь улсын өмч болгох буюу албадан хураахтай адил үр нөлөөтэй арга хэмжээнээс (эдгээрийг мөн 4 дүгээр зүйлээр хориглосон) цөөн тохиолддог байж болно. Гэвч маргааны бүхэл бүтэн ангиллыг хамарсан хэвээр байгаа арбитрын заалтыг effet utile буюу бодит үр нөлөөгүй гэж шударгаар хэлж болно гэж бүрэлдэхүүн үзэхгүй.

449. Шууд болон шууд бус хөрөнгө албадан хураалтын аль алинд тусгай арбитрын бүрэлдэхүүнд хандах боломжтой. Шууд бус хураалтын хувьд хөрөнгө оруулагч нөхөн төлбөрийн асуудлыг шүүхээс гадуурх журмаар шийдвэрлүүлэхээр үлдээж, хөрөнгө албадан хураалт болсон тухай шүүхээс (эсхүл зохих захиргааны байгууллагаас) тогтоол гаргуулахыг хүсэх, эсхүл өөрийн үзэж байгаагаар хөрөнгө албадан хураахтай адил үр нөлөөтэй арга хэмжээнээс хөрөнгө оруулалтаа шүүхийн ажиллагаагаар хамгаалуулахыг хүсэх боломжтой. Хөрөнгө оруулагч өмнөх шүүхийн ажиллагаанд нөхөн төлбөрийн асуудлыг арбитраар шийдвэрлүүлэхээр илэрхий үлдээсэн бол 8 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн маргаан шийдвэрлэх замыг сонгох тухай заалт тусгай арбитрын бүрэлдэхүүний харьяаллыг үгүйсгэнэ гэж бүрэлдэхүүн үзэхгүй.

450. Иймээс хөрөнгө оруулагч Хэлэлцээрийн тусгай арбитрт хандах заалтыг ашиглах бодит боломжгүй үлдэнэ гэж бүрэлдэхүүн үзэхгүй. Мөн 8 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн арбитрын тохиролцооны хүрээнээс гаднах нөхцөлд хөрөнгө оруулалтаа хамгаалах эрх зүйн арга замгүй үлдэнэ гэж үзэхгүй. Дээр онцолсноор Хэлэлцээрт төсөөлсөн маргаан шийдвэрлэх үндсэн арга нь хэлэлцээгээр эвийн журмаар шийдвэрлэх болон хөрөнгө оруулалтыг хүлээн авсан улсын шүүхийн ажиллагаа юм. Хэлэлцээрийн дагуу эдгээр

[804] Жишээ нь үзнэ үү: Tza Yap Shum v. The Republic of Peru (ICSID хэрэг № ARB/07/6) Харьяалал болон эрх хэмжээний тухай шийдвэр, 2009 оны 6 дугаар сарын 19 (Эрх зүйн эх сурвалж CLA-32); Sanum Investments Limited v. The Government of the Lao People's Democratic Republic, [2016] SGCA 57 (Эрх зүйн эх сурвалж CLA-153).

шүүхэд хөрөнгө оруулалтын аливаа маргааны (“Хэлэлцэн тохиролцогч нэг улсын хөрөнгө оруулагч болон нөгөө улсын хооронд, хөрөнгө оруулалттай холбоотой аливаа маргаан”) талаар ерөнхий буюу өргөн, хязгаарлагдаагүй харьяалал олгосон. Ялангуяа арбитрыг онцгой тохиолдол байхаар зохицуулсан гэрээний хүрээнд арбитрыг эдгээр аргаас давуу гэж үзэх үндэслэл бүрэлдэхүүнд харагдахгүй байна. Арбитрын илүү өргөн заалт байхгүй нь хөрөнгө оруулагчдыг эрх зүйн хамгаалалтын арга замгүй орхино гэж мөн үзэхгүй.

451. Тайлбар хийхдээ Хэлэлцээрийн зорилго, зориулалтыг харгалзан үзвэл өөр дүгнэлтэд хүрэх боломжтой гэсэн үндэслэл мөн бүрэлдэхүүнийг үнэмшүүлсэнгүй. Гэрээний зорилго, зориулалтыг ихэвчлэн тусгадаг оршил нь энэ Хэлэлцээрт ганц догол мөрөөс бүрдэж байгааг бүрэлдэхүүн тэмдэглэв. Тэнд Хэлэлцэн тохиролцогч хоёр улс “бүрэн эрхт байдал, эрх тэгш байдал, харилцан ашигтай байх зарчмыг харилцан хүндэтгэхэд үндэслэн, хоёр улсын эдийн засгийн хамтын ажиллагаа болон найрсаг харилцааг хөгжүүлэх зорилгоор Хэлэлцэн тохиролцогч нэг улсын хөрөнгө оруулагчдын нөгөө улсын нутаг дэвсгэрт хийх хөрөнгө оруулалтыг хөхүүлэн дэмжих, хамгаалах, таатай нөхцөл бүрдүүлэх” хүслээ илэрхийлсэн. Хөрөнгө албадан хураасан гэх асуудалтай холбоотой бүх асуудлаар өргөн харьяаллыг 8 дугаар зүйлийн дагуу байгуулах арбитрын бүрэлдэхүүнд олгохыг хоёр улс зорьсон гэж үзэх зүйл оршилд алга. Хэрэв тийм зорилготой байсан бол 8 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт Хэлэлцээрийн 4 дүгээр зүйлтэй холбоотой маргаан, эсхүл хөрөнгө албадан хураахтай холбоотой маргаан гэж шууд зааж болох байв. Ийм томьёолол нь хөрөнгө албадан хураасан гэх үйлдэлтэй холбоотой аливаа асуудал, үүнд нөхөн төлбөрийн хэмжээг шийдвэрлэх харьяаллыг бүрэлдэхүүнд олгох байсан. Олон улсын шүүхийн тайлбарласнаар олон улсын эрх зүйн дагуу “тодорхой асуудлын маргаанд харьяалал нэгэнт байгаа бол үүрэг зөрчсөний улмаас талын хүссэн эрх зүйн хамгаалалтын арга хэмжээг авч үзэхэд Шүүхэд харьяаллын тусдаа үндэслэл шаардахгүй”.[805] Гэвч Хэлэлцэн тохиролцогч улсууд 8 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн бичвэрийг “хөрөнгө албадан хураасны нөхөн төлбөрийн хэмжээтэй холбоотой маргаан”-д хамааруулан зориуд нарийн томьёолсон. Зөвхөн энэ явцуу асуудал арбитрын бүрэлдэхүүний харьяалалд хамаарах бөгөөд бүх маргааныг, үүнд нөхөн төлбөрийн хэмжээтэй холбоотой маргааныг ч хөрөнгө оруулалтыг хүлээн авсан улсын эрх бүхий шүүхэд гаргаж болно. Монгол, Хятад хоёр улс 1991 онд Хэлэлцээрт гарын үсэг зурахдаа чухам үүнийг тохиролцсон. Тухайн үед хоёр улс улс төр, эдийн засгийн төстэй тогтолцоотой байсан бөгөөд нөгөө талын шүүхийн тогтолцоонд эргэлзэх, улмаар хөрөнгө оруулалтын маргааныг шийдвэрлэхэд олон улсын арбитрыг илүүд үзэх шалтгаангүй байсныг харгалзвал энэ зохицуулалт гайхах зүйл биш юм.

452. Иймд “Хариуцагч Нэхэмжлэгчдийн хөрөнгө оруулалтыг хууль бусаар албадан хураснаараа Хэлэлцээрийн 4 дүгээр зүйлийг зөрчсөн” гэх Нэхэмжлэгчдийн нэхэмжлэлийг шийдвэрлэх ratione materiae харьяалалгүй гэж Арбитрын бүрэлдэхүүн дүгнэв.

---

[805] LaGrand (Germany v. United States of America), Шүүхийн шийдвэр, I.C.J. Reports 2001, хуудас 466, холбогдох хуудас 485, догол мөр 48; үүнтэй адил Олон улсын шударга ёсны байнгын шүүхийн «Хоржувын үйлдвэрийн тухай хэрэг (Нөхөн төлбөрийн нэхэмжлэл)», Харьяалал, 1927 оны 7 дугаар сарын 26-ны өдрийн шийдвэр, P.C.I.J. Reports, Série A, № 9, хуудас 4, холбогдох хуудсууд 21–25.

453. Ийм дүгнэлтэд хүрсэн тул Хариуцагчийн гаргасан харьяаллын үлдсэн татгалзлуудыг авч үзэх шаардлагагүй.

454. Мөн ижил үндэслэлээр Хариуцагчийн сөрөг нэхэмжлэлүүдийг шийдвэрлэх харьяалал бүрэлдэхүүнд байхгүй.

VIII. ЗАРДАЛ

455. Арбитрын бүрэлдэхүүн хуралдааны сүүлчийн өдөр буюу 2015 оны 9 дүгээр сарын 18-нд хүсэлт гаргасны дагуу тал тус бүр энэхүү ажиллагаанд гаргасан зардлынхаа талаар Арбитрын бүрэлдэхүүнд тайлбар ирүүлсэн.

Нэхэмжлэгчдийн байр суурь

456. Нэхэмжлэгчид зардлын талаарх тайлбартаа “Хожувын үйлдвэрийн хэрэгт тогтоосон бүрэн нөхөн төлөх зарчмын дагуу холбогдох зардал, хөлсийг бүрэн хэмжээгээр гаргуулах” хүсэлт гаргасан.[806]

457. Нэхэмжлэгчдийн үзэж байгаагаар, Арбитрын бүрэлдэхүүн “ажиллагааныхаа журмыг өөрөө тогтоох” бөгөөд Хөрөнгө оруулалтын маргааныг шийдвэрлэх олон улсын төвийн (“ICSID”) дүрмийг “баримжаа болгож болох”-оор заасан Хэлэлцээрийн 8 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн дагуу Арбитрын бүрэлдэхүүн зардал гаргуулах эрхтэй. Арбитрын бүрэлдэхүүн Ажиллагааны тухай 1 дүгээр захирамждаа “ICSID-ийн дүрэм, UNCITRAL-ын дүрэм болон талуудын зохистой гэж үзсэн бусад эх сурвалжид буй ийм удирдамжийг” бүрэлдэхүүний анхааралд танилцуулахыг талуудад даалгасныг Нэхэмжлэгчид дурдсан. ICSID болон UNCITRAL-ын Арбитрын дүрэм хоёул зардал гаргуулах асуудлыг өөрийн үзэмжээр шийдвэрлэх эрхийг Арбитрын бүрэлдэхүүнд олгодог гэж Нэхэмжлэгчид тэмдэглэсэн.

458. Нэхэмжлэгчид ICSID болон UNCITRAL-ын дүрмийн дагуу шийдвэрлэсэн өмнөх хэргүүдийг үндэслэн, эдгээр заалт нь “арбитрын зардлыг хэрхэн хуваарилахыг шийдвэрлэх өргөн эрх хэмжээг Арбитрын бүрэлдэхүүнд олгодог” гэж тайлбарласан.[807] Гэхдээ Арбитрын бүрэлдэхүүн “тал тус бүрийн үндэслэл хэр хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн” болон “арбитрын ажиллагаан дахь тал тус бүрийн үйлдэл”, тухайлбал аль нэг тал ажиллагааг “шаардлагагүйгээр сунжруулсан” буюу “саад учруулсан” эсэхийг харгалзан үзэх ёстой гэж Нэхэмжлэгчид үзсэн.[808]

459. Арбитрын бүрэлдэхүүн харьяалал болон маргааны мөн чанарын асуудлаар Нэхэмжлэгчдийн талд шийдвэрлэвэл зардлыг хэргийн үр дүнгээс хамааруулан хариуцуулах ёстой гэж Нэхэмжлэгчид тайлбарласан.[809] Түүнчлэн арбитрын бүрэлдэхүүнүүд “тухайлбал, харьяалал эсхүл нэхэмжлэлийг хүлээн авч хэлэлцэх боломжийн талаар үндэслэлгүй урьдчилсан татгалзал гаргах, эсхүл хэт их ачаалал үүсгэх баримт гаргуулах хүсэлт тавих зэргээр арбитрын ажиллагааг шаардлагагүйгээр

[806] Нэхэмжлэгчдийн зардлын талаарх тайлбар, догол мөр 1.

[807] Нэхэмжлэгчдийн зардлын талаарх тайлбар, догол мөр 9.

[808] Нэхэмжлэгчдийн зардлын талаарх тайлбар, догол мөр 9.

[809] Нэхэмжлэгчдийн зардлын талаарх тайлбар, догол мөрүүд 10-12.

сунжруулж, саад учруулсан талаас" зардал гаргуулах нь ерөнхийдөө илүү түгээмэл гэж Нэхэмжлэгчид тайлбарласан.[810]

460. Нэхэмжлэгчид зардлаа бүрэн хэмжээгээр гаргуулж чадахгүй байсан ч Хариуцагчийн хүсэлтээр хуралдааныг хойшлуулсантай холбоотой гарсан зардлыг нөхөн төлүүлэх хүсэлт гаргасан.[811]

Хариуцагчийн байр суурь

461. Хариуцагчийн тайлбарласнаар, "UNCITRAL-ын дүрмийн 38, 40 дүгээр зүйл болон арбитрын нийтлэг практик нь нөхөн төлүүлэх боломжтой зардлыг тогтоох эрх, уг зардлыг талуудын хооронд өөрийн үзэмжээр хуваарилах эрхийг Арбитрын бүрэлдэхүүнд олгодог".[812]

462. Нэхэмжлэгчид "хийсэн гэж мэдүүлсэн хөрөнгө оруулалтаа нотолж чадаагүй", харин Хариуцагч 939A тусгай зөвшөөрлийг "худал мэдээлэл өгөх замаар олж авсан" болохыг тогтоосон гэсэн үндэслэлээр зардлаа гаргуулахыг Хариуцагч Арбитрын бүрэлдэхүүнээс хүссэн.[813] Арбитрын ажиллагааг эхлүүлэхдээ удааширсан, анхны даргалагч арбитрч огцорсны дараа Арбитрын бүрэлдэхүүнийг дахин бүрдүүлэх явцыг удаашруулсан, мөн хэт туйлширсан байр суурь баримталсан зэргээр Нэхэмжлэгчид ажиллагааны зардлыг нэмэгдүүлсэн гэж Хариуцагч цааш тайлбарласан.[814]

Арбитрын бүрэлдэхүүний дүгнэлт

463. Хоёр тал хоёул энэхүү ажиллагаанд гаргасан зардлаа гаргуулах хүсэлт тавьж, уг зардлын талаар тайлбар ирүүлснийг Арбитрын бүрэлдэхүүн тэмдэглэж байна. Арбитрын бүрэлдэхүүн зардал гаргуулах эрхтэй гэж хоёр тал хоёул тайлбарласан.

464. Гэвч Хэлэлцээрийн 8 дугаар зүйлийн 8 дахь хэсэгт дараах байдлаар заасныг Арбитрын бүрэлдэхүүн тэмдэглэж байна:

> Маргаанд оролцогч тал тус бүр өөрийн томилсон арбитрын бүрэлдэхүүний гишүүний зардал болон ажиллагаанд өөрийгөө төлөөлүүлэх зардлыг хариуцна. Томилогдсон даргалагчийн зардал болон үлдэх зардлыг маргаанд оролцогч талууд тэнцүү хэмжээгээр хариуцна.

465. Зардлын талаарх тайлбартаа аль ч тал Хэлэлцээрийн энэхүү заалтыг авч үзээгүй. Гэвч Хэлэлцээрээр Арбитрын бүрэлдэхүүн ажиллагааныхаа журмыг өөрөө тогтоох эрхтэйг хүлээн зөвшөөрсөн хэдий ч энэхүү заалт өөрт нь заавал биелэгдэх шинжтэй гэж Арбитрын бүрэлдэхүүн үзэж байна.

466. Иймд тал тус бүр энэхүү ажиллагаанд өөрийн хууль зүйн төлөөллийн зардлыг хариуцах бөгөөд Арбитрын бүрэлдэхүүн арбитрын зардлыг 8 дугаар зүйлийн 8 дахь хэсгийн дагуу

---

[810] Нэхэмжлэгчдийн зардлын талаарх тайлбар, догол мөр 13.

[811] Нэхэмжлэгчдийн зардлын талаарх тайлбар, догол мөрүүд 30-37.

[812] Хариуцагчийн зардлын талаарх тайлбарууд, хуудас 1.

[813] Хариуцагчийн зардлын талаарх тайлбарууд, хуудас 4.

[814] Хариуцагчийн зардлын талаарх тайлбарууд, хуудсууд 5-6.

хуваарилна. Ингэхдээ энэхүү ажиллагааны аль ч үед Арбитрын бүрэлдэхүүний аль нэг гишүүн өөрийг нь томилсон талын хувьд бүрэн хараат бус, төвийг сахисан байхаас өөрөөр өөрийгөө үзэж байгаагүйг Арбитрын бүрэлдэхүүн тэмдэглэхийг хүсэж байна.

467. Арбитрын зардлын хэмжээг тогтоох тухайд, талууд энэхүү ажиллагааны арбитрын зардлын урьдчилгаа болгон РСА-д нийт 1,030,000.00 ам.доллар (Нэхэмжлэгчид 515,000.00 ам.доллар, Хариуцагч 515,000.00 ам.доллар) байршуулсан.

468. Нэхэмжлэгчдийн томилсон арбитрч, доктор Яс Банифатэмигийн хөлс 216,440.00 ам.доллар, зардал 10,441.09 ам.доллар болсон. Эдгээр дүнг РСА-д байршуулсан урьдчилгааны Нэхэмжлэгчдэд ногдох хэсгээс суутгана.

469. Хариуцагчийн томилсон арбитрч, ноён Марк Клодфелтерийн хөлс 300,270.00 ам.доллар, зардал 21,206.44 ам.доллар болсон. Эдгээр дүнг РСА-д байршуулсан урьдчилгааны Хариуцагчид ногдох хэсгээс суутгана.

470. 2013 оны 2 дугаар сарын 6-нд огцрох хүртлээ даргалагч арбитрчаар ажилласан ноён Дональд Донованы хөлс 42,700.00 ам.доллар, зардал 742.78 ам.доллар болсон.

471. 2014 оны 1 дүгээр сарын 26-наас даргалагч арбитрчаар ажилласан шүүгч Петер Томкагийн хөлс 199,150.00 ам.доллар болсон.

472. Арбитрын бүрэлдэхүүний Ажиллагааны тухай 1 дүгээр захирамжийн дагуу энэхүү арбитрын ажиллагааг захиргааны хувьд зохион байгуулах байгууллагаар РСА-ийн Олон улсын товчоог томилсон. РСА-ийн нарийн бичгийн даргын үйлчилгээний хөлс 120,044.48 ам.доллар болсон.

473. Мөн Арбитрын бүрэлдэхүүний Ажиллагааны тухай 1 дүгээр захирамжийн дагуу ноён Донован даргалагч арбитрчаар ажиллаж байх хугацаанд Debevoise & Plimpton LLP хуулийн фирмээс арбитрын бүрэлдэхүүний нарийн бичгийн даргыг томилсон. Тухайн хугацаанд арбитрын бүрэлдэхүүний нарийн бичгийн даргын хөлс 17,600.00 ам.доллар болсон.

474. Энэхүү арбитрын ажиллагаанд гарсан бүрэлдэхүүний бусад зардал, үүнд хуралдааны тэмдэглэл хөтлөгч, орчуулагч, хуралдааны танхимын тоног төхөөрөмж, банкны шимтгэл болон арбитрын ажиллагаатай холбоотой бусад бүх зардал нийлээд 97,544.99 ам.доллар болсон.

475. Дээрх тоон дүнд үндэслэн, томилогдсон даргалагчдын хөлс, РСА болон арбитрын бүрэлдэхүүний нарийн бичгийн даргын хөлс, үлдэх зардал нийт 477,782.25 ам.доллар болсон бөгөөд энэ дүнг байршуулсан урьдчилгаанаас тэнцүү хэмжээгээр (тал тус бүрээс 238,891.13 ам.доллар) суутгана.

476. РСА-д байршуулсан урьдчилгааны Нэхэмжлэгчдэд ногдох хэсгийн зарцуулагдаагүй үлдэгдэл болох 49,227.79 ам.долларыг Нэхэмжлэгчдэд буцаан олгоно. Хариуцагч РСА-д байршуулсан урьдчилгааны өөрт ногдох хэсгийг нөхөх зорилгоор энэхүү Арбитрын шийдвэр гарсан өдрөөс хойш 30 хоногийн дотор РСА-д 45,367.57 ам.доллар төлөх үүрэгтэй.

* * *

IX. ТОГТООХ ХЭСЭГ

477. Дээр дурдсан үндэслэлээр Арбитрын бүрэлдэхүүн:

(a) Хэрэгт оролцогч этгээдээр тодорхойлогдох харьяаллын (ratione personae) талаар Хариуцагчийн гаргасан татгалзлыг хэрэгсэхгүй болгосугай;

(b) Маргааны зүйлээр тодорхойлогдох харьяаллын (ratione materiae) талаар Хариуцагчийн гаргасан татгалзлыг хүлээн авсугай;

(c) Нэхэмжлэгчдийн нэхэмжлэлийн шаардлагыг хянан шийдвэрлэх харьяалалгүй болохыг тогтоосугай;

(d) Хариуцагчийн сөрөг нэхэмжлэлийн шаардлагыг хянан шийдвэрлэх харьяалалгүй болохыг тогтоосугай;

(e) Талууд тус тусын хууль зүйн төлөөллийн зардлыг өөрсдөө хариуцах бөгөөд арбитрын зардлыг дээр дурдсан болон Хэлэлцээрийн 8 дугаар зүйлийн 8 дахь хэсэгт заасан журмын дагуу хариуцсугай;

(f) Хэлэлцээрийн 8 дугаар зүйлийн 8 дахь хэсгийн дагуу өөрийн томилсон арбитрчийн төлөгдөөгүй хөлс, зардал болох 45,367.57 ам.долларыг энэхүү Арбитрын шийдвэр гарсан өдрөөс хойш 30 хоногийн дотор PCA-д төлөхийг Хариуцагчид даалгасугай.

* * *

2017 оны 6 дугаар сарын 30-нд арбитрын суудал болох Нью-Йорк хотод үйлдэв.

[Гарын үсэг]
Доктор Яс Банифатэми
Арбитрч

[Гарын үсэг]
Ноён Марк Клодфелтер
Арбитрч

[Гарын үсэг]
Шүүгч Петер Томка
Даргалагч арбитрч